



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6-118
<hr/>	
<i>1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	10-55
<i>2.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	55-118

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 13-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Х.Баделхан, Х.Болорчулуун, С.Бямбацогт, Х.Ганхуяг, Б.Жавхлан, Г.Занданиатар, Ж.Мөнхбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Л.Оюун-Эрдэнэ, Д.Тогтохсүрэн, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Саранчимэг;

Тасалсан: Д.Ганбат;

Хоцорсон: С.Батболд-4 цаг 07 минут, Д.Батлут-16 минут, Б.Баярсайхан-2 цаг 14 минут, С.Ганбаатар-1 цаг 12 минут, Т.Доржханд-10 минут, С.Одонтуяа-15 минут, М.Оюунчимэг-19 минут, Ш.Раднаасэд-1 цаг 01 минут, Д.Цогтбаатар-46 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж нар үг хэлж, Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Б.Чойжилсүрэн нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Наранцогт, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимэдсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Н.Мөнхзэсэм, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Ц.Даваасүрэн, Г.Ганболд, Ц.Анандбазар, Ж.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, Ж.Батжаргал, М.Оюунчимэг, Б.Баттөмөр, Ц.Туваан, Т.Энхтүвшин, Н.Ганибал, Ш.Адъяа, Ж.Батсуурь, Ц.Цэрэнпунцаг, Д.Батлут нарын тавьсан асуултад Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Наранцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимэдсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Үдийн завсарлагын цаг болсон тул хуралдаан 13 цаг 09 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 09 минутад эхлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг үргэлжлүүлэн явуулав.

Т.Аюурсайхан: Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 22

Бүгд: 51

56.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Санхүү, эдийн засгийн газрын дарга Ж.Бямбасүрэн,

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Наранцогт, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимэдсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Хосбаяр, Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо, мөн яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Эрх зүй, эрсдэлийн удирдлагын газрын дарга Ч.Ариунхур, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Дэд бүтцийн хяналтын газрын дарга Д.Жаргал, Хүнсний аюулгүй байдлын хяналтын газрын дарга Б.Алтантуяа, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга Р.Ганхуяг, Хөгжлийн банкны Тэргүүн дэд захирал Ж.Батаа, мөн банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирал З.Батырбек нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Н.Мөнхзэсэм, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Жаргалмаа, Ж.Чинбүрэн, Ё.Баатарбилэг, Ц.Туваан, М.Оюунчимэг, Н.Энхболд, Б.Энх-Амгалан, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Г.Ганболд, Д.Батлут, Д.Өнөрболор, С.Одонтуяа, Т.Доржханд, Н.Наранбаатар, Б.Баярсайхан, С.Ганбаатар, Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Наранцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Ц.Даваасүрэн, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Санал хураалтыг дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэн явуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 3 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн багш, магистрантууд, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Д.Сарангэрэл, Т.Доржханд нарын урилгаар Хан-Уул дүүргийн ахмад багш нарын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг нарын урилгаар Сүхбаатар дүүргийн 3, 16 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Н.Энхболд, Ж.Батжаргал нарын урилгаар Төв аймгийн Зуунмод сумын ахмадуудын төлөөлөл, Төв аймгийн Баян сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн нарын урилгаар Хөвсгөл аймгийн ахмад багш нарын төлөөлөл, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ахмадуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Багануур дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийн төвийн бизнес эрхлэгчид, Нийгмийн ардчилал, Монголын эмэгтэйчүүдийн холбооны тэргүүлэгчид, Налайх дүүргийн “Чандмань Налайх” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын албан хаагчид, Дархан-Уул аймгийн Дархан сумын “Дархан-Эмпати” сургуулийн ахлах ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Л.Оюун-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ нарын урилгаар Хэнтий аймгийн Биндэр сумын оюутнуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн урилгаар Говь-Алтай аймгийн Тайшир сумын малчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал нарын урилгаар Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын урилгаар зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн бие бүрэлдэхүүний төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн урилгаар Баянзүрх дүүргийн ахмадуудын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж “7 жил биш 5 жилээр тэтгэврээ тогтоолгоцгооё” гэсэн бичиг бүхий зурагт хуудсыг ширээн дээрээ байрлуулсан байв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 06 минут үргэлжилж, 76 гишүүнээс 60 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 18 цаг 11 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 05 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц 52.6 хувьд хүрсэн учраас 2022 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдэж байна.

Нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нийт 9 асуудал байна.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Хоёр.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд.

Гурав.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Дөрөв.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Тав.Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Зургаа.Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Долоо.Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Найм.Түр хорооны даргыг сонгох тухай асуудал.

Ес.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Ийм 9 асуудал байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гарах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн, Бөхчулууны Пүрэвдорж нараас тус тус ирүүлсэн албан бичгүүдийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа, 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн гэсэн албан тоот байна.

Мөн ижил утгатай албан тоотыг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржоос ирүүлсэн болно. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнд үг хэлэх зөвшөөрөл өгье.

Т.Аюурсайхан: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн

тухай хуулийн 13.4-т гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гарах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн, Бөхчулууны Пүрэвдорж нараас тус тус ирүүлсэн албан бичгүүдийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа. 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх зөвшөөрөл олгоно уу.

Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн гэсэн албан тоот байна. Мөн ижил утгатай албан тоотыг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржоос ирүүлсэн болно.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнд үг хэлэх зөвшөөрөл өгье.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Та бүгдийн энэ өглөөний амгаланг эрье.

Тэгэхээр би нэг асуудлыг одоо энэ 7 хоногийн хуваарьт оруулж өгөөч гээд ингээд яриад ерөөсөө болж өгөхгүй байна. Аюурсайхан дарга минь одоо Их Хурлын даргыг орлож байх үедээ нэг анхаарч өгөөч. Өөрөө сайн мэдэж байгаа. Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн заалт тайлбарласан. Журам гэж үгэнд одоо холимог тогтолцоо багтаж байгаа юм байна гэж. Та санаж байгаа. Та өөрөө санаачлаад тэгээд одоо бидний хэсэг гишүүн тэр 21.4-т нэмэлт, өөрчлөлтөөр орох гэж байсан холимог тогтолцоо гэж үгийг авч хаясан. Тийм биз? Авч хаясан. Гэтэл одоо энийг байгаа мэтээр ингээд

Үндсэн хуулийн цэц тайлбарлачихсан. Үндсэн хуулиа зөрччихсэн. Ер нь Үндсэн хуулийг тайлбарлах эрх бол Үндсэн хуулийн цэц-д байхгүй. Тэгээд одоо энэ 76 гишүүнийг сонгосон тэр иргэдийн хүнээ сонгох эрхийг нам дугуйлах, болох мэтээр ингээд тайлбарлачихсан.

Тэгэхдээ гишүүд ч гэсэн анхаармаар байгаа юм. Би одоо ганцаараа тэгээд яах вэ дээ, би ямар ганцаараа ард түмнээр сонгогдоод, та нар намаар сонгогдчихсон биш. Гишүүд ч гэсэн анхаарах хэрэгтэй шүү дээ. Яг үнэндээ хэлэхэд энэ 76 гишүүний хэдхэн хүнд л энэ хамааралтай болохоос биш дийлэнхэд нь энэ ямар ч хамаарал байхгүй эд байхгүй юу. Намын жагсаалтаар сонгогдох бол. Аргаа барчихсан хэдэн гарын л олон нийтэд сонгогдох боломжгүй болчихсон нөхдүүдийн л хийж байгаа үйлдлийг 76-уулаа үүрмээргүй байгаа байхгүй юу даа.

Тийм учраас та нар ч гэлээ гэсэн бас одоо энэ асуудлыг Их Хурлаар хэлэлцэхэд нь анхаараад өгчихмөөр байна шүү дээ. Би 2 асуудал тавьсан байгаа. Тэр хууль бус шийдвэр гаргасан Үндсэн хуулийн цэцийн хугацаа нь дуусчихсан байгаа, Их Хурлаас томилогдсон 3 нөхдүүдийг буцаад татаач ээ гэдэг.

Хоёрдугаарт, би Үндсэн хуулийн цэц-д Улсын Их Хурлын гишүүний хувьд гомдол гаргасан байгаа. Тэгж болдог, тэгж болдог. Тэгэхдээ энэ бүгдийг одоо хэлэлцэхгүй гэж үзэж байгаа юм бол тэр Байнгын хороодоор нь оруулаад надад хариу өг. Байнгын хороодоор нь оруулаад хариу өг. Ийм ийм талаасаа болохгүй байна. Энэ энэ талаасаа болж байна гээд ингээд хариу өг. Тэрнээс биш ингээд таг дараад суучхаж болохгүй. Таг дараад байгаа учраас би Их Хурлын даргыг хэлээд байгаа шүү дээ. Та захиалсан байна аа. Тэр Баянхонгорт одоо эрсдэлтэй болоод ирэнгүүтээ захиалсан байна гэж. Тэгж л би хардаад байгаа юм. Тэгээгүй юм бол энийг одоо

Их Хурлаар хэлэлцээд, шийдвэр гаргачихад юу нь болдоггүй юм? Үгүй ээ, энэ чинь одоо шударга ёс ярьж байгаад л гарч ирээ биз дээ?

Тэгээд иргэдийнхээ сонгох эрхийг хулгайлж байгаа чинь тэгээд шударга ёс юм уу? Тэгэх гэж бид нар тэмцэл хийсэн юм уу? Эцсийн эцэст нь эд нарын сонгодог эрхийг нь булааж авъя гэж шударга ёсны хувьсгал хийсэн юм уу? Тэгээгүй юм бол энийг хэлэлцээд нэг тийш нь болго л доо. Тэр Үндсэн хууль зөрчөөд байгаа цэцийн гишүүдээ буцааж тат л даа. Юунд энд нь одоо ингээд хүчлэн эсэргүүцээд, дарж суугаад байгааг би ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Гишүүд минь эхлээд одоо энэ асуудлыг шийдэхэд анхаарч өг л дөө. Их Хурлаас өөр энийг хэн ч шийдэхгүй. Дараагийн шийдэх боломж нь бол нийгэм байгаа байхгүй юу. Нийгмээ тэгж одоо бужигнуулах хэрэгтэй юм уу? Бас гишүүд хариуцлагатай байдаг баймаар байна. Надад падлийгүй гээд л ингээд л. Үгүй ээ, одоо бид нар чинь одоо энд ямар нэг хувиа хичээх, өөрсдийгөө болгох гэж орж ирсэн улс уу? Үгүй ээ, тэгээд сонгууль болохоор очоод л, гуйгаад л, гувшаад л бүгдийг шийднэ, чадна гээд л ингээд л гүйлдээд байдаг шүү дээ. Оюутолгойг хүртэл одоо эсэргүүцэж байгаа хүн болоод л, жужиглээд л байдаг шүү дээ.

Тэгсэн мөртөө яг иргэдийн чинь сонгох эрхийг ингээд халдчихаад байхад, хулгайлчихаад байхад намын жагсаалтаар сонгох тухай асуудал Үндсэн хуульд байхгүй байгаад байхад энэ Их Хурал яагаад ингээд одоо таг суугаад байгаа юм бэ? Ингээд явах ёстой юм бол ард түмнээсээ асууя л даа хэдүүлээ. Адаглаад нэг бол ард түмнээсээ асуучихъя. Одоо энэ намын жагсаалтыг дэмжиж байгаа юм уу, үгүй юу гээд. Тэгээд нэг тийш нь болгочихъё. Хэрвээ ард иргэд одоо намын жагсаалт, нам дагуулахыг зөвшөөрч байгаа бол надад хэлэх юм алга. Хэлэх юм алга. Нэг бол тэгж шийд. Одоо ард иргэдээсээ асуу. Та нар нам

сонгох уу, хүнээ сонгох уу гэдгийг нь асуу.

Тэгээд Үндсэн хуульдаа одоо тэр өөрчлөлтийг нь хийгээд яв. Үндсэн хууль зөрчиж байхад ингээд мэлийгээд мэдээгүй юм шиг суугаад байдаг гишүүд байж болохгүй шүү дээ. Би зүгээр ний нуугүй хэлье. Тэгээд сонгогдох болохоор улайраад л гүйчихнэ, гуйгаад л суучихна.

Тийм учраас энэ асуудлыг одоо хэдүүлээ нэг тийш.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Даваасүрэн гишүүний хэлж байгаа саналыг бас миний зүгээс Улсын Их Хурлын даргад хэлж байгаа. Улсын Их Хурлын дарга 2022 оны 8 дугаар сарын 22-ны өдөр хуралдсан ээлжит бус чуулганы нээлт дээр бас энэ талаар байр сууриа тодорхой илэрхийлсэн.

Тухайлбал: Үндсэн хууль өөрөө Үндсэн хуулийг зөрчсөн гэж Цэц дүгнэж, хүчингүй болгох шийдвэр гаргасан ноцтой үр дагавар үүсгэж болох томоохон алдаа бөгөөд Цэц Үндсэн хуулиас бусад хууль, Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх эрхтэй болохоос Үндсэн хуулийн зүйл, заалтыг хүчингүй болгох эрх байхгүй.

Харин нэмэлт, өөрчлөлт оруулах бүрэн эрх гагцхүү Улсын Их Хуралд бий гэсэн. Үүнийг бол бас чуулганы нээлтийн үгэн дээрээ Улсын Их Хурлын дарга бас хэлсэн.

Тийм учраас энэ чиглэлээр бас холбогдох зохицуулалт, арга хэмжээг авна гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Монголын бүх ахмадууддаа энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхлээр өнгөрсөн 2022 оны 2 сарын 1-ний өдөр Улсын Их Хурлын ээлжит бус

чуулганаараа тэтгэврийн доод хэмжээг 300, 350 байсныг 400, 500 болгосон. Тэгэхлээр энэ нэмэгдэл бол тухайн үедээ ахмадуудын хувьд бол сайн мэдээ байсан боловч өнөөдөр Монгол Улсын Засгийн газар энэ эдийн засгийг буруу удирдаж, Монголбанк мөнгөний бодлогыг зөв явуулгаагүйн үндсэн дээр айхтар их барааны үнэ нэмэгдэж, ханш уналт бий болж, үүнээс шалтгаалаад тухайн үед 350000 төгрөгөөр авч байсан бараа өнөөдөр яг тэр тэтгэврийн нэмэгдэл 500000-аар авахад хүрэх хэмжээний, бараг заримдаа хүрэхгүй хэмжээний. Өөрөөр хэлбэл зарим бараа бүтээгдэхүүн бол 1 дахин зарим, ихэнх нь бол 40-50 хувь өссөн байж байгаа. Энэ бол ахмадуудын амьдралд маш тийм хүнд цохилт өгч байна.

Тийм учраас өнөөдөр энэ ахмадуудынхаа тэтгэврийг нэмэгдүүлэх, ялангуяа тэтгэвэрт шинээр гарч байгаа, 7 жилээр бодуулж байгаа тэр иргэд бол өнөөдөр бүгдээрээ нийт тэтгэвэр авагчдын 85-90 хувь нь, бараг 88 хувь нь бүгдээрээ бүрэн тэтгэврийн доод хэмжээ 400000, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 400000, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 500000 л авчихна шүү дээ. Бүгд тэгж бодуулж байна. 7 жил тогтвортой ажил хийдэг хүн ерөөсөө алга. Ховд аймагт нэг сумын орлогч хийж байсан, мал эмнэлгийн тасгийн дарга хийж байсан, тэгээд мал эмнэлгийн мэргэжилтэн хийж байсан хүн насаараа өндөр цалин авч явж байгаад дундуур нь ганцхан удаа 500000 төгрөгийн цалин авахад л тэр хүний тэтгэвэр 24000 төгрөгөөр буурч байна шүү дээ.

Тэгэхлээр 7 жилийн туршид тогтвортой ажил хийдэг хүн бол Монгол Улсад үнэхээр байхгүй. Тийм учраас энэ тэтгэврийн доод хэмжээг, тэтгэврийг тогтоохдоо 7 жилийн дунджаар биш 5 жилийн дунджаар бодох энэ хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлж өгөөч гэж хүсээд байгаа юм.

Манай Чинзориг гишүүн энэ ажлын хэсгийн даргаар тавигдсан. Би бол Чинзориг гишүүн бол маш энэ тэтгэврийн асуудалтай, нийгмийн даатгалын асуудалтай маш тийм холбоотой сайн ажилласан сайд гэж ойлгодог. Одоо сайд нь эзгүй болчихсон байгаа. Таныг дахин томилогдоосой гэж би бас чин сэтгэлээсээ хүсэж байна. Тийм учраас энэ сайд болохоосоо өмнө энэ хуулийн ажлын хэсгийг яаралтай хурал ирэх 7 хоногт хуралдуулаад энэ хуулийг хэлэлцүүлж өгөхгүй бол ирэх 2023 оны улсын төсвийн төсөл хэлэлцэж байна. Дээрээс нь Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл хэлэлцэж байна. Энэ дээр нэг 5-хан тэрбум төгрөг, ирэх жил бол 6 тэрбум төгрөг болох байх. 6 тэрбум төгрөгийн нэмэгдэл хийгээд л энэ 5 жилээр бодчих юм бол Нийгмийн даатгалын сангаас гарах зардал чинь 6-хан тэрбум байгаа юм. Энэ хөшөө дурсгал босож байхын оронд амьд бурхад болсон ахмадууддаа хэдэн төгрөг харамлахгүй энэ шийдвэрийг гаргаж өгөөч, энэ хуулийг хэлэлцүүлж өгөөч гэж та бүхнээс хүсэж байна.

Энд ч баахан ахмадууд сууж байна. Та бүхэн миний хуулийг дэмжиж байгаа биз дээ? Тийм учраас энэ гишүүдэд бас сайн шаардаж өг, энэ группт ороод энэ өөрийнхөө тойргийн гишүүд рүүгээ хандаж үгээ хэлцгээ. Энийг ерөөсөө ингээд нэг ийм албан тушаал бодсон хэдэн гөлийсөн нөхдүүд энэ Их Хурал дотор суугаад байгаа шүү. Анхаараарай нөхдүүд.

Т.Аюурсайхан: Зочин танилцуулья. Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг, Салдангийн Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 3 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашзэвгийн Амарбаясгалан танилцуулна. Индэрт урьж байна таныг.

Д.Амарбаясгалан: Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан, уучлаарай.

Улсын Их Хурлын дэд дарга, Эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-25 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Дэлхий нийтийг хамарсан коронавируст цар тахлын халдвар бүрэн дарагдаагүйн зэрэгцээ 2022 оны 2 дугаар сарын 24-нд Оросын Холбооны Улс, Украин хоорондын харилцаа хурцдаж эхэлсэн. Олон улсад ээдрээтэй нөхцөл байдлыг үүсгээд байна.

Улмаар дэлхий дахинд хүнс, эрчим хүчний нийлүүлэлтийн сүлжээний тасалдал үүсэж, үнийн өсөлт бий болж байгаа. Сүүлийн 40 жилд байгаагүйгээр инфляцыг хөөрөгдөн эдийн засгийг саарууллаа.

Иймд олон улсын байгууллагууд 2023 оны дэлхийн эдийн засгийн

өсөлтийн төсөөллөө удаа дараа бууруулсаар байна.

Улс орнуудын хувьд инфляцыг тогтворжуулах нь нэн тэргүүний зорилт болж, төсөв, мөнгөний эрс хатуу бодлого барих болсон нь хөгжиж буй орнуудын хувьд хөрөнгийн гадагшлах урсгалыг нэмэгдүүлж, өрийн дахин санхүүжилтийн эх үүсвэрийг хайх, валютын ханшийг тогтоон барих сорилтуудыг бий болгож байгаа нь олон улсын байгууллагууд онцолж байна.

Гадаад секторын хувьд тодорхой бус байдал үргэлжилж байгаа ч Засгийн газраас төсвийн бодлогыг боловсруулахдаа уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг цар тахлын өмнөх буюу 2019 оны түвшинд хүргэхэд чиглүүлэн томоохон зорилтыг тавилаа. Тухайлбал, Шинэ сэргэлтийн бодлогод туссан томоохон төслүүдийг эхлүүлж, уул уурхайн салбарын өсөлтийг 2023 онд 14.6 хувьд хүргэхийн зэрэгцээ тус салбарыг дагасан тээвэр, худалдаа зэрэг бусад эдийн засгийн үйл ажиллагаа сайжирна гэсэн хүлээлттэй байна.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах төсвийн бодлогыг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлаас 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-25 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн зарим үзүүлэлтийг өөрчлөх шаардлага үүсэж байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2023 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагаар дотоодын нийт бүтээгдэхүүний 3.6 хувь байхаар батлагдсан хэдий ч Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн төсөлд төсвийн алдагдлыг -1.5 их наяд төгрөг

буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувьд хүргэн бууруулж чадлаа.

Улсын Их Хурлын дэд дарга эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Засгийн газраас боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-25 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Т.Аюурсайхан: Баярлалаа. Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 24-25 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газраас коронавируст халдвар, цар тахлын дараах улс орны эдийн засаг сэргэж байгаагаас үүдсэн үнийн өсөлтийг зорилтот түвшинд барих, боомтын сэргэлтийг эрчимжүүлэн, экспортоос орох, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй төсөл, хөтөлбөрт чиглүүлэх, дэд бүтцийг сайжруулах, төрийн хэмнэлтийг хэрэгжүүлэх, Шинэ сэргэлтийн бодлогыг дэмжих, импортын дарамтыг сааруулах, нөөцийн оновчтой хуваарилалтаар дамжуулан макро эдийн засгийг

тогтворжуулан төсвийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 24-25 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн ирэх онд өрийн дээд хязгаарыг бууруулах боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир улсын төсвийн алдагдлыг бууруулж, алдагдалгүй төсөв батлах боломжтой эсэх талаар, ирэх онд шинээр хөрөнгө оруулалтын зардлыг 23 оны төсөвт тусгаагүй хэдий ч нийт зарлагын хэмжээ нэмэгдсэн талаар, мөн татварыг шударгаар тайлагнах нөхцөл бололцоог бүрдүүлэх, далд эдийн засгийг ил болгох, төсвийн шинэ орлогын эх үүсвэр олгох боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Баделхан төрийн албан хаагчдын орон тоо, нийт цалингийн зардал хэд болж байгаа, халамжийн зардал нь дотоодын нийт бүтээгдэхүүний хэдэн хувийг эзэлдэг талаар бусад улс оронтой харьцуулсан судалгаа байгаа эсэх, өрийн дээд хязгаарыг цаашид хэрхэн бууруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин Төсвийн хүрээний мэдэгдлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тусгагдсан дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 5 хувьд, хэрэглээний үнийн өсөлтийн түвшнийг 8 хувьд хүрэхээр тооцсон нь бодитой эсэх, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих бодлогын арга хэмжээ нь ирэх оны төсөвт шууд нөлөөлөх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн Засгийн газрын өрийн баталгааг гаргах зөвшөөрөл олгох тухай тогтоолын төсөлд тусгасан Хөгжлийн банкны зээлийн төлөлтийг

дахин санхүүжүүлэх заалтыг хасах нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин хос төмөр замын дэд бүтцийг хөгжүүлэхийг дэмжиж байна. Цаашид эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргасан болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-25 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 63.6 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 24-25 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Т.Аюурсайхан: Баярлалаа. Ажлын хэсгээ танилцуулъя. Дашзэгвийн Амарбаясгалан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Санжаагийн Мөнгөнчимэг Сангийн дэд сайд, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөрхуягийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Цэндгомбын Болорчулуун Хүнс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Батсүхийн Сүх-Очир Сангийн яамны

Санхүүгийн бодлогын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Ганболдын Золбоо мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга гэсэн ажлын хэсгийг танилцуулж байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байвал нэрээ өгье. Батлут гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг асуулт асууна.

С.Чинзориг: Хэдэн зүйл тодруулъя. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл уг нь миний ойлгож байгаагаар нэлээд тогтвортой байх ёстой үзүүлэлтүүд л гэж би бол ойлгодог шүү дээ. Төсвийн талаар бидний баримтлах, 5 жилийн хугацаанд баримтлах үндсэн суурь үзүүлэлтүүдийг бол ингээд бид Их Хурлаар бол баталчхаж байгаа юм. Тэгээд энэ хүрээндээ л бид нар жил жилийнхээ төсвийг боловсруулж батлуулж явах ёстой.

Гэтэл сүүлийн жилүүд ингээд бид өөрсдийнхөө үйл ажиллагаанд тааруулаад л, төсвийн хүрээний мэдэгдлийг байнга л өөрчлөөд л ингээд яваад байна л даа. Энэ бол нэг их тийм зөв ч бас арга биш. Хэрвээ ингээд жил болгон өөрчлөөд өөрсдийнхөө үйл ажиллагаанд ингээд харуулаад өөрчлөөд яваад байх юм бол төсвийн хүрээний мэдэгдэл гээд тийм 5 жилийн хугацаатай суурь параметр үзүүлэлтүүдийг батлах ямар ч шаардлагагүй л бичээд байгаа юм л даа.

Гэхдээ одоо яах вэ, ингээд л олон улсын нөхцөл байдал, КОВИД-ын нөхцөл байдал, төсөв санхүү, эдийн засгийн байдал амаргүй байна гээд л ингээд тайлбар хийгээд л ингээд яваад байх юм. Цаашдаа ингээд энийгээ

тогтвортой өөрчлөхгүйгээр хатуу мөрдүүлдэг байх талаар манай Засгийн газар, Сангийн яам ер нь ямар бодлого баримтлах ёстойг та бүхэн үзээд байгаа юм бэ гэдэг энийг асуумаар байх юм.

Хоёр дахь асуудал нь энэ төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт орсноор өрийн тааз 65 хувьд хүрэх юм байна л даа. Одоо миний ойлгож байгаагаар өрийн тааз чинь бол нэг 51-тэй байгаа гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр өрийн таазыг заавал ирэх жил 14 хувиар нэмэгдүүлэх, өсгөх шаардлага байгаа юм уу? Нөгөө тогтвортой байдлынхаа тухай хуультай уялдуулж байгаа гээд л тайлбар хэлэх л байх. Заавал тэгээд ийм боломж байгаа бол өрийн таазыг нэмэгдүүлж 14 хувиар нэмэгдүүлж 65 хувьд хүргэх хэрэг байгаа юм уу? Харин нөгөө талдаа ийм боломж байгаа бол харин энэ гадаад зээлийнхээ өр төлбөрийг жаахан дорвитойхон барагдуулах талаас нь ажиллавал яасан юм? Заавал өрийн таазыг ингээд 14 хувиар нэмэгдүүлээд 65 хувь хүрэх хэрэг байгаа юм уу? Би бол хэрвээ ийм боломж байгаа бол тэр тулгамдсан гадаадынхаа өр зээлийг барагдуулаад, тэгээд өрийн таазаа хивэнд нь энэ 50 орчим юм уу? Хувьд нь, хивэнд нь бариад явах ийм боломж бол байхгүй.

Гурав дахь асуудал нь өрийн тааз нэмэгдэх дээр тодорхой хэмжээгээр энэ чинь гишүүдийн дунд бас болгоомжлол үүснэ л дээ. Өрийн тааз ингээд 50 байснаа 65 болохлоор тодорхой хэмжээний боломж гарах юм байна. Гадаад өр зээл авах юм байна гэж ийм асуудал гарна л даа. Тэгэхээр ер нь гадаад нөхцөл байдал ямар байгаа юм? Ийм гадаадад чинь тэгээд тийм эх үүсвэр олдох уу, үгүй юу? Хэрвээ зээл авна гэж байгаа бол та бүхэн ирэх жил ер нь ямар хэмжээний гадаад зээл авах тийм тооцоо хийж байгаа юм? Гаднаас авах зээл чинь тэгээд ямар хэмжээтэй, хүүтэй зээл олдох тийм боломж байгаа юм? Би бол гаднаас зээл авах юм бол жилийн 8 хувиас доош хүүтэй зээл олдоно гэдэг асуудал бол одоо бараг л байхгүй болчихсон болов уу

гэж бол ойлгож байна. Бид чинь өмнө нь 6 хувьтай, 7 хувьтай авч байгаа зээлийг гаргаж л арилжааны зээл, өндөр хүүтэй зээл гээд л их ярьдаг байсан. Одоо бол, хэрвээ гадаадаас зээл шинээр авах асуудал яригдвал 1 жилийн 8 хувиас доош хүүтэй зээл олдохгүй болов уу гэсэн би бол ингэж л бодож байгаа юм. Та бүхэн энийг яаж төсөөлж байгаа юм бэ гэсэн ийм 3 асуултад хариулт авъя.

Т.Аюурсайхан: Сангийн яам хариулъя. 80 дугаар микрофон дээр Ганбат даргад микрофон өгье.

Ж.Ганбат: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Яах вэ, төсөв бол бид нар төсвийн хүрээний мэдэгдлээ хавар батлуулаад 5 сарын 1-ний дотор батлуулаад төсийн хүрээний мэдэгдэл дээрээ бид нар үндэслэн дараа жилийнхээ төсвийн төсөөллийг бол боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлдэг байх ийм цаглавартай. Яах вэ, КОВИД-ын нөхцөл байдал, эдийн засгийн гадна болон дотоод хүчин зүйлсээс хамаараад бид төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх зайлшгүй шаардлагууд үүсээд байгаа. Ийм нөхцөл байдалтай байгааг бас ойлгож байгаа байх гэж бодож байгаа юм. Зүгээр Сангийн яамны байр суурь Засгийн газрын зүгээс бид бол КОВИД-ын өмнө төсвийн хүрээний мэдэгдлийг аль болох өөрчлөхгүй, тэр чинь батлагдсан төсвийн хүрээний мэдэгдлийнхээ хүрээнд төсвийн төслөө боловсруулаад оруулж ирэх нь зүйтэй юм гэдэг ийм байр суурийг ер нь баримталж бол ирсэн. Цаашдаа ч бид энэ байр суурийг бол баримталж ингэж явна гэдгээ энэ дээр хэлье гэж байна.

Өрийн хязгаарын хувьд бол бид нар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр бол өрийн дээд хязгаарыг бол зааж өгсөн байдаг. Ирэх жил бол дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх өрийн дээд хязгаар 65 хувь, дараагийн 2 жилд нь 60 хувьд байхаар. Яг одоогийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх өрийн хязгаар бол 51 хувь байна. Бид бол

яг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаарынхаа хүрээнд л, энэ өрийн таазныхаа хүрээнд өрийг бол ингэж барьж явах ийм үүрэгтэй. Энэ хүрээндээ л явж байгаа юм.

Яг одоо байгаа бид 51 хувиа Чинзориг гишүүний асуугаад байгаагаар бид ингэж огцом нэмэгдүүлж байгаа юм шиг бол харагдуулж байгаа гэдэг нь энэ бол яг хуулийнхаа хязгаарынхаа хүрээнд л бид нар хүргэх. Одоо 51 хувиа тэр чигээр нь ирэх онд 51 хувь гэдгээ бариад явна гэх дээр яах вэ, гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл бас ханшийн хэлбэлзлээс хамаараад хэт хатуу тавих дээр бидэнд бол өрийн таазаа бол, хүндрэлтэй нөхцөл байдлууд үүсэх учраас бид нар яг төсвийн тогтвортой байдлын хуульд заасан хязгаарын хүрээнд 65 хувиа бол бариад явъя гэдэг ийм байдлаар явж байгаа. Яг Засгийн газрын өр бол 2022 оны хагас жилийн байдлаар бол 28.5 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэх үлдэгдэл нь 23.8 их наяд төгрөгийн төгрөгтэй тэнцэж байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний 50.1 хувьтай бол тэнцэж байгаа юм. Энэ бол яг бид нарын хуулийн дээд хязгаар бол 70 хувь байхаар ингэж үзэж байгаа юм.

Ирэх жилийн бол бид нар хэд хэдэн том гадаад төлбөр, бондын төлбөрүүдийг бол ирэх жил хийнэ. Бид нар заримыг нь төсвөөсөө төлнө гэдэг ингэж тооцож оруулж ирсэн. Зарим нь бол дахин санхүүжилт байдлаар явна гэж байгаа. Яах вэ, яг одоогийн нөхцөл байдалд, гадаад зах зээлийн нөхцөл байдал бол жоохон амаргүй байна. Гадаад бондын хүүгийн түвшин бол зээлжих зэрэглэлээс хамаараад энэ дээр бол хэлбэлзэлтэй байгаа. Бид нар одоо бол зээлжих зэрэглэлийн хувьд бол сүүлийн 2 зээлжих зэрэглэлийг бол Засгийн газрын зүгээс бол бид нар тогтвортой ингэж зээлжих зэрэглэлийг бол хадгалж авч гарч чадсан. Энэ гадна талдаа бол зөв мессеж өгөгдөөд явж байгаа. Ирэх жил бид нар 500 гаран сая долларын бондын

төлбөрийг бол ирэх хавар бид төлөх үүрэгтэй. Энийгээ бол бид өрийн удирдлагынхаа хүрээнд төлөөд ингээд явна. Одоо бол бас яг энэ цаг үед бол Валютын сангийн уулзалтад Сангийн сайд оролцож байгаа, мөн гадаадын хөрөнгө оруулагч нар дээр бол Монголын эдийн засгийн нөхцөл байдлын талаар юмнуудаа бол тайлбарлаад, ойлгуулаад бол ингээд явж байгаа.

Тэгэх дээр бол энэ гадаад төлбөрүүдээ төлөхөд бол ирэх жил хүндрэл гарахгүйгээр бид нар энэ төсвийн хүрээндээ зохицуулаад явчих бүрэн бололцоотой юм гэж ингэж ойлгож байгаа юм.

Т.Аюурсайхан: Чинзориг гишүүнд микрофон өгье. Тодруулъя.

С.Чинзориг: Хэрвээ боломж нь байгаа бол заавал Тогтвортой байдлын тухай хуулиар 70 байх ёстой. 70-даа хүрэхгүй байгаа юм. 65 болгох гэж байгаа юм гээд. Тэр хуульдаа хүрэх гэж байгаа юм гээд байх юм. Сайн үзүүлэлтийг бол заавал хуульдаа хүргэж, шахаж болно л доо. Энэ чинь бол нэг их тийм сайн үзүүлэлт биш шүү дээ. Тийм учраас бол хэрвээ боломж байгаа бол тэр дотоодын нийт бүтээгдэхүүнээ 51 хувиасаа хэтрүүлэхгүй, заавал 70 хувь байх ёстой юм, бид нар 65 болгож байгаа юм. Тэр рүү нь ойртуулж байгаа юм гээд байж болохгүй гэж би л бодож байгаа юм.

Нөгөө талаасаа хэрвээ ийм боломж байгаа бол та бүхэн энэ өрнийхөө таазыг нэмэхгүйгээр Засгийн газрынхаа өрийг дорвитой хэмжээгээр бас бууруулах тийм арга хэмжээ авчих боломж байхгүй байгаа юм уу л гэж асуугаад байгаа шүү дээ. Хэрвээ 65 бол тэгээд та бүхэн надтай шулуухан асуух, хэлэхэд яг хэдий хэмжээний зээл авах боломж нээгдэж байгаа юм бэ?

Т.Аюурсайхан: 80 дээр гүйцээж хариул. Ганбат дарга.

Ж.Ганбат: Чинзориг гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. Яг тантай санал нэг байгаа. Бид бол сүүлийн 3, 4 жил бид нар өрийн хязгаараа ерөнхийдөө 50 хувь дээрээ бол хадгалаад яваад байгаа. Гэхдээ бид энийг яах вэ, цаашдаа ч гэсэн бид бол энэ өрнийхөө таазыг нэмэхгүйгээр энэ хүрээндээ бол бид хадгалаад, энийг аль болох бууруулахын төлөө бол ингээд ажиллаж байгаа юм. Гэхдээ биднээс хамаарахгүйгээр гадаад хүчин зүйлээс ханшийн хэлбэлзэл байгаа учраас бид энэ дээр бол бас хатуу үүрэг авч бас яг энэ тоогоо яг 50 дээрээ барина гэж явахад бол хүндрэлтэй. Нэмж бол ямар нэгэн байдлаар бол бид нар бол шинээр зээл энэ тэр бол авахгүйн төлөө явна. Улсын Их Хурлаар батлагдсан өрийн стратегийнхаа хүрээнд л бид энэ юмнуудаа бол зохион байгуулж, өрнийхөө юмыг, зохион байгуулалтыг бол авч явна. Шинээр бид нар бонд гаргаж, төсвийн алдагдлыг бол ирэх жил санхүүжүүлэхгүй. 22.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн багш, магистрантууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрдмийн их ажилд нь өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Сангийн сайд маань байхгүй байгаа юм байна. Эдийн засгийн сайд маань байхгүй бас байх шиг байна. Тэгээд Байнгын хороод бас хариулна биз. Сангийн яам хариулаад. Би зүгээр энэ төсвийн хүрээний мэдэгдлийг бол яах вэ, ингээд л бид нар сүүлийн үед нэг ийм хавтгайрсан буруу ойлголт яах вэ, ингээд л нэг тоо тавьчихдаг юм гэсэн байдлаар явдаг болчхоод байгаа байхгүй юу. Тэгээд л 65

гээд л тавьчихъя, ирэх жил л 60 гээд л тавьчихъя. Тэгээд л тэр үед нь ахиад л өөрчилж болдог юм шиг гэж. Өөрчилж болдог болчихсон байхгүй юу энд. Төсвийн тогтвортой байдлын хууль, энэ төсвийн хүрээний мэдэгдэл энэ тэрийг.

Тэгэхээр энд нэг их ач холбогдол өгөхгүй болчхоод байгаа юм. Би гишүүдийн тэр өрийн хязгаартай яриад байгаатай санал нэг байна. 65 гээд л тавьчихаж байгаа юм. Одоо 50, 51 байгаа гэсэн мөртөө 65 гээд л 14 хувиар өсгөнө гээд л. Тэгэхээр одоо бол зээл авах хүндрэлтэй Ганбатаа та нар сайн энийг сонсож байгаарай. Хүндрэлтэй шүү. Яагаад гэвэл өнөөдрийн байдлаар Засгийн газрын бондын өгөөж одоо энэ 12 сард төлөх бондыг чинь өгөөд 35.5 хувь байгаа. Ирэх 23 онд төлөх бондын чинь өгөөж бол 28.3 хувь байгаа. Ингээд 20, 30 хувийн хүүтэй бондын асуудал ярьж болохгүй шүү дээ. Ийм л үнэтэй мөнгө олдоно. Олдлоо ч эргээд зээлээ төлж чадахгүй болно. Зээлээ төлж чадахгүй болно. Тэгэхээр энийг Эдийн засгийн байнгын хороо юу гэж үзэж байна вэ? Энэ улс орны энэ өрийн энэ хүндэрсэн асуудлуудыг? Энийг хүнд болчихлоо гэж үзэж байна уу? Ингээд Засгийн газарт эрхийг нь олгоод ингээд зээл ав гээд явъя гэж бодож байна уу?

Хоёрдугаарт, энэ зээл нь хаачихсан юм бэ гэдэг асуудал. Энэ зээл нь тэгээд л нөгөө Хөгжлийн банк руу ороод л, тэгээд л улс төрчид нь авчихсан зээлүүд шүү дээ. Энэ нөгөө компаниуд нь төлж байгаа юм байхгүй. Жишээлбэл, улс төрчидтэй холбоотой, манай Сангийн сайд, нөхдүүдтэй холбоотой байж болзошгүй компаниуд хүртэл байгаа. Тэр “Дархан минж” байна, “Мондулаан” трейд байна, тэр Чингис банкны захиралтай холбоотой. “Монфлекс” байна. “Зэст-Өндөр” байна, Ган хүдэр орд байна. Зөвхөн Чингис хаан банк гэж үзээгүй шүү. Тэр “Пример инвестмент гэйт” гэдэг компани бол ер нь Хөгжлийн банк, тэгээд л энэ ЖДҮ, “Жэтфинанс” нь бол бичил зээлийн сан гээд л. Ингээд л ерөөсөө

хаана мөнгөний боломж байна бүгдийг нь ороод хусчихсан байгаа байхгүй юу. Бүгдийг нь ороод хусчихсан. Тэгээд ийм Сангийн сайдтай байвал яаж энэ улс орон чинь хөгжих юм. Тэгээд улсаар төлүүлэх гээд сууж байна шүү дээ. Тэгээд улсаар баталгаа гаргуулах гээд байж байна шүү дээ. Тэгээд энийг нь Их Хурал нь зөвшөөрөөд. Ингээд баталчхаж болохгүй. Ингээд баталж болохгүй. Хөгжлийн банкиг дээрэмдсэн нөхдүүд бол Индианагийн их сургуулийг төгссөн баг байж байгаа. Баг байж байгаа. Баярмагнай, Батбаяр, Батхүү энэ тэр гээд. Зохион байгуулалттайгаар ингэж болдог юм уу? Энэ хууль хяналтын байгууллагууд энийг шалгасан юм байдаг юм уу? Тэгээд улсаар төлүүлээд дараа нь нөгөө банкаа энэ явахгүй юм байна лээ гээд ингээд дампууруулаад хаячих байхгүй юу. Би аргыг нь мэдэж л байна.

Тийм учраас наадах нэг улсаар төлүүлнэ гэсэн юмаа хэлэлцүүлгийн явцад авч хаяж, наад зээлийн одоо энэ төсвийн хүрээний мэдэгдэлд байгаа өндөр хувиа бууруул, боль. Би хэллээ шүү. Одоо олодох зээл чинь бол 30 хувиас нааш олодохгүй. Bloomberg дээр тийм.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Байнгын хорооноос нэг асуулт асуусан. Цэрэнпунцаг дарга хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Энэ эдийн засгийн байдал хүнд, хэцүү байгааг бид нар бүгдээрээ ойлгож байгаа. Ер нь энэ өнөөдөр энэ өр ширийн асуудал өнөөдөр энэ жилийн төсөв дээр гарч ирээд яригдаж байгаа асуудал биш. Ер нь өр нэмэгдээд сүүлийн энэ 10 хэдэн жил явж ирсэн, энэ хураагдсан өр ширийн асуудал өнөөдөр байгаа шүү дээ. Тэгээд өнөөдөр ер нь зүгээр дэлхийн санхүүгийн зах зээл дээр зээлийн хүү нэмэгдсэн, бондуудын өгөөж нь бүгд нэмэгдсэн л байгаа. Тэгэхээр зэрэг бид нар ер нь энэ гаднын зээл тусламжгүйгээр бол явдаг юм байхгүй шүү дээ. Тэгэхдээ энэ зээл тусламжийг авчраад яаж ашиглаж байгаа

вэ гэдэг асуудал байгаа. Зээл муу юм уу, сайн юм уу гэдэг асуудал өөрт нь зээлд биш. Зээлийг, ялангуяа манайх шиг энэ хөгжлийн түвшинд явж байгаа улс орон бол зээлийг, ялангуяа хөгжлийн зээлийг бол авч ашиглах ёстой. Тэр утгаараа бол зээлээ авах ёстой. Тэгэхдээ зээлээ бид нар бага хүүтэй олж ирэхийн тулд бид нар төсвийн сахилга баттай байгаа, гадагш нь гадаадын хөрөнгө оруулагчдад, гадаадын санхүүгийн байгууллагуудад, гадаадын түнш орнуудад харуулах хэрэгтэй.

Тийм учраас бол энэ төсвийг бол алдагдал багатай, болж өгвөл алдагдалгүй батлах ёстой л гэж байр сууриа би бас эхний энэ төсвийн хэлэлцэх эсэх асуудал дээр Сангийн сайдаас асуусан. Харин харамсалтай нь цаг хугацаа байгаагүй юу тодорхой хариулт авч чадаагүй. Тэгэхлээр Эдийн засгийн байнгын хорооны байр суурь бол төсвийг, бодлогыг чангатгаж, хариуцлагатай, сахилга баттай төсөв батлах ёстой л гэж харж байгаа.

Нөгөө талдаа мөнгөний бодлогоо чангалж, тэгээд бид нар гадаад санхүүгийн зах зээл дээр сахилга бат харуулж, энэ гадаадын үнэлгээ хийдэг энэ компаниуд, үнэлгээ хийдэг үнэлгээний компаниудын үнэлгээг нь сайн авах ёстой. Ингээд бид нар тэр 30, 35 байгаа, 25 байгаа тэр өгөөжөө доош нь буулгаж, ингэж зээлээ л авч ажиллах ёстой гэж байгаа юм. Тэгээд харин авсан зээлээ бол дараа нь бид нар энэ хөгжлийн төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийж байна уу, үгүй юу гэдгийг нь бид нар, Их Хурал араас нь хянаж, анхаарал тавьж ажиллах ёстой. Ийм л байр суурьтай байгаа.

Ер нь бол бид нар энэ нэг хөгжил дэвшил, эдийн засаг, нийгмийн хөгжлийг бид нар бий болгоход гарцаа байхгүй энийг чинь хийж бүтээхэд ордог орц байгаа тиймээ? Хүнээ чадавхжуулах ёстой. Хүн нь нэг талаасаа ажиллах хүч.

Нөгөө талаасаа энийг бүтээхэд хэрэгтэй тэр тоног төхөөрөмж, технологи, энэ санхүүгийн эх үүсвэр бол гарцаагүй хэрэгтэй. Тэгээд манай улс орон бол өнөөдөр өөрсдөө ийм хуримтлал, ийм нөөц бололцоо байхгүй.

Тийм учраас энийг бид нар гаднаас л олж ирэх ёстой. Тэгэхлээр энэ бид нар гадаад, гаднаас орж ирэх, авчрах энэ зээл, авах зээлийг бол бид нар үр дүнтэй ашиглах. Үр дүнтэй ашиглахын тулд бол бид нар хариуцлагатай, тэр буцаад тэр өгөөжөө өгдөг, эдийн засгийн хувьд өгөөжөө өгдөг, урт хугацаандаа нийгмийнхээ үр өгөөжийг өгдөг ийм л төсөл хөтөлбөрт хандуулж хийх ёстой гэсэн байр суурьтай байгаа.

Хоёрдугаар асуудал бол ер нь энэ гадаадын хөрөнгө оруулагчид бид нарт хамгийн чухал асуудал байгаа юм. Эд нарыгаа бид нар үргээмээргүй байгаа юм. Одоо хэчнээн жил айлгаж хөөв. Тэгээд нэг жоохон юм оодроод нөгөө ишиг эврээ ургахаар эхийгээ мөргөнө гэдэг шиг нэг жоохон болцоо гараад ирэхээр бүгдийг нь хөөж туугаад гаргадаг. Энэ дээрээ цаашаа бид нар попорч, сонгогчдод сайн хүн болж харагдах гэж ингэж гаднынхныг үзэн ядах, энэ гадаадын хөрөнгө оруулагчдыг хөөж туудаг ийм.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн гишүүн тодруулъя. Микрофон өгье.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр Хөгжлийн зээл, хөтөлбөрийн зээл гэж Эдийн засгийн байнгын хороо ямар зээлийг хэлээд байна вэ? Энэ бондын баталгаа чинь яг эндээ ордог юм уу? Ямар компанийг хэн хөөчихсөн юм бэ, гадаадын хөрөнгө оруулагч? Бодитой хэл. Ер нь тэгээд импортыг орлох юм хийгээд, жишээлбэл тэр Эрдэнэтэд байгаа гангийн үйлдвэр, энэ хар төмөрлөгийн үйлдвэр энэ тэрээ холбоод, тэгээд би төмөр арматур төмрөө хийгээд ингээд хэмнээд 200 сая. Үгүй ээ,

экспортоо нэмэгдүүлээд бас байж болно. Тэгээд Эдийн засгийн байнгын хороо нь ингээд л гаднынхан л гээд ингээд суучих юм бол ингээд энэ улс орон чинь ер нь зээлийн өрөнд баригдаад дуусах юм биш үү? Үгүй, ер нь тэр нөгөө Японы нөхрийг энэ хүчний байгууллагыг чинь л дээрэмдээд л ингээд л энэ хүчнийхэн энэ улс төрд чинь энэ гаднынхны нөхдүүдийг дарамталж, дээрэмдээд л, ингээд л хөөгөөд л гаргаад байгаа болохоос биш. Өөр хөөгөөд байгаа хэн байгаа юм? Яг юу гээд хөөчихсөн юм? Жишээ тат. Яг ингээд тэр.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Цэрэнпунцаг дарга гүйцээж хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Энэ хэн хэн хэнийг хөөгөөд, гадаадын хөрөнгө оруулагчдыг үргээв, хөөв гэдэг асуудлыг би энд тоочвол, нэрлэвэл хувь хүний асуудлууд руу орсон юм болно. Энэ мэдээлэл бүх юм ил тод байгаа шүү дээ. Бүх л хүмүүс мэдэж байгаа. Энэ дундаа бол сүүлийн энэ 10 хэдэн жил энэ улс төрд хутгалдсанг та бүхэн бол бүр сайн мэдэж байх ёстой.

Тэгэхлээр энийг надаас асуух биш, энэ хариулт бол гадна талд ил тод бүгд байж л байгаа шүү дээ. Энэ зээлгүй бид нар яаж амьдрах юм? Зээл авч л таараа. Гаднаас зээл тусламж авах ёстой. Авахдаа бид нар энэ яаж зарцуулах вэ гэдэг асуудал байгаа учраас бид нар энэ дээр нь. Үгүй, энэ чинь бүгд бид нар төсвөө хэлэлцэж байна. Энд авсан зээлийг юунд зарах гэж байгаа юм гэж ярина шүү дээ. Энэ хэзээ, яаж эргэж, эдийн засгийнх нь ойрын хугацаанд ямар өгөөжөө өгөх юм? Тэд.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Болсон. Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд асуулт асууна.

Г.Ганболд: 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байна. Бид нар саяхан 5 сарын 20-д гараад энэ төсвийн өрөөний мэдэгдлээ баталсан л

даа. Тэгээд тэр баталсан төсвийн хүрээний мэдэгдэлтэйгээ энэ орж ирж байгаагаа бүх тоогоор нь нэг харьцуулаад үзээрэй. Хэлбэрийн төдий. Бүгдээрээ эрс нэмэгдчихсэн. Төсвийн орлогоо 3 их наядаар нэмэгдүүлж байна. Сайн байна. Хөрөнгө оруулалтаа тэглэлээ. Би бол энэ төсөв дээр бол баярлаж байсан юм. Харамсалтай нь төсвийн урсгал зардлаа 2.5 их наядаар нэмэгдүүлчхэж байгаа байхгүй юу. Сайд нарын багц дээр тавиад ингээд урсгал зардлаа нэмэгдүүлчихээр ямар ч хөрөнгө оруулалтаа тэглэсэн, төсвийн орлогоо нэмэгдүүлсэн ач холбогдол байхгүй болчхож байгаа юм.

Ер нь ард түмэн чинь хамгийн их санаа зовж байгаа юм энэ улсын өрөнд л их санаа зовж байна шүү дээ. Өөрсдөө бүгдээрээ өр зээлтэй. Тэгсэн хэр нь өөрийнхөө өр зээлд санаа зовохгүй, улсын өрөнд санаа зовоод. Энэ улс орон маань бас энэ Шри-Ланкын араас энэ деполт болчих вий, улс маань дампуурчих вий л гэж санаа зовж байгаа байхгүй юу.

Гэтэл бид нар өнөөдөр ингээд 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ өрийн тооцоо 65 хувь гээд 35 их наяд, төсвийн төсөөлөл дээрээ 24, 25 он дээр бүр 38 их наяд болгоно гээд өрөө нэмэгдүүлнэ гээд л хэдүүлээ төсөөлөөд сууж байдаг. Энэ өөрөө харамсалтай байгаа байхгүй юу. Ер нь улс орон гэдэг чинь нэг олон хүүхэдтэй айл шүү дээ. Бид нар айлын эзэд, эцгүүд үр хүүхдээ төлчихнө гээд өрөнд оруулчихъя гээд хэн ч боддоггүй байхгүй юу. Тэгэхээр энэ аль нэгэн Засгийн газар, аль нэгэн Их Хурал энэ өрийг тэглэх, ирээдүйдээ өргүй байх дээр бол заавал нэг шийдвэр гаргах ёстой. Тэр Их Хурал нь тэр Засгийн газар нь энэ одоогийн Засгийн газар, Их Хурал байгаасай гэж бодож байгаа юм.

Тэгэхээр жил болгоны төсөв дээр ядаж энэ улсынхаа өрийг 1 их наядаар бууруулдаг ийм төсвийн төсөөллөө бид нар баталж явж байж, ирээдүйд энд өнөөс салахгүй бол үнэхээр энэ улс орны өрөнд

бол ард иргэд санаа зовж байна шүү. Өр зээл бол тэгэхдээ авч болно. Бид нар урт хугацаатай юм, хүү багатай юм гээд баахан зээл авдаг. Харамсалтай нь авч байгаа зээлийн өртөг нь асар өндөр. Өнөөдөр манай бизнесийнхэн бүгд л мэдэж байна шүү дээ. “Чингис хаан” нисэх онгоцны буудлыг 750 сая доллароор бариулсан. Гэтэл яг ийм буудлыг дэлхийн зарим улс орнуудад 250 сая доллароор бариулчихсан байна. 4 дахин өндөр өртөгтэй. Саяхан бид нар Их Хурал дээр 4 аймагт махны үйлдвэр барина гээд Хятадаас зээл авна гээд. Хоногт мянган бог нядлах хүчин чадалтай яг тийм үйлдвэр өнөөдөр зах зээлийн ханшаар 10 орчим тэрбумаар барьж байхад Хятадын зээлээр бид нар 1 үйлдвэрийн 60 тэрбумаар барих зээл аваад сууж байгаа байхгүй юу.

Тэгэхээр зэрэг зээл авахдаа бид нар зээлээ өөрөө удирддаг ийм зээл авахгүй бол гаднаас зээл авна гээд тэр зээл нь өөрөө гаднынхан удирддаг, тухайн орны компани заавал тэрийг авдаг, тэр нь өөрөө дотоодын төсөвт өртгөөр 5 дахин өндөр өртөгтэй ийм зээл аваад байх юм бол энэ улс орон чинь яаж явах юм бэ? Тэгэхээр зэрэг би бол бас Их Хурлын гишүүдийг энэ төсвийн хүрээний мэдэгдлийн 2023 оны төсөв дээр жил болгон ядаж энэ улсынхаа өрийг 1 их наядаар буулгадаг ийм төслийг батлаад жил бүр явах юм бол бид нар энэ улс орон өр зээлээ сална шүү гэдэг ийм саналуудыг бас хэлэх гээд байгаа юм.

Тэгэхээр энэ дээр заавал энэ төсвийн хүрээний мэдэгдэл гэж бид нар энэ хэлбэрийн төдий юм баталж байхаар, эсвэл хуульдаа, түрүүн Даваасүрэн гишүүний хэлдгээр дахиж хуулиа өөрчлөөд, төсвийн хүрээний мэдэгдлээ ерөөсөө өөрчилдөггүй ийм л хэлбэрээр батлаад тэр хүрээн дотроо хэдүүлээ ярьж явахгүй бол. Хэрэв өөрчилдөг байх юм бол бид нар энийг хавар баталдаг байх ямар ч ач холбогдолгүй болчхоод байна шүү дээ. Тэгээд ийм боломжууд байгаа юу гэдгийг би бас асуух гээд байна.

Т.Аюурсайхан: 80 дугаар микрофон дээр Сангийн яам хариулъя. Ганбат дарга.

Ж.Ганбат: Ганболд гишүүний асуултад хариулъя. Бид төсвийн хүрээний мэдэгдлээ 5 сарын 1-нд бол Улсын Их Хурлаар батлуулдаг. Тэгээд энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ үндэслээд дараа жилийн төсвийн төслөө бол ингээд боловсруулдаг. Гэхдээ бол яах вэ, бид бол КОВИД-оос өмнөх үед бол Сангийн яам, Засгийн газраас бол хүрээний мэдэгдлээ аль болох өөрчлөхгүй, яг төсвийн хүрээнийхээ мэдэгдлийн хүрээнд дараа жилийн төсвийн төслөө бол боловсруулж оруулж ирж бол ингэхийг зорьж байсан. Яг энийгээ ч 1 жил бол биелүүлж ирсэн. Үнэхээр КОВИД-ын нөхцөл байдал, тэгээд яг энэ оны хувьд бол яг гадна талын хүчин зүйлээс хамаарсан бас амаргүй нөхцөл байдал, Хятадын ТЭГ-КОВИД-ын бодлого, Орос, Украйны нөхцөл байдлаас хамаараад бид нар төсвийн хүрээний мэдэгдлээр батлагдсан мэдэгдлийг бид нар өөрчлөхөөс өөр аргагүй бас ийм нөхцөл байдал үүсээд байгаа юм.

Бид бол ер нь, цаашдаа ер нь энэ батлагдсан төсвийн хүрээний мэдэгдлийнхээ хүрээнд л төсвийн төсвөө боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлдэг байх. Энэ зарчмаа л хангаж ажиллахыг бол зорьж ажиллана гэдгээ бол энд бол хэлье.

Төсийн хүрээний мэдэгдлээс яах вэ, урсгал зардал дээр нэмэгдсэн гол өөрчлөлт юмнууд яах вэ, Улсын Их Хурлаар батлагдсан болон бид нарын бас гадаад нөхцөл байдлаас хамаарсан гол гол, бас зардлын өөрчлөлтүүдийн хүрээнд бид нар урсгал зардал дээрээ нэмэгдүүлэхээс өөр аргагүй ийм нөхцөл байдал бол үүссэн байгаа. Энэ дээр бол тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой зардлууд болон гадаад зээлийн хүүгийн зардал болон хүн амын өсөлт, хүүхдийн тооны

өсөлт, эрчим хүчний тарифын өөрчлөлт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлт гэсэн энэ хүчин зүйлээс хамаараад бид зайлшгүй бид нар урсгал зардлаа нэмэгдүүлж орж ирэхээс өөр аргагүй бас ийм нөхцөл байдал орж ирснийг бол энд бол хэлэх нь зөв байх тэгж байна.

Өрийн хувьд бол Засгийн газраас бол 17 онд 72 хувьтай байсан өрийн, 17 онд дотоодын нийт бүтээгдэхүүний өрийн хувь хэмжээ бол 72.5 хувь байсныг бол бид нар 22 онд 50.1 хувь болгож ингэж бууруулсан. Энэ бол 17 оноос хойш сүүлийн 72.5 байсан хувийг бол жил болгон үе шаттай бууруулаад, яг өнөөдрийн байдлаар бид нар дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх өрийн хязгаарыг 50.1 хувь болгож бууруулж бол ингэж чадсан. Энийгээ цаашаа бол үе шаттай бууруулахын төлөө бид ажиллана.

Энэ өр болон дахин санхүүжилт, гадаад зээлийн төлбөр төлөхөд бол бид нар гадаад орчны манай улсыг үзэх хандлага энэ дээр бол бид нар зээлжих зэрэглэлийг бол сүүлийн 2 удаагийн зээлжих зэрэглэл дээр бид нар “В+” гэдэг үзүүлэлтээ бол бид нар энэ оны 5 сард, 7 сард хийсэн зээлжих зэрэглэлийн үнэлгээ дээр бол бид нар хадгалж бол авч чадсан. Энэ маань бол бид нар бол гадаад эх үүсвэр босгох, гадаад бондын төлбөр төлөхөд энэ бол маш чухал үүрэгтэй байгаа.

Ер нь бол бид нар төсөв дээрээ бол, ирэх жилийн төсөв дээр бид нар гадаад зээлийн төлбөр төлөх дээр бол бас нэлээн том хэмжээний дүнгүүдийг бид нар төсөв дээр бол оруулж ирж тооцож төлөхөөр ингэж тусгасан байгаа. Ирэх жил бол Засгийн газрын гадаад үйлчилгээнд бол 1 тэрбум 47 сая долларыг төлнө. Үүнээс бид нар 533 сая ам. Долларыг бид нар “Гэрэгээ” бондын төлбөрт, 330 сая ам. Долларыг нь гадаад зээлийн төлбөр ингээд сар бүр хуваарийн дагуу бол ингээд төлөөд явна. Бид бол үнэхээр энэ

өрийн дарамт яг бодитойгоор бол ийм хүндрэлтэй байгаа.

Мөн гадаад бондын хүүгийн төлбөрт 175 сая ам. Доллар, гадаад зээлийн хүүгийн төлбөрт 109 сая долларыг бол бид нар ирэх жил бол төлнө. Улсын Их Хурлаар батлагдсан өрийн стратегийн хүрээнд бол бид нар өмнө нь авч байсан зээлүүдээсээ бид нар эдийн засагт нөлөө.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин, Даваажанцангийн Сарангэрэл, Тогмидын Доржханд нарын урилгаар Хан-Уул дүүргийн ахмад багш нарын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын гишүүн Цогт-Очирын Анандбазар асуулт асууна.

Ц.Анандбазар: Баярлалаа. Төсвийн хүрээний мэдэгдлийн хамгийн гол амь болсон зүйл дээр тодорхой хариултууд өгмөөр байна. Юуны өмнө Хэрэг эрхлэхийн дарга Амарбаясгалан даргыг ер нь Сангийн ямаар нэг орж үзээч гэж зөвлөмөөр байгаа юм. Маш, мөнгөн урсгал гэж Монгол Улсын амин чухал зүйл байна. Мөнгөн урсгалыг яг хэн барьж, хэн энийг зохион байгуулж байгааг Байнгын хороон дээр би олон удаа асуусан. Ер нь мөнгөн урсгалыг удирдана гэдэг бол санхүүгийн өндөр мэдлэг, аж ахуй, тооцоо мэддэг ийм хүний ажил байдаг. Олон хүн мөнгөн урсгалыг удирдана гэж ер нь байдаггүй юм. Тийм ч учраас төсвийн мэдэгдлийн хүрээнд орж ирж байгаа энэ зүйл өрийн зээлийн таазыг нэмэгдүүлээд, урсгал зардлаа нэмэгдүүлээд, үргүй олон зээл авахаар ийм санал орж ирж байгаа зүйл ажиглагдаж байгаа юм.

Түрүүчийн Даваасүрэн гишүүний хэлсэн, өмнөх гишүүдийн хэлсэн зүйлүүд бүгд үнэн шүү дээ. Авч байгаа зээл маань ажлын байр бий болгодоггүй, экспортын бараа бүтээгдэхүүн нэмдэггүй, түргэн хугацаанд үр ашгаа нийгэм болоод эдийн засагт өгдөггүй ийм төслүүдийг сонгоод байхаар цаашлаад эдийн засаг улам хүндэрнэ.

Тийм учраас зарлагын яам, Сангийн ямаар энэ төсвийн мэдэгдлийн хүрээллийг бариулах биш Эдийн засгийн сайддаа голлож өгөх шаардлагатай байна гэж харагдаж байна.

Дээрээс нь хэрвээ энэ төсвийн мэдэгдлийн хүрээлэлд өрийн таазыг нэмье гэж байвал урсгал зардлаа танах хэрэгтэй. Урсгал зардлаар өр зээл нэмдэггүй юм. Ийм боломж байхгүй. Мэдсээр байж эсрэг юм хийгээд байх юм бол Монгол Улс маш хүнд байдалд орно шүү дээ. Болж өгвөл 24 онд улсаа дампууруулчихсан, ийм хэцүү эдийн засагтаа хүргэмээргүй байна. Амарбаясгалан дарга их идэвхтэй ажиллаж харагдаад байгаа юм. Тэгэхдээ Сангийн яамнаас ажлаа эхлэхгүй бол болохгүй гэж бодож байгаа юм. Энэ ер нь төсвийг эргэж задлахгүй бол болохгүй гэж ялангуяа хөдөөгийн гишүүд үзэж байгаа. Хөдөөгийн хөрөнгө оруулалтыг бүрэн танасан байна. Та түрүүхэнд ярилаа. Дайн байлдаан болж байна, эдийн засаг хүндэрч байна гээд. Үгүй, тэгээд энийгээ мэдэж байж яагаад хоол хүнсээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн бариад байгаа хүнсний бодлого дээр бодитой хөрөнгө оруулалт тавихгүй байгаа юм бэ? Түгжрэлд мөнгө тавина гээд байна. Түгжрэлийг бол мөнгөөр болгодог эд биш шүү дээ. Түгжрэлийг шинэлэг санаачилга, Ай Ти Технологи, зөв менежментийн бодлогоор буулгах ёстой. Улаанбаатар хотод жил болгон 35-50 мянган оюутан нэмэгдэж байна. Монгол Улсын Ерөнхий сайд уг нь зөв санаачилга эхэлсэн шүү дээ. Нэгдүгээр курсийн оюутнаас тавдугаар курсийн оюутан хүртэл тэр Өмнөговьд сургууль

байгуулж байна лээ. Бүтнээрээ нь сургуулийг шилжүүлбэл дампуурна. Харин нэгдүгээр курсийнхээ оюутнуудыг хөдөө орон нутагт шилжүүлчих юм бол 50 мянган оюутан энэ түгжрэл бий болгодог байдлаас болих юм байгаа юм. Хөдөө орон нутагт ийм боловсон хүчин бэлэн байгаа шүү дээ.

Сайн засаглал, сайн менежменттэй үргэлжлүүлмээр байна. Яагаад төсвийн мэдэгдлийн хүрээлэл ингэж огцом өөрчлөгдөж орж ирж байна гэхээр сайд дарга нар өөрчлөгдсөнтэй холбоотой урсгал зардал нэмэгдэж орж ирж байна шүү дээ. Дээр нь энэ төсвийн хүрээнд би нэг зүйлийг шалгая гэж зориуд бодож байгаа. Ажлын хэсэг байгуулах санал гараад гаргана. Хууль хүчний байгууллагын зардал, хөрөнгө оруулалт гэж замбараагаа алдсан. Үр дүн байхгүй, зөвхөн зарлага хийдэг, хуйвалдаан зохион байгуулдаг ийм бүтэц болсон. Энэ дэд хороо байдаг юм байна лээ. Нямаагийн Энхболд гишүүнээр ахлуулсан. Энэ төсвийг хянаж үзэхгүй бол ямар тоо явдгийг ер нь мэддэг хүн энд байхгүй байх. Нууцын зэрэглэлд оруулчихдаг. Тэгээд тэр таазны ар талд юу хийдгийг мэдэхгүй байгаа. Урсгал зардал дээр тухайлан задаргаа авч ажлын хэсэг байгуулж ажиллах хэрэгтэй. Ганбат даргыг гишүүн болгонтой уулзаж, энийгээ танилцуулах хэрэгтэй гэж хүсэж байна. Хүнсний бодлогын ажлын байр бий болгодог хөдөө аж ахуйн.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Анандбазар гишүүнд 1 минут өгье. Асуултаа гүйцээе.

Ц.Анандбазар: Ажлын байрыг бий болгодог ямар ямар төслүүд хөрөнгө оруулалт дээр нэмэгдээд өрийн тааз нэмэгдэж байна вэ? Уул уурхайн бүтээгдэхүүний гол экспортыг хариуцаж байгаа энэ боомтуудыг хүчин чадлыг нэмэгдүүлэх дээр ямар төсөл хийчхэв? Яг бодитой ажлын байр гаргадаг хэдэн төсөл байна вэ? Урсгал зардал 2.3 гэнэ үү, 2.6 их наядаар нэмэгдсэн байна. Энийгээ тат.

Ийм юм байж болохгүй. Энэ чинь дарга нарынхаа урсгал зардлыг нэмчхээд ард түмний амьдрал ийм хүнд байхад ийм төсөв оруулж ирж болохгүй шүү дээ.

Тэгээд энэ дээр их серёзны ярихгүй бол болохгүй байна. Ер нь бол арай дэндэж байна шүү. Цаашдаа ийм байдлаар явах юм бол Монгол Улс маш хүнд байдалд орно. Юм ярихаар тэгээд ус ч хийсэн сэгсэрнэ, алт ч хийсэн сэгсэрнэ гэдэг шиг сэгсрээд орхичих юм. Заавал хэрүүл тэмцэлдээ хүрч байж, асуудал гаргаж байж шийддэг ийм байж болохгүй шүү дээ. Ард түмнээс сонгогдсон гишүүд яриад байна. Аймгаар нь.../минут дуусав./

Т.Аюурсайхан: 80 дугаар микрофон дээр Сангийн яам хариулъя. Ганбат дарга.

Ж.Ганбат: Анандбазар гишүүний асуултад хариулъя. Бид төрийн сангийн мөнгөн хөрөнгийг бол, ер нь бол аль ч улсын Сангийн яам төрийн сан дээрээ бол төрийн сангийн мөнгөн хөрөнгөө удирдаад явдаг ийм олон улсын жишиг байгаа. Бид бол яг энэ хүрээндээ л Сангийн яаман дээр төрийн сангийн мөнгөн хөрөнгийг удирдаад, яг энэ хүрээн дээрээ Сангийн яам бол үйл ажиллагаа бол явуулж байгаа гэдгийг бол энд бас хэлэх нь зөв байх гэж бодож байна.

Өрийн таазыг бол бид ирэх жил нэмэгдүүлж байгаа юм бол байхгүй. Бид бол Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан өрийн таазны хүрээндээ байгаа. Би харин ирэх жил энэ 70 хувь байгаа Тогтвортой байдлын хуулийн 70-ыг бид нар ирэх жил 65 хувь, сүүлийн 2 жилд нь 60 хувь дээр барина гэж байгаа. Бид 17 онд 72.5 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний өрийн хувь хэмжээ 72.5 хувь байсныг 20 онд бид нар 50.1 хувь болгож бууруулсан. Бид нар энэ өрнийхөө энийгээ хадгална, энийгээ цаашид бид бол өрийг нэмэгдүүлэхгүй

байх энэ талд нь бол анхаарч ингэж бол ажиллаж байгаа.

Ирэх жил бид нар төсвийн алдагдлыг хуулиараа бол дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх төсвийн алдагдал бол 3.6 хувь байх ёстой алдагдлыг бид энэ оны төсөв дээр бид нар 2.8 хувь буюу 1.5 их наядын алдагдалтайгаар оруулж ирсэн. Энэ оны хувьд бол бид нар 2.4 их наядын алдагдалтай байсныг бид нар 1.5 их наядын алдагдалтай байхаар ингэж сайжруулж бол өргөн барьж ингэсэн. Энэ төсвийн алдагдал өөрөөр хэлэх юм бол буурна гэдэг маань бол бид өр тавихгүй, мөнгө төгрөг зээлэхгүй гэдэг ийм байдлаар бодлогоор бол, өөрөөр хэлбэл төсвийн алдагдлаа сайжруулж, тэнцлээ сайжруулж, ингэж бол өмнөх жилүүдээсээ бид нар эрс сайжруулж орж ирсэн. Яг хуулиараа бол бид нар 3.6, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн алдагдлыг 3.6 хувь байхыг бид нар 2.8 хувь болгож ингэж сайжруулж бол уг нь өргөн барьсан байгаа юм.

Энэ оны хувьд бол бид нар төсвийн хөрөнгө оруулалт дээр бол шинэ хөрөнгө оруулалт байхгүйгээр бол ингээд тусгаж орж ирсэн байгаа. Энэ дээр бол бид өмнөх жилүүдээ үргэлжлэх хөрөнгө оруулалтыг ирэх жил дуусгана гэдэг ийм байдлаар хөрөнгө оруулалт тавьсан. Ямар нэгэн шинэ хөрөнгө оруулалт бол тавиагүй, өмнөх жилүүдийн хөрөнгө оруулалтаа бол дуусгаж ингэж явья гэдэг ийм байдлаар бол тусгаж орж ирснийг энд илтгэн хэлж байна.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ асуулт асууна.

Ж.Бат-Эрдэнэ: Төсвийн хүрээний мэдэгдэл орж ирж байна. Энэ маш их чухал юм ш дээ уг нь бол. Энэ дээрээ бид нар нэлээн ач холбогдол өгч байж, энэ төлөвлөлтөө сайн харж байж, тэгээд дараа дараагийнхаа жилүүдийн төсвийг бид нар базаж байх ёстой. Тэгээд сайд нар маань алга байна, уг нь бол яг энэ үед

л сайд нар маань байх ёстой шүү дээ. Энэ дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 5 хувьд хүргэнэ гээд байгаа юм. Яг ямар ямар өсөлтүүд, ямар салбарууд дээр гарах гээд байна? Энэний төлөө яг юу хийх гээд байгаа юм? Энийгээ нэг хар даа. 23 оны асуудал байж байна, 24 онд байж байна, ямар өөрчлөлтүүдийг гаргах юм? Өнөөдрийн байж байгаа нөхцөл байдалд тэр боомтуудын асуудлууд, тэр худалдааны асуудлууд, экспортыг нэмэгдүүлэх, импортоо орлох гэх мэтчилэн энэ дээр ямар асуудлууд яг төлөвлөлт гэж орж ирж байгаа? Бид өр зээл гэсэн хэдэн тоондоо л эргэлдээд байна. Гэтэл эцсийн эцэст эдийн засгийг хөгжүүлэх, эдийн засгийн орлого нэмэгдүүлэх, мөнгөн хөрөнгө болон валютыг нэмэгдүүлэх асуудал дээр бид нар нэлээн ач холбогдол өгөх ёстой шүү дээ.

Хоёрдугаар асуудал энэ хөдөө аж ахуйтай холбоотой асуудал бол хөдөө аж ахуйн эдийн засгийн өсөлт ер нь ямаршуу байх ёстой юм, ямаршуу байгаагаар төсөөлж байгаа юм? Яг энэтэй уялдуулаад нөгөө Монгол Улсын Ерөнхийлөгчөөс барьсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн хүнсний аюулгүй байдлын байдалтай холбоотой асуудал дээр ер нь ямархуу хэмжээний төсөөлөл гарч ирж байгаа вэ?

Төсвийн хүрээний алдагдал буурч байгаа, бууруулж байгаа сайн байна. Энэ орлогын тэнцэл 1.5-1.2 руу оруулья гэж бодож байгаа юм байна. Бид нар чинь 2-той байсныг 1.5 руу татаад байгаа шүү дээ. Болж байна. Ингэхийн тулд нөгөө эдийн засгийн өсөлт, нөгөө орлого, зарлага хоёрын тэнцэл энийгээ яаж өсгөж байгаа юм? Одоо бол үндсэндээ зарлага бол нэмэгдчих гээд харагдаад байна шүү дээ. Тэгэхээр зөрж байж орлого чинь нэмэгдэж байж, энэ төлбөрийн тэнцэл чинь тогтворжих ёстой шүү дээ. Бага болгох ёстой байхгүй юу.

Тэгэхээр зарлагаа татаж байгаа юм уу, эсвэл орлогоо нэмэгдүүлж байгаа юм уу? Яг энэтэй уялдуулаад нэг зүйлийг л та бүхэн маань төлөвлөөд өгөөч. Яг орлого олж байгаа, баялаг бүтээж байгаа үйлдвэрлэл дээр ер нь ямар төсөөллийг бид нар цаашаа гаргах ёстой юм бэ, ямар төсөөллийг барих ёстой юм бэ? Би та бүхэнд зөндөө л ярьж байгаа юм. Үйлдвэрлэлийг дэмжье гэхээр хувийн хэвшлийг улсын төсвөөр дэмжихгүй гээд л зогсоочоод байгаа байхгүй юу.

Тэгээд одоо өнөөдрийг хүртэл хувийн хэвшил маань өөрөө яваад ингээд хаа хүрч бид нар хөгжил дээр очиж байгаа билээ, хаа хүрч баялаг бүтээж чадаж байгаа билээ гэдгээ бол бас бодох хэрэгтэй байна шүү дээ. Үндсэндээ бол улсын төсвөөс орж ирсэн хэдэн төгрөгөө, татвараар оруулж ирсэн хэдэн төгрөгөө бид нар барилга байгууламж, зам харгуй болгодог. Тэр лүүгээ хэдэн аж ахуй нэгжүүд нь ордог, тэгээд буцаад эргээд татвар төлдөг, тэрийгээ дахиад барилга байшин болгодог гээд нэг ийм жижиг тогоон дотор л бид нар эргэлдээд байна шүү дээ. Яг цаад талдаа баялаг бүтээж байгаа зүйл харагдахгүй. Тэгээд нэг зам зааж өгмөөр санагдаад байна. Яг бодит үйлдвэрлэлийн хэдэн үйлдвэр байгуулаач. Энийг төлөвлөөч. Тэгээд энийгээ эздийг нь хэн нэгэн улаан, ногоон, цэнхэр өнгөтэй компани гэхээсээ илүү жигд энийгээ ямар нэгэн байдлаар тендер байдаг юм уу? Юмаар нь сонгож шалгаруулаад эзэнтэй болго.

Хоёрдугаарт, магадгүй энийг ард түмэн өөрсдөө наадхынхаа хувь хувьцааг нь эзэмших, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой бол малчид нь хувийг нь эзэмшиж байдаг, газар тариалантай холбоотой үйлдвэрлэл бол газар тариалангийн компани нь өөрсдөө хувийг нь эзэмшиж байдаг, ард иргэдээ хөрөнгөжүүлэх, ард иргэд маань өөрсдөө энийгээ хийх ийм боломж болчихсон харагдаад байна шүү дээ. Наад зах нь гээд хүнсний зоорины асуудал байж байна. Ногоочид чинь өөрсдөө энэнийхээ

хувийг эзэмшээд явах боломж болчихсон харагдаад байна шүү дээ. Баярлалаа.

Т.Аюурсайхан: 80 дээр Сангийн яам хариулъя. Хөдөө аж ахуйн салбар эдийн засгийн өсөлтөд хэдэн хувийн нөлөө үзүүлж байна? Тоогоор нь тооцоолсон биз дээ? Салбар хоорондын балансаа хийсэн үү? 81 дүгээр микрофон дээр.

С.Наранцогт: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн хөгжлийн дэд сайд Наранцогт байна. Эдийн засгийн өсөлтийг бол 5 хувьд буюу цар тахлын өмнөх үед хүргэх Засгийн газар зорилт тавьж, бодлого гаргаж, ингэж ажиллаж байгаа. Гол анхаарах зүйл бол мэдээж хэрэг энэ гол эдийн засгийн өсөлтөд нөлөө үзүүлдэг уул уурхайн салбараа экспортынхоо хэмжээг цар тахлын өмнөх түвшинд хүргэнэ гэж үзэж байгаа. Тэгээд энэнээс бол эдийн засгийн өсөлтийн хувьд салбараар нь авч үзэх юм бол уул уурхайн салбар 14.6 хувь, таны асуусан хөдөө аж ахуйн салбар бол 4.5, бусад салбарууд бол энэ уул уурхайн бусад салбарт дунджаар 3.7 хувь байхаар ингэж төсөөлсөн. Тэр дундаа яах вэ, ажиллах хүчний оролцоо нэлээн нэмэгддэг салбаруудын хувьд бол хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарыг бол түлхүү дэмжинэ гэсэн ийм бодлого барьж байгаа. Энэ дээр бол Засгийн газар тодорхой хөтөлбөрүүд аялал жуулчлал дээр гаргаад байгаа. Хөдөө аж ахуйн хувьд хүнсний хөдөө аж ахуйн хувьд бол энэ Ерөнхийлөгчийн санаачилсан энэ бүх нийтийн хөдөлгөөн, хүнсний хөдөлгөөнийг дэмжих нэлээд олон тодорхой чиглэлүүдийг гарсан байгаа. Ялангуяа гадаад зээл тусламжтай төсвийн Хөдөө аж ахуйн яаман дээр Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан, хавсралтад туссан нэр бүхий төслүүд байгаа. Улсын Их Хурал өөрөө баталж өгсөн энэ төслүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Тэгээд гол юм бол өнөөдрийн нөхцөл байдлын энэ хүндрэл бол энэ цар тахлын хүндрэлээс үүсээд эдийн засгийн нөхцөл байдал бол нэлээн тогтворгүй байдалтай байгаа. Тэгэхээр эхний бодлого бол эхний улиралдаа энэ оны сүүлийн улирлаас эхлээд ирэх оны эхний хагас жилийн гол зорилго бол макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангая гэдэг ийм бодлого барьж байгаа. Энэ оруулж ирж байгаа төсөв ч гэсэн өөрөө бол төсвөө нэлээдгүй сайн хумьж, төсөв мөнгөний бодлого нэлээн хатуурч, ингээд инфляцыг тогтворжуулах, энэ валютын нөөцийг нэмэгдүүлэх энэ гол түгшүүрүүдээрээ дамжуулж эдийн засгаа тогтворжуулж авах гэсэн ийм гол бодлого явна. Энэний дараа бол таны хэлсэн тодорхой салбаруудыг бол түлхүү дэмжих, тодорхой төслүүдийг дэмжих ийм зүйлүүд бол ороод явж байгаа гэдгийг хэлье.

Т.Аюурсайхан: Бат-Эрдэнэ гишүүнд микрофон өгье. Тодруулъя асуулт.

Ж.Бат-Эрдэнэ: Төсвийн алдагдлаа бууруулж байгаа шүү дээ. Жил тутам ингээд бууруулаад байгаа юм. Энэ маш зөв, ингэх л ёстой бид нар. Гэхдээ нөгөө орлого, зарлагынхаа тэнцлийг яг яаж харж байгаа юм бэ? Эсвэл би хэлсэн шүү дээ. Орлогоо нэмэгдүүлээд байна уу, эсвэл зарлагаа буцааж татаад байна уу?

Хоёрдугаарт төсвийн алдагдлаа юугаар нь өгөх гэж байгаа билээ? Энэ дээр.

Гуравдугаарт энэ уул уурхайтай холбоотой асуудал, тэр тусмаа тээвэр ложистикийн асуудлаа бид нар сайжруулах гээд нэлээн юм хийгээд байх шиг байна. Сая Тавантолгой, Гашуунсухайтын төмөр зам орлоо. Гэхдээ энэ бүрэн ороогүй шүү дээ. Хил дээр очоод л бас л зогсчихсон байж байгаа. Тэнд ачиж буулгах ийм боомт гэх юм уу тийм юм дахиад шинээр байгуулж байгаа юм. Тэгэхээр энд тээврийнхэн энэ

над дээр нэг хариулт өгөөдхөөч. Төмөр замтай холбоотой энэ уул уурхайн бүтээгдэхүүнийг гаргах боломж бололцоо чинь хэр их нээгдэж байгаа юм бэ? Төмөр замаар хэдийг гаргах юм, энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр хэд гэж гарсан юм? Тэгж байж энэ уул уурхайн өсөлт.../минут дуусав./

Т.Аюурсайхан: 80 дээр хариулъя. Ганбат дарга.

Ж.Ганбат: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Бид ирэх жилийн төсөв дээр бол бид нар төсвийн алдагдлаа бууруулахдаа бид бол ер нь зардлаа бид нар жоохон хумих байдлаар бууруулсан. Өөрөөр хэлбэл шинэ хөрөнгө оруулалт байхгүй, бид шинэ хөрөнгө оруулалт тавиагүй. Энүүгээрээ нэг дэх нь бол зардлаа бол.

Хоёр дахь нь бол бид урсгал зардлыг бол ерөнхийдөө 22 оных нь түвшнээс нэмэгдүүлэхгүй байх гэдэг ийм зарчим байсан. Гэхдээ зайлшгүй хүн амын тоо болон Улсын Их Хурлаар батлагдсан хүн амын өсөлт, статистикийн тоо хэмжээ болон өмнө нь батлагдсан хуулийн өөрчлөлтийн хүрээнд бол 1.5 их наядаар зайлшгүй нэмсэн. Энэнээс бусад тохиолдолд бид нар урсгал зардлыг бол 22 оны түвшинд нь бол ингэж нэмэгдүүлэхгүй байх ийм зарчим бариад яг энэ урсгал болон хөрөнгийн зардлын энэ хэмжээгээрээ бид нар төсвийн алдагдлаа сайжруулж орж ирүүлсэн. Өөрөөр хэлэх юм бол бид орлогоо аль болох хий нэмж бид нар.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа. Хүн ирэхлээр танд хариултыг нь авч өгнө.

Х.Булгантуяа: Төсвийн хүрээний мэдэгдлийг бид нар 2023 оныхыг 22 оны 5 сарын 27-нд баталсан. Тэгээд энэ бол уг нь бол Засгийн газар орлогоо энэ хэмжээнд, зарлагаа энэ хэмжээнд, алдагдлаа энэ хэмжээнээс илүү гаргахгүй, өрөө энэ хэмжээнээс илүү гарахгүй 4 сарын хооронд төсвөө хийгээд

10 сарын 1-нд Улсын Их Хуралд өргөн бариарай гэсэн нэг бодлын уг нь бол үүрэг даалгавар өгч байгаа юм. Тэгээд хэм хэмжээг нь заагаад өгчхөж байгаа юм. Одоо нэлээн тоонууд нь өөрчлөгдөж орж ирсэн байна л даа. Орлого 1.6 их наядаар нэмэгдсэн байна.

Тэгэхээр тухайн үед 5 сарын нөхцөл байдал хоёрын хооронд ямар том өөрчлөлт ороод 1.7 орчим их наядаар орлого өснө гэж нэмэгдүүлж орж ирсэн юм бэ? Төсвийн зарлага бас нэмэгдэж орж иржээ. 1.2, 1.3 орчим их наядаар. Энэ дээр ямар хууль эрх зүйн байдаг юм уу, ямар томоохон 2023 онд санхүүжүүлэх гэж нэмэгдэж оруулж ирж байгаа юм бэ? Мөн өрийн хэмжээ нь 1 их наяд орчмоор нэмэгдсэн байна. Засгийн газрын өрийн нийт хэмжээ 34.4 их наядыг энэ үүн дээр 35 болгож оруулж ирсэн байна. Тэгэхээр үүнийг бас ямар өрийн баталгаа гаргах гэж байгаа юм уу? Иргэдээс жишээлбэл над руу ирж байгаа мессеж нь Хөгжлийн банкны асуудал дээр дахиж Засгийн газрын баталгаа гаргаж, эс үгүй бол бонд гаргаж санхүүжүүлэх гэж байна гэдэг дээр маш их бухимдалтай байна лээ. Тэгэхээр энэ өр яагаад 1 их наядаар нэмэгдсэн юм бэ?

Хүүхдийн мөнгийг нийгмийн халамж болгож үзэж байгаа учраас гээд миний ойлгосноор бараг 2 их наяд орчим төгрөг болгож нэмэгдэж байгаа юм байна. Тэгснээ 2024 оноос бол энэ хүүхдийн мөнгийг буцаад хуучин шигээ олгоно гэж байгаа юм уу? Төсвийн төсөөлөл дээр 24 оных дээр 570 тэрбум төгрөг болгосон байна. 1.4 их наядаа буцаад хасчихсан байна. Тэгэхээр энэ бас юу гэсэн үг юм бэ? Бид нар нөгөө дунд хугацаанд ингээд төлөвлөнө гээд улс эх орныхоо бас эдийн засгийг дунд хугацаандаа харъя гэж байгаа нь зөв зүйтэй байх. Тэгэхдээ дунд хугацааны маань төлөвлөлт 4 сарын хугацаатай өөрчлөгдөөд байвал энэ бол дунд хугацааны биш, богино хугацааны улирлын шинж чанартай өөрчлөлт л болж харагдаад байна л даа. КОВИД-ын

нөхцөл байдал, энэ дайн байлдааны нөхцөл байдлаас болоод олон улсын Дэлхийн банк, Валютын сангаас авхуулаад л өөрсдөө ч гэсэн тоогоо өөрчилж байх шиг байна. Тэрийг бол ойлгож байна. Тэгэхдээ тоонуудаа өөрсдөө сайжруулах биш, муутгаж өөрчлөөд байна лээ шүү дээ. Тэгэхээр би харин энэ орлого нь нэмэгдээд энийгээ дагаад манай зарлага бас нэмэгдээд, халамж маань ч гэсэн бас ингэж нэмэгдэж орж ирээд байгааг тодруулж асуух гэсэн юм.

Т.Аюурсайхан: Тодорхой асуултууд асуулаа. 80 дээр Ганбат дарга хариулья.

Ж.Ганбат: Булгантуяа гишүүний асуултад хариулья. Яг үнэхээр 4 сард бид нар төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулж байх үеийн нөхцөл байдлаас өнөөгийн нөхцөл байдал бол сайжирсан. Бид өөрөөр хэлэх юм бол оны эхний 3 сард экспортоо бид нар сэргээж чадахгүй маш хүнд байдалд байсан. Тухайн үед бол бид нар экспортыг сэргээж чадна гэхэд бол яг үнэндээ бол 100 хувь итгэл бол байгаагүй. Хятадын ТЭГ-КОВИД бодлого бол маш хүчтэй явсан. Бид эхний 3 сар дээрээ бол экспортоо үнэхээр маш хүнд явсан. Өдөрт бид нар 100 гаран машин л гарч байсан. Бараг зарим өдөр бол машин гарахгүй, Хятад талдаа маш хатуу хөл хориотой байсан. Ийм учраас бид бол энэ юун дээр орлого талдаа бол яг төсвийн хэрээний мэдэгдэл боловсруулж байгаа үед маш болгоомжтой хандсан.

Өнөөдрийн түвшинд бол бид экспортыг бол ялангуяа нүүрсний экспортыг бол сэргээж чадсан. Бид өдөрт 1500 машин буюу 200 мянган тонн нүүрс дунджаар өдөрт гаргаж байна. Энэ маань бол өөрөөр хэлэх юм бол бид бараг КОВИД-ын өмнөх нөхцөл дээрээ нүүрсний экспортыг хүргэж чадсан нь бол бидний хувьд том амжилт байсан. Энэнтэй холбогдуулаад бид бол орлогыг бол нэмэгдүүлж бол орж ирсэн. Ирэх жил

бид 36 сая тонн нүүрс бол хамгийн багадаа бол экспортлох бол бүрэн бололцоотой байна гэдэг дээрээ бид бол ингэж орлогыг бол нэмэгдүүлж орж ирсэн байгаа. Зарлага талдаа бол бид 2022 оны түвшинд бол урсгал зардлыг бол бид нар барихыг хичээсэн.

Нөгөө талдаа бид нар хүн амын тооны өсөлт болон статистик тоотой холбоотой Улсын Их Хурлаар батлагдсан шийдвэртэй холбоотой бид нар зайлшгүй 1.5 тэрбум төгрөгөөр бол урсгал зардлыг бол нэмэгдүүлж, их наядар нэмэгдүүлэхээс өөр аргагүй ийм боломж бол байгаагүй учраас урсгал зардлыг бол нэмэгдүүлж орж ирсэн. Ирэх бол бид бол шинэ хөрөнгө оруулалт байхгүй гэдэг ийм байдлаар бол юмнуудаа бол тооцож орж ирсэн байгаа.

Өрийн хувьд бол бид нар Шинэ сэргэлтийн бодлогод бол тусгасан 1 тэрбум доллар хүртэл Засгийн газрын өрийн баталгаа гаргах тооцоог бол бид нар өрийн тооцоонд бол оруулсан. Гэхдээ энийг бол тухай бүрд нь бол Улсын Их Хурлаас бол бид нар зөвшөөрлөө аваад үүнийг хэрэгжүүлнэ гэдэг ийм байдлаар бол нэмэгдүүлж болж орж ирсэн байгаа.

Т.Аюурсайхан: Булгантуяа гишүүнд 1 минут өгье. Асуултаа тодруулья.

Х.Булгантуяа: Хүмүүст ирэх жил доллар хэд хүрэх боллоо гэж маш их асууж байна. Тэгэхээр 2023 он дээр долларыг та бүхэн хэд гэж тооцож авсан бэ? Нэгдүгээрт.

Дотоодын нийт бүтээгдэхүүнээ бас хэд гэж тооцож авсан бэ? 5 сарын 27-той харьцуулахад нэмэгдүүлж оруулж ирсэн үү? Дээрээс нь 23 оноос зардал нэмэгдүүлэх ямар хууль шинээр үйлчилж эхэлж байна вэ? Зардал нэмэгдүүлэх бүр нэлээн үр дагавартай хуулиуд, хэрэгжилтүүд заримдаа байдаг шүү дээ. Зарим жилүүдэд, Тийм ямар хууль байна вэ?

Т.Аюурсайхан: 80 дээр гүйцээж хариулья.

Ж.Ганбат: Бид бол төсөв дээр бол төсвийн төсөв боловсруулахдаа бол бид нар тооцооллын ханш гэдэг юм бол бид гаргаж ирж бол тооцож байгаа. Энийг тооцохдоо бид нар тухайн үед яг төсөв боловсруулаад өргөн барих үеийн ханшийг бол тооцоололдоо авч бол ингэж бол авч ашигладаг байгаа. Энэ дээр яах вэ, юун дээрээ Эдийн засгийн хөгжлийн яам нэмж бол тайлбар хэлэх байх гэж бодож байна. Бид нар гарцаагүй зайлшгүй нэмэгдүүлэх шийдвэр гэдэг дээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор зардал бол нэгд нэмэгдэж байна. Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах арга хэмжээний Улсын Их Хурлын тогтоол байгаа. Энэнтэй холбоотой 230-аад тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа.

Мөн төрийн албан албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор бол нэмэгдэнэ. Мөн Улсын Их Хурлаар нөгөө 2 сард батлагдсан нөгөө тэтгэврийг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор бол энэ.../минут дуусав./

Т.Аюурсайхан: 81 дээр нэмж хариулах уу? Тэр америк долларын ханш яг хэдээр төсөвлөсөн юм бэ? Энэ чинь энгийн л асуулт шүү дээ. Байж байгаа ш дээ. Тэрийгээ хариулчихна. Дээр нь ирэх жил төсөвт зардал нэмэгдүүлэхээр хэрэгжиж байгаа хуулиуд ямар ямар хуулиуд байна гээд нэр усаар нь гүйцээгээд хэлчих.

С.Наранцогт: Булгантуяа гишүүний асуултад хариулья. Ер нь яах вэ, сүүлийн жилүүдэд төсөв өргөн барихдаа бол төсөв өргөн барих өдрийн ханшаар долларыг ер нь тооцож явах нь арай бодитой гэж үзсэн. 10 сарын 1-нд бол 3344 байсан. Тэгээд энэ өрийн үйлчилгээ нэмэгдэж байгаа нь ч гэсэн энэ долларын ханш нэмэгдсэнтэй бас холбоотой. Та ирэх жил ямар байх вэ

гэдэг юм асуусан. Тэгээд ирэх жилийн хувьд бол бид хэд мэдээж хэрэг энэ долларын ханш бол улсын гадаад валютын албан нөөц, төлбөрийн тэнцэлтэй л шууд ул уялдаад байгаа юм. Тэгэхээр Засгийн газраас ямар арга хэмжээ авав гэхээр сая өнгөрсөн Засгийн газрын хуралдаанаар бол бид нар энэ экспортын бодит мөнгөн орлогыг нэмэгдүүлэх дээр нэлээн бодитой арга хэмжээнүүд аваад, ялангуяа Төрийн өмчит компаниудад бол энэ ачилт, экспортынхоо зохицуулалтыг уян хатан байдлаар зохицуулаад, валютын орлогыг бодитойгоор нэмэгдүүлэх ийм.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал асуулт асууна.

Ж.Батжаргал: Тийм. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг бид баталчихсан. Одоо 23 оны төсөв боловсрогдож байгаатай холбогдуулж өөрчлөлт оруулахаар орж ирж байна. Тэгэхээр нэлээн олон тоон дээр өөрчлөлт орчихсон юм билээ. Сая асуулаа. Тэгээд тодорхой хариулт юмнууд өгөгдөж байх шиг байна.

Гэхдээ бид хуулийн хязгаарт гээд ингээд дээд хэмжээний тоо тавьчихаад баймгүй байна. Улсын чинь Засгийн газрын өр өнөөдөр яг хэд байгаа юм? 2023 онд бид ямар шаардлага үндэслэлээр, хэдий хэмжээний юм нэмэгдүүлэх юм гэдэг юман дээрээ тооцож тоо тавихгүй бол энэ нийгэмд ч буруу мэдээлэл өгөөд байгаа. Ер нь тооцооллын хувьд ч буруу зүйл байхгүй юу. Дээд хэмжээ 65 хувь байж болох юм гэсэн тэр хуулийн заалтаар аваачиж тоо тавьчихаад ингээд ард түмнийг, гишүүдийг төөрөгдүүлээд байдгаа больчихмоор байна. Үүнийгээ нэг зөв болгож өгөөч. 8.7 тэрбум долларын өр байгаа юм шиг байгаа юм. Би тэгж ойлгоод байгаа юм. Тэрийг нь валютын үнэ цэнээр нь тооцоод үзэхээр зэрэг би нэг 30 орчим их наядын асуудал байгаа

юм уу гэж харагдаад байгаа. Гэтэл та бүхэн 35 гаргаж тавьчихаад ингээд иргэд олон түмнийг ч, энэ гишүүдийг ч төөрөгдүүлээд баймгүй байна. Бодит тоогоо тавимаар байна. Нэг.

Хоёр дахь зүйл бодвол энэ халамжийн зардал 1.5 орчим их наядаар өсчхөж байгаа юм байна лээ. Хүүхдийн мөнгөнийх нь юу энэ рүүгээ ороод ирж байгаа юм байна гэж ингэж харагдаж байгаа. Ард тэр Ирээдүйн өв сангийн тухай хууль дээр бас биднүүс 65-ыг тэглэх тухай асуудал яриад ерөөсөө Ирээдүйн өв сан руугаа энэ жил хөрөнгө хуваарилахгүй байлгах, энэ рүүгээ оруулж ирж хүүхдийн мөнгө рүүгээ гаргах тухай асуудал яригдаж байгаа юм байна гэж ингэж ойлгож байгаа. Энэ мэдээлэл юмнуудаа их зөв болгож ярихгүй бол бид халамжаас хөдөлмөрийн тухай яриад байдаг. Тэгсэн хэр нь халамжийн зардал нь өмнөх онтой нь харьцуулаад үзэхээр зэрэг 1.4 их наядаар өсчхөөд яваад байдаг ийм байж боломгүй л байна л даа. Тэгэхээр үүнийг бас та бүхэн минь энэ зөв үзүүлэлтээр нь авч хэрэглэх тухай асуудал байх юм болов уу гэсэн нэг ийм зүйл байгаад байгаа юм гэж.

Яах вэ, төсвийн хүрээний мэдэгдэл, орлого зарлага 2-ыг нэмэгдүүлж болдог юм байж, энэ хөрөнгийн зардлын чинь хэмжээ яагаад 4.4-ийн төсөөлөлтэй явж байсан үзүүлэлт 5.3 их наяд болоод өсчихдөг юм бэ? Энэний цаана юу байгаад байгаа юм бэ? Энэ үүн дээр тов тодорхой мэдээлэл авмаар байна. Уг нь биднүүсийн барих ёстой асуудал бол энэ төсвийн хүрээний мэдэгдэл нь тэр Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь, өрийн удирдлагын хууль энэ тэр нь ер нь нэлээн тогтвортой байж энэ эдийн засгийн үзүүлэлтүүдээ түүндээ нийцүүлж авч явахын тулд холбогдох зохицуулалт, арга хэмжээнүүдээ авч ингэснээрээ л эдийн засаг, төсөв, санхүүгийн чинь эрүүлжүүлэлтийн асуудал, бас гайгүй үзүүлэлтүүд гарах, энүүгээрээ дамжиж энэ улс орны чинь эдийн засгийн өсөлт,

иргэдийн амь амьжиргааны асуудал нь хангагдаж явах л ёстой л доо. Цаг үеийн нөхцөл байдал хүнд байна гээд ингээд л хувьсан өөрчлөгддөг системээр хуульдаа жилд 2, 3 удаа гар хүрээд л яваад байх юм бол бидэнд хэзээ ч нааштай үзүүлэлт, үр дүн гарахгүй. Хүнд байгаа нь үнэн. Тэрийг даван туулах гэж нэлээдгүй арга хэмжээнүүдийг зохицуулж яваа нь үнэн.

Гэхдээ л бид тодорхой тоон үзүүлэлтүүд дотроо тогтвортой барьж захирагдаж явах тухай л асуудал байгаад байна л даа. Энийгээ биднүүс сахилгын тухай ярьцаагаад байгаа юм шиг байгаа юм. Ингэж явж чадвал наад үзүүлэлт юмнууд чинь гайгүй уул нь гарах болов уу гэж бодоод байх юм. Тэгээд тэгэх янзгүй болтол нь өөрчлөөд байгаа учраас бид.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг нарын урилгаар Сүхбаатар дүүргийн 3, 16 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

82 дээр Ганбат дарга хариулъя. Нэлээн олон гишүүд бас адилхан асуултыг. 80 дээр. 80 дугаар микрофон гэсэн.

Ж.Ганбат: Засгийн газрын Батжаргал гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын үр яг одоогийн байдлаар бол 28.5 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээрх үлдэгдэл нь 23.8 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний 50.1 хувьтай тэнцэж байгаа юм. Яг өнөөгийн үеийн байдлаар халамжийн хувьд бол нийтдээ бид нар 2 их наядын халамжийн зардал байна. Үүний 1.4 их наяд нь бол хүүхдийн мөнгө байна.

Бид энэ 2022 оны хувьд бол хүүхдийн мөнгийг Ирээдүйн өв сангаас санхүүжүүлэхээр бол ингэж Улсын Их Хурлаар батлагдсан байгаа. Энийг бид нар 23 онд бид нар улсын төсвөөс санхүүжүүлэхээр оруулж ирсэнтэй холбоотойгоор халамжийн зардал бол 2 их наяд болсон. Энэ Ирээдүйн өв сангаас санхүүжиж байсан хүүхдийн мөнгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасантай холбоотойгоор Ирээдүйн өв санд орж байсан зарим орлогыг бид нар улсын төсөв дээр шилжилтийн байдлаар бол оруулж ирэхээр хуулийн өөрчлөлтийг нь оруулж ирсэн байгаа. Энэ дээр бол ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бид нар Ирээдүйн өв санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65 хувь ордог байсныг 23 онд улсын төсөвт орохоор бол ингэж өөрчлөлтийг нь хийгээд, энийг 2, 3 жилийн хугацаатай ийм шилжилтийн үе явуулаад, дараа нь бол 100 хувь буцаагаад Ирээдүйн өв санд төвлөрөхөөр бол ингэж тооцсон байгаа.

Хөрөнгө оруулалтын хувьд бол тэр дүн нь нэмэгдчихсэн байгаа шалтгаан нь бол ийм дүнгээр бол өөрчлөгдсөн байгаа. Бид нар хөрөнгийн зардал дээр бол 23 онд нийслэлийн түгжрэлийг бууруулахтай холбоотой 339 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Мөн барилгын бараа материалын үнийн өсөлттэй холбоотой 300 тэрбум төгрөг, гадаад зээл тусламжийн Монголын талын санхүүжилтээр 232 тэрбум төгрөгөөр, нийтдээ 863 тэрбум төгрөгөөр хөрөнгийн зардал бол ингэж нэмэгдсэн байдалтай бол харагдаж байгаа.

Т.Аюурсайхан: Батжаргал гишүүнд микрофон өгье.

Ж.Батжаргал: Тийм, тэгээд одоо ийм л мэдээллүүд орж ирээд байгаа юм. Дээр нь нэг зүйл тодруулмаар байх юм. Сангийн яам Улсын Их Хуралд төсөв өргөн барьж байгаа бол гүйцэд баримаар байна. Хөрөнгө оруулалтын жол жагсаалтууд, дагаж өөрчлөгдөх хуулийн

жагсаалтууд төслүүд өргөн барьчаад салбарынхаа багцуудыг тэр чигт нь атгаад үлдчихээд байгаа нь ямар учиртай юм? Бидэнд орж ирсэн материал дээр чинь ямар ч дүгнэлт хийх боломжгүй байгаа яг үнэнийг хэлэхэд. Аль ч салбарын чинь төсвийн задаргаа байхгүй. Тэгээд тэр дотроо юу багтаж яваад байгаа юм? Нийслэл дээр 1 их наядын тухай яригдаж байсан, одоо 339-ийн тухай л ярьж байна шүү дээ. Тэгэхээр нийслэлийн төсөв дээр та нар үндсэндээ 670 орчим тэрбум төгрөгийг шингээгээд үлдээчихсэн тухай л асуудал яригдана шүү дээ наадах чинь.

Тэгэхээр энэ төсвийг гүйцэд өргөн барьчихдаг эрх зүйн зохицуулалт юмыг нь Төсвийн байнгын хорооны даргаа энэ эрх зүйн зохицуулалтуудыг нь тодорхой болгож өгөхгүй бол энэ чинь ингээд.../минут дуусав./

Т.Аюурсайхан: 80 дээр буцааж хариулъя. Ганбат дарга.

Ж.Ганбат: Төсвийн хүрээний мэдэгдэл дээр бол бид нар ерөөсөө нийтдээ 9 үзүүлэлтүүдийг л бол бөөн дүнгээрээ бол өргөн барьж, ингэж бол батлуулдаг хуулийн заалттай байгаа. Төсөв дээр бол бид нар Батжаргал гишүүн саяын таны хэлсэн, бид нар яг задгайгаар нь, дэлгэрэнгүйгээр бол бид нар өргөн барьдаг хуультай. Яг тэрнийхээ дагуу бол бид төсөв дээрээ бол хөрөнгө оруулалтыг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь, яг харьяалагдах сайдынх нь багцад нь ингээд тусгасан. Дэлгэрэнгүй байдлаар бол бид нар өргөн барьдаг ийм хуулийн заалттай яг тэр шаардлагаа дагуу л бид өргөн барьж байгаа. Мөн бид нар юуг. Орон нутгийн төсөв дээр бол бид орон нутгийн төвлөрүүлэх орлого болон санхүүгийн дэмжлэгийг бөөн дүнгээр нь бол ингэж 2 тоог бол ингэж баталдаг бол ийм хуулийн заалттай байгаа. Бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын бид нар, урсгал зардлыг бол эдийн засгийн ангиллаар нь болон төсвийн төвлөрөл, ерөнхийлөн

захирагчаар нь бол ингэж задгайгаар нь өргөн барьдаг хуулийн заалттай. Энэ шаардлагаа.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Батжаргал. 1 минут нэмж өгье.

Ж.Батжаргал: Тийм, төсвийн хүрээний мэдэгдэл ярьж байна. Энэ бол угаасаа эдийн засгийн хэдэн гол үзүүлэлтүүдийнх нь хүрэх, барих ёстой түвшнүүд байхгүй юу. Тэгээд энэний чинь цаана наад төсвийн чинь задаргаа өөрөө баталгаа нь болж орж ирдэг ийм зүйл. Төсвийн хууль чинь. Одоо болтол яг таны наад хэлж байгаагаар нь юмыг чинь олж харахгүй байгаад байгаа үнэнийг хэлье.

Хоёрдугаарт, бид энэ валютын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах ёстой. Ингэхийн тулд энэ тэвээр логистикийнхоо асуудлыг зөв шийдэхгүй бол болохгүй байна. Сая Эрдэнэт дээр очоод ажиллаад ирсэн 15 мянган тонн зэсийн баяжмал ашиглаж чадахгүй байж байгаа байхгүй юу. Эрдэнэт өдөртөө 35 вагоны хуваарилалттай байгаад байх юм бол үйлдвэрлэлийнх нь үйл явцаар яг бүтэн экспортууд нь хэвийн гараад байх бололцоотой юм билээ.

Гэтэл 30, 31-ийг өгчхөөд байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр 15 мянган тонн зэсийн баяжмал гэдэг чинь өнөөдөр бараг 8 мянга орчим доллар байгаа биз дээ 1 тонн нь? Тэгэхээр хэдий хэмжээний валют орж ирээд Монголын валютын нөөц нэмэгдэх.../минут дуусав./

Т.Аюурсайхан: 81 дүгээр микрофон дээр Наранцогт дарга. Эдийн засгийн хөгжлийн яам.

С.Наранцогт: Батжаргал гишүүний асуултад тодруулж хариулъя. Валютын бодит орлогыг нэмэгдүүлэх дээр танд хэлсэн нэлээд олон төрлийн арга хэмжээ бас Засгийн газраас аваад үүрэг даалгаврууд тогтоолоор өгөгдсөн. Энэ дээр яг сая ярьж байгаа Улаанбаатар

төмөр замд яг эхний ээлжид энэ экспортын бодит орлогыг нэмэгдүүлэх чиглэлд ачаа тээврийнхээ асуудлыг зохицуул гэдэг ийм үүрэг даалгавар өгсөн. Энэ үүрэг даалгаврын хэрэгжилтийг бол бид нар 7 хоног болгон бас хяналт тавьж, Засгийн газар танилцуулаад явах юм. Энэ дээр бол тодорхой үүрэг даалгавар өгөгдсөн. Ер нь бол яах вэ, түрүүн бас Бат-Эрдэнэ гишүүн ч асуугаад байгаа. Энэ гол боомтууд дээрээ нэмэлт байгууламжгүй буюу жолоочгүй тээврийн хэрэгсэл, тээвэр ложистикийн чингэлэгт тээврийн терминал гээд нэмэлт байгууламжууд нэмэгдсэнээр бол бодит экспортын боломж бол нэмэгдчихээд байгаа юм. Ганцхан тээвэр зохион байгуулалт дээр бол нэлээд .../минут дуусав./

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг асуулт асууна.

М.Оюунчимэг: Бид нар яг одоогоос 5 сарын өмнө 2022 оны 5 сарын 18-нд энэ Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг оруулж ирээд хэлэлцэж байхад Улсын Их Хурлын гишүүдийн дийлэнх нь та нар маань нэг л гутрангуй Төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөл оруулж ирээд байна. Энэ тоонууд чинь арай л биш байгаа юм биш үү гээд маш сайн хэлж байсан. Би ч хэлсэн, Баттөмөр гишүүн маань ч энийг маш тодорхой хэлж байсан. Тэгээд та нар маань нөхцөл байдал яг ийм байна гэсэн. Өнөөдөр яг л бид нарын хэлснээр нөгөө гутрангуй тоо баримтаа арай нэг өөдрөгөөр засаад л ороод ирсэн байна л даа. Тэгэхээр бас гишүүдийнхээ үгийг сайн сонсож байх хэрэгтэй байна. Бид нар чинь бас тал талын салбарынхантай уулзаж байна, төсөөлөлтэй уулзаж байна. Өчигдөр л гэхэд Мишээл экспод “Экспо 2022 он” 2 жилийн дараа, КОВИД-ын дараа болж байна. Европын холбооны том том компаниуд оролцож байна. Тэд нар бас ярьж байгаа байхгүй юу. Та бүхэн маань Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хөрөнгө оруулалтыг дэмжинэ,

хөрөнгө оруулагчдаа дэмжинэ гээд байгаа хэр нь танай энэ Төсвийн хүрээний мэдэгдэл, одоо хэлэлцэж байгаа төсөв, төрийн мөнгөний бодлогыг харахад бас яг яаж дэмжих гээд байгаа чинь тодорхойгүй байгаад байна. Ер нь жоохон тодорхойгүй, бүрхэг байна. Бид нар тэгээд л нэг л ойлголтгүй байна гэж ярьж байгаа байхгүй юу.

Тэгэхээр өнөөдөр бас та нараас бид нар асуугаад байна л даа. Өрийн тааз 65 хувьд хүрч орж ирж байна гэдэг чинь энэ чинь 14 хувиар нэмэгдэж байна. Хэн ч бүгд яриад байна шүү дээ. Энэ чинь гадаадаас зээл авах тийм орон зайг нь та нар нээж өгөөд л ингээд орж ирж байна шүү дээ. Тэгэхээр яг ямар хүүтэй, ямар хугацаатай бизнесийн, арилжааны зээл юм уу, эсвэл ашигтай тийм 2 улсын гэрээний засгийн газар хоорондын зээл авахаар төлөвлөж байгаа юм уу? Хүү хугацааны талаар энэ талаар гадагшаа ярьж хөөрч байгаа юм байгаа юм уу гээд олон гишүүн асуугаад байна. Энэ дээр бас та бүхэн маань маш тодорхой тайлбар нэгдүгээрт өгчих хэрэгтэй байна. Нэгдүгээр асуулт.

Хоёр дахь асуулт нь манай гишүүд ингээд л байх юм. Нийгмийн халамж нэмэгдээд байна. Хавтгайрсан халамж гэдэг нэг үгийг бүр ингээд хэллэг болгочоод байна л даа. Гэтэл энэ тооцооллоос ингээд аваад үзэхэд тийм хавтгайрсан халамж бол харагдахгүй байгаа байхгүй юу. Халамжийн тухай хуулийг бид нар ингээд үзэж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний төсвийн хүрээний мэдэгдлээс харахад Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ бид нар нөгөө төсвийн хүрээний мэдэгдэл батлахад 604.8 тэрбум төгрөгөөр баталж байсан. Энэ нь өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүний 1.1 хувийг л эзэлж байгаа.

Тэгээд сая ингэж байна л даа. Ирээдүйн өв сангаас бид 2023 оны төсөв рүү энэ зардлыг оруулж ирж байгаа

учраас төсөвт ингээд ачаалал нэмж орж ирж байгаа гээд байгаа юм. Тэгэхээр энэ чинь Ирээдүйн өв сан дээр тэр байтугай 100 хувьд олгож байсан бол бид 93 хувь гэж бас орж ирээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ халамж маань ингэж нэмэгдээд байгаа юм уу, эсвэл Ирээдүйн өв санд байсан тэр хэмжээний зардал маань л 23 оны улсын төсөв дээр ингэж орж ирж байна. Энэ чинь дарамт болж юм уу, ачаалал болж орж ирээгүй гэж би ойлгоод байгаа шүү дээ. Яагаад гэвэл угаасаа энэ мөнгө Ирээдүйн өв сан дээр байж байгаа мөнгийг л 23 оны улсын төсөв рүү та нар маань татаж авчирч байгаа гэж би сая Наранцогт даргын ярианаас жишээлбэл ойлгож байна л даа.

Тэгэхээр энэ үнэхээр халамж тэгээд хавтгайруулж ингэж орж ирээд байгаа юм уу, эсвэл зүгээр дүнгийн хувьд адилхан байна шүү дээ. Бүр тэр битгий хэл дотоодын нийт бүтээгдэхүүний 1.1 хувь л байна шүү дээ. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр ингээд хараад үзэхэд.

Тэгээд энэ тоо баримтаа та нар маань ингээд бодитоор ярихгүй бол нэг хэсэг нь ингээд л халамж хавтгайрчихсан юм шиг. Гэтэл яг төсвийн хүрээний мэдэгдэл дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувьтай нь харьцуулаад үзэхэд өмнөх жилээс их гарсан юм огт байхгүй шүү дээ. 1.1 хувь л байна шүү дээ. Тэгээд энэ нь тооцооллоо зөв хэлэхгүй бол ингээд буруу ойлголт өгөөд нөгөө бид нарын явж байгаа. Энэ Шинэ сэргэлтийн бодлого энэ тэр чинь эндээ ингээд иргэдэд буруу ойлголтоор яваад байна л даа. Тэгэхээр та нар маань яг энэ хавтгайрсан халамж гэдэг байхгүй шүү дээ. Ирээдүйн өв сангаас 2023 оны төсөв рүү татаж авчрах шалтгаан нь юу байгаа юм? Ингэж татаж авчирснаар төсөвт үнэхээр дарамт болж, их хэмжээний мөнгө орж ирж байгаа юм уу? Үгүй байх гэж би бодоод байгаа юм. Яагаад гэвэл хүүхдээ өгч байгаа хүүхдийн тоотой харьцуулаад үзэхэд. Тэгээд энэ энэ тэр дээрээ яг задаргаагаар тодорхой нэг тайлбарыг би эхлээд авчхаад, дараа нь

тодруулж асууя гэж бодож байна. Баярлалаа.

Т.Аюурсайхан: 80 дээр Ганбат дарга хариулна. Сангийн яам.

Ж.Ганбат: Бид яах вэ, таны хэлж байгаа төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж байх үеийн нөхцөл байдал одоогийн нөхцөл байдал 2 өөр болсон л доо. Гэхдээ бид бол бас хавар, үнэхээр бол бас 4 сард бид нар төсвийн хүрээний мэдэгдлийг өргөн бариад 5 сарын 1-нд Улсын Их Хурлаар батлагдаж байх үед нөхцөл байдал үнэхээр амаргүй байсан. Бид үнэхээр экспортыг сэргээж чадна гэдэгтээ бол 100 хувь бол итгэл бол байгаагүй. Үнэхээр Хятадын бол ТЭГ-КОВИД-ын бодлого үнэхээр маш хатуу байсан. Ийм учраас бол бид үнэхээр Төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ бол болгоомжтой ингэж хандсан. Ер нь бол бид аль болох өөдрөг биш, жоохон бодитой бас эрсдэлүүдийг тооцсон ийм байдлаар төсөв болон Төсвийн хүрээний мэдэгдлийг бол боловсруулах нь зөв юм гэсэн. Бас хэт өөдрөг төсөв, Төсвийн хүрээний мэдэгдлийг бас боловсруулах нь бол эргээд асар өндөр эрсдэлийг дагуулдаг учраас энэ дээр бол бид нар маш болгоомжтойгоор ингэж хандаж байсан нь бол үнэн гэдгийг хэлье.

Өрийн хувьд бол яг өнөөгийн байдлаар бол Засгийн газрын өр бол 2022 оны яг өнөөгийн байдлаар бол 28.5 их наяд төгрөг. Өнөөгийн үнэ цэнээрх үлдэгдэл нь 23.8 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний 50.1 хувьтай тэнцэж байгаа юм. Бид бол ирэх жил ямар нэгэн байдлаар шинээр нэмж эх үүсвэр бол нэмж гаднаас бол зээл, өр авъя гэж ингэж бол төлөвлөөгүй. Бид нар өрийг бол нэмэгдүүлэхгүй, аль болох энэ одоогийн энэ 50.1 гэдэг түвшнээ хадгалаад цаашаа аль болох бууруулах ийм бол бодлогыг бол баримталж байгаа.

2017 онд бол дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх өрийн хэмжээ бол

72.5 хувь байсан. Бид өнөөдөр 50.1 хувь болгож бол бууруулсан. Энийгээ бид ирэх жил бол хадгалаад ингээд цаашаа аль болох нэмэгдүүлэхгүй байх талаар нь ингэж явна. Яг халамжийн хувьд бол бид нар энэ онд Улсын Их Хурлаар батлагдсан төсвийн хуулиар бол хүүхдийн мөнгийг бол Ирээдүйн өв сангаас санхүүжүүлж байгаа. Энийг 23 онд бид улсын төсвөөс санхүүжүүлэхээр оруулж ирсэн. Энэнтэй холбоотой 1.4 их наядаар бол халамжийн зардал нэмэгдээд нийтдээ 2 их наяд болж болж ингэж харагдаж байгаа. Яг энэнтэй холбоотой бол эх үүсвэрийн хувьд бид нар холбогдох завсрын бол шилжилтийн байдлаар болгон эх үүсвэрүүдийг мөн улсын төсөв рүү яг энэ хүүхдийн мөнгө шилжиж байгаатай холбоотойгоор бол зохицуулалтуудыг хийж ингэж оруулж ирсэн байгаа.

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан, Нямаагийн Энхболд, Жигжидийн Батжаргал нарын урилгаар Төв аймгийн Зуунмод хотын ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг асуултаа тодруулна.

М.Оюунчимэг: Манай Сангийн яам, Ганбат дарга маань ингээд л гишүүдийн асуултад тал талаас нь тэгээд ерөнхий л нэг төстэй л хариулт өгөөд байх юм л даа. Жишээлбэл, миний асуулт бол Ирээдүйн өв сангаас 2023 оны төсөв рүү авчирч байгаагийн шалтгаан нь юу юм бэ? Ингэснээрээ халамжийн зардал үнэхээр нэмэгдээд байгаа юм уу, эсвэл 22 өмнөх оныхоо түвшинд, 20 оныхоо түвшинд юм байгаа юм уу гэдэг асуулт байсан. Тэгэхэд тэрнээс 23 оны төсөв дээр ирж байгааг бид нар бүгдээрээ мэдээлэл байна л даа. Энэ дээрээ яг тодорхой хариулаад өгөөч. Яаж нэмэгдэж

байгаа юм, эсвэл нэмэгдээгүй юм уу, түвшиндээ байгаа юм уу? Ер нь эндээс Ирээдүйн өв сангаас авчрах шалтгаан нь юу байгаа юм бэ л гэж би нэгд сууж байгаа юм. Эндээ нэг хариулт өгөөч гэж.

Хоёрт нь бид нар өнөөдөр бүгд анзаараад л хараад байна л даа. Нэг л өөрчлөлт, Монголын эдийн засаг ирэх онд 5 хувь, инфляцыг 8 хувьд авчраад, ямар ч байсан эдийн засгийн сэргэлт болох тийм итгэлийг хүмүүст өгөх тийм хандлага бол байна л даа. Өчигдөр би хөрөнгө оруулагчтай энэ тэртэй уулзаж байхад. Тэгэхдээ яаж, ямар арга зам юм? Хөрөнгө мөнгө хөрөнгө.../минут дуусав./

Т.Аюурсайхан: 80 дээр гүйцээж хариулъя. Ганбат дарга.

Ж.Ганбат: Энэ онын төсөв дээр бол хүүхдийн мөнгийг Ирээдүйн өв сангаас. Гэхдээ энэ дээр бид нар хуримтлалтай хүүхэд гэдэг бодлогыг хэрэгжүүлэхээр бол Улсын Их Хурлаар бол энэ батлагдсан. Гэхдээ яг хэрэгжилтийн явцад бол энэ хуримтлал гэдэг юм бол үүсгэгдэхгүй байна. Ер нь бол хүүхдийн мөнгө 100 хувь зарлага болж гарч байна. Тэгэхлээр бид энэ ингээд Ирээдүйн өв сан бол өөрөө цэвэр хуримтлалын сан. Энэ бол ирээдүй хойч үедээ зарцуулагдах ёстой мөнгө. Бид үүнийг нэгэнт энэ дээрээ хуримтлалтай хүүхэд гэдэг энэ хөтөлбөр арга хэмжээ маань хэрэгжихгүй байгаа учраас зарлага болоод санхүүжилттэй байгаа учраас Ирээдүйн өв сангаа бид нар хуримтлалаар нь авч үлдье. Энийгээ бид нар улсын төсөв дээр нь зарлага байдлаараа хүүхдийн мөнгөө оруулж ирээд халамж дээр нь ингээд тавья гэдэг ийм байдлаар бол гол зорилгоороо үүднээс бол энийг хүүхдийн мөнгийг улсын төсөв дээр оруулж ирчихсэн байгаа. Энэнтэй холбоотойгоор бол яах вэ, нөгөө халамжийн маань зардал 2 их наяд болсон. Нийт.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Оюунчимэг гишүүнд микрофон өгье. Гүйцээгээд асууя.

М.Оюунчимэг: Би яах вэ, энэ нөхцөл байдлыг нь ойлгож байна л даа. Ирээдүйн өв сан гэдэг чинь өөрөө нөгөө хуримтлалтай хүүхэд, хуримтлал гэдгээрээ одоо Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар л ер нь орж ирж байна шүү дээ. Халамж хэлбэр болгож байна шүү дээ. Тийм ээ? Тийм, тэрийгээ л хэлчихгүй юу даа. Тэгэхдээ хүүхдийн мөнгө бол 604.8 тэрбум дээр байхад одоо бол энэ Ирээдүй өв сангаас халамж руу буюу төсөв рүү орж ирэхдээ 1.4 их наяд гээд ингээд нэмэгдээд байгаа шүү дээ. Тэгэхдээ энэ ганц хүүхдийн мөнгө биш. Тэгэхээр энэ халамжийн энэ хуультайгаа холбоотойгоор бас ийм тооны зөрүү бас гарч байгаа гэдэг тайлбараа манай Сангийн яамныхан бас иргэдээ нэг зөв өгчих хэрэгтэй. Тоо зөв байвал, тэгээд бас анхнаасаа л юм тодорхой явчихвал цаашдаа асуудал, маргаан ч юм уу үүсэхгүй шүү дээ. Би тэрийг л ингээд тодотгож та нар асуугаад байгаа юм. Тэрнээс биш буруу зөрүүгийн тухай энд асуудал байхгүй шүү дээ. Зүгээр мэдээлэл, тоо зөв байж байж цаашаа бодлого зөв явна гэдэг үүднээс асуудалд хандаж ярьж байгаа юм шүү. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр асуулт асууна.

Б.Баттөмөр: Ямар ч байсан энэ орж ирж байгаа төсвийн хүрээний мэдэгдэлд хэд хэдэн өөрчлөлтүүд орсон байна. Энэ өөрчлөлт бол орж болно л доо. Урагшаагаа харж хөгжил рүүгээ харсан татварын орлогын хэмжээг бас бага ч гэсэн нэмэгдүүлээд ороод ирж байгааг бол би зөв гэж ингэж ойлгож байгаа юм.

Энэ яах вэ дээ, орлого бол 1.6 их наядаар, зарлага 1.3 их наядаар нэмэгдэж орж ирж байгаа юм. Энэ Засгийн газрын

өрийн хэмжээ энэ жил чинь нэг 28.2 их наяд төгрөг байгаа шүү дээ. Тэгээд 35.4 болж байна л даа. Тэгээд энэ дээр ханшийн зөрүү, ханшийн уналтаас хэчнээн хэмжээний өсөлт гарч ирж байна?

Хоёрдугаарт, хэд нь ямар хэмжээний мөнгө гаднаас авах гээд байна юм? Энэ дээр ялгаж тайлбарлаж өгөөч гэсэн эхний асуулт байна.

Тэгээд ер нь бол яах вэ дээ, бид нар бол Монгол Улсын эдийн засаг байгаа боломжийг бол их гутранги л хараад байгаа юм л даа. Одоо ингээд энэ төсвийн хүрээний мэдэгдлийг үзээд цаашдаа дунд хугацаанд гээд тэгэхэд ер нь Монгол Улсын төсвийн орлого олигтой нэмэгдэхгүй байна. Монгол Улсын төсөвт, өөрөөр хэлбэл төсөвт ер нь тийм бодитой хуримтлал бий болохгүй байна. Тэгээд л ийм өлөн зөмөн тэгээд л 1 жилд хэдэн төгрөг ойрх жижиг мөнгө олоод л тэрийгээ нэг гандангийн тагтаа нарт будаа тарааж байгаа юм шиг ингээд л. Ингэж болохгүй нөхдүүд минь. Манай Сангийн яамныхан Хөгжлийн яам байгуулагдаад энэ далд эдийн засаг гэдэг үгийг хэлж сурч байгаад би их баярлаж байна. Энэ төсвийн баримт дотор ямар ч тоо байхгүй, тэгэхдээ далд эдийн засгийг ил болгоно гэсэн ганц тоо байна. Бүтээмж гэдэг үгийг хэлж сурч байгаад бас их баярлаж байна. Бүтээмж дээр ямар ч тоо байхгүй. Ийм л байгаа шүү дээ. Энэ жилийн энэ 5 хувийн эдийн засгийн өсөлт дотор тэр далд эдийн засгаас орж ирж байгаа мөнгөний хэмжээгээр өсөх өсөлт нь хэдэн хувь байна? Бүтээмжээс бий болох хүсэлт нь хэд юм? Энэ 2 тоог хэлээч.

Энэ нүүрсийг бол энэ тогтворжуулсан үнэ нь, тэнцвэржүүлсэн үнэ нь 110.8 доллароор 1 тонныг нь худалдах юм байна л даа. Энэ Хятадын Жин тан гээд боомтоор 7 дугаар сард 439 доллар 1 тонн нүүрс, 8 дугаар сард 347-гоор буурсан байна. 9, 10 дугаар сард

өсөж байгаа гэсэн мэдээллүүд бол байна. Би 110-аар тооцсон байна. Тэгээд яах вэ, урд талын юуг бол яах вэ, урд талын тоог бол жоохон нэмэгдүүлж орж ирж. Үгүй, энийг яагаад 110 гэж байна? Энэнээс илүү нэмэх боломжууд байгаа шүү дээ. Зэсийн үнийг 8400 доллар гэсэн байна. Энэ чинь тэр шинжээчид чинь бол энэ дөнгөж 23 онд гараад энэ зэсийн чинь үнэ нэмэгдэнэ. 11 мянган доллар хүрнэ гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ орлого талдаа бол дайчлах юм бол их тааруухан л яваад байна даа. Энийг та нар юу гэж үзэж байгаа юм?

Тэгээд би бол ямар санал хэлэх гэж байгаа юм бол энэ хасах зардлууд бол их байна. Энэ халамжтай холбоотой зардлуудынхаа тэрийг зам засна гэдэг нэг соёлын төв, өргөтгөл гээд. Ингээд энэ 2023 оны төсвийг алдагдалгүй хасчихвал яасан юм? Анх удаа энэ 30 жилийн хугацаанд анх удаа нэг алдагдалгүй болсон. Энэний цаад талд бол юу гэхээр инфляц тогтворжино, ханшийн уналт зогсоно. Тэр Английн туршлага байна шүү дээ. Фунтыг яаж уналтыг яаж аварч байна? Ийм саналыг би хэлэх гэж байгаа юм. Энийг та нар үзээч гэсэн ийм саналыг та нар хэлье. Дээр нь бол юу гэхлээр зэрэг 11 тэрбум доллар орж ирнэ. 2019 оны түвшинд хүргэнэ гэж. 2019 онд чинь 7.2 тэрбум доллар орж ирсэн байгаа юм.

Т.Аюурсайхан: Сангийн яам, 80 дугаар микрофон дээр.

Ж.Ганбат: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. 2022 оны байдлаар бол Засгийн газрын өр бол 28 их наяд байгаа. Энэ дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ нь 50.1 хувь. Энэ нь бол ирэх жил бид нар 34 болж нэмэгдэж байгаа нь бол ханшийн нөлөөлөл байгаа. Мөн олон улсын байгууллагаас авах хөтөлбөрийн зээлээс бас нэмэгдэхээр хөтөлбөрийн зээлээс 1 их наяд төгрөг, гадаад төслийн зээлийн ашиглалтаар 0.9 их наядар нэмэгдэхээр байгаа. Энэний нөлөөллөөр бол нэмэгдэж

бол энэ 34 бол төсвийн хүрээний мэдэгдэл дээр бол 35 болж бол ингэж тусгагдаж байгаа гэдгийг энэ дор хэлье.

Далд эдийн засагтай холбоотойгоор далд эдийн засгийг бууруулах чиглэлээр бол бид нар бараа бүтээгдэхүүн, ашигт малтмалын үйлдвэрлэл, борлуулалт, импорт, экспортын үе шатууд, цахим төлбөрийн баримт, гаалийн мэдүүлэг, гаалийн лабораторийн дүгнэлтэд үндэслэн татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, бүртгэлтэй холбоотойгоор бол бид нэлээн ажлуудыг хийж байгаа.

Ер нь бол гол манай далд эдийн засаг бол ерөнхийдөө уул уурхайн салбар дээр бид нар байгаа гэж үзэж байгаа. Энэ дээрээ бид нэлээн ажлуудыг бол татвар, гааль манай Сангийн яамны харьяанд байдаг Санхүүгийн мэдээллийн төв дээр бол хамтарч энэ ажлуудыг ингэж хийж байгаа. Энэний хүрээндээ бид ирэх жил бол далд эдийн засгийг бууруулах байдлаар 200 тэрбум төгрөгийн орлогыг бол нэмж олно гэдэг ийм байдлаар бол тооцоолол дээрээ, төсөв дээрээ бол тусгаж бол орж ирсэн байгаа.

Т.Аюурсайхан: 81 дүгээр микрофон дээр Наранцогт дарга нэмж хариулъя.

С.Наранцогт: Баттөмөр гишүүний асуултад нэмж бас тодруулж хариулъя. Таны хэлсэнчлэн яах вэ, бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийн асуудал байгаа юм. Жоохон бага авсан болов уу гээд. Яах вэ, одоо бол энэ инфляцаас болоод дэлхийн улс орнууд голлох эдийн засгууд бүгдээрээ бодлогын хүүгээ нэмэгдсэн. Энэнээс үүдээд мэдээж хэрэг эдийн засгийн хувьд бол өсөлтийн хувьд бэрхшээл үзээд, тэгээд ер нь түүхий эдийн эрэлт буурах гэсэн ийм олон улсын төсөөллүүд гарч ирж байгаа юм. Энэнээс үндэслэж бол бид нар бас их өөдрөг төсөөлөх бололцоогүй байсан гэдэг зүйлийг бас хэлье.

Далд эдийн засгийн хувьд бас Ганбат дарга ярилаа. Энэ гол юм бол уул уурхайн дээр бол жишээлбэл 40 хувийн далд эдийн засаг явж байгаа. Энийг илрүүлж, ил болгох тал дээр саяын Ганбат дарга хэлсэн зүйлүүд хийгдэж байгаа. Дээр нь нэмээд бид хэд, та төсвийн хүрээний мэдэгдэлд орсон энэ орлого дээр харахад НӨАТ бол ирэх онд 30 хувиар нэмэгдэнэ гэж. Өөрөөр хэлбэл НӨАТ-ын хамралт ингэж нэмэгдэнэ гэдэг маань бодит эдийн засгийнхаа өсөлтөөс бараг 2 дахин илүү нэмэгдэнэ. Тэр хэмжээгээр бол далд эдийн засаг багасна гэсэн үг. Бүтээмжийн хувьд бол бид нарын зохион байгуулалтын арга хэмжээн дээр аваад төрийн өмчит, ялангуяа уул уурхайн компаниудын бүтээмжийг бол нэмэгдүүлэх чиглэл дээр тодорхой ажлууд хийгдэж байгаа. Тооцооллын хувьд бол тантай санал нэг байна. Бид энд бүтээмж гэдэг зүйлүүдийг анхаарч бас тодорхой арга хэрэгслүүд дээр ажиллаж эхэлж байгаа. Тэгээд энийг бол сайжруулаад яг бас жил жилд бүтээмжээ яаж нэмэгдүүлэх вэ, хэр хэмжээний өсөлтийн тооцоололд бүрдүүлэх үү гэдэг зүйлийг бас нарийвчилсан тоогоор гарч ирэх боломжтой болох ийм учиртай.

Т.Аюурсайхан: Баттөмөр гишүүнд 1 минут өгье.

Б.Баттөмөр: Энэ Монгол Улсын Ерөнхий сайдын энэ хэлсэн үг байгаа шүү дээ. Монгол Улсын далд эдийн засгийн хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүн одоо тэнцүү хэмжээнд. Энэ жилийн 23 оны дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээний 54 орчим их наяд төгрөг байгаа шүү дээ. 200 тэрбум төгрөгийг далд эдийн засгаас олно гэдэг бол 1 хувь ч хүрэхгүй л юм байна л даа. Тэгээд ингээд далд эдийн засаг гэдэг юмтай бол тэмцэхгүйгээр Монгол Улс хөгжихгүй, төсөвт мөнгө орохгүй. Ганбат даргаа та энийгээ та нар нэмэх хэрэгтэй шүү. Би Төсвийн байнгын хорооны энэ ажлын хэсэгт орж ажиллаж байгаа. Энэ дээрээ та нар зоригтой тоо тавьж

ажиллахгүй бол энэ төсөв дээр чинь бид нар бол хатуу ярина шүү. Энийг өнөөдөр хэлчихье гэж бодож байгаа юм.

Энэ Оюу толгой төслөөс Монгол Улсын эдийн засагт эдийн засгийн өсөлт, энэ татварын орлого тэр 19.8 их наяд төгрөгт энэ өгөөж ямар юм байна? Тэр яах вэ, татвар охор хэдэн төгрөг орж байгаа. Тэр 34 хувийг нь өгөөжөөс бид нар.../минут дуусав./

Т.Аюурсайхан: 80 дээр Ганбат дарга тодорхой хариулаарай. 84 дүгээр микрофон өгье.

Б.Тэлмүүн: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Баттөмөр гишүүний асуултад хариулья. Далд эдийн засгийн хувьд Үндэсний статистикийн хорооноос бол 5 жил тутам судалгаа хийдэг. Энэ жилийн хувьд бол хамгийн сүүлийн судалгаа бол одоо хийгдэж байгаа гэсэн мэдээлэлтэй байгаа. 2018 оны байдлаар хийсэн далд эдийн засгийн судалгаа 2020 онд гарахад нийт 9.5 хувьтай гэсэн ийм дүгнэлт гарсан байгаа.

Мөн Монгол Улсын далд эдийн засгийг хэмжсэн хамгийн сүүлийн үеийн судалгаа бол 19 онд гарсан байдаг юм. Далд эдийн засгийг ил болгох чиглэлээр бол олон улсын судалгаа гарсан. Энэ судалгаагаар бол Монгол Улсын далд эдийн засгийн хэмжээг бол 14.5 хувьтай гэж дүгнэсэн байгаа. Бид нар бол жил болгоны төсөв дээр далд эдийн засгийг бууруулах, ялангуяа уул уурхайн экспорттой холбоотойгоороо далд эдийн засгийг бууруулах, ашигт малтмалаас орлогоо бүрэн авах чиглэлээр бол үе шаттай ажлууд бол хийгдэж байгаа.

Тэгээд бид нар өнгөрсөн жилүүдийн хувьд бол жил болгон бол 200 гаруй.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Баттөмөр гишүүнд 1 минут нэмж өгье.

Б.Батгөмөр: 9.5 хувийн далд эдийн засагтай байсан бол Ерөнхий сайд худлаа ярьсан юм байна л даа. Ерөнхий сайдаасаа энэ талаар асууж тодруулаарай. Ямар тоо хэлчихсэн юм бэ? Энэ Дэлхийн банкны гаргасан судалгаагаар байж байгаа шүү дээ. 40 хувь, 40-50 хувийн далд эдийн засаг байна гээд. Энэ далд эдийн засаг дээрээ та нар энэ тоогоо нэгтгэж, энэ зорилго, энэ ажлаа нэгтгэж үзэхгүй бол хамаг боломж чинь энд яваад байгаа шүү дээ. Алдагдсан боломж чинь энд яваад байгаа шүү дээ. Энийгээ үзээрэй. Маш их хэмжээтэй байгаа. Би бол Ерөнхий сайдтай санал нэг байгаа. 1 дахин их. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн. Тэр 44 орчим их наяд төгрөг байх үед эрхэлсэн тоо шүү. Тийм учраас энэ дээрээ тэр нэгтгэж байгаарай. Дэлхийн банкны хийсэн судалгаа байгаа. Ер нь энэ далд эдийн засгийн юмыг бол маш сайн судалж, энэ дээр тодорхой арга хэмжээ авахгүй бол болохгүй шүү.

Т.Аюурсайхан: Тоо баримтаа сайн нягталж, үнэн бодит мэдээлэл өг гэдэг шүүмжлэлийг хэлж байна. Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан асуулт асууна.

Ц.Туваан: 23 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт орж байгаа. Тэгээд энэ дээр бол энэ хөрөнгө оруулалтыг бол 0 гэж орж ирж байгаа. Тэгэхээр энэ бол яах вэ, нэг талдаа өмнө нь явж байсан энэ он дамжиж, шилжих хөрөнгө оруулалтуудаа гүйцээх гээд ингээд тайлбарлаж байгаа. Тэгэхдээ л ер нь бол мэдээж шаардлагатай хөрөнгө оруулалтууд байсан уу, байгаа юу гэвэл байгаа. Тэгэхээр энийг 24, 25 оны төсвийн хүрээний мэдэгдэлтэй хөрөнгө оруулалт яг орж ирэх үү? Энэ дээр нэг тодорхой хариулт авъя.

Хоёрдугаарт нь энэ гол, салбар маань энэ хөдөө аж ахуйн салбар. Ялангуяа энэ хямралтай байгаа энэ цаг хугацаанд бол ард түмнийг бол хүнсээр аюулгүй, найдвартай хангаж байх ёстой. Тэгэхээр энэ хөдөө аж ахуйн салбар дээр

явж байгаа бодлогууд дотор бол зөрчилтэй 2 зүйл орж ирж байгаа. Нэг нь бол энэ хөдөө аж ахуйн салбар бол дэлхийд ч тэр, хаана ч тэр татаас өгч байж, дэмжиж байж явдаг ийм хоол ундаа дэмждэг ийм бодлого явдаг. Тэгэхээр энэ жилийн төсөв дээр, 23 оны төсөв дээр гэхэд хөдөө аж ахуйд олгох урамшууллын хэмжээ 44 тэр бум төгрөг болоод ингээд буураад ороод ирчихсэн. Энийг цаашдаа яаж явуулах вэ, бодлого нь яаж явах юм, нэмэгдүүлэх үү, яах вэ?

Хоёрдугаарт, Хөдөө аж ахуйн яамныхан бас ажлын хэсэгт байгаа байх. Энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар Улсын Их Хурлын төлөвлөгөөг тогтоолоор баталсан. Ирэх жилийн төсөв дээр 228 тэрбум төгрөг гээд тавьсан гээд байгаа юм. Энэний задаргааг нэг хэлээд өгөөч. Би бол бас сайн ойлгохгүй байгаа юм. Тэгээд цаашдаа энэ чинь өөрөө 1.7 их наядын шаардсан энэ хөтөлбөр байгаа, төсөл байгаа. Тэгэхээр энийг цаашдаа хэдэн жилийн хугацаанд жил жилд энэ төсвүүд дээр хэдээр тусгаж явуулах юм бэ? Энэ талаараа Хөдөө аж ахуйн яам, Сангийн яамтайгаа нэг бодолтой байгаа юу гэдэг ийм асуултыг асууя.

Хоёрдугаарт нь энэ бид нар өөрсдөө нэг юм хийгээд, ингээд тэрийгээ цааш нь үргэлжлүүлдэггүй хаядгийн хамгийн тод жишээ нь Дарханы арьс ширний цогцолбор. Хувийн хэвшлийнхэн хийгээд бүх асуудлууд нь, сая манай гишүүд явж ирээд ярьж байна лээ. Бүх асуудлуудын зарим хувь нь бараг 100 хувь хийчихсэн байгаа энэ төслөө зогсоогоод, зэрэгцүүлээд төрийн гээд нэг юм хийж байгаа юм. Ингэхээр чинь дараа энэ хувийн хэвшлийнхэн чинь ямар зориг гаргаж, энэ хөдөө аж ахуй, бусад салбарууд руу ингэж хөрөнгө оруулалт хийх юм бэ? Тэгэхээр энэ дээр ирэх жилийн Төсвийн төсөөлөлд, Төсвийн хүрээний мэдэгдэл дээр ямар байдлаар тусгаж байгаа вэ гэсэн ийм тодорхой асуултуудад хариулт авъя.

Т.Аюурсайхан: Эхлээд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Жамбалцэрэн дарга хариульж тийм ээ? 96 дугаар микрофон. 1 дүгээр индэр.

Т.Жамбалцэрэн: Туваан гишүүний асуултад хариульж. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн. Хүнсний хангамж, аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөнтэйг хэрэгжүүлэхтэй холбоотой Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас төсвийн саналыг 510 тэрбумаар өгсөн. Ирэх онд хөрөнгө оруулалт дээр нэмэгдэл зардал тавигдаагүй учраас 228 тэрбум төгрөгийн төсвийг тавьсан. Үүнтэй холбоотой хүнсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд арилжааны банкны болон бусад санхүүжилтийн эх үүсвэрээс бид нар хөрөнгө босгоно гэж үзэж байгаа. Үүнтэй холбоотой хүүгийн хөнгөлөлт, татаас урамшуулалд 138.2 тэрбум төгрөгийг тусгасан. Салбарын урсгал үйл ажиллагааны зардал дээр 89.9 тэрбум төгрөгөөр хянагдсан байгаа. Үүнийг задаргаагаар нь хүнсний үйлдвэрийг хөгжүүлэхэд 127 сая, мал аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд 4 тэрбум төгрөг, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээн дээр 41 тэрбум, газар тариалангийн салбарыг хөгжүүлэх дээр 39.9 тэрбум, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, хоршоог хөгжүүлэх дээр 2 тэрбум, хөдөө аж ахуйн газар, газар тариалан, аж үйлдвэр хөгжүүлэх судалгаа шинжилгээний ажил дээр 2.1 тэрбум төгрөг тавьсан байгаа. Мөн Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын багцад энэ чиглэлээр судалгаа шинжилгээний зардал дээр 1.9 тэрбум төгрөгийн төсвийг суугдаж өгсөн байгаа.

Дарханы арьс ширний цогцолбортой холбоотой асуудал дээр бол улсын төсөв дээр энэ дээр мөнгө төгрөг тавигдсан зүйл байхгүй. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай хийгдэж байгаа аж ахуй нэгжтэй холбоотой

асуудал энэ хууль хяналтын байгууллага дээр хянагдаад явж байгаа. Төрийн өмчит компанийн хувьд техник эдийн засгийн үндэслэл болон холбогдох судалгаа шинжилгээний ажлууд бол хийгдсэн. Хөрөнгө оруулалтын ажил дээр бол хөрөнгө мөнгө төсөвлөгдөөгүй ийм дүнтэй байна.

Т.Аюурсайхан: Тийм үү? Туваан гишүүнд 1 минут өгье.

Ц.Туваан: Тэр задаргаа чинь ингээд өмнөх жилүүдийн төсвүүд дээр яг энэ салбарууд дээр орсон төсвүүдтэй харьцуулсан задаргааг надад нэг өгчхөөрэй Жамбалцэрэн дарга. Энэ нэг л тийм, яг л өмнөх юмаа задлаад өгчхөж байгаа юм шиг ингэж харагдаж байгаа юм.

Хоёрдугаарт, энэ Сангийн яамных нь түрүүний асуултууд дээр нөгөө 24, 25 оны төсвийн төсөөлөл дээрээ хариулт авъя. Дээрээс нь цалин тэтгэвэр яаж орж ирж байгаа юм 24, 25 дээр? Ирэх жилийнх дээр бол төрийн албан хаагчдын, орон нутагт ажиллаж байгаа төрийн албаны төрийн ТЗ-гийн ажилчид дээр 20 хувь гээд байгаа. Орон нутгийн төсвөөс 80 хувь гээд байгаа. Тэгээд энийг нэг ойлгомжтой бас тайлбарлаад өгчихмөөр байна. Орон нутгийн нэмэгдэл гэж ингэж орж ирж байгаа. Хэдэн тэрбум төгрөг суусан юм бэ гэдэг? Энэ жоохон төсөв рүү орж байгаа байх. Тэгэхдээ боломжтой бол хариулт авчихъя.

Т.Аюурсайхан: 80 дээр Сангийн яам хариульж. 82 дугаар микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариульж. Ирэх жил бол бид нар төрийн албан хаагчийн цалингийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд өмнө нь эхлүүлсэн эрүүл мэнд, боловсрол дээр хэрэгжүүлж эхэлж байгаа гүйцэтгэлээр нь буюу хийсэн бүтээсэн бүтээмжээс шалтгаалан цалин хөлс нэмэгдүүлэх боломжийг бол

мөн төрийн захиргааны байгууллагууд дээр болон биеийн тамир, спортын салбарууд дээр бол оруулж ирэхээр бол хичээж ажиллаж байна. Мөн хот хөдөөгийн тэнцвэртэй байдлыг хадгалах хүрээнд бол төрийн албан хаагчийн цалин хөлсний тогтолцоонд бол бид нар орон нутгийн нэмэгдэл гэдэг ойлголтыг бол өмнө нь авч байгаагүй төрийн захиргаан дээр бол шинээр бол оруулж ирж байгаа.

2023 оны төсвийн дээр бол бид бол орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид дээр бол 20 хувийн нэмэгдлийг бол тооцож бол суурь зардал дээр нь бол тусгасан байгаа. Мөн аймаг бол тухайн аймаг нь бол эдийн засаг нь идэвхжээд, компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн нарын урилгаар Хөвсгөл аймгийн ахмад багш нарын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүн Төмөртогтоогийн Энхтүвшин асуулт асууна.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Бид бол энэ төсвийн хүрээний мэдэгдлийг 2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийг 22 оны 5 сарын 27-ны өдрөөр бол 23 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 24, 25 оны төсвийн төсөөллийг ингэж баталсан байж байгаа. Тэгээд нийтдээ ийм бас 9 үзүүлэлт баталсан л даа. Тэгээд яг одоогийн байдлаар ингээд 7 үзүүлэлтэд өөрчлөлт оруулъя гэдэг ийм санал төсвийн хүрээний мэдэгдэл дээр орж ирж байна. Тэгээд ингээд байн байн өөрчлөгдөөд байх юм бол бид нар энийг 5 сард хуралдаад батлах шаардлага байсан юм болов уу? Энэ нөгөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд чинь

ер нь нийцэж байгаа юм уу, нийцэхгүй байгаа юм уу? Нэг мөр юу гэдэг юм, бид нар 9 сард төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг 23, 24, 25 оны төсөөллөө батлаад явбал илүү их үр дүнтэй юм биш үү гэдэг ийм бодол төрж байна. Энэ дээр нэгдүгээрт нэг хариулт авъя.

Хоёр дахь асуудал бол энэ, бид нар энэ дотоодын үйлдвэрлэлүүдээ их сайн дэмжих ёстой юм байна лээ. Манай Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр дээр байж байгаа. Нэмүү өртөг шингэсэн ажлын байрыг нэмэгдүүлсэн ийм боловсруулах болон баяжуулах үйлдвэрүүдийг бий болгоно, уул уурхайн бүтээгдэхүүнээ аль болохоор юу гэдэг юм түүхийгээр нь биш боловсруулж гаргана гээд ийм зорилтыг дэвшүүлчихсэн байж байгаа. Харамсалтай нь юу гэдэг юм АМНАТ-аас болоод нөгөө уул уурхайн бүтээгдэхүүнүүдийг чинь баяжуулдаг, боловсруулдаг үйлдвэрүүд чинь үндсэндээ хаагдаад дууслаа, дуусаж байна, Сая Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймаг, Орхон аймгаар бас ажиллаад ирсэн нэмүү өртөг шингэсэн зардлуудаас нь дэлхийн жишгээр шууд тооцож АМНАТ аваад байна. Үүнээс болоод бид нар хохирч байна. Дэлхийн жишиг бид нар юу гэдэг юм энэ боловсруулсан бүтээгдэхүүнээ зарж чадахгүй байна.. Бид бол дэлхийн жишгээс 30 хувь доогуур үнээр бараа бүтээгдэхүүнээ зарж байхад дэлхийн жишгээр тооцож АМНАТ аваад байна. Тийм учраас цаашид бол оршин тогтнох бололцоо, боломж алга гэдэг ийм асуудал байж байна.

Тийм учраас Сангийн яамныхан та хэд маань энд АМНАТ тооцдог аргачлалаа өөрчлөх хэрэгтэй байна. АМНАТ тооцдог аргачлалаа өөрчлөх хэрэгтэй байна. Яахаараа нэмүү өртөг шингэчихсэн юу гэдэг юм, гэрэл цахилгаан, цалин хөлс гээд өөр бусад зардалтай ус ч гэдэг юм уу, зардалтай холбоотой бүх зардлуудыг нь хасахгүйгээр АМНАТ тооцоод байдаг

юм? Яахаараа энэ дэлхийн жишгээр АМНАТ-ын үнийг тооцоод байдаг юм? Өнөөдөр Дарханд байж байгаа хорголжин тэжээл хийж байгаа төмрийн торголжин төмөр хийж байгаа үйлдвэр бол дэлхийн жишигт хүргэж тэр хорголжин төмрөө зарж чадахгүй шүү дээ. Ойлгомжтой шүү дээ. Тэгээд үүнээс чинь болоод маш олон хүмүүс ажилгүй болж байна, маш олон компаниуд хаалгаа барьж байна. Жонш, төмөр, бусад төрлийн энэ баяжуулах болон боловсруулах үйлдвэрүүд чинь. Тэгэхээр бид нар өөрсдөө ингээд мөрийн хөтөлбөртөө их сайхан юм дэвшүүлчхээд, яг бодит байдал дээр ингээд татвараар дарамталж энэ аж ахуйн нэгж байгууллагуудаа ингээд татаж унагаж байгаа юм байна лээ шүү.

Тийм учраас бид нар энэ аль болохоор үндэсний үйлдвэрлэлүүдээ дэмжих, бага хүүтэй зээл өгөх, ялангуяа энэ уул уурхайн бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгож байгаа энэ үйлдвэрүүдээ энэ АМНАТ-аар нь дэмжээд явах нь бол хамгийн чухал юм билээ шүү. АМНАТ-ыг бол бүр больчих гэж байгаа юм биш юм байна лээ. Аргачлалаа жоохон өөрчлөөд, бодитой тооцоод яваач гэдэг ийм асуудлыг бас ярьж байна. Тийм учраас энэ АМНАТ бол юу гэдэг юм Монголын нийт төсвийн орлогын 12.7 хувийг бол бүрдүүлдэг юм байна. Тэгээд нээх айхтар буурчихгүй байх. АМНАТ гэдэг бол өөрөө ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр байдаг. Ашигт малтмалын нөөцийг бол уул уурхайн “А” лицензтэй компани л олборлодог. Энэ компаниуд л юу гэдэг юм АМНАТ-аа төлөөд явах ёстой. Тийм учраас энэ дээр та хэд маань бас нэг эргэж нэг хараач.

Т.Аюурсайхан: Сангийн яам 80 дугаар микрофон тийм ээ? Ганбат дарга.

Ж.Ганбат: Энхтүвшин гишүүний асуултад хариулья. Төсвийн хүрээний мэдэгдлийг бид өөрчилж оруулж ирж байгаа. Би бас өмнө нь хэлсэн

тайлбаруудаа давтаад хэлье. Ер нь бол төсвийн хүрээний мэдэгдлийг бид өөрчлөхгүй байх ёстой. Гэхдээ бол сүүлийн үеийн нөхцөл, гадаад нөхцөл байдлаас хамаараад, КОВИД-ын нөхцөл байдлаас хамаараад бас зайлшгүй өөрчлөгдөх нөхцөл байдлууд үүсэж байгаа юм. Бид 4 сард төсвийн хүрээний мэдэгдэл 3, 4 сард боловсруулаад 5 сарын 1-нд Улсын Их Хуралд өргөн бариад батлагдах үеийн нөхцөл байдал, одоогийн нөхцөл байдал 2-ыг харьцуулахад бас өөр нөхцөл байдал үүссэн учраас бид нар хаврын төсөөлж байснаас бид нар эерэг үзүүлэлтүүд гарсан учраас бид нар төсвийн хүрээний мэдэгдлийг бол өөрчилж бол оруулж ирсэн.

Ер нь бол цаашдаа бид аль болох л төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчлөхгүй. Төсвийн хүрээний мэдэгдлийнхээ хүрээнд үндэслэн төсвийн төслийг боловсруулж өргөн барьж байх энэ зарчим бол баримтална.

Дараачийнх нь бол боловсруулах, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрийг дэмжих АМНАТ-аар гээд. Энэ АМНАТ бол энэ дээр бас ийм 2 төрлийн ойлголт байгаад байгаа юм. АМНАТ бол байгалийн баялгийг шууд олборлоод, тэрийг борлуулаад ингээд а ж ахуйн нэгжүүд зарж байгаа. АМНАТ бол шууд энийг олборлосных нь төлөө борлуулалтын орлогоос нь шууд хуваарь авдаг бол ийм төрөлтэй. Өөрөөр хэлэх юм бол энэ бол тухайн ашигт малтмалын баялаг бол ард түмний баялаг, бид нар бол үүнийг аль болох л бид нар үр дүнтэй, үр ашигтай, эндээс татвар, төлбөр хураамжууд бол бүрэн авдаг ийм л байхыг зорьж байгаа юм.

Бид аль болох л олон улсын зах зээл дээр байгаа үнээр нь АМНАТ-ыг борлуулалтаас нь тооцож авна гэдэг ийм зарчим баримталж байгаа. Ер нь бол энэ ч зөв, бусад орнуудын жишгээр бол АМНАТ бол өөрөөр хэлэх юм бол тэр бизнес ашигтай байна уу, ашиггүйгээс үл

хамаараад тухайн байгалийн баялгийг олборлож байгаа хувьд төлж байгаа төлбөр байгаад байгаа юм. Тэгэх дээр бол бид үүнийг бол АМНАТ-ыг бол шууд борлуулалтын орлогоос нь ингэж хувиар тооцож бол авч байгаа. Энэ дээр бол яах вэ, олон улсын зах зээлийн үнэ, манайхны зарж байгаа үнэ хоёрын хооронд л зөрүүтэй асуудал бол байдаг. Ийм ч учраас бид бол жишиг үнийг гэдэг юм гаргаж ирдэг.

Нөгөө талдаа аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр бол бид харин тэр холбогдох зардлын юмнуудыг нь хасаж тооцоод ингээд бол явдаг ийм бол зарчимтай. Бид бол АМНАТ-ыг бол ингээд 2 янзын туйл байна. Нэг хэсэг нь бол байгалийн баялгаасаа авах ёстой. Энэ ард түмний баялгаасаа бүрэн татвар, төлбөр хураамжууд авахгүй байна гээд байдаг. Нөгөө талдаа нэг хэсэг нөхдүүд өндөр аваад байна гэдэг ийм 2 туйлын юм яригдаад байгаа. Бид бол яг л олон улсын зах зээл дээр тэр байгалийн баялаг ямар үнээр зарагдаж байна тэрнээс нь л бид нар хувиар нь тооцоод л, ингээд бол аваад явж байгаа ийм л зарчимтай юм байгаад байгаа юм. Энэ дээр бол яах вэ, тэр бизнес эрхэлж байгаа аж ахуй нэгжүүд өндөр авлаа гэдэг, нөгөө талдаа бол ард түмэн бол хямд үнээр зарж байна гээд ийм маргаан мэтгэлцээн үеийн үед л явж ирж байсан л даа.

Юун дээр бол, АМНАТ-ыг бол тооцохдоо бид нар жишиг үнийн арга гэдэг. Жишиг үнийг нь бол сар бол, бид нар олон улсын зах зээл дээрх үнийн мэдээллийг нь аваад, тэгээд энэ жишиг үнийнхээ мэдээллийг сар болгон зарлаад, тэр зарласан үнэ дээрээ үндэслээд АМНАТ-аа тооцож авч байгаа. Энэ дээр бол яах вэ, аж ахуйн нэгжүүдээс тавьсан саналын дагуу энэ ангиллыг нь илүү тодорхой болгооч, ойлгомжтой болгооч гэдэг хүсэлт тавьж байсны дагуу энийг нь энэ хавар бид энэ асуудлыг судалж үзээд энэ ангилал зэрэглэлийн юмнуудыг нь өөрсдөө боловсронгуй болгосон энэ шийдвэрийг бол Засгийн газраараа бол

бид батлуулж мөрдөөд хэрэгжүүлээд эхэлчихсэн байгаа. Тэх.

Т.Аюурсайхан: Энхтүвшин гишүүнд микрофон өгье. Асуултаа тодруулъя.

Т.Энхтүвшин: Би энэ хуулийг бид нар 5 сард баталсан л даа. 23 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 24 оны 24, 5 оны Төсвийн төсөөллийн тухай хууль. Энийг ер нь хуульдаа өөрчлөлт оруулаад 9 сард баталж байвал яасан юм бэ? Тэгвэл ингэж их өөрчлөлт орохгүй шүү дээ. Мэдээж 5 сард баталж байхаар чинь юу гэдэг юм, амьдрал баян гэдэгтэй адилхан 6, 7, 8, 9 саруудад бол нэлээн их өөрчлөлтүүд явагддаг. Ялангуяа манай улсын хувьд цаг агаарын байдал нь дулаараад борлуулалт өөрчлөлтүүд их хийгддэг. Тийм учраас энийг төсвийн хүрээний мэдэгдэлд төсөөллөө ер нь 9 сард баталж байвал яасан юм бэ? Энэ хууль эрх зүйд нь өөрчлөлт оруулаад явбал яасан юм бэ гэдэг ийм байр суурьтай байж байгаа. Тэгэх юм бол ингэж олон удаа өөрчлөгдөхгүй. Олон энэ хардлага сэрдлэг ингээд дагуулахгүй явах юм болов уу гэж бодож байгаа юм. АМНАТ-ын асуудал дээр бол та хэд эргэж нэг харна биз дээ. Ашигт малтмалын нөөц ашигласны татвар гэдэг бол “А” лицензтэй компанид л нөөцийг олборлодог шүү дээ. Тэндээс худалдаж авсан.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Санал хэллээ. Аубакир гишүүн алга байна. Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибал асуулт асууна.

Н.Ганибал: 23 оны төсвийн хүрээний мэдэгдэл, ер нь бид нар нэг ийм буруу жишгээр өнөөдрийг хүртэл яваад байгаа. Төсвөө дагуулаад баахан хууль оруулж ирдэг. Энэ төсөв маань Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрх Улсын Их Хурлын бүрэн эрх рүү бас халдаад ингээд явдаг ийм жишгээр сүүлийн 20 жил явж байгаа гэж байгаа юм. Тэгээд энийгээ ингээд засаач гээд өнгөрсөн жил бас

төсөв өргөн барихад дагуулаад орж ирж байгаа хуулиудаа эхлээд хуулиа баталчхаад хуулийнхаа хүрээнд төсвөө оруулж ирдэг энэ жишиг рүү оруулж ирэхгүй бол энэ нөгөө сахилга батын асуудал, төсвийн асуудлууд, энэ маань бүр сүүлдээ төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг өөрчилдөг төсөвтэй болоод ингээд жишиг маань бүр буруу тийшээ яваад эхэллээ л дээ. Тэгэхээр энэ асуудлууд дээр бол ер нь энэ төсвийн сахилга бат, цаашид авах арга хэмжээнүүд дээр ер нь бодох зайлшгүй энэ асуудал бол энэ шүү. Тэрнээс ямар нэгэн юм Их Хурлын гишүүд маань баталчхаад, тэгээд тэрийгээ төсөв дагуулж ингээд өөрчлөөд байдаг байх юм бол тэгээд Их Хуралд энэ хууль тогтоогоод бараг шаардлага байгаа ч юм уу?

Тэгээд ер нь 23 оны энэ хөрөнгө оруулалтыг энэ жил ер нь 5 их наяд болж байгаа шүү дээ тийм ээ? Төсөв дээр энэ түүхэндээ байхгүй төсвийн хөрөнгө оруулалттай он жил гэж байгаа юм. Тэгэхдээ шинэ зүйл байхгүй. Эргээд энэ юуг хэлээд байна вэ гэхээрээ нөгөө зарлагдсан тендерүүд, тэгээд хариуцлагагүй компаниуд, буруу төлөвлөлт, энэнийхээ төлбөрийг төлж байгаа ийм төсөв бид нар батлаад оруулж ирлээ. Тэгээд олон зэрэг, олон байгууламжууд ашиглалтад орох байх гэсэн ийм горьдлоготой л даа. Тэгэхдээ энэ бүтэх үү, үгүй юу гэдэг бол бас цаг хугацааны асуудал байх. Тэгэхээр энэ дээр бас зөв төлөвлөлт яваагүйгээс болж байгаа ийм хохирол амссан ийм төсөв болж байгаа.

Ер нь олон байшин барилга бариад зэрэг ашиглалтад оруулахаасаа илүү Монгол Ардын намынхан маань сонгуулийн үед өрийг Монголын ард түмэн өргүй болгоно гэдэг ийм амралтаар улс төр хийгээд өнөөдөр ингээд 62-уулаа сууж байгаа. Тэр өр багасгах ажил дээрээ анхаарлаа хандуулах юм бол магадгүй та бүхнийг эргээд сонгох Монголын сонгогч нар байж магадгүй шүү. Тэрнээс өнөөдөр

150 сая төгрөгийн өртэй байсан. Өргүй болгоно гэж орж ирчхээд 30 сая төгрөгийн өртэй болгочоод эргээд зээл авна гээд төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг өөрчлөөд явж байна гэдэг чинь бол бүр амралтаасаа бүр илүү олон дахин ухарсан ийм зүйл болох гээд байна гэдгийг бас анхааруулчихъя.

Тэгээд энэ хөдөө аж ахуйн сайд ер нь хаа байна? Сайд болсноосоо хойш орж ирэхгүй байх хэдэн үг захих гээд байдаг. Гадаадад яваад байгаа юм билээ. Одоо энэ махны экспортын хөөцөлдөөд явж байгаа гэж найдъя даа. Дэд сайдыг нь ч яах вэ, улс төрийн шалтгаанаар бариад хорьчихлоо. Одоо Төрийн нарийн өнөөдөр орж ирсэн байна. Энэ баруун аймгууд хэцүү байна. Баруун аймгуудад өвөлжилт хэцүү байна, тэнд малчид зээл авч чадахгүй байна, мал нь тарга тэвээрэг алга байна, өвс тэжээлээ авах мөнгөгүй байна. Зүүн аймгуудад өвс тэжээл байна. Газар тариалангийн бүс нутгуудад тэжээлийн таримлуудаа хураачихлаа, тэрийгээ зарж борлуулах аргаа олохгүй байна. Энэ төр энэ холбооснуудыг нь хийж өгмөөр байна. Яг хаана нь юу нь хэрэгтэй байгаа тэр холбооснуудыг нь хийгээд ингээд энэ дотор нь эргэлдүүлэх энэ өвөлжилтийн нь бэлтгэл ажлыг хангуулахгүй бол эргээд төсөв дээр орох орлого маань багасна. Хавар хэрвээ энэ арга хэмжээнүүдээ авч чадахгүй бол нэлээн малын хорогдолтой болно. Эргээд малчид асуудал үүснэ. Хэрвээ зөв зохион байгуулаад махны экспортоо гаргаж чадах юм бол төсвийн орлого нэмэгдэнэ, та бүхэн бас ашигтай төсөв гаргаж болно. Энэ асуудлуудаа яримаар байх юм. Тэгээд хэнтэй нь ярих юм? Энэ асуудал.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Цэндийн Сандаг-Очир нарын урилгаар Багануур дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийн төвийн бизнес эрхлэгчид, Социал Демократ Монголын эмэгтэйчүүдийн холбооны тэргүүлэгчид Улсын Их

Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Сангийн яам хариулъя. 80 дугаар микрофон.

Ж.Ганбат: Асуултад хариулъя. Төсвийг боловсруулах төсвийг өргөн барихдаа бол тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд боловсруулж ингэж өргөн барьдаг байгаа. Нэг дэх зарчим нь. 2 дахь нь бол аливаа нэгэн хуулийн өөрчлөлтийг хийх бол төсвөө дагалдуулж өргөн барьж ингэж хэлэлцүүлдэг ийм бол зарчим дээрээ үндэслэж, ер нь ингэж л явж ирсэн. Ийм л зарчимтай, хууль эрх зүйн хувьд. Энэ зарчмынхаа хүрээнд л бид төсвийн төслийг боловсруулж ингэж төсөв дагалдуулсан, холбогдох өөрчлөлтийн хуулиудыг нь өргөн барьсан байгаа Улсын Их Хуралд.

2023 онд бол шинэ хөрөнгө оруулалт бол байхгүй. Яах вэ, Улаанбаатар хотын түгжрэлтэй холбоотой хөрөнгө оруулалтууд бол тавьсан. Энэ бол бид гол зорилго нь бол яах вэ, их хэмжээний хөрөнгө оруулалт тавьчихад тэрийгээ үргэлжлүүлж орж ирсэн юм бас биш л дээ. Гол шалтгаан нь бол бид нар 2023 онд бид эдийн засгаа тогтворжуулах гэж байгаа. Энэ хүрээнд мөнгөний хатуу бодлого, төсвийн хатуу бодлогыг бид хэрэгжүүлэхээс ерөөсөө өөр аргагүй ийм нөхцөл байдалтай байгаа учраас эдийн засгаа тогтворжуулах зорилгоор бол ирэх жил шинэ хөрөнгө оруулалтыг бол тавиагүй орж ирсэн. Энэ оны хувьд бол шилжих хөрөнгө, нийтдээ бол улсын төсөв дээр бол 2.7 их наядын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг бид бол ирэх жил хэрэгжүүлнэ. Үүн дээр нэмэх нь өмнө жилүүдэд хийгдсэн концессын төлбөрийн 279 тэрбум гээд нийтдээ 2.9 их наядын шилжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг бид нар 2023 онд хэрэгжүүлэхээр ингэж тооцсон

байгаа. Хөдөө, аж ахуйн яамнаас үлдэгдлийг хариулна.

Т.Аюурсайхан: Жамбалцэрэн дарга, 96 дугаар микрофон 1 дүгээр индэр.

Т.Жамбалцэрэн: Хөдөө аж ахуйн сайд айлчлалтай явж байгаа. Ганибал гишүүний асуултад хариу хэлье. Болорчулуун сайд Улсын Их Хурлын даргын айлчлалын бүрэлдэхүүнд гадаад томилолттой ажиллаж байгаа. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар гаргаад ажиллаж байгаа. Монгол Улсын Шадар сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар Улсын онцгой комиссоос өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр хамтарсан ажлын хэсэг орон нутагт ажиллаж байна. Салбарын яамны хувьд 7 хоног бүр аймгуудад чиглэл өгсний дагуу өвөлжилтийн бэлтгэлийг хангах чиглэлээр биелэлтийг хангуулан ажиллаж байгаа. Энэ жилийн тухайд бид нар 70 сая малыг өвөлжүүлж, 20 сая малыг эдийн засгийн эргэлтэд оруулах энэ ажлыг хийж байна. Мал, махны экспорт хийх ажлын хүрээнд 2020 оны 9 сарын 30-ны байдлаар 3300 орчим тонн махыг Казахстан, ОХУ, Япон, Аз руу, Иран, Хонг Конг, Узбекистан гэсэн улсуудад экспортолсон байна. Ойрын хугацаанд Зүүн өмнөд Азийн Тайланд, Вьетнамтай хорио цээрийн протокол, холбогдох гэрчилгээг тохироод 10 сарын 11 сардаа багтаад эхний экспортыг хийнэ гэж тооцоолж байна. Ойрх Дорнодын болон булангийн орнуудтай хорио цээрийн протоколыг тохирсон гэрчилгээгээ тохирч байна. Мөн экспортлох боломж, шинэ зах зээл бүрдэнэ гэж харж байна.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа асуулт асууна.

Ш.Адьяа: Өнөөдөр Монгол Улсын 23, 24 оны улсын төсвийг Улсын

Их Хурлаар хэлэлцэж байна. Шинэ хөрөнгө оруулалт байхгүй. Улс орны эдийн засгийн хүндэрсэн нөхцөл байдлаас улбаалж энэ төсвийн хөрөнгө оруулалтын асуудал нэлээн хүндэрсэн гэдэгтэй бид санал нэг байна. Энэ ингэхээс ч өөр арга байхгүй. Сангийн яам бас энэ хүнд нөхцөлд тодорхой зөв шийдэл олгох ийм арга хэмжээг зохион байгуулсан гэж би бодож байна. Тэгэхдээ энд ам, ажил 2 нь цаашдаа зөрж байна. Энэ хөрөнгө оруулалтын асуудлуудыг 22, 23 он дамжсан хөрөнгө оруулалтыг шийдэх асуудал дээр бүх төслүүдээ эрэмбэлнэ гэж Сангийн сайд Ардчилсан намын бүлгийг Сангийн яаман дээр аваачиж, төлөөллүүдтэй уулзаж хэлж байсан, хэлж байсан. Өнөөдөр Улаанбаатар хотын түгжрэлийг шийдэх асуудал дээр бүх анхаарлаа Засгийн газар, Улсын Их Хурал анхаарч байна. Энэ зөв байх энэ шийд. Түгжрэлийг бууруулах ёстой.

Гэтэл өнөөдөр Улсын Их Хурлын 50 гишүүн хөдөө орон нутгаас сонгогдсон, тэнд бас шийдэх ёстой олон асуудал байгаа. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан байгаль орчин, хүний эрүүл мэндтэй холбоотой энэ утааны асуудал дээр баруун бүс нутаг, Засгийн газрын мөрийн хөтөлбөрөөр Хөшөөтийн уурхайг түшиглэсэн сайжруулсан түлшний үйлдвэрийг байгуулна гэж 22, 23, 21 оны төсөв дээр бид хөрөнгө мөнгө тавиад энэ асуудлыг шийдэхийн төлөө баруун бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын 15 гишүүн энд их анхаарал хандуулж явсан. Энэ асуудал яагаад 24 он руу ордог юм бэ? Энэ хүний эрүүл мэндтэй холбоотой, энэ байгаль орчны холбоотой асуудлыг чинь яагаад эрэмбэлж хойшоо оруулж байгаа юм? Энэ дээр нэг хариулт авъя.

Ер нь өнөөдөр баруун 5 аймагт 300 гаруй мянган хүний эрх ашиг байна. Улаанбаатар хотод сая хүний эрх ашиг байдаг юм бол баруун аймаг чинь 300, 400 мянган хүний эрх ашиг байна Дээр нь өнөөдөр Монгол Улсын Засгийн газраас

байгаль орчин, агаар, хөрсний бохирдол, хүний эрүүл мэндийн төлөө бүх зүйлийг шийднэ гэж байгаа. Шинэ сэргэлтийн бодлого чинь ч ийм бодлого явуулж байгаа юм. Энэ дээр нэг хариулт авъя.

Дээр нь Наранцогт даргаас асуулт авна. Өнөөдөр улс орны орны эдийн засаг хүнд байдалд орсон, валютын хомсдол бий болсон, төгрөгийн хөрвөх чадвар муудсан энэ цаг нөхцөлд Эдийн засгийн яам зайлшгүй 2 асуудлыг шийдэх ёстой гэдэг дээр би Улсын Их Хурал дээр удаа дараа ярьж байгаа. Өнөөдөр гаднын хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниуд, гаднын хөрөнгө оруулалтаа газрын тосны компаниуд өнөөдөр Монгол Улсын банкаар мөнгөө оруулж ирэхгүй байна. Монголын баялгийг өнөөдөр хэдэн тэрбумаар гэрээ хийгээд зөөж гаргаж байгаа зөвхөн урсгал зардлаа Монгол Улсын банкаар банк санхүүгийн байгууллагаар оруулж ирж цалин хөлс, бусад урсгал зардал, ийм их хэмжээний үр дүн бүхий ийм их хэмжээний валютыг уул уурхайн баялгийг зөөчхөөд яагаад Монгол Улсын банк санхүүгийн байгууллагаар оруулж ирж энэ валютын энэ хомсдолыг бууруулах гол хүчин зүйл болсон энэ асуудлыг хуулийн хүрээнд яагаад шийдэхгүй байна. Засгийн газар энэ Оюу толгойтой ярих юм байхгүй. Дээр нь тэр эс чи гээд Сабс Гоби /Sabs Gobi/ гээд тэр.../минут дуусав./

Т.Аюурсайхан: 80 дээрх Ганбат дарга хариулъя. 86 дээр үү? Чимэдсүрэн дарга уу?

Ч.Чимэдсүрэн: Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чимэдсүрэн. Адышаа гишүүний асуултад хариулъя. Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэсэн сайжруулсан шахмал түлштэй холбоотой үйлдвэрийн яагаад 24 он руу шилжүүлсэн бэ гэсэн асуудал байгаа. Тэгэхээр та түрүүн хэлсэн 23 он бол энэ хөрөнгө оруулалтын хувьд бол хамгийн их ачаалал өндөртэй жил байгаа. Зөвхөн шилжих хөрөнгийн хуулиараа

шилжиж байгаа дүн гэхэд 2.4 их наяд, тэгээд түүн дээр үнийн өсөлтийн 303, Монгол талын зайлшгүй нэмэгдэх ёстой 232, мөн түрүүний хэлсэн хотын түгжрэлтэй холбоотой 330 гэх мэтчилэн, мөн 22 онд хийгдчихсэн 2 удаагийн тодотголоор 840 тэрбумын өсөлттэй шилжих дүн бол ингээд 23 онд ирсэн ийм ачаалалтай байгаа. Тэгээд үүнтэй уялдуулаад дуусах хугацааг бол 24 хоног болгож бол өөрчилсөн. Гэхдээ энэ үйлдвэртэй холбоотой үнийн өсөлтийг бол авч төсөвт өртөгт бол нэмэгдүүлсэн байгаа. Тэгээд эдгээрийг хийж тооцохдоо бол төслийн хэрэгжилттэй бол холбож, гүйцэтгэлтэй нь бол уялдуулж бол шийдвэрлэсэн байгаа.

Т.Аюурсайхан: Адьшаа гишүүнд микрофон өгье.

Ш.Адьяа: Чимэдцэрэн чи ийм худлаа нэг өөрийгөө хамгаалсан юм битгий яриад бай. 21 оны төсвөөс та нар хэмнэлт гэж хойшоо татсан. 22 онд бүх зүйлийг дуусгана гэсэн. Зовлонг бид ойлгож байгаа. Гэтэл энэ юмаа эрэмбэлнэ гэсэн шүү дээ. Тэр агаар, хөрсний бохирдол тэр баруун бүсийн 400 мянган хүний эрүүл мэндтэй холбоотой, утаатай холбоотой асуудал яахаар энэ түгжрэлийн дараа бусад тэр хэдэн жил дамжаад ирсэн төсвийн чинь дараа ордог юм? Ийм юм ярихгүй шүү. Бид өнөөдөр та нар хариуцлага ярина, ажлаа хийнэ, юмыг эрэмбэлнэ гэж ингэж ярьдаг. Чи нэмээд дахиад тайлбар өгөөд байх. Би энэнтэй бүр нэлээн асуудал ярина. Танай Сангийн яаман дээр Сангийн сайд 1 газрын даргатайгаа надад өөр юм ярьсан. Гэтэл чи өөр юм ярьж байдаг. Сайд нь байхгүй болохоор ингэж ярьдаг юм уу? Ямар учиртай юм? Дээр нь Наранцогт даргаас тэр хариултаа авъя.

Т.Аюурсайхан: 81 дүгээр микрофон дээр Наранцогт дарга хариулъя.

С.Наранцогт: Адьшаа гишүүний асуултад хариулъя. Энэ төлбөрийн

тэнцэл муудсан, экспортоос орж ирэх бодит мөнгөн орлого буурсан асуудлыг бол бид нар бас судалсан, нэлээн авч үзсэн. Монголбанкны төлбөрийн системээр дамжуулаад энэ экспортлогч компаниудын экспорт чинь бодит тоо хэмжээ, Монгол Улсад оруулж ирж байгаа валют энэ дээр ингээд бас тодорхой хэмжээний зөрүүнүүд гарсан. Нэлээд том хэмжээтэй дүн гарсан ч асуудлууд байгаа. Тэгэхээр энэ дээр бол бид нар дүгнэлт хийгээд Засгийн газраас бол тодорхой тогтоол гаргуулж байгаа, гаргуулж ажиллаад эхэлсэн. Төрийн өмчийн компаниуд бол мэдээж хэрэг 100 хувь гаргасан, экспортолсон хэмжээгээрээ валютаа бол Монгол Улсад оруулж ирэх, тэгээд оруулж ирээд Монголбанканд тушаах энэ асуудал бол тогтоолоор үүрэг өгч байгаа. Хувийн секторуудын хувьд.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Адьшаа гишүүнд микрофон өгье.

Ш.Адьяа: Төрийн өмчийн компани бол Монголын төрийн өмч учраас ойлгож байгаа. Энэ гаднын хөрөнгө оруулагчдын өмнө энэ толгой бөхийлгөдгөө Монголын төр хэзээ болих юм? Энэ чинь хууль гаргаад зохицуулж яагаад болдоггүй юм? Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бол Монгол Улсын хуулийг мөрдөх ёстой, Монгол Улсын хуулийн хүрээнд өнөөдөр үйл ажиллагаа явуулах ёстой. Бид ийм хуулийн төслийг өргөн баривал Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам дэмжих үү? Энийг ард түмэн нэг хэлчихмээр байна.

Т.Аюурсайхан: 80 гүйцээгээд хариулъя Ганбат дарга, Сангийн яам. 81, Эдийн засаг хөгжлийн яам.

С.Наранцогт: Тэгэхээр хувийн хэвшлийн хувьд бол бид нар энэ нэлээд зөрүүд оруулсан компаниудын хувьд бол тэр татвараас зайлсхийх, ашиг шилжүүлэх гээд энэ олон улсын конвенцын дагуу бол бас татварын

шалгалт хийгээд явах ийм тухай заалт бол Засгийн газрын тогтоолд орсон байгаа. Бид бол татварын харилцаагаараа л ийм маягаар харилцахгүй бол сая бас энэ тодорхой гишүүнүүд, Оюунчимэг гишүүн бас ярьсан энэ гадаадын хөрөнгө оруулалтыг татах тухай асуудал, сая бас манай бондын өгөөж их нэмэгдээд явдаг асуудал бол энэ капитал контрол Монгол Улс хийгээд эхэллээ гэдэг мессеж бас буруу гарсантай холбоотой ийм зүйлүүд үүснэ.

Тэгэхээр бид хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалтыг татах, тэгээд мэдээж хэрэг хяналт шалгалтыг хийх асуудлыг балансалж л явахаас өөр арга байхгүй. Шууд ингээд бүх мөнгөө Монгол Улсын банкаар дамжуул гэдэг хатуу шаардлага бол бас их хатуу шаардлага. Энэ хөрөнгө оруулалтыг.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь асуулт асууна.

Ж.Батсуурь: Энэ төсөв хэлэлцэж байгаа үед олон зүйлийг бол ярьж болно. Тэгэхдээ олдож байгаа минутад бол тэр бүгдийг ярих боломжгүй учраас нэг зүйл дээр онцлон анхааруулж, асуулт буюу санал хэлье гэж бодож байна. Тэгээд би бас Амарбаясгалан сайдыг энд бас анхаарлаа хандуулж үзээч гэж ингэж бодож байгаа юм. Тэгэхээр сүүлийн15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийгээд харахад энэ гаднын зээл тусламжийн асуудал нэлээд анхаарал татдаг. Мэдээж энэ том агуулгаараа бол бас төрийн бодлого байдаг байх. Гэхдээ энэ зээл тусламж, буцалтгүй тусламжийн энэ төслүүдийн үр ашиг бол орон нутагт бол төсвийн хөрөнгө оруулалтаас хэд дахин доогуур, үр өгөөж муутай байдаг. Би энийг Байнгын хороо болон олон зүйл дээр ярьж байна. Тийм учраас Амарбаясгалан дарга яг энэ орон нутагт байгаа энэ өр зээлийн асуудлуудыг нэг татаж үзээч гэж үзэх гэж байгаа юм. Жишээ нь нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл ч гэдэг юм уу,

орон нутагт өөрсдийг нь хүсээгүй байхад нь гаднын зээл тусламжуудаар баахан хөрөнгө оруулалт хийдэг.

Тэгээд тэр нь зарим газрууд улсын комисс аваагүй байхад огт байхгүй болчихсон, огт байхгүй болчихсон. Жишээлэхэд, уурын зуухны шинэчлэх төсөл гэдэг юм уу, хот тохижилтын гэдэг юм уу, цэвэрлэх байгууламжийн төсөл ингээд хөрөнгө оруулалтын үр ашиг нь байхгүй. Улсын комисс аваагүй байхад нь тэр үр дүнгүй болоод дараагийн шинэчлэлүүд нь хийгдчихээд байхад өр үүсчхээд ингээд орон нутаг дээр бүр байхгүй зээл, байхгүй хүү төлөөд ингээд яваад байдаг. Энийг нэг тусгайлан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар анхаарч авч ирж, энэ орон нутаг дээр үүссэн эзэн биетгүй, тэгсэн мөртөө хүүтэй энэ зээлүүдийг тэглээч гэж хэлэх гээд. Тэглээч гэж. Бусад том стратегийн зээлүүд бол мэдээж Сангийн яаман дээр яригдаж байгаа. Бүх аймгууд дээр байж байгаа. Эзэн биет байхгүй зээлүүд. Тэгээд хүү төлөөд байдаг. Энэ жилээс, өнгөрсөн жилээс төсвийн татаас буюу мөн дэмжлэгээс нь хасаж суутгах замаар оролцсон.

Тэгэхлээр энэ чинь нөгөө чөтгөрийн гар гэдэг шиг эзэнгүй зээл, эзэнгүй хүү орон нутаг дээр өсөөд л байдаг. Тэгээд хэдэн жил ч явах юм билээ. Ингэсээр байж байгаад зээл нь хэд ч нугарах юм билээ. Тийм учраас энийг Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар бүр яг орон нутагтай холбоотой хэсгийг нь татаж аваад тэглэх юм уу, энэ тэр байтугай Хөгжлийн банкны саяхны зээлүүдийг янз бүрээс төрөөс тэглэе, барья, зөрүүг нь төлье энэ тэр гэж орж ирж байна шүү дээ.

Ер нь төсвийн тэнцлийг хангах, төслийн үр ашгийг сайжруулъя гэх юм бол зөвхөн улсын төсөвтэй зээлээ аваад, улсын төсөв дээрээ яриад хөрөнгө оруулалт хийх нь бол би хамаагүй ач тустай гэж ингэж үзэж байгаа юм. Жишээлэх юм бол нийтийн аж ахуйг

хөгжүүлэх зээл, дулааны станцын өргөтгөл гэж орж ирж байгаа юм. Түрүүнд Ганболд гишүүн яг үнэнийг хэлчихлээ. Хэд дахин үнэтэй, 5 дахин үнэтэй, 10 дахин үнэтэй зүйлийг гаднын зээл тусламжаар хийчихдэг. Ор үгүйгээс охинтой нь, зүгээр өгч байгаа юм. Үгүй бол олон жилийн зээл юм гэнэ лээ гээд авчихдаг. Тэр нь ямар ч үр өгөөж байхгүй. Дулааны станцын өргөтгөлийн зуухнуудыг тавьж байгаа тэр эх үүсвэрийг нь судлаад үзэнгүүт Хятадын зүгээр нэг захын үйлдвэрт, хямдхан үйлдвэрлүүлж авчраад Монголын хөдөөгийн аймгуудад шахаж байгаа шүү дээ. Энэ асуудлыг таслан зогсоомор байна. Энэ асуудлуудаас үүссэн олон жилийн энэ өр, авлагыг орон нутагт цэгцэлж өгмөөр байна гэсэн ийм асуулт байна. Цаашдаа энэ төсвийн үр ашгийг сайжруулах үүдэн дээр бол энэ тусламж зээл, хөнгөлөлттэй зээлүүдийг бол бас л онцгой анхаарахгүй бол төсвийн гадуур яваад.../минут дуусав./

Т.Аюурсайхан: 80 дугаар микрофон дээр Ганбат дарга хариулъя.

Ж.Ганбат: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Ер нь бол гадаад зээлийн ашиглалт, гадаад зээл тусламжаар авч хэрэгжүүлж байгаа энэ арга хэмжээнүүд төсөл, арга хэмжээг үр дүнтэй болгох асуудал бол чухал. Ер нь бол энэ асуудал яригдаж байгаа. Энэ хүрээнд бол Улсын Их Хурлаар энэ 5 сард батлагдсан өрийн стратеги дээр эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий Засгийн гадаад зээлийн эх үүсвэрийг авч ашиглаад, татгалзах гэсэн бодлого баримталчихсан байгаа. Нэг дэх нь энэ.

Хоёр дахь нь бол ер нь бол зээл, гадаад зээл аваад бид бол ингээд өмнө нь бол дамжуулан зээл байдлаар орон нутаг энэ тэрд бол өгөөд явдаг юмнууд байгаа.

Гэхдээ энэ дээр нэг хангалтгүй юм өнөөдрийг хүртэл явж ирсэн нь гадаад зээлийг аваад дамжуулан байдлаар орон нутаг ашиглагчаад тэрийгээ буцааж төлдөггүй ийм байдлууд бол байна л даа. Тэгэх дээр одоо нийтдээ ингээд яг аймгууд дээр орон нутаг дээр яг авч хэрэгжүүлсэн нийт яг өнөөдрийн байдлаар 208.5 тэрбум төгрөгийн дамжуулан зээлийн өрийн үлдэгдэл байна. Бид бол орон нутаг, энэ зээлийг авсан бол буцааж төл гэдэг ийм л шаардлага тавьдаг Сангийн яам. Яах вэ, орон нутаг бол янз бүрийн шалтгаанаар бол бид төсөв төлөх боломжгүй байна тэр нөхцөл байдал бол ярьж байгаа. Гэхдээ тухайн үедээ авч гэрээ хийж авахдаа бол буцаагаад төлнө гэдэг ийм нөхцөл байдлаар л гэрээ хийчэж байгаа.

Нөгөө талдаа яг тэр орон нутаг болон нэгж дээрээ хэрэг хэрэгжиж байгаа төслүүдийн үр ашиг дээр бол тухайн аймгийн орон нутгийн удирдлагууд болон тэр нөгөө яамдын төлөөлөл, төсвийн ерөнхийлөн захирагч нар бол ингээд хяналт тавих ёстой. Бид төсөл хэрэгжүүлж байна гэж хэлээд л, юм л авч байвал болно гэсэн сэтгэлээр хандаад байх дээр нөгөөдөх нь яг бодитоор хэрэгжихдээ их хэмжээний урсгал зардал шаардсан, технологийн хувьд үр ашиггүй гэх мэтчилэн бол шаардлага хангахгүй ийм юмнууд бол нэлээд гарч байсан. Үүнийг бол бид аль болох хэрэгжих төслүүд дээрээ бол гаргахгүйн тулд бид бол техник эдийн засгийн үндэслэл гэдэг юмыг маш сайн боловсруулдаг байх ёстой. Техник эдийн засгийн үндэслэлээ бид маш сайн боловсруулж байж л энэ гадаад зээл, тусламжийн хөрөнгийг зарцуулдаг болохгүй бол бэлэн биш төсөл дээр авчихсан юмнууд маань эргээд нөгөө технологийн хувьд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, зардал их шаардсан ийм арга хэмжээнүүд болоод байдаг учраас энэнээс болоод эргээд нөгөө төслөө явуулахад ч хэцүү ийм хүндрэлтэй байдлууд үүснэ.

Нөгөө талдаа гадаадын зээл тусламжаар хийж байгаа төслүүдийн хэрэгжилт дээр хугацааны хувьд хүндрэлтэй юм үүсээд байгаа юм. Маш удаан хугацаанд хэрэгждэг. Зээлээ авах гэж хугацаа алддаг, гэрээгээ байгуулах гэж хугацаа алддаг, нөгөөдхийг хэрэгжүүлэх гэж хугацаа алддаг. Гэтэл нөгөө шаардлага маань яг тийм нөгөө хугацааны хувьд жоохон сунжирсан байдалтай болоод ирэх дээр нөгөөдөх нь 5, 10 жилийн дараа хэрэгжээд эхлэхэд нөгөө шаардлага нь өөр болчихдог. Энэнээс улбаатай хүндрэлүүд үүсээд байгаа учраас бид одоо авч хэрэгжүүлэх энэ ер нь өрийн бодлогоо, Шинэ сэргэлтийн бодлоготойгоо уялдуулаад гадаад зээл, тусламжийн болон Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлье. Ер нь үр ашигтай төслүүд дээрээ л авъя, дараа нь бид нар техник, эдийн засгийн үндэслэл нь бэлэн төслүүдээр авч хэрэгжүүлье гэдэг ийм бодлогыг бол маш хатуу баримталж бол ажиллаж байгаа.

Ер нь бол зээлийг авсан нэг зээлийг бол ямар нэгэн байдлаар тэглэх байна уу, тэрнээс чөлөөлөх гэдэг өөрөө бодлого маань буруу болчихоод байгаа юм. Яах вэ, өмнө нь явж ирсэн практикууд дээр бол янз бүрийн өрийн дарамт, энэ зээлийг бол чөлөөлж байсан юм байгаа юм. Гэтэл орон нутгууд нэгэнт аваад өөрсдөө хэрэгжүүлчихсэн зээлээ бол төлөх л ёстой. Төлөх ёстой. Гэтэл энийг нь орон нутаг төлөхгүй өмнөөс нь улсын төсөв төлөөд байгаа юм нь эргээд энэ маань улсын төсөв дээр бол дарамт болж орж ирээд байгаа учраас бид сүүлийн 3 жил бол ер нь энэ орон нутгийн дамжуулан зээлийн өрүүдийг орон нутгийг өөрсдөө төл гэдэг ийм байдлаар нэлээн шахаж бол ингэж бол ажиллаж байгаа.

Т.Аюурсайхан: Батсуурь гишүүнд микрофон өгье. Асуултаа тодруулъя.

Ж.Батсуурь: Ер нь ийм л дээ. Орон нутагт бол хүсээгүй зээлүүд очдог л доо. Жишээлэх юм бол энэ чинь яг одоог

яриагүй байна. Олон жилийн өмнөх зүйлүүдийг ярьж байна шүү дээ. Энэ жил өвлийг давахгүй байна, хөлдөх гэж байна ч гэдэг юм уу, хүсэл байвал Засгийн газар тухайн үеийн яамнууд ярьдаг. Өө та нар тэгж байгаа юу? Тэгвэл танай дээр Азийн хөгжлийн банкны санхүүжилт дээр ийм зүйл хийнэ, үгүй бол -КОЙКА-гоор тийм зүйл хийнэ гээд орон нутгаас ерөөсөө ажлын даалгавар аваагүйгээр, хүсээгүй байхад нь тэр зээлээр бид нар мэдэж байгаа. Бидний хийж байгаа зүйл гэж хийгээд, тэгээд яг тэр нь ямар ч ашиглалтгүйгээр устаад үгүй болчихоод ингээд үр өгөөжөө өгөөгүй байгаа юмыг орон нутаг дараагийнхаа, хойшдынхоо боломжийг хулгайлж, тэрийг одоо хүртэл төлнө гэдэг бол утгагүй асуудал. Харин шинээр барьж байгаа, өөрсдийнхөө хариуцлагаар авч байгаа зээл бол шал өөр асуудал. Тэгэхлээр би энэ Хөгжлийн банк болон бусад банкнуудын зээлийг ингэж барьж.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Цэрэнпунцаг гишүүн асуулт асууя.

Ц.Цэрэнпунцаг: 2 асуулт, 1 санал байна.

Нэгдүгээрт, энэ 23 онд Монголбанкнаас ипотекийн зээл Засгийн газар руу шилжих ёстой. Энэний бэлтгэл ажил яаж хийгдэх юм? Энэнтэй холбоотой зардал чирэгдлийн юм суулгасан юм байгаа юм уу? Ямар бүтэцтэй юм байж байж энийг цааш нь авч явах юм? Энэ тал дээр төсөвтөө тусгагдсан юм бий юу? Мөн ипотекийн зээлтэй холбоотой, ипотекийн зээл энэ КОВИД-ын хууль ингээд 12 сарын 31-нээр дуусгавар болох юм бол ипотекийн зээл авсан хүмүүс зээлийнхээ графикийн дагуу төлөх энэ горим руугаа орох байх тийм ээ? Тэгэхээр зэрэг эндээс цугласан мөнгөө бид нар эргэж гаргана. Засгийн газар ингэж эрүүл саруул зарчмаараа явах ёстой. Тэгэхдээ энийгээ бид нар жоохон зарчим, бодлоготой гаргамаар байгаа юм. Ялангуяа энэ Улаанбаатар руу нүүж байгаа энэ нүүдлийг

саармагжуулах, хөдөө рүү нь яаж эргүүлэх вэ гээд бид нар чинь олон бодлого гаргаж байгаа шүү дээ. Ингээд энэ хөдөө нутаг, аймаг бүр, ялангуяа сумдад орон сууц баригдвал энэ рүү ипотекийнхээ зээлийг чиглүүлэх ийм яг бодлого тусгаж байгаа юмнууд юу байна?

Хоёрдугаарт, хоёр дахь асуудал. Бид нар энэ эрчим хүчнийхээ салбарыг либералчилна гэж ярьж байгаа. Тэгээд энэ салбарт маань эх үүсвэр, энэ үйлдвэрлэлийн эх үүсвэр дутмаг байгаа. Гаднаас өвөл болоод ирэхээр бид нар чинь хойноос баахан эрчим хүчээ авдаг тийм ээ? Тэгээд энэ дээр ингээд шинэ хөрөнгө оруулалт хийгээд ингээд явж байхад энэ хүндрэлтэй юмнууд их гарч харагдах юм. Ялангуяа энэ тусгай зөвшөөрөл, лицензтэй холбоотой. Энэ гаднын байгууллагын гаргасан тэр дүгнэлт байна. Дунджаар тусгай зөвшөөрөл лицензээ авахад 280 хоног шаардагдаж байна гэж байна. Тэгээд лиценз, зөвшөөрлийг нь 1 жил хөөцөлдөхөд дахиад бүтээн байгуулалт ингээд энэ чинь энэ орох төсөл хөтөлбөр, энэ том төслүүдийг чинь одоо тэгээд л зөвхөн зөвшөөрөл дээр энэ Засгийн газар чинь 1 жилийг нь авхуулаад байхаар яаж энэ ажил богино хугацаанд үр дүнгээ өгөх юм бэ? Энэ дээр ямар нэгэн тодорхой, 1 ч төгрөг зарахгүйгээр шийдэх асуудал шүү дээ. Энийг та бүхэн бас яаж шийдэх тал дээр, энэ зөвшөөрөл лицензтэй юман дээр яаж, ямар бодлого баримталж байгаа юм бол гэж?

Дээрээс нь бид нар энэ экспортынхоо орлогыг нэмэгдүүлье гээд байгаа юм. Энэ дээр олон төсөл хөтөлбөрүүд, бас нэг зөвшөөрөл лицензтэй ингээд хөдөлж чадахгүй байгаа юмнууд байгаа. Энэ төслүүдээ түргэн хөдөлгөхийн тулд бас та нар ямар бодлого баримтлах юм? Энд одоо тусч байгаа янз бүрийн бодлого, тодорхой авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна уу гээд. Ингээд 2 дахь асуулт нь энэ.

Ингээд саналаа хэлчихье. 1 санал байна. Энэ санал бол бид нар энэ төсвөө аль аль болохоор алдагдал багатай, алдагдалгүй баталчих юм сан гэж олон гишүүд ярьж байна тийм ээ? Та бүхэн сонсож байгаа. Тэгэхдээ энэ дунд бид нар хүүхдийнхээ мөнгийг өгнө гээд Жавхлан сайд маань хэвлэл мэдээлэлд өгсөн ярилцлага байх шиг байна лээ.

Тэгээд энэ дээр энэ хүүхдийнхээ мөнгийг бид нар жишээлбэл 50 хувьд нь юм уу, яг шаардлагатай өнөө сар сардаа өгч байх ёстой, гаргаж байх ёстой, хэрэглэх хэрэгтэй гээд бодоход үлдсэн 50 хувийнхаа хүүхдийн мөнгийг бид нар удаан хугацаатай хадгаламж болгож хүүхдүүдээ хийж өгөөд, тэгээд энэ эх үүсвэрээ буцаад тэр Засгийн газрынхаа үнэт цаасыг авах эх үүсвэр болгож заагаад ингээд энийгээ тэр явдаг зарчмаар нь арилжааныхаа банкуудаар дамжуулаад энэ эх үүсвэрийг буцааж Засгийн газрынхаа бонд авах энэ зохицуулалтыг хийж болдоггүй юм уу? Энэ дээр та нар ямар бодлоготой байна? Одоо энэ Засгийн газрын бонд гаргаад, тэгээд энэ мөнгөний нийлүүлэлт багасчихсан энэ үед хувийн хэвшлүүдийнхээ энэ.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Сангийн яам харуулья. 80.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулья. Ипотекийн зээлтэй холбоотой энэ асуудлыг бол Монголбанкнаас улсын төсөв рүү шилжүүлэх асуудлыг бол ингэж бол яригддаг. Энэ асуудал бол сүүлийн 3, 4 жил ингээд бол яригдаж байгаа. Бид бол шууд төсөв дээр, ирэх жилийн төсөв дээр энэ ипотекийн зээлийг улсын төсөв рүү шууд шилжүүлээд авна гэхэд бол хүндрэлтэй ийм асуудал байгаа. Бид бол яах вэ, тодорхой үе шаттайгаар энийг авч хэрэгжүүлэх ийм байдлаар бол явах нь зүйтэй юм гэдэг ийм байр суурийг баримталж байгаа.

Нөгөө талдаа бид бол хөдөө орон нутагт очиж суурьшиж байгаа иргэд

ипотекийн зээл авах юм бол тэдний хүүгийн зөрүүг нь 3 хүүтэй ипотекийн зээл авлаа гэхэд зөрүү хувь бид нар 3 хувийг нь улсын төсөв дээр хүүгийн татаас, хүүгийн хөнгөлөлтийг нь даана гэдэг ийм байдлаар бол энэ оноос эхлээд энэ бодлого бол хэрэгжээд явж байгаа. Энэнтэй холбоотой бид нар хүүгийн зардлыг нь бол төсөв дээр бол тусгачихсан бол ингээд явж байгаа. Ирэх жил бол бид нар 2023 онд орон нутагт шилжсэн болон анх удаа орон сууцны зээлд хамрагдаж байгаа, орон нутагт шилжиж очсон 5600 иргэнд ипотекийн зээл олгоход зориулаад хүүгийн татаасыг нь олгоно гээд нийтдээ 12.9 тэрбум төгрөгийг бид нар бол тусгасан ийм байгаа.

Нөгөө талд 2 дахь асуулт бол эрчим хүч бид нар дулааны төслийг бол бид нар татварын бодлогоороо бол дэмжих байдлаар 2023 оноос эхлэн хойш хэрэгжүүлэх дулаан цахилгаан, үйлдвэрлэх төслийн үндсэн үйл ажиллагааны орлогын татвар луу орлого олж эхэлснээс хойш 3 жилд 90 хувь, дараагийн 3 жилд нь 50 хувиар бол хөнгөлөхөөр бол ингэж яах вэ, яг Сангийн яамны хувьд бол татварын бодлогоороо дэмжих ийм бол бодлогын арга хэмжээнд оруулж ирж байгаа. Таны асуусан эрчим хүч, дулааны лиценз, зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг бол би салбарын яам нь илүү тодорхой хариулах нь зөв болов уу гэсэн ийм байр суурьтай байна.

Т.Аюурсайхан: Цэрэнпунцаг гишүүнд 1 минут өгье.

Ц.Цэрэнпунцаг: Би сая тэр нэг санал хэлсэн шүү дээ. Тэр саналд бас та нар юугаа хэлчих үү? Тэр саналаа би бас гүйцээгээд тодруулаад хэлчихье. Засгийн газрын үнэт цаас гаргах гээд байгаа юм. Их наядаар нь хэдэн их наяд тавьсан юм? Засгийн газрын үнэт цаасны гаргах хэмжээ хэд байгаа юм? Тэрний эх үүсвэрийг одоо энэ банкнаас, банкны энэ зээл гээд банкин дээр байгаа жоохон

мөнгөн дээр өсгүүлж байгаа хувийн хэвшлүүдийнхээ ингээд өрсөлдөөд сороод аваад явчих нь. Ингээд 1 сумаар 2 туулай гэдэг шиг тэр хүүхдүүдийнхээ, хүүхдийн мөнгөө удаан хугацаатай хагас хувийн боломжтой тэр үлдсэн 50 хувийг нь бол өгөөд 50 хувийг нь энэ удаан хугацаатай хадгаламж болгож хүүхдүүдээ өгөөд энэнээсээ эх үүсвэрийг нь тэр тэр эх үүсвэрийг нь банкнуудтайгаа хэлэлцээрийг хийгээд, тэгээд тэрүүгээрээ Засгийн газрын үнэт цаас авах тэгээд нөхцөлөө тохироод ингээд ийм маягаар шийдэж болохгүй юм уу гээд санал хэлсэн шүү. Энэ дээр бас нэг сонсмоор байна. Тэр.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Ганбат дарга, 80 дугаар микрофон гүйцээгээд хариулчих.

Ж.Ганбат: Хүүхдийн мөнгөтэй холбоотой яах вэ, яг уг нь бол яг таны хэлээд байгаа санаа бол бид энэ 2022 оны төсвийн хууль дээр бол бид хуримтлалтай хүүхэд гээд Ирээдүйн өв сангаас бид нар тодорхой хувь нь бэлэн мөнгөөр авна. Зарим хүүхдүүд нь бол хуримтлал хэлбэрээр явна гэдэг энэ схем бол энэ оны төсвийн хууль дээр батлагдсан. Бид нарын бол яг таны хэлж байгаа саналаар бид бол нийтдээ бол 50 хувь нь өөрөөр хэлэх юм бол тодорхой хувь нь бол хуримтлал үүсгээд явчих юм байна. Энийг бол бид арилжааны банкнууд дээрээ ярьж байгаад өөрөөр хэлэх юм бол нөгөө хуримтлалтай хүүхдэд бүр хадгаламж үүсгэж байгаад, энэ бол арилжааны банкин дээр эх үүсвэр болгоод, энэ эх үүсвэрийг бид өөр төсөл, арга хэмжээнүүдийг бас санхүүжүүлээд ингээд таны хэлдгээр 1 сумаар 2 туулай буудаад яг ийм схемийн, таны хэлдэг схемийг бол энэ оны түвшинд бол, өөрөөр хэлбэл энэ оны төсөв.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Цэрэнпунцаг гишүүн дахиад тодруулъя.

Ц.Цэрэнпунцаг: Ганбат дарга саяныхыгаа гүйцээгээд хариулчхаарай, нэгд.

Хоёрт, тэр татварын бодлогоор эрчим хүчний салбар, энэ үйлдвэрлэл энэ дээр хөрөнгө оруулалт орж байгаа юмыг дэмжинэ гээд байна. Тэр хэд хэдэн татварууд байна лээ. Тэр яах вэ. Яг энэ бодитой хамгийн түрүүнд хөрөнгө оруулалтаар бол энэ чинь тоног төхөөрөмжүүдэд их хөрөнгө оруулалт ордог юм шүү дээ. Ингээд л гааль, НӨАТ-ын татвараас авхуулаад л татварууд байгаа. Энэ дээр нь яг бодлого дээр дэмжлэг үзүүлэх юм, энийг нь ядах нь хойшлуулах, үйлдвэрлэл эхэлтэл нь хойшлуулах ч юм уу? Ийм авч хэрэгжүүлэх арга хэмжээ байгаа юм уу?

Хоёрдугаарт, ипотекийн зээл бол хөдөөд урьдчилгаа 30 хувь нь бол өндөрдөөд байгаа юм. Ингээд хөдөөд чиглүүлээд ИПОТЕК-ээ явуулбал энэ урьдчилгааг багасгах, урьдчилгааны жишээлбэл 30 биш 15 хүртэл буулгах ийм арга хэмжээ авахын тулд энэ дээр зарцуулах нөөц, хүүг нь татаасан дээр 12.9 тэрбумыг тавьсан гэж байна. Тэгэхлээр урьдчилгааг буулгахдаа шаардлагатай, гаргахад бүр урьдчилгаа буулгахад шаардлагатай тэр санхүүгийн эх үүсвэрийг л бид нар гарцаагүй гаргах хэрэгтэй.

Т.Аюурсайхан: 80 дээр гүйцээгээд хариулъя.

Ж.Ганбат: Би түрүүний хүүхдийн мөнгөө бол гүйцээгээд хариулчихъя. Яг таны хэлж байгаа тэр хэсгийг нь бид энэ онд бодсон. Гэтэл яг амьдрал дээр бол яг бодитой хууль хэрэгжээд явахад хуримтлалтай хүүхэд гэдэг дээр биш хуримтлал үүсгэхээсээ илүү бэлнээр авч зарцуулах нь бол давамгайлсан учраас бол энэ арга хэмжээ бол хэрэгжихэд хүндрэл учирчихсан. Тэрнээс яг хуримтлал үүсгээд явахад бол болохгүй юм бол байхгүй ийм байна.

Хоёр дахь нь бол тэр дэд бүтцийн төслүүд дээрээ бол татварыг нь бид нар 2 жилээр хойшлуулах хууль, эрх зүйн орчин бол байгаа. Энэ бол Засгийн газар бол 2 жил хүртэлх хугацаанд бол тэр дэд бүтцийн төслүүдийн татварыг хойшлуулах ийм хөнгөлөлт, чөлөөлөлтийн юмнууд бол байгаа.

Өөр дээрээс нь нэмэх нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль дээр, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2.3-т заасан салбар буюу энэ дэд бүтцийн салбарууд байгаа. Улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулагчийн тухайн төсөл, арга хэмжээний.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Доржханд гишүүн алга байна. Сарангэрэл гишүүн алга байна. Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут асуулт асууна.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Надад 2, 3 асуулт байна. Монгол Улс 1999 оноос хойш Монгол Улсын зээлжих зэрэглэлийн хувьд 6 удаа эерэг, 13 удаа хасах үнэлгээ рүү бууж байсан ийм түүх байгаа. Тэгээд саяхан 2022 оны 5 сард л хэвийн үнэлгээтэй болсон байгаа. Тэгээд Монголын зээлжих зэрэглэлийг нэг зэрэглээ нэмэгдүүлэхийн тулд төсвийн алдагдлыг 5 орчим хувиар бууруулсан байх ёстой л доо. Тэгэхэд өнөөдөр бид нар бондын 1.4 тэрбум америк доллар, мөн своп хэлцлийн 2.5 тэрбум долларын зээлийг ирэх онд төлнө.

Мөн төсвийн алдагдлаа 1.6 их наяд төгрөг байна гээд яриад сууж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ зээлийг авснаараа ямар нөхцөл байдалд орох гээд байгаа вэ гэвэл магадгүй бид нар зээлээ эргэн төлөх үү, үгүй юу гэдэг асуудалд хүрнэ. Зээлжих зэрэглэл доошоо буурна. Цаашлаад Монгол Улс маань ямар болохыг хэлж мэдэхгүй болно. 22 онд бид нар 1 их наядын алдагдалтай төсөв баталж байсан. Одоо 1.6 их наядын алдагдалтай төсөв батлах гээд яриад сууж

байгаа шүү дээ. Тэгэхээр бид нарт зээл хэрэг байгаа юм уу одоо? Энийгээ яаж зохицуулах гэж та бүхэн тооцож байгаа юм бол?

Хоёрдугаарт нь Монгол Улсын нийт өр бол дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулахад 200 хувьд хүрсэн байна л даа. Тэгэхдээ Япон улс мөн яг адилхан ийм жишиг байгаа. 200 хувьд хүрчихсэн явж байгаа улс. Харин Япон улсын хувьд бол эдийн засаг тэлсэн гэдэг үзүүлэлттэй явж байгаа. Тэгэхээр үр өгөөжтэй байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр манайд ямар үр өгөөжтэй байгаа юм бол? Би ганц, хоёрхон жишээ хэлье л дээ. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт гээд 16-20 онд хэрэгжүүлнэ гээд 50 сая долларын зээл авсан байгаа. Тэгээд энэ зээлээр, зээл маань аваад ямар үр дүн гаргасан юм бэ? Яг тэр 4 зорилтдоо хүргэж чадсан юм уу?

Хоёрдугаарт нь, Байгаль орчин, аялал жуулчлалын яам Монголын унаган байгалийн хүлцэл ба тогтворжилтыг хангах төсөл гээд 7.9 сая америк долларын төслийг Даян дэлхийн байгаль орчны сангаас авсан байна. 2019-2026 онд хэрэгжүүлнэ гээд 3 жилийн хугацаанд цөлжилтийг бууруулж, хөдөөгийн иргэдийн амьжиргааг нэмэгдүүлнэ гэсэн. Зорилго нь. Гэтэл судалгаагаараа 2015 он онд цөлжилтөд өртсөн газар нутгийн хэмжээ 76.9 хувь гэж гарсан бол 2020 онд яг л адилхан байгаа. 76.9 хувиараа л байгаа. 22 он гээд ямар нэгэн дүгнэлт гараагүй байна.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүн амын сангаас 5 сая америк долларын төсөл авч жендер, хүчирхийлэлтэй тэмцэх төсөл хэрэгжүүлсэн байна. Тэгээд яах вэ, Баян-Өлгий, Хөвсгөл аймаг, Баянзүрх дүүрэгт нэг цэгийн үйлчилгээний төвд шаардлагатай эд хогшил, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээнд 20, 20-н сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн гээд л ийм л тайлантай сууж байна шүү дээ бид нар. Ингээд харахаар манайх зээл аваад хэрэгжүүлж

байгаа төслүүд маань төдийлөн үр дүнд хүрэхгүй байна. Тэгэхээр энийг бид бүхэн яах юм бэ цаашдаа? Энэ чигээрээ яваад байх юм уу? Энэ төслийн үр өгөөжийг бид нар яаж үр өгөөжтэй болгоё гэж зорьж байгаа юм бэ гэдэг дээр хариулт авъя. Баярлалаа.

Т.Аюурсайхан: 80 дээр Ганбат дарга хариулья.

Ж.Ганбат: Бид, Батлут гишүүний асуултад хариулья. Төсвийн алдагдал бол 2020 онд 4.4 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 12 хувь байсан. Бид бол энэ КОВИД-ын үед бол ийм өндөр байсан. 21 онд бид нар 2.9 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 6.9 хувь, 2022 онд бид нар 2.4 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 5.1 хувь. Бид нарын энэ үүний 23 онд бид нар энэ алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний нийт алдагдлыг 2.8 хувь, тэгээд 1.5 их наяд болгож бууруулж байгаа. Өөрөөр хэлэх юм бол бид нар 2020 оноос хойш 2 дахин бууруулж байгаа. Бид нар хуулиараа бол дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх алдагдал 3.6 хувь байх ёстой бид 2.8 гээд, энэ оны бид нар 2.4 их наяд байгаа алдагдлыг 1.5 их наяд болгоод төсвийн алдагдлыг бол бид сайжруулж хуулийн хязгаараас бол бид сайжруулж өргөн барьсан байгаа. Бид үүнийг, ер нь төсвийн алдагдлаа бид бууруулж байж гадаад зээлийн өрөө төлөх ийм зарчим бол баримтлах төсвийг өргөн барьсан байгаа.

Гадаад, манай бондын өгөөжүүд бол нэлээн өндөр байж байгаад, энэ дээр бол яах вэ, тодорхой. Өнгөрсөн 7 хоногт Bloomberg дээр гарсан нэг мэдээллээс болоод бондын өгөөж бол хэлбэлзсэн. Энэ дээрээ бол бид нар холбогдох арга хэмжээг аваад гадаадын хөрөнгө оруулагч нартаа мэдээллийг нь өгөөд, бодит мэдээллийг өгсөн хүмүүс энэ бол харьцангуй тогтворжиж байгаа. Энэ бол буураад, бид нар зээлжих зэрэглэл дээр бид нар энэ онд 2 удаа манай дээр ирж

бол энэ зээлжих зэрэглэлийг бол тогтоосон байгаа. Олон улсын байгууллагын зүгээс зээлжих зэрэглэлийг тогтоодог. Бид нар 22 оны 5 сард бол “В” тогтвортой бол хэвээр нь хадгалж чадсан. 22 оны бид нар 7 сард бол дахиад ирсэн. Энэ дээр би тогтвортой хэвээрээ нь бол хадгалсан.

Ер нь бол энэ бид энэ зээлжих зэрэглэлээ би тогтвортой хэвээр нь хадгалж чадаж байгаа маань бол гадна талдаа бол бид нар бол энэ дээр эерэг үзүүлэлт болж байгаа. Бид ирэх жил бол нийтдээ 1.1 тэрбум ам. Долларыг гадаад зээлийн үйлчилгээнд бол төлнө. Энэнтэй холбоотой бид зээлжих зэрэглэлийг бид одоогийнхоо энэ түвшинг бол хадгалаад энэ хэвээр нь яваад байх юм бол бид ирэх жил гадаад зээлийн төлбөр төлөхөд бол ямар нэгэн бол хүндрэл үүсэхгүй. Бид бол ирэх жил төлөх 1.1 тэрбум доллароосоо 300 сая ам.долларыг нь бид нар төсвөөсөө бол өөрсдөө төлнө. 330 сая ам. Долларыг нь бид өөрсдөө төлнө. Үлдсэнийг нь бид нар дахин санхүүжилт байдлаар төлнө гэсэн ийм байдалтай бол ажиллаж байгаа бид нар.

Төслийн санхүүжилтийн тал дээр бол бид гадаад зээлийн ашиглалтын тал дээр бол бид нар төслийн санхүүжилтийг бол төсөв дээр бол гадаад зээлийн ашиглалтыг бол тусгаад явж байгаа. Энэ бол өөрөөр хэлэх юм бол энэ манай зардал талдаа тусгаад явдаг учраас бид гадаад зээлийн ашиглалтыг бол бид нар үр ашигтай байгуулах тал дээр нь бол онцгой анхаарч ингэж ажиллаж байгаа.

Ер нь бол төслүүдийн үр өгөөж, үр дүнд төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжилт, хяналтаа муу тавьдаг, төслийн хэрэгжүүлэх нэгж хангалттай ажилладаггүй, юу гэдэг юм техник эдийн засгийн үндэслэлүүдийг бүрэн боловсруулаагүй холбоотойгоор тухайн төслүүд бол хэрэгжихдээ бол хүндрэлтэй ийм асуу.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Гишүүд асуулт. 1 минут өгөх үү? Батлут гишүүнд.

Д.Батлут: Мэдээллийг бид нар ингээд захаас нь аваад шүүрдээд үзэхэд 2, 3 олон улсын байгууллагаас санхүүжилттэй төсөл бол хүрэх үр дүндээ хүрээ ч үгүй, ямар ч үр дүнгүй хий явж байгаа байхгүй юу. Тэгээд бид нар энийгээ баталж байгаа аятай ахиад зээл авна гэж явж байгаа нь эмгэнэлтэй санагдаж байна л даа. Өнөөдөр дэлхий нийтээрээ хямарчихсан байна. Дэлхийн эдийн засгийн өсөлтийг энэ оны эхэнд бол 4.4 хувьтай байхаар тооцоолж байсан бол 3 хувь хүрэхгүй л байна шүү дээ. Бид хаанаас хэдэн хувийн хүүтэй зээл авах юм, тэр мөнгө нь байгаа ч юм уу, үгүй ч юм уу гээд бөөн асуудал болно. Оллоо гэхэд эргээд яах юм? Ахиад л ийм үр дүнгүй хөрөнгө оруулалтуудад хийгээд байх ёстой юм уу? Бид ийм байдлаар цаашдаа явж болохгүй шүү дээ. Тэгээд энэ дээр тодорхой бичгээр та тэр төслүүдийн гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг надад ирүүлээрэй гэж хүсье. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Үг хэллээ. Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье. Бейсен гишүүнээр тусаллаа. Завсарлана. Тийм, тэгээд дараа нь 14 цагаас санал хураана гэж төлөвлөж байна. Бейсен гишүүнд микрофон өгье.

Б.Бейсен: Энэ төсвийн төслийн хэлэлцүүлэгтэй танилцлаа. Яах вэ урд хөршид КОВИД, хойд хөршид маань дайн, нөгөө талаар хэмнэлтийн хууль, төсөв хүнд байгааг алдагдалтай төсөв баталж байгаа ойлгож байна л даа. Гэхдээ энэ эрүүл мэндийн боловсролын талын асуудал дээр онцгой анхаарахгүй бол болохгүй байна. Ялангуяа багш нарт компьютерын хангалт муу байна, зарим сургуулиуд дээр сурагчдын сурах боломж муу байна. Багш нар ч гэсэн сургах тоног төхөөрөмж хангалтгүй байна. Энэ дээр онцгой анхаарах шаардлагатай гэж бодож байна.

Эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлээр санхүүжихэд сумууд дээр, өрхийн эмнэлгүүд дээр оношилгооны тоног төхөөрөмж дутагдалтай байна. Бид бас саналаа явуулсан. Эрүүл мэндийн яам холбогдох газарт нь өгсөн. Уг нь гишүүдийн багцаар шийднэ гэсэн. Энэ жил тэгээд бүх хөрөнгө оруулалтыг хасаж байх шиг байна. Энэ дээр анхаарахгүй бол гүйцэтгэлээр санхүүжихэд, тэгээд оношилгооны баг дутагдлаас болж аймаг руу яваад аймгийн нэгдэн эмнэлгийн ачаалал ихсэх, тэгээд төв рүүгээ яваад хотын эмнэлгүүдийн ачаалал ихсэх ийм хүндрэлтэй асуудал үүсэх гээд байна.

Тийм учраас энэ дээр анхаараад бас эрүүл мэндийн сайдууд бусад сайдуудын багцыг нэмэгдүүлсэн юм байна л даа. Хөрөнгө оруулалт хийсэн. Энэ дээр анхаараад тодорхой хэмжээний юм тавихгүй бол бас болохгүй нь. Нөгөө талаараа чөлөөт бүсийн асуудал байна, Цагааннуур, Алтанбулаг, Замын-Үүдийн чөлөөлт бүс. Энэ чөлөөт бүсүүдийг зүгээр хашаа л байж байгаа. Захиргаа нь хотод байдаг. Олон жил тэжээж байна. Сая бид Цагааннуур явсан. Хоосон хаашаа л байна. Яах вэ тэнд ажлын албатай мөртөө байр нь байдаг, удирдлага нь хотод байдаг. Зөвхөн төсөв гэхэд 320 хэдэн сая жилийн төсөвтэй, 15 жил тэжээж байна шүү дээ.

Тийм учраас энэ дээр бас чөлөөт бүсүүд дээр тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтын асуудал хийхгүй бол бас болохгүй нь. Цагааннуурын боомтоор жишээлбэл нефть орж байна. Шатахуун, хүнсний бүтээгдэхүүн, жимс ногоо бүгд орж байна, барилгын материал орж байна, малын тэжээлийн асуудал орж байна. Айл өрх бүр чөлөөт бүс болчихсон. Чөлөөт бүсийг нэгтгээд гаалийн асуудлыг нь шийдчихвэл боломжтой л юм шиг харагдаад байх юм. Хуучин Цагааннуурын дамжлага баазын гаалийн баталгаатай агуулах хийх том складууд нь байж байна. Зөвхөн Цагааннуур биш Замын-Үүд, Алтанбулаг

энэ дээр онцгой анхаарахгүй бол бас болохгүй нь. Энэ дээр анхаараач гэсэн саналаа хэлье гэж бодож байна.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Энэ нь жил болгон улсын төсөв дээр айхтар их нүүрс экспортлоод, тэндээсээ орлого олно гээд орлогоо өндөр тавьж байгаад зардлаа нэмээд л байдаг ийм л юм энэ жил дахиад л ороод ирж байна л даа. Тэгэхлээр яах вэ, нүүрс экспортлох тэр зорилтыг бол би үгүйсгэхгүй байгаа юм. Тэр зорилтод хүрэхийн тулд нэг тодорхой ажлыг хийх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл өнөөдрийн Тавантолгой, Гашуунсухайтын хооронд тавьсан өргөн төмөр зам, тупик нөхцөл байдалд орлоо. Энэ тупик зам боллоо. Өөрөөр хэлбэл энүүгээр ойрын үед нүүрс тээвэрлэх боломжгүй болж байгаа. Өөрөөр хэлбэл дахин дамжуулах энэ терминал барих ёстой. Тэр нь төмөр замынхаа үнэтэй адилхан. Ийм хөрөнгө оруулалтыг хийх боломж өнөөдөртөө байхгүй.

Энэ дээр дээрээс нь аж ахуй нэгжүүд, тээврийн компаниуд, нөгөө жолоочгүй автомат удирдлагатай чингэлэг тээвэр лүү хөрөнгө оруулалтаа хийгээд явчихсан. Тийм учраас энийг зардлаа нөхөхийн тулд тодорхой хэмжээгээр тэнд одоо авто тээврийн нүүрс тээвэр л явах юм л дээ. Тэгээд энэ төмөр зам нь явахгүй нь.

Тэгэхлээр энэ дээр би, тэгээд нарийн төмөр замаар тавья гэх дээр экс Ерөнхийлөгч Баттулгаас нэг айдаг, Оросын бодлогоос айдаг нь л ийм л болчихоод байгаа юм. Тийм учраас энэ уул уурхай байгаа, төмөр замын бодлого, бичиг баримт дээр байгаа уул уурхайн ордоос хилийн боомт хүртэл ямар царигаар барихыг Засгийн газрын өргөн барьсны дагуу Их Хурал шийднэ гэж ийм заалт байгаад байгаа юм.

Гэтэл харамсалтай нь Тавантолгой, Гашуунсухайтын төмөр замыг өргөн, нарийн барихыг Их Хурлын тогтоол гараагүй байж байхад бариад явчихсан ийм алдаа дутагдал байгаад байгаа юм. Энийг засах гээд энэ уул уурхайн ордоос тухайн орны царигийн дагуу төмөр зам барина гэсэн ийм тогтоолын төслийг Засгийн газраас санал аваад, өргөн барьчхаад байж байгаа. Ингэх юм бол дараа дараагийн алдаанууд гарахгүй юм. Өөрөөр хэлбэл одоо тэр шивээ хүрэн дээр байгаа Ханги руу тавьж байгаа, мөн түүнчлэн Бичигт рүү тавьж байгаа, цаашлаад Ховдын Булган. Байтаг руу тавих энэ төмөр замууд бүгдээрээ зөв болоод явчих юм. Тэгээд энэ тогтоолын төслийг Засгийн газраас дэмжээд, энэ Их Хурал бас энэ тогтоолын төслийн дагуу нарийн царигтай төмөр замыг тавиад, ялангуяа хүний оролцоогүй энэ КОВИД-ын нөхцөл байдал дээр хүний оролцоогүй цаанаас нь 60 вагон нүүрсийг манаанаас нь 3 зүтгүүр түлхээд оччихдог. Цаанаас нь 3 зүтгүүр аваад гарчихдаг ийм экспортын хийх юм бол та нарын хүсээд байгаа тэр нүүрсний экспорт чинь хэд дахин даваад, тэгээд хангалттай хэмжээний хөрөнгө оруулалт хийх ийм боломжийг гаргаж чадах юм.

Тэгэхлээр цаашдаа бид нар нөгөө зардал талдаа биш, орлого талдаа яаж Засгийн газар мэргэн ухаан гаргах уу гэдэг дээрээ л анхаарах ийм зайлшгүй шаардлага гараад байгаа юм. Тийм учраас энд Засгийн газрын гишүүд сууж байна. Дээрээс нь төсвийн орлогыг бол бүрдүүлэх талаар маш их ажилладаг Сангийн яамныхан сууж байна. Тийм учраас энэ өргөн баригдсан тэр тогтоолын төсөл дээр илүү сайн хамтраад ажиллах юм бол Монгол Улсын гадаад худалдаа, дээрээс нь экспортын орлого энэ тал дээр бол бид нар бол нэн шинэ шатанд гарах ийм боломжийг бүрдүүлэх юм гэдгийг хэлье. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Гишүүд үг хэлж дууслаа. 13 цаг болсон байна. Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдааныг түр

завсарлуулж байна. Үдээс хойш 14 цагаас нэгдсэн хуралдаан санал хураалтаар үргэлжилнэ.

13.09 цаг

*Пүрэв гараг 13 Аравдугаар сар 2022
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 09 минут.*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Т.Аюурсайхан: Үдээс хойших хуралдаанаа нээж байна. Санал хураалт явуулна. Гишүүд танхимдаа цуглаарай. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёолоор санал хураах гэж байна. Гишүүд, ажлын хэсэг байраа эзэлье. Гишүүд танхимдаа цуглая.

Төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүдэд мэндчилгээ дэвшүүлье. 10 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат, 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Баттогтохын Чойжилсүрэн нарын төрсөн өдөр нь тохиож байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүн Цагаанхүүгийн Идэрбат, Баттогтохын Чойжилсүрэн нарт төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн түшээ та бүхэнд болон гэр бүлийнхэнд нь Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөж байна.

Улсын Их Хурлын нийт 12 гишүүн Улсын Их Хурлаас болон Засгийн газрын шийдвэрээр, мөн олон улсын байгууллагын шугамаар гадаад томилолттой байна. 1 гишүүн эмнэлгийн чөлөөтэй, ингээд 13 гишүүн албан ёсны чөлөөтэй байна. Ингээд 77.6 хувийн

ирцтэйгээр чуулганы хуралдаан үргэлжилж байна. Санал хураалт явуулна. Байнгын хорооны дарга нар танхимдаа хүрэлцэн ирээрэй. Төсвийн байнгын хорооны дарга танхимдаа хүрэлцэн ирээрэй. Төсвийн байнгын хорооны.

14.24 цаг

Хоёр.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн нарын урилгаар Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Санал хураалт явуулна. Гишүүд байраа эзэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашзэвгийн Амарбаясгалан танилцуулна. Индэрт урьж байна таныг.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Техникийн бэлэн байдлыг шалгаж, туршилтын санал хураалт явуулъя. Гишүүд, ирцэд байгаа гишүүд техникийнхээ бүрэн байдлыг шалгая. Эдийн засгийн байнгын хорооны дарга танхимд хүрэлцэн ирээрэй, Төсвийн байнгын хорооны дарга хүрэлцэн ирээрэй.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан нийт 101 хуулийн төсөл, 6 Улсын Их Хурлын тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн билээ. Өргөн мэдүүлсэн хууль, тогтоомжийн төслүүдийн талаар дурдвал:

Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэлээр гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байна. Санал хураалт явуулъя гишүүд ээ. Хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Уул уурхайн үйл ажиллагаанаас нутгийн иргэдийн хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх хандив тусламжийг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх, тус хандив тусламжийн гэрээ ил тод байх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор боловсруулсан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

56.9 хувийн саналаар дэмжигдлээ. Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцсон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийнхаа асуудалдаа орёе.

2.Төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох, түүнчлэн төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарсан боловч төрийн албан хаагчийн статустайгаар албан тушаалын үндсэн цалин болон хуульд заасан нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг тэтгэврийн хамт авч байгаад хязгаарлалт тавих зорилготой Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

3.Олон улсын нөхцөл байдлаас шалтгаалж инфляц өндөр байгаа энэ цаг

үед орлогын эрсдэлтэй ойрхон байгаа болон бага хэрэглээтэй өрхүүдийн орлогын баталгааг сайжруулах зорилгоор өрхүүдийн амьжиргааны түвшнийг харгалзан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 91 хувьд үргэлжлүүлэн олгоход чиглэсэн Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай оруулах тухай хуулийн төсөл.

4.Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үнэт цаасны зах зээл, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, бизнесийн орчныг дэмжих, татварын хөнгөлөлт эдлүүлэх, шаталсан татварын тогтолцоог нэвтрүүлэх, цахим төлбөрийн баримтын тогтолцоог өргөжүүлэх хүрээнд Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний зориулалт бүхий шинэ автобусыг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн зориулалттай үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн татвараас 100 хувь хөнгөлөх тухай хуулийн төсөл болон эдгээртэй холбоотой бусад хуулийн төслүүд.

5.Мэргэжлийн хяналт шалгалтын оновчтой, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх, мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлж байгаа байгууллагууд болон улсын байцаагчдын чиг үүргийн давхардлыг арилгах, салбарын бодлогыг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүргийн уялдаа холбоог хангах, хариуцлагыг тодорхой болгох, зохих шийдвэр, түүний хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Төрийн хяналт, шалгалтын тухай хууль болон холбогдох бусад 82 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, түүнчлэн Засгийн газрын харьяа байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны хуульд бүрэн нийцэж, төрийн үйлчилгээнд хүнд

суртал, дарамт учруулахгүй байхын зэрэгцээ ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөж байгаа эсэхэд шууд хяналт шалгалт хийж, алдаа дутагдал, хууль зөрчигдсөн байдлыг таслан зогсоож, зохих хариуцлагыг тооцон Төрийн бүтээмжийг дээшлүүлж, иргэдийн эрх ашгийг хамгаалах, шуурхай, илүү үр дүнтэй тогтолцоо бүрдүүлэх зорилготой гүйцэтгэх засаглал дахь Хяналтын тухай анхдагч хуулийн төсөл.

6.Засгийн газрын үнэт цаас, баталгаа гаргах, эрх олгох тухай, Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Засгийн газрын зарим агентлагийг шинээр байгуулахтай холбогдуулан тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангид үдийн хоолны үйлчилгээг нэвтрүүлэх хугацаатай холбогдуулан тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг тус тус боловсруулан танилцуулж байна.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Т.Аюурсайхан: Баярлалаа. Одоо төслийн талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Амартүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчаас уул уурхайн төсөл, хөтөлбөрөөс орон нутгийн иргэдийн хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх, төрийн захиргааны албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл олгох, түүнчлэн төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарсан боловч төрийн албан хаагчийн статустайгаар албан тушаалын үндсэн цалинг тэтгэврийн хамт авч байгааг хязгаарлах, олон улсын нөхцөл байдлаас шалтгаалж хэрэглээний үнэний өсөлт өндөр байгаатай холбогдуулан өрхийн амьжиргааны түвшнийг харгалзан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 91 хувьд нь үргэлжлүүлэн олгох, үнэт цаасны зах зээл, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, бизнесийн орчинг дэмжих, татварын хөнгөлөлт эдлүүлэх, шаталсан татварын тогтолцоог нэвтрүүлэх, цахим төлбөрийн баримтын тогтолцоог өргөжүүлэх зүйтэй гэж үзэж холбогдох хууль, тогтоолын төслүүдийг боловсруулжээ.

Засгийн газрын харьяа байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хуулийн хэрэгжилтийг хангуулах, сахил сахилга, хариуцлага дээшлүүлэх, Засгийн газрын дотоод хяналт буюу Засгийн газраас харьяа байгууллага, албан тушаалтанд Хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэх, иргэдийн эрх, эрх чөлөөг баталгаатай хангах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор гүйцэтгэх засаглал дахь Хяналтын тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Түүнчлэн салбарын хяналт, шал шалгалтын оновчтой, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх, улсын байцаагчдын чиг үүргийн давхцалыг арилгах, нэгдсэн удирдлага, зохион

байгуулалтаар хангах, хариуцлагыг тодорхой болгох зорилгоор Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох 82 хуулийн төслийг боловсруулжээ.

Хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын 2023 оны төсвийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг багцлан санал хураалгах нь зүйтэй гэсэн санал гарсан тул хууль, тогтоолын төслүүдийг багцлан санал хураалгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Баделхан өндөр настны тэтгэвэрт гарсан хүмүүсийг төрийн албанд ажиллуулахыг хориглох нь хүний эрхийн талаасаа оновчтой шийдвэр мөн эсэх, мөн хүчний байгууллагын албан хаагчид эрт тэтгэвэрт гардаг онцлогтой тул тэтгэвэр, цалин хоёрын аль нэгийг нь сонголт хийх боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн Ирээдүйн өв санд хуваарилах хувийг 2023 онд 0 болгож бууруулснаас гадна 2024, 2025, 2026 онуудыг хөндсөн нь хуульд нийцэж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс гишүүдээс санал гараагүй болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн албан албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай, Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон сууцын тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Органик хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүрэлдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Таримал ургамлын үр сортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн зарим

заалт хүчингүй болсонд тооцох тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалтын бүс, газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай, Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай, Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах, Тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай, Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Т.Аюурсайхан: Баярлалаа. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Баян сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийг одоо танилцуулъя. Дашзэгвийн Амарбаясгалан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Бямбажавын Ганбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Мягмар тус газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Бямбасүрэн тус газрын Санхүү, эдийн засгийн газрын дарга, Эдийн засаг хөгжлийн яам Санжаагийн Наранцогт Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Энх-Амгалан мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Сангийн яамнаас Санжаагийн Мөнгөнчимэг Сангийн дэд сайд, Ганбат тусын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санжаадорж тус яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Тэлмүүн тус яамны Татварын бодлогын газрын дарга, Чимэдсүрэн тус яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Энхболд тус яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Золбоо тус яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Одонтуяа тус яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Дэлгэржаргал тусын яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ганзориг тус яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөр-Уяагийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Болорчулуун тус яамны Бодлого төлөвлөлтийн газрын

дарга, Энхтүвшингийн Золбоо Барилга, хот байгуулалтын дэд сайд, Баярбат тусын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ганхуяг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Захиргаа удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга, Зам, тээврийн хөгжлийн яамнаас Сандагдоржийн Батболд тус яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас Барсүрэнгийн Баасандорж Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Ариунхур тус газрын Эрх зүй, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Ган-Эрдэнэ тус газрын Мэдээллийн технологийн газрын дарга, Жаргал тус газрын Дэд бүтцийн хяналтын газрын дарга, Алтантуяа тус газрын Хүнсний аюулгүй байдлын хяналтын газрын дарга гэсэн ажлын хэсгийг танилцуулж байна.

Одоо хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байвал нэрээ өгье. Жигжидийн Батжаргал гишүүнээр нэрийг тасаллаа. Одоо Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин асуулт асууна.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Би 2 асуулт байж байгаа юм. Нэгдүгээр асуудал нь энэ. Бат-Эрдэнэ гишүүнээ байж бай даа.

Нэгдүгээр асуудал энэ орон нутаг, энэ бие дааж төсвөө бүрдүүлж байгаа 5 аймаг байж байгаа. Тэгээд орлогоороо юу гэдэг юм зардлаа нөхдөг, эргүүлээд сум, орон нутагтаа хөрөнгө оруулалт хийдэг. Барилга байгууламж, сургууль, эмнэлэг, цэцэрлэгээ барьдаг. Нэг ийм 5 аймаг байж байгаа юм. Тэгээд одоо энэ төсвийн тухай дагалдах хуулийг хараад байхад нөгөө бие даасан нөгөө 5 аймаг маань зөвхөн засвар үйлчилгээ хийгээд бусад төрлийн юу гэдэг юм, сургууль цэцэрлэг ч юм уу, зам барих ч гэдэг юм уу, эмнэлэг барих ч гэдэг юм уу энэ

асуудлыг хийж чадахгүйд хүрч байгаа юм байна л даа.

Тэгээд нөгөө бидний яриад байдаг орон нутаг бие дааж хөгжих ёстой, орон нутгийн санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх ёстой, орон нутаг аль болохоор улсын төвлөрсөн төсвөөс мөнгө авахгүйгээр орон нутагтаа орлогоо олж, тэр барилга байгууламжаа барьдаг байх ёстой гэдэг энэ асуудал чинь байхгүй болох юм биш үү? Нэг. Эрдэнэт байна, Өмнөговь байна, Дархан, Дорноговь, Дорнод гээд 5 л аймаг байж байгаа шүү дээ. Тэгээд энэ аймаг чинь олсон орлогоороо сургууль, цэцэрлэг, эмнэлэг, зам харгуйгаа барихгүй бол юу хийх юм? Манай аймгийн хувьд бол жилдээ 70-50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийдэг, энэ жил гэхэд сургууль 640 хүүхдийн сургууль, халдвартын эмнэлэг, 20 гаруй километр зам, түрээсийн орон сууц гээд томоохон барилга байгууламжуудыг эхлүүлээд явж байгаа шүү дээ.

Тэгээд бусад аймгуудтай адилтгаж, энэ бие даасан өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг орлогын төлөө бас ингэж явдаг аймгуудаа ингэж боомилсон ийм асуудал орж ирж байна. Энэ асуудлыг эргэж нэг харж өгөөч. Энэ дээр ямар хариулт байгаа юм? Энийг нэгдүгээрт сонсьё гэдэг дээр.

Хоёр дахь асуудал дээр бол энэ Мэргэжлийн хяналтыг ингээд татан буулгах л юм байна л даа. Тэгээд нэгдсэн хяналттай байсан бол ингээд салбарын хяналттай болох юм байна, салбарын хяналттай. Нөгөө салбарын хяналтууд маань аж ахуйн нэгж байгууллагууд дээр давхцаад улам их хүнд суртал вий болгох вий? Би зүгээр уул уурхай дээр жишээ авъя. 1 уул уурхай дээр гэхэд чинь уул уурхайн хяналт нь Уул уурхайн яамнаасаа, байгаль орчны хяналт нь Байгаль орчны яамнаасаа, газрын хяналт, хөдөлмөрийн хяналт нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаасаа, эрүүл ахуйн хяналт нь Эрүүл мэндийн

яамнаасаа, замын хяналт гэдэг юм уу Зам, тээврийн яамнаас явах ийм олон салбарын хяналтууд очиж энэ аж ахуй нэгж байгууллага дээр хүнд суртал, ажлыг нь хийлгэхгүй давхардсан хяналт шалгалтууд хийгдэх ийм эрсдэл бий болж байна гэж миний хувьд хараад байгаа юм.

Нэгдсэн нэг хяналт хийдэг ийм тогтолцоог өнөөдөр задалж, салбарын хяналт руу бид нар оруулж байгаа юм байна. Одоо салбарын хяналтад оруулчих юм бол ингээд сайд нь шийдвэр гаргадаг. Сайдын шийдвэрийн хэрэгжилтийг тэр тухайн сайдын оруулж байгаа хяналт шалгадаг нэг ийм л арга барил руу орох гээд байна шүү дээ. Энэ чинь ер нь явах юм уу, явахгүй юм уу? Энэ Засгийн газар чинь нэгдсэн хөндлөнгийн хяналттай байх нь зөв юм биш үү? Нэгдсэн хяналттай? Тэгээд яагаад, юу болоод энийг нэгтгэхээр болчхов? Хүний амь нас, эрүүл мэндээс хол ийм хяналтуудаа юу гэдэг юм, салбар луу нь өгч болж байна. Соёлын хяналт ч байдаг юм уу, боловсролын хяналт ч байдаг юм уу. Яг энэ хүний амь нас, байгаль орчинтой юу гэдэг юм холбоотой, ийм эрсдэл дагуулсан хяналтуудаа бол нэгтгээд нэгдсэн хяналтаараа явах нь зөв байх л гэсэн ийм байр суурийг илэрхийлээд тэгээд энэ 2 асуулт дээрээ хариулт авъя.

Т.Аюурсайхан: 93 дугаар микрофон дээр ажлын хэсгээс Баасандорж дарга хариулъя.

Б.Баасандорж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Баасандорж Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. 2 дахь асуултаар хуулийн өөрчлөлттэй холбоотой асуулт асууж байна. 2003 онд Монгол Улсад бол нэлээн том өөрчлөлт орсон, 2003 онд Төрийн хяналт, шалгалтын хууль батлагдсанаар хуучнаар 13 улсын хяналтын алба тус тусдаа хэрэгжүүлдэг байсан хяналт, шалгалтуудыг нэгтгэсэн. Энэ бол маш том өөрчлөлт хийсэн. Яг тэр 2003 оноос өмнө бол яагаад өөрчлөх болсон шалтгаан юм бэ гээд зүйлийг

судалж үзэхээр тухайн үеийн яг хуулийн үзэл баримтлал нь өөрөө 2003 оноос хэрэгждэг байсан улсын 13 хяналтын алба тус тусдаа, тус тусдаа дүрэм, журмаар энэ хяналт шалгалтыг зохицуулдаг байсан. Нэгдсэн 1 стандарт, нэгдсэн нэг хууль байхгүй. Тэгэхээр 2003 оны маань энэ том өөрчлөлтийн нэг дэх том зорилт нь бол яг нэгдсэн 1 процессын хуультай больё гэдэг үүднээс Төрийн хяналт, шалгалтын тухай хууль батлагдсан. Энэ Төрийн хяналт, шалтгааны тухай хууль бол өөрөө мэргэжлийн хяналтын байгууллагын хууль биш. Энэ бол хяналт шалгалтыг зохицуулсан процессын хууль байгаа.

Ингээд 2003 онд яг нэгдмэл тогтолцоотой Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг мөн энэ хуулийн 9 дүгээр зүйлээр байгуулж өгсөн байгаа. Энхтүвшин гишүүн бол мэдээж яг маш чухал асуулт асууж байна. Давхардал, тэгээд эрсдэлээ зөв тооцоолох уу гэдэг зүйлүүд бол мэдээж анхаарах ёстой асуудлын нэг. 2003 онд энийг шийдсэн. 2011 онд мөн Төрийн шалгалтын тухай хуульд нэлээн том өөрчлөлт орсон. Энэ нь өөрөө эрсдэл дээр суурилж хяналт шалгалтаа бид төлөвлөдөг болсон. 2003 онд байгуулагдсан төрийн хянан шалгалт маань өнгөрсөн 20 жилийн хугацаанд харамсалтай нь Энхтүвшин гишүүнээ яг өнөөдөр нэгдмэл тогтолцоотой биш болсон. Жишээ нь Энхтүвшин гишүүн бол манай Мэргэжлийн хяналтын байгууллагад ажиллаж байсан, санхүүгийн хяналтын чиглэлээр илүү түлхүү ажиллаж байсан. Тэгэхээр 2003 онд байгуулагдсан Мэргэжлийн хяналтын 30 гаруй хяналтууд 25, 26 хяналтыг л хийдэг болсон. Өөрөөр хэлбэл, 2015 оноос санхүүгийн хяналт хуулиараа өөр байгууллагад шилжсэн, хилийн хорио цээр хуулиар өөр байгууллагад шилжсэн, мал эмнэлгийн хяналт хуулиар өөр байгууллагад шилжсэн, эм, эмнэлгийн хэрэгсэлд хуулиар өөр байгууллагад шилжсэн.

Өөрөөр хэлбэл энэ 2003 онд байгуулагдсан мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоо биш болсон. Дээрээс нь мэргэжлийн хяналтын байгууллага маань хуулиар хүлээдэггүй маш олон чиг үүргүүдийг хүлээдэг болсон. Дүрэм, журмаар нь, хамтарсан төрийн байгууллагуудын тушаалаар. Тэгээд бид нар бас энэ өөрчлөлтийг хийхдээ бид нар олон улсын туршлагыг судалсан. Олон улсын туршлагыг судлахад дэлхий дээр яг манайх шиг мэргэжлийн хяналтын нэгдмэл тогтолцоотой яг 3-4 орон л байгаа. Жишээ нь нэгд нь бол Босния байгаа. Босния бол яг мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоотой яг манайх шиг ийм тогтолцоотой. Бусад яамнууд нь давхцаж хяналт хийдэггүй. Хорват байна. Бас яг манайхтай адилхан тогтолцоотой. Гэхдээ Хорват бол илүү хянан шалгана гэхээсээ илүү зөвлөн тусалдаг, сануулдаг, анхааруулдаг энэ чиглэл рүү илүү түлхүү юм байна лээ.

Манай Монгол улс бол 2003 онд яг Босниатай адилхан мэргэжлийн тийм тогтолцоо байгуулсан боловч өнөөдөр 15 оноос, 14 оноос эхлээд энэ нэгдмэл тогтолцоо маань задраад, давхцал ихсээд өнөөдөр мэргэжлийн хяналтын яг ийм нэгдмэл тогтолцоо өөрөө алдагдсан. Өөрөө эрэмдэг болсон. Тэгэхээр энэ бол өөрөө 2003 онд болгосон мэргэжлийн хяналт маань яг тухайн хуулийн үзэл баримтлалаар байгуулагдсан зүйл биш болсон шүү гэдгийг хэлээд байгаа юм. Мэдээж ингээд салбар салбар луугаа би бол.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн, тодруулах юм уу та? Энхтүвшин гишүүнд микрофон өгье. 80 дугаар микрофон дээр Сангийн яам нэмж хариулья.

Ж.Ганбат: Энхтүвшин гишүүний асуултад хариулья. Бид нар 2023 оны төсөв дээр бол эдийн засгийг тогтворжуулах бодлогын хүрээнд бид нар шинэ хөрөнгө оруулалтыг улсын төсөв дээрээ хэрэгжүүлэхгүй байхаар ингэж авч

үзэж байгаа. Яг энэ хүрээндээ бид нар бүх шатны төсөв дээр энэ бодлогыг бол хэрэгжүүлэх зорилгоор орон нутаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөв дээр бас энийгээ хэрэгжүүлнэ. Тэгээд энэ төсөв дагалдуулаад өргөн барьсан Улсын Их Хурлын тогтоолын 3 дахь заалт дээрээ энэ талаар л бүх шатны орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эх үүсвэрээр 2023 онд шинээр хөрөнгө оруулалт, барилга байгууламж хэрэгжүүлэхгүй гэдэг ийм байдлаар гэж. Энэ бол зүгээр яах вэ, 1 жилийн хугацаанд энэ шинэ хөрөнгө оруулалтаа хийхгүй, тэвчээч гэдэг ийм байдлаар бид нар Макро эдийн засгийн бодлогын хүрээнд энэ арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа. Энийг бүх шатандаа хэрэгжүүлнэ.

Т.Аюурсайхан: Энхтүвшин гишүүнд микрофон өгье. Энийгээ нэг эргэж хараач Ганбат даргаа. Энэ нэг бие даасан аймгууд чинь тэгээд орлого олох гээд тэгээд сургууль, цэцэрлэг, эмнэлгээ бас бариад явдаг, төсвийн ачааллыг бас тодорхой хэмжээгээр үүрч байдаг, улсын төвлөрсөн төсвөөс ганц ч мөнгө авахгүйгээр бие дааж хөгжөөд явж байгаа аймаг шүү дээ. Тэгээд 60, 70 тэрбум төгрөгөөр энэ аймгууд чинь засвар үйлчилгээ хийнэ гэж байхгүй шүү дээ. Бодит амьдрал дээр. Тэр нэг сумын эмнэлэг барих шаардлага байж байна, цэцэрлэг барих шаардлага байж байна, аймгийн төвдөө барилга байгууламж, зам тавих шаардлага байж байна шүү дээ. Тэгээд энийг бусад юу гэдэг юм улсын төвлөрсөн төсвөөс санхүүжиж байгаа аймагтай адилтаж битгий ингэж, ийм дүрэм, журам гаргаач гэж хүсмээр байна.

Хоёрдугаарт, тэр мэргэжлийн хяналт дээрээ та хэд нэлээн сайн акцент хийж сайн харахгүй бол маш том алдаа эндэгдэл гарах вий. Энэ аж ахуй нэгж, байгууллагууд чинь дарамталсан.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Санал хэлж байна. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Цэндийн Сандаг-Очир нарын урилгаар Налайх дүүргийн Чандмань-Налайх орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа асуулт асууна.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Төсөв хэлэлцэж байгаа энэ цаг мөчид бас нэг зүйлийг дахин дахин хэлж, Сангийн яамныхан болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан мөн Улсын Их Хурлын гишүүддээ бас ойлголт, мэдээллийг өгөх зайлшгүй шаардлага байгаа гэдгийг бас би дахиад хэлье. Хүүхэд хамгааллын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш хүүхэд хамгаалах, хөгжлийн чиглэлээр зарцуулсан тооцооллыг харах юм бол яг 2017 онд 900 сая төгрөг, тэгээд он онд бас тодорхой хэмжээнд нэмэгдсээр байгаад 2022 онд нийтдээ нэг 8 тэрбум төгрөгийг бас хүүхэд хамгааллын төсөвт бас тусгаж чадаж байсан байна.

Хэдийгээр бас тодорхой хэмжээний санхүүжилтийг өгч, хүүхэд хамгааллын төсөв нэмэгдсэн ч хүчирхийлэлд өртөх, өртөх өндөр эрсдэлтэй хүүхэд хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн гүйцэд үзүүлж чадахгүй, мөн тасралтгүйгээр явуулах тэр боломжгүй ийм нөхцөл байдал үүссэн хэвээрээ байгаа.

Гэтэл 2023 оны төсөв орж ирэхтэй зэрэгцээд уг нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас нийтдээ 10 тэрбум төгрөг хэмээн төсөвлөж, Сангийн яаманд саналаа өгсөн юм байна. Гэтэл одоо бидэнд орж ирсэн төсвөөр нийтдээ 5.2 тэрбум төгрөг буюу 5 тэрбум 249 сая 999 мянган төгрөг. Өөрөөр хэлэх юм бол өнгөрсөн оны төсвөөс 2 тэрбум 750 сая

төгрөгөөр хасагдсан байгаа юм. Өнөөдөр Монгол Улсын нийт хүн амын 37.7 хувийн 3 хувийг эзэлж байгаа 0-18 нас хүртэлх насны хүүхдүүдээ үзүүлэх үйлчилгээгээ бид ийнхүү танаж байна. Төсөвт танаж болох олон зүйлүүд байгаа. Монголын төр хүүхдүүдээсээ бас харамлаж, хүүхдүүдийнхээ эрсдэлгүй, аюулгүй байдал тэр боломжийг хааж, энэ төсвийн таналтыг хийж болохгүй байх гэдэг байр суурийг илэрхийлэх гэсэн юм.

Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд нийтдээ 11 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаа. Эдгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээс 70 хувь нь л тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгт хамрагдаж чадаж байгаа юм. Үүнээс 30 хувь нь хамрагдаж чадахгүй байгаа. 2022 онд нийтдээ 106 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургууль, цэцэрлэгт хамруулж байсан байна. Гэтэл 23 онд тавьж байгаа төсвөөр 70 хүүхдийг л энэ сургуульд, цэцэрлэгт хамруулж чадах нь. Би хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүддээ хэр анхаарч ажиллаж байгаа вэ? 6 сарын 15-наас Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Боловсролын яам хэр ажиллаж байна вэ гэж мэдээллээ өгөөч гэсэн боловч Боловсролын яамнаас мэдээлэл ирсэн, бусад яамнаас мэдээлэл ирээгүй байгаа.

Өнөөдөр 10 дугаар хороонд үйл ажиллагаа явуулдаг “Энэрэлийн Түүчээ” ТББ-аас над дээр бас албан бичиг ирж байна. Уг нь нийслэлийн удирдлагууд Монгол Улсын төр бас хариуцлагаа үүрээд, нийтдээ 40 гаруй хүүхдүүдийг тусгай цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагаа дэмжээд тэр байранд үйл ажиллагаа явуулж байсан боловч байр чөлөөл гэдэг үүрэг өгсөн.

Нэгдүгээрт, биднүүс хувьсах зардал хасагдсан. Одоо байргүй. Энэ 30 гаруй хүүхдээ бид нар асрах боломжгүй болж байна гэж байгаа юм. Ийм хүмүүсээс бид

нар төсвөө харамлаад байх уу, бид нарын хэмнэгдсэн төсөв чухам хаашаа орж байна вэ гэдэг дээр бас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам тайлбар хэлээч. Бид төсвөө хэмнэж чадаж байна уу? Өнөөдөр 108 хүүхдийн утсанд очоод үз. Хүүхдүүд чинь ямар байранд түр хоргодож байна, түр хамгаалагдаж байна. Бид хамгаалах нэрээр тэр хүүхдүүдийг хорьж байгаа юу? Ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Баярсайхан гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг. Бид очиж үзсэн. Үнэхээр зүрх өвдсөн. Өчигдөр хүүхэд хамгааллын ажлын хэсгийнхэнтэй уулзаад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхны өмнө, Боловсролын яамныхны өмнө нь Эрүүл мэндийн яамныхны өмнө уйлангаа алдлаа. Бид хүүхдүүдээ ингэж хамгаалмааргүй байна, ингэж хайрламааргүй байна, ийм орчинд өсөж байгаа хүүхдүүд бидний ирээдүйг авч явж чадах уу, үгүй юу гэдэг асуултыг би тавимаар байна. Хариултаа авчхаад дараагийнхаа асуултыг тавья.

Т.Аюурсайхан: 82 дугаар микрофон дээр ажлын хэсэг хариулья.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулья. Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ гэж байгаа. Хариу үйлчилгээ гэдэгт бол эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасан зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгдэх үе шат буюу ийм бүтэн нэг циклийг ингээд тойруулж хэлсэн байгаа.

Тэгэхлээр бол Хүүхэд хамгааллын тухай хууль дээр бол өнгөрсөн жил энэ жилийн төсвийг бол батлуулахдаа энэ циклийн норм, норматив яг хэрэгжүүлэх ажлын юу гэдэг юм, тэр схемийг бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Сангийн сайд бол хамтран батална

гэдэг хуулийн заалт оруулаад үүнийх нь дагуу бол тарифаар батлуулаад бид нар бол холбогдох зардлыг бол тавиад явж байгаа. Хүүхэд хамгааллын зардал бол 8 тэрбум төгрөг гэдэг бол өөрөө бол хэвээрээ байгаа. Яг энэ хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ гэдэг зориулалт дээр бол таны хэлсэн саяын дүн бол байж байгаа. Бусад зардлууд нь бол тэгэхлээр хаана байна вэ гэхлээр шатахууны зардал, тэгээд бусад энэ зардлуудаа бол шингэж байгаа. Жишээ нь бол 2022 оны төсөв дээр бол хүүхэд хамгаалалтай холбоотой Өнөр бүл, Олон улсын Найрамдал төв, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн хүүхдийн төлөө газар, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр гэж байгууллагууд байгаа. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа. Эдгээр байгууллагуудын нийт зардал нь бол 31 тэрбум 481 сая төгрөг байгаа. Ирэх жилийн буюу 23 оны төсвийн төсөл дээр яг эдгээр байгууллагуудын зардал бол 31 тэрбум 527 сая төгрөг гээд яг энэ жилийнх нь түвшинд бол ингээд хадгалагдаад байж байгаа.

Өөрөөр хэлбэл бид бол хүүхэд хамгааллын зардлыг бол илүү яг хууль дээр заасан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ гэдэг зориулалт дээрээ, мөн урьдчилан сэргийлэх асуудлыг нь бол урьдчилан сэргийлэх гэдэг зориулалтаар бол ингээд тарааж тавьсан байгаа. 8 тэрбум төгрөгийн зардал нь бол тэгэхлээр байж байгаа.

Т.Аюурсайхан: Жаргалмаа гишүүнд микрофон өгье. Асуултаа тодруулъя.

Б.Жаргалмаа: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн төсвийн төсөөлөл дээрээ яг хэрхэн яаж туссаныг би сая хараад бас мэдээлэл өгсөн л дээ. Энэ дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан өөрсдөө өгсөн төсвийн саналаа бас хамгаалаарай

гэж би хэлэх байна. Үнэхээр 8 тэрбум төгрөг тавигдсан бол сайн байна. Нэмэгдээд төсөвт тавигдчихсан бол сайн байна. Монгол Улсын Засгийн газраас бас хүүхдүүдээ бүрэн цэцэрлэгт хамруулахын тулд бас тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж, хүүхдүүд маань цэцэрлэгт хамрагдаж чадаж байгаа. Өнөөдөр хүүхэд харах үйлчилгээний зардал хэмээн бас энэ төсөв дээр туссан байна л даа. Энэ хүүхэд харах үйлчилгээний зардлыг хэрхэн яг юунд зарцуулж байгаа вэ гэдэг дээр бас тайлбар хэлээч гэдэг зүйлийг хүсэж байна.

Ер нь бол хэмнэж болох зардал гэдэг юм уу, бусад зардлууд дээр яадаг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд дээр илүүтэй их анхаарч өгөөч гэдэг хүсэлтийг тавимаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжлийн төв дээр өнөөдөр Хятадын Засгийн газраас баригдсан том барилга байгаа боловч өнөөдөр бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа. Энэ байгууллагыг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулахын тулд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ямар арга хэмжээ авч байгаа вэ гэдгээ тайлбар хэлээч. Хятадын Засгийн газар том барилга бариад өгчихсөн. Өнөөдөр усан санг нь хариуцсан Монголын компани нь усан эмчилгээнийх нь бассейныг ажиллуулж өгч чадахгүй.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан, танхимд оруулаарай. Дэд сайд ирсэн байгаа юм байна. Танхимд дугаар, микрофон өгөөд хариулт өгнө. Таны хариултыг удахгүй авч өгнө. Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан асуулт асууна. Байна уу? Алга байна. Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн асуулт асууна.

Ж.Чинбүрэн: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Би энэ Монгол Улсын Засгийн газраас 22 оны энэ 23 онд

Төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн энэ хуулийн нэмэлт өөрчлөлтүүдийг ерөнхийдөө дэмжиж байгаа. Тэр дотроо энэ эрүүл мэндийн салбар бол гүйцэтгэлийн санхүүжилтээр яагаад 20 оны өөрчлөлтөөр эмийн агентлаг байгуулсан. Эм, эмнэлгийн хэрэгсэл зохицуулах газар. Энэ газар бол эмийн чанарыг хянах энэ тогтолцоог мэргэжлийн хяналтын байгууллагаас татаад авчихсан. Би бас бүлгийн хурал дээрээс асууж байсан Баасандоржоос. Яг энэ хугацаанд, энэ 2 жилийн хугацаанд, ялангуяа энэ КОВИД цар тахалтай байх хугацаанд бол эмийн агентлаг бас тийм ч муу ажиллаагүй гэж би боддог. Ялангуяа шуурхай ийм технологийн дэвшил рэмдэсвир / remdesivir/ тэрийг бол шуурхай татах, тэр хатгаагаар хүндрэх улсуудыг эд нар шийдэхэд бол нэлээн тийм нэгдсэн худалдан авалт хийх, үйлдвэртэй гэрээ хийх, үнэ хямдхан орж ирэх энэ тэр гээд амжилттай сайн талууд бий боловч яг энэ хугацаанд эмийн чанарт хэр зэрэг дэвшил гарав? Хэдэн чанаргүй эмүүдийг цуцалж чадсан бэ? Зах зээл дээрх үнийн хяналтуудыг хийж чадсан уу?

Тэгэхлээр яг одоо таны энэ оруулж ирж байгаа өөрчлөлт эрүүл мэндийн салбарт түрүүлээд нэг туршилт маягаар явчихсан гэж үзэж байгаа. Тэгэхлээр энэ байдал нь одоо эргээд харахад хэр сайн зөв байсан, юу дутуу байсан бэ гэдгийг. Мөн ялгаагүй Эрүүл мэндийн даатгалын сан бас яг тийм. Гүйцэтгэлээрээ санхүүжүүлнэ. Гүйцэтгэсэн гээд нэхэмжилж байгаа тэр байгууллага болгон үнэн үү, чанартай юу, иргэн бүрийг эмчилж чадсан уу? Эс үгүй бол зөвхөн мөнгөний араас явж байна уу, үгүй юу гэдэг тэрийг шалгах, хянах бас нэг ийм үүрэг байгаа. Тэгэхлээр энэ бүхэнд бүхлээрээ эрүүл мэндийн салбарын гүйцэтгэл, тэр дотроо иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх тэр тогтолцооны л бас нэг илрэл гэж харж байгаа юм. Тэгэхлээр энэ дээр та дэвшил юу байна? Хэлж өгөөч.

Т.Аюурсайхан: 92, 93 Баасандорж дарга. 93 дугаар микрофон.

Б.Баасандорж: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя Баасандорж. 2020 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий гарзын хяналтын чиг үүргүүдийн нэгд бол яг эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт бол байсан. 2020 оны хуулиар Эрүүл мэндийн яаманд яг тусдаа сая гишүүний хэлсэнчлэн агентлаг болоод шилжсэн байгаа. Ингээд агентлагт шилжээд одоо дэвшил тодорхой түвшинд гарсан уу гэвэл би бол гарсан гэж хэлнэ. Гэхдээ юу дутуу байсан бэ гэж та асуулаа. Яг энэ хуулийг батлахдаа нэг зүйлийг орхигдуулсан байгаа. Жишээ нь яг энэ хууль дээрээ тухайн эм, эмнэлгийн хэрэгслийн агентлагт шилжсэн 30 гаруй алба хаагчид маань байцаагчийн эрхийг хэрхэн яаж авах юм, байцаагчийн эрхтэй байх юм уу, үгүй юу?

Мөн зөрчил шалган шийдвэрлэх энэ 31 байцаагч маань төрийн хяналт шалгалтын процесс яваад хэрвээ тухайн зүйл дээр зөрчил үүсэх юм бол шууд зөрчигчийн процесс руу эрх бүхий албан тушаалтан бол ордог. Тэгэхээр энэ асуудлыг нь харьяаллыг нь мөн шийдэж өгөөгүй байсан Зөрчлийн хуулиар. Харьяалал нь хаягдсан Зөрчлийн хуульд. Зөрчлийн хууль дээрээ Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, гэхдээ эм, эмнэлгийн хэрэгсэл дээр хяналт тавина шүү гэдэг нь чиг үүрэг дээрээ шилжүүлчихсэн.

Тэгэхээр энэ байцаагчийн эрхтэй холбоотой, зөрчлийн харьяалалтай холбоотой энэ асуудлуудыг бол маш түргэн шуурхай хуулиар нь шийдвэрлэж өгөх нь зүйтэй гэж харж байгаа юм. Би Эрүүл мэндийн яаманд энэ хяналт очсоноороо би бол зөв гэж харж байгаа юм. Юу зөв вэ гэвэл бодлого, хэрэгжилт, хяналт 3 нэг дор очиж байгаа. Яагаад гэвэл бодлого, хэрэгжилт, хяналт 3 хоорондоо салшгүй холбоотой.

Хяналтаараа илэрсэн маш олон зөрчлүүдийг илрүүлээд бодлого өөрөө сайжирна. Эргээд хэрэгжилтдээ нөлөөлнө, ахиад тэрийгээ хяналт нь салбар салбар бүртээ хянадаг. Ер нь олон улсын нийтлэг жишиг нь бол өөрөө салбар салбартаа бодлогоо барьдаг. Хүнсний чиглэл нь хүнсэндээ, эрүүл мэндийн чиглэл нь яг эрүүл мэнд чиглэлдээ. Ер нь мэргэжлийн хяналт дотор бол хамгийн эрсдэл өндөр 3 хяналт бол ялт ч үгүй таны саяын хэлсэн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, байгаль орчны аюулгүй байдал. Энэ 3 бол маш эрсдэл өндөртэй хяналт байгаа.

Тэгэхээр энийг салбар салбарт нь яг бодлоготой нь уялдуулаад, хэрэгжилттэй нь уялдуулаад хараат бусаар хяналт шалгалтаа хийх юм бол энэ дэвшил гарна. Олон улсын жишигт нийцсэн дэвшил гарна гэж үзэж байгаа юм.

Т.Аюурсайхан: Чинбүрэн гишүүнд микрофон уу? Тодруулъя асуултаа.

Ж.Чинбүрэн: Ер нь яг би бас тантай санал нэг байна. Ер нь бол Эрүүл мэндийн яам өөрөө гүйцэтгэдэг биш, өөрөө худалдан авалт хийдэг биш, энэ эмнэлгийн тусламж нь эмнэлэг дээрээ очоод бие даасан тогтолцоогоороо төлөөлөн удирдах зөвлөлөөрөө хагас бие даасан тогтолцоо руугаа ороод, харин Эрүүл мэндийн яам гүйцэтгэлийг худалдаж авдаг. Худалдан авалтаараа дамжуулан санхүүжилтээ хийчихдэг, бодлогоо хэрэгжүүлдэг, тэр нь хэр зэрэг чанартай вэ гэдгийг хянадаг энэ тогтолцоо зайлшгүй шаардлагатай. Тэх, тийм учраас энэ бол зөв гэж үзэж байна. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг асуулт асууна.

Ё.Баатарбилэг: Гишүүдийнхээ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр Засгийн газраас өргөн барьсан энэ төсөв дагасан

дагалдах хуулиудтай холбоотой 2, 3 зүйл байна. Энэ 2020 оны 8 сард энэ Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар явж байсан энэ спортын магадлан итгэмжлэгдсэн клубүүдээр үйлчлүүлсэн энэ үйлчлүүлэгчдийг эрүүл мэндийн даатгалаас бас л олговор олгох тийм нэг юм явж байгаад хасагдчихсан юм. Тэгээд 21 оны 1 сараас ингээд энэ бол боломжгүй гээд. Энэ агуулга нь бол эрүүл мэндийн даатгал төлөөд байгаа, идэвхтэй ажил хийж байгаа энэ залуучууд дунд насныхан ингээд эрүүл мэнддээ анхаарснаараа эрүүл мэндийн даатгалынхаа шимийг хүртэхгүй байна, тодорхой эрүүл мэнддээ анхаарч ингэж эмнэлгээр үйлчлүүлээгүй энэ улсуудаа бас биеийн тамир, спортоор хичээллэж байгаа энэ байдлыг нь дэмжиж урамшуулъя гэдэг агуулгатай л ийм юм явж байгаад төсөвт суучихсан явж байгаад, энэ даатгалын юунд явж байгаад хасагдчихсан юм л даа. Тэгээд одоо бид нар ингээд нэг суман дээр нэг спорт заал барихад хүртэл нэг соёлын төв барихад хүртэл ер нь суманд спорт заал, соёлын төвөөр яах гээд байгаа юм гэдэг юм хүртэл яриад тэр суманд ажиллаж амьдарч байгаа иргэдийн нийгмийн асуудал бол дараагийн асуудал, Улаанбаатар хот нэгдүгээр асуудал болчхоод байна шүү дээ. Энэ Үндсэн хуулийн бүр асуудал шүү. Хүний эрхийн асуудал.

Тэгэхээр энэнтэй холбоотой би ямар зүйл тодруулж асуух гээд байгаа юм гэхээр нэгдүгээрт, яг энэ дээр эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдийн яг энэ эрүүл мэнддээ анхаарч байгаа иргэдэд тэр спортоор хичээллэх, нийтийн биеийн тамираар хичээллэх энэ боломж дээр нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй юм бол эрүүл мэндийг дэмжих сан гэж байна шүү дээ. Тусгай сан дотор. Эрүүл мэндийг дэмжих сангийнх нь журамд нь өөрчлөлт оруулаад ингээд явуулах боломж байна уу? Эрүүл мэндийг дэмжих сан бол одоо энэ Монгол Улсад импортоор орж ирж байгаа архи, тамхи, энэ үйлдвэрлэж

байгаа архи, тамхины энэ онцгой албан татварын 1 хувийг ингээд төвлөрүүлдэг, жилд тодорхой уг нь бол дүнгээрээ бол 10 гаруй тэрбум төгрөг төвлөрүүлэх боломжтой ийм хуулиараа бол сан юм байна лээ. Яах вэ, юунаас улсын төсөв батлахад бол нэг 3 тэрбум төгрөгийг л хуваарилж өгдөг юм байна.

Тэгвэл иргэд энэ эрүүл мэнддээ анхаараад идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллээд ингэж байгаа иргэдэд эрүүл мэндийн хөгжлийн сангаасаа тэр дэмжлэг, урамшууллыг нь өгөөд явах ямар боломж байна? Энэ тал дээр энэ Сангийн яамны нөхдүүд хэрвээ хуульд нь, журамд нь өөрчлөлт оруулаад явбал боломж байна уу? Жишээлэхэд өнгөрсөн жил Эрүүл мэндийн яамнаас энэ эрүүл мэндийн хөгжлийн сангаас олгосон төслүүд дотор ерөөсөө энэ идэвхтэй, эрүүл амьдралын төлөө дасгал, хөдөлгөөн хийлгэсэн, иргэдийн дунд ийм биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулсан, иргэдэд идэвхтэй чийрэгжүүлэлтийн дасгал сурталчилж, үндэсний сургагч багш бэлтгэсэн гээд дандаа спортын эрүүл мэндийн чиглэлийн спортын арга хэмжээнүүдийн төслүүд шалгарсан гээд ингээд тайлангууд нь байж л байна л даа Эрүүл мэндийн яамнаас.

Тэгвэл эдгээрийгээ ингээд яг энэ олимпиадын спорт хариуцсан сайдтай болчихлоо. Сайд энэ дээр бас ямархуу байр суурьтай байгаа юм? Энэ архи согтууруулах ундаанаас олж байгаа энэ онцгой албан татварын тодорхой хувийг энэ эрүүл мэндийн хөгжлийн санд төвлөрүүлж байгаа бол энэ Эрүүл мэндийн дэмжих сангаасаа яг энэ рүү нь энэ 2 сайдын хамтарсан тушаалаар юм уу, энэ сум орон нутагт байгаа спортын клубүүд, энэ спортоор хичээллэж байгаа энэ орон нутгийн иргэдээ дэмжих, урамшуулал олгох энэ юм руугаа журамд нь өөрчлөлт оруулаад явбал яадаг юм гэсэн ийм асуулт байна. Тэгээд энэ дээр Сангийн яам, Биеийн тамирын сайд 2

хариулаадахвал би дараа нь тодруулж нэг зүйл асууя.

Т.Аюурсайхан: Ганбат дарга 80 дугаар микрофон дээрээс хариулъя эхлээд.

Ж.Ганбат: Баатарбилэг гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн даатгалын сан маань өөрөө зорилго нь өөр. Хүн бол өөрөөр хэлэх юм бол энд эмчилгээ, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө өөрийнхөө төлсөн мөнөөсөө ингээд энэ даатгалаас санхүүжилтийг нь аваад ингээд явах зориулалттай. Эндээс бол тэгэх дээр яг бол даатгалаас бол ийм төрлийн үйлчилгээг бол санхүүжүүлэх бол энэ бол энэ даатгалынхаа үндсэн чиг үүрэг, зарчимтай бол нийцэхгүй учраас энийг бол эрүүл мэндийн даатгал санхүүжүүлэх боломжгүй.

Эрүүл мэндийг дэмжих сангаас бас энэ хараа яг энэ төрлийн арга хэмжээг санхүүжүүлэх нь зөв үү, буруу юу гэдэг ийм асуудал яригдана. Яах вэ, Сангийн яамны хувьд бид үүнийг бол эрүүл мэндийг дэмжих сан маань өөрөө зорилго нь бол хууль дээрээ бол энэ халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэгээд эрүүл мэндийн гэсэн ийм зорилгоор. Тэгээд эрүүл мэнд дэмжих сангийн хөрөнгөнөөс аливаа татаас, урамшуулал, тусламж олгохыг хориглоно гэсэн ийм зориулалттай байгаа юм.

Нөгөө талдаа бид бол, ер нь тусгай сангийн хууль, энэ Засгийн газрын тусгай сангуудыг бол бид 17 оноос, 18 оноос бол нэлээн цэгцэлсэн. Ер нь бол энэ тусгай сангаар энэ янз бүрийн юмнуудыг явуулж байх нь бол бас зохимжгүй. Энэ эрүүл мэндийг дэмжих сан гэдгийгээ бас үйл ажиллагаатай, энэ төрлийн үйл ажиллагаанд тэр зөв үү гэдэг асуудал дээр бол нэлээн маргаан үүсээд байгаа. Бид бол энэ дээр Сангийн яамныхаа байр суурь бол ийм төрлийн үйл ажиллагааг ер нь иргэд өөрсдийнхөө хариуцлагын хүрээнд, өөрсдөө энэ дээрээ бас тодорхой

хэмжээний үүрэг хариуцлагаа хүлээгээд энэ төрлийн зардлыг бол өөрсдөө нэгт даах.

Хоёр дахь нь биеийн тамир, спортын нөгөө нийтийн биеийн тамирынхаа арга хэмжээний хүрээндээ энэ асуудлуудаа зохицуулаад явбал ямар боломж байгаа юм бэ гэдэг ийм байдал байгаа. Нөгөө талдаа бид биеийн тамир, спортын талаар татварын бодлогоор бол дэмжлэг үзүүлсэн юмнууд бол байгаа. Энэ дээр бол бид нар янз бүрийн биеийн тамир, спортын чиглэлийн барилга байгууламж эндээ хөрөнгө оруулалтын зардал дээр нь тодорхой хэмжээний хөнгөлөлт үзүүлдэг. Спортыг дэмжих санд спортын холбоо, клубийн хуулиа дэмжих зорилгоор 10 хүртэл сая төгрөгийн хандив мөн хасах зардлаа тооцох энэ тэр гээд ийм дэмжлэгүүд бол байгаа.

Т.Аюурсайхан: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ сайд нэмж хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баатарбилэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр өмнө нь 2, 3 парламентын бүрэн эрхийн хугацаанд энэ асуудлыг ярьж байгаад тэгээд эрүүл мэндийн даатгалаасаа эрүүл мэндээ хамгаалах, эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх энэ үйл ажиллагаанд бас тодорхой хэмжээний магадлан итгэмжлэгдсэн фитнес клубүүдэд тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх ийм хуулийн зохицуулалт ороод ингээд бас нэлээн үр дүнтэй. Ер нь эхлэлийн хувьд бол 16 клуб зөвхөн Улаанбаатар хотод биш томоохон төвлөрсөн Эрдэнэт, Дархан хэд хэдэн аймгуудад хэрэгжээд явсан юм л даа. Тэгээд яах вэ, 19 онд шиг санаж байна. Энэ төсөв дагасан хуулиар энийг бол ингээд КОВИД-ын нөхцөл байдал хөдөлгөөн хязгаарласан ийм үед энийг хүчингүй болгоно гээд ингээд оруулж ирээд дагасан хуулиар хүчингүй болгочихсон юм байгаа юм.

Тэгээд одоо ингээд энэ асуудлаа сэргээх тухай асуудал ярихаар Сангийн

яам, Эрүүл мэндийн яам бол энэ зориулалт нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад зориулагдсан ийм Эрүүл мэндийн даатгалын сан учраас энэ бололцоо байхгүй байна гэж ингэж үзэж байгаа юм. Тэгэхээр зэрэг эрүүл мэндийг дэмжих сангийн саяын таны хэлж байгаатай бол санал нэг байна л даа. Эрүүл мэндийг дэмжих сангаасаа тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх юм бол өмнө нь шалгаруулсан төслүүдэд бас биеийн тамир, эрүүл мэндийн чиглэлийн ийм төслүүдийг шалгаруулаад явж байгаа ийм зүйлүүд байгаа юм байна.

Тэгэхээр бол Засгийн газрын баримталж байгаа зарчим бол энэ зөвхөн биеийн тамирыг төдийгүй соёл урлагийн энэ байгууллагуудыг либералчлах, ялангуяа улсын төсөв бүгдийг нь нуруун дээр үүрэх тийм бололцоо байхгүй учраас энэ хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тодорхой, бүр тодорхой газрын үл хөдлөх хөрөнгийн оруулж ирж байгаа тоног төхөөрөмж, яг тэр зориулалтынхаа дагуу орж ирж байгаа материал хэрэгслээс нь чөлөөлөх ч байдаг юм уу, тодорхой хэмжээгээр энийг нь дэмжлэг үзүүлэхгүй бол болохооргүй байна л даа.

Сүүлийн жилүүдэд бол нэлээн энэ хувийн хэвшлийнхний идэвх оролцоо бол нэлээн нэмэгдсэн. Та бид нарын сайн мэдэх энэ “Steppe Arena” гээд өвлийн спортын цогцолбор ордон байна. Энэ “Уранган” гэдэг компани Америкийн сагсан бөмбөгийн Лигийн ийм стандартыг хангасан спортын заал, танхим, иж бүрэн цогцолборыг барьж байгуулсан, Мөнхийн үсэг компани одоо томоохон спортын цогцолбор барьж байгуулсан гээд ингээд дурдах юм бол олом байгаа юм.

Тэгэхээр энэ бол эргүүлж нөгөө оруулсан хөрөнгө оруулалтаа эргүүлэн нөхөх гэдэг юм уу, ашгийн байх тийм бололцоогүй байгаа учраас ийм аж ахуй

нэгж байгууллагуудыг яаж хөхүүлэн.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Баатарбилэг гишүүнд 1 минут өгье.

Ё.Баатарбилэг: Тэгэхээр саяын энэ эрүүл мэндийг дэмжих сангаас яагаад ийм дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна гээд байхаар сая спорт хариуцсан сайд Бат-Эрдэнэ сайд хэлж байна л даа. Хөдөө орон нутагт одоо ингээд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нөгөө спорт, клубүүд, соёлын төвүүд гээд барихгүй гээд байдаг. Хувийн хэвшлийнхэн өөрсдийнхөө хөрөнгөөр барихаар тэр нь ямар ч ашиггүй болчихоод байгаа болохоор хувийн хэвшил барихгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр төр, хувийн хэвшлийн түншлэл саяын энэ либералчлах бодлогын хүрээнд тэнд сумын төвд хувийн хэвшлийнхэн сайхан заал барьчихад тэнд нь тодорхой төрөөс дэмжлэгтэйгээр иргэдийг нийтийн биеийн тамир, дасгал хөдөлгөөнд уриалж оролцуулах боломжийг л хангахад ямар боломж байна л гээд. Тэгвэл наад улсын төсөв дээр ингээд гишүүдэд тойрогтоо ингээд нэг заал барих гээд ингээд зүтгээд байх, ингээд төсөв төсөв рүү дайраад байх ямар ч шаардлагагүй болох юм байгаа юм. Энэ агуулгаар энэ энэ тал руугаа жаахан бодлогоо явуулбал яасан юм гэдэг ийм санаагаар л энийг яриад байгаа юм л даа.

Т.Аюурсайхан: Бат-Эрдэнэ сайд хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр бид нар “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр, Засгийн газраас өнөөдөр дэвшүүлж байгаа энэ биеийн тамир, спортын салбар, урлаг, соёлын энэ салбараараа нийгэмд эерэг хандлага бий болгоё. Ялангуяа энэ биеийн тамир, спортоор дамжуулаад энэ биеийн тамир, спорт бол хүний хөгжлийн

чухал хүчин зүйл байна. Энэ биеийн тамир, спортоор дамжуулаад хүн амынхаа эрүүл, идэвхтэй амьдрал, энэ эрүүл мэндийг нь хамгаалах, урьдчилан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх энэ тун, хүний хөгжлийнх нь суурийг нь бүрдүүлье. Ингээд энэ 2050, 50 он гэхэд бол манай улсын эдийн засаг 10 дахин нэмэгдэнэ. Хүний хөгжлийн индексээрээ тэргүүлэх зэрэгт хүрнэ. Энэ үед бол Монгол Улс олимпын дэлхийн хүн төрөлхтний эв нэгдлийн энэ их баяр наадам, олимпыг зохион байгуулах ийм бүрэн бололцоо гарна. Олимпыг зохион байгуулах тийм том зорилт тавиа гэж Ерөнхий сайд.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Баатарбилэг гишүүнд 1 минут өгье.

Ё.Баатарбилэг: Дараагийн нэг асуудал энэ төсөв дээр энэ хүүхдийн мөнгийг тодорхой хувиар бууруулж, тодорхой 60 гаруй тэрбум төгрөгийг хэмнэх, хэмнэх юу байх вэ дээ. Энийг Ирээдүйн өв сан руу төвлөрүүлэх нэг ийм асуудал явж байгаа юм байна лээ. Энэ төсөв дээр. Үнэхээр тийм 60 гаруй тэрбум төгрөгийн асуудал явж байгаа бол энийгээ тэр хүүхдүүд рүүгээ хүүхдийнхээ эрүүл мэнд, боловсрол руу хандсан юм руу оруулбал яадаг юм гэдэг энэ саналыг хэлэх гээд байгаа юм. Ийм боломж байна уу? Нөгөө багш нарыг компьютержуулах асуудал чинь зуун задгай байгаа. Энэ рүүгээ хэдэн төгрөгийг нь оруулаад. Саяын энэ спортыг яриад байгаа энэ хүүхдийн эрүүл мэнд, спортоор хичээллэх ийм юм руу оруулаад одоо энэ Ирээдүйн өв сангийн чинь мөнгийг яг ийм хүнд цаг үед л зарцуулна гэж үндсэндээ бол хуримтлал үүсгэж явж байгаа шүү дээ. Тэгээд тэр хүнд цаг үе чинь ирчхээд байна. Маш их хүндрэлтэй асуудлууд байгаа. Энэ үед энэ зайлшгүй нийгэмд тулгарсан энэ асуудлууд руугаа оруулаад явахгүй юм уу гэдэг ийм боломж байна уу гэдэг ийм зүйлийг Сангийн яамны нөхдөөс асуугаад байхъя.

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Дархан-Уул аймгийн Дархан сумын “Дархан-Эмпати” сургуулийн багш, ахлах ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

40 дүгээр микрофон дээр Сангийн яам нэмээд хариулъя даа. Гүйцээгээд хариулъя. 80 наяд дээр уучлаарай.

Ж.Ганбат: Баатарбилэг гишүүний асуултад хариулъя. Бид 2023 оны төсөв дээрээ эдийн засгийг тогтворжуулах ийм яаралтай бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм гэж үзээд энэ хүрээндээ бид нар төсвийн урсгал зардлыг хүн амын тооны өсөлт болон Улсын Их Хурлаар батлагдсан хууль, эрх зүйн орчинд нөлөөлсөн бусад урсгал зардлыг 22 оны түвшинд нь бол бид нар нэмэгдүүлэхгүй ингээд барьж байгаа. Тэгээд шинэ хөрөнгө оруулалт бол нэмэгдүүлэхгүй, шинэ хөрөнгө оруулалт бол ингээд ирэх жил бол байхгүй гэдэг ийм байдлаар төсөв мөнгөний бас жоохон хатуу бодлого барьсан ийм төсөв бол өргөн барьж байгаа юм.

Энэ хүрээндээ бид хүүхдийн мөнгийг бол боломж орлогын хувьд бололцоотой хүмүүс нь бол хүүхдийн мөнгөнөөс бол татгалзаач гэдэг ийм байдлаар бол оруулж ирсэн байгаа юм. Тэгээд бид нар төсвийн алдагдлаа бол сайжруулаад өргөн барьчихсан, бүх тэнцлээ ингээд бариад өргөн барьчихсан учраас тэр хэмнэгдэж байгаа мөнгийг тийм юманд зарцуулна, ингэж тийшээ өгнө гэх дээр бол тийм бас боломжгүй л дээ. Яг шулуухан хэлэхэд нэгд.

Хоёр дахь нь бол Ирээдүйн өв сангаас бид КОВИД-ын үед бол 1 жилийнхээ, энэ 22 оны хувьд бол КОВИД-ын ийм хүндрэлтэй байгаа үед хүүхдийн мөнгийг Ирээдүйн өв сангаас

санхүүжүүлэх гэхээр Улсын Их Хурал хууль батлагдсан. Одоо бид КОВИД-оос өнгөрсөн эдийн засгаа бид нар ингээд боломжтойгоо уялдуулаад хүүхдийн мөнгийг бид улсын төсвөөс санхүүжүүлэхээр ингээд тусгачихсан. Яг Ирээдүйн өв сангийн маань хуулиар бол 2035 он хүртэл бол бид Ирээдүйн өв санд бол гар хүрэхгүйгээр хуримтлуулах бол ийм хуулийн үндсэн заалттай. Бид бол яах вэ, яг КОВИД-ын сүүлийн 2 жилийн хүндрэлтэй нөхцөл байдал бол давчихсан. Энэ хүний хувьд бол бид бол ирэх жилийн гол зорилго бол КОВИД-ын өмнөх үед бол эдийн засгаа хүргэнэ гэдэг ийм том зорилт тавьж байгаа учраас ирэх жилийг бол бид нар хүндрэлтэй үеэ давчихсан учраас бид Ирээдүйн өв санг бол дахиж бол хэрэглэхгүй гэдэг ийм зарчмыг барьж бол төсөв боловсруулсан байгаа юм.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн, танаас асуусан уу нэмж? Бат-Эрдэнэ сайд гүйцээж хариулъя. 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Баатарбилэг гишүүний асуултад би гүйцээж хариулъя. Тэгэхээр би түрүүн хэллээ Монгол Улсын Засгийн газар, түүний тэргүүн Ерөнхий сайд, 2050 онд Монгол Улс бол эдийн засгийн хүчин чадлаараа, хүний хөгжлийн индексээрээ, ер нь хөгжлөөрөө олимп зохион байгуулах тийм түвшинд хүрнэ. Тийм учраас бүгдээрээ 2050 онд Монгол Улсад олимп зохион байгуулъя гэдэг том зорилт тавиад байгаа юм.

Тэгээд энэ хүний хөгжлийн суурийг хангах чухал нөхцөл болсон биеийн тамир, спорт руугаа, ялангуяа нийтийн биеийн тамир руугаа хангасан бодлого хэрэгжүүлье гэхээр зэрэг өөрөө өөрийнхөө хөдөлмөрийн хөлснөөс эрүүл мэндийн даатгал төлж байгаа тэр хөрөнгө мөнгөнөөсөө ашиглах, зарцуулах эрх байхгүй. Өчнөөн олон мянган хүн эрүүл мэндээ өөрөө хамгаалаад бэхжүүлээд эмнэлгийн ямар нэгэн тусламж үйлчилгээ, эм тариа элдвийн юманд

орохгүй ингээд яваад байгаа юм. Тэгтэл тэр бодлогыг нь хаагаад өгье. Эрүүл мэндийг дэмжих, сангаас зарцуулах эрх байхгүй. Дээрээс нь манай төсөвт нийтийн биеийн тамирын зардал бол тун.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан асуулт асууна.

Ц.Туваан: Төсвийн тухай хууль дагаж орж ирж байгаа хуулиудын талаар хэлэлцэгдэж байна. Тэгээд энэ дээр бас 82 хуульд дагалдаж өөрчлөлт орж байгаа юм байна. Энэ дотор анхаарал татаад байгаа асуудлуудын нэг нь энэ хүүхдийн мөнгөтэй холбоотой асуудал. Тэгэхээр гаргалгаа нь юу юм? Аль хуульд өөрчлөлт оруулж гарах юм? Миний сонссоноор Халамжийн тухай хууль руу оруулж гарах юм биш үү? Тэгээд ингээд нөгөө халамж гээд юм чинь нөгөө халамж гэдэг үг чинь ерөөсөө хэцүү болчихлоо шүү дээ. Хавтгайрсан халамж гээд. Тэгэхээр ингэж гарах нь зөв үү? Яг хүүхдийн мөнгөнд хэдэн төгрөг, хэдэн тэрбум? Ойролцоогоор 2.4 их наяд юм шиг санаж байна. Мөнгө байгаа. Тэгээд тэндээс 91.9 хувь дээр нь хэдэн төгрөг хэмнэх гээд байгаа юм бэ? Ингээд хүүхдүүдээ бас ингээд тэр хүмүүсийн, боломжийн амьдралтай хүмүүсийн татгалзах санал гаргана гээд байгаа юм. Тэгэхээр энийгээ яаж ялгах юм, ялгах ийм боломж байгаа юм уу гэдэг ийм зүйл дээр тодорхой хариулт авъя.

Тэр төрийн захиргааны албан хаагч дээр бол энэ орон нутгийн нэмэгдэл гээд түрүүн би бас асуултад асуусан, тэгээд энэ дээр ямар хуульд сууж өгөх юм? Бас яг хэдэн төгрөгөөр нэмэгдэж байгаа юм бэ? Энэ 20 хувиа тодорхой хэлчхээч. 80 хувь бол яг ний нуугүй хэлэхэд би тэр 2, 3 аймгаас бусад газар дээр бол энэ төсвөөс татаас авч байгаа аймаг дээр бол яаж нэмэх вэ дээ. Тэр бол жоохон худлаа л гэж ингэж хараад байгаа юм. Энэ дагаж орж байгаа хууль нь дотор энэ нийгмийн даатгалын хуульд өөрчлөлт орж байгаа.

Бид нар өнгөрсөн жил Нийгмийн даатгалын ерөнхий хууль, түүнийг дагасан багц хуулиудыг Засгийн газар өргөн барьсан, чуулган руу орж ирэхийн өмнө хууль санаачлагч татаж авсан. Тухайн үед бол маш хурдан хугацаанд өөрчлөлтүүд оруулж ирнэ гэдэг хариулт хэлсэн. Тэгээд одоо болтол байхгүй байгаа. Энэ хууль хэлэлцэхээр дагаж нэг асуудал гарч ирэх нь. Энэ тэтгэврийн нэмэгдлийн асуудал бол гарч ирнэ. Тэгэхээр энэ дээр санхүү эдийн засаг ийм хүнд байгаа ийм үе гэж ойлгоод тэгээд энэ асуудал нь орж ирэхгүй л байгаа юм л даа.

Тэгэхээр энэ дээр яг бодитойгоор энэ цалин, тэтгэврийн асуудал чинь ер нь өнөөдрийн энэ үнийн хөөргөдөл энэ тэрнээс чинь бол хол хоцорч байгаа. Тэгэхээр энэ нийгмийн даатгалын хууль дотор чинь энэ тэр өргөн барьсан хэмжээнд нь энэ хуулиуд нь орж ирж байгаа юу гэдэг нэг асуулт байна.

Дараагаар нь энэ хяналтын асуудал чинь ингээд задрах нь л дээ. Салбар салбар руугаа явж байгаа. Бүх асуудалд 2 юм байгаа. Хүн өөрөө өөрийнхөө салбар, ер нь өөрөө өөртөө хяналт тавина гэж бол бараг байхгүй дээ. Тэгэхээр яах вэ, өөрөөсөө дооших түвшинд бол хяналт тавих л байх. Нэгэнтээ энэ асуудал ингээд ороод ирж байгаа дотоод хяналтыг хэрэгжүүлэх гэж байгаа нэг талаараа зөв байх. Тэгэхээр энэ хяналтын бүх яам мэдээж өөр өөрс дээрээ хяналтаа авахгүй байх. Энэ хяналттай холбоотой бүтэц чинь яг ямар байдлаар үлдэж байгаа вэ? Энэ дагалдах хуулиуд дээр чинь яаж тусаж байгаа вэ гэдэг асуудлыг асууя.

Тэгээд ер нь бол энэ шинэ хөрөнгө оруулалт байхгүй гэдэг нэрийн дор энэ мэргэжлийн хяналтаар зайлшгүй нураах шаардлагатай ан цав үүсчихсэн, хүүхэд сурах боломжгүй, эмнэлэг байх боломжгүй ийм газрууд байгаа. Тухайлах юм бол Төв аймгийн Баян сумын хүн эмнэлэг, Угтаалцайдам сумын Ерөнхий

боловсролын сургуулиуд гээд. Шинэ хөрөнгө оруулалт тавихдаа энэ мэргэжлийн хяналтаар орчихсон юмнуудаа тавьж болоогүй юм уу? Тэгэхээр энд чинь 1 жил, 2 жил дахиад яг ийм энэ нөхцөл байдлаас болоод нурах аюултай, иргэдийн амь нас, эрүүл мэндэд хүндрэлтэй байгаа ийм объектууд чинь шийдлээ хүлээгээд л ингээд л хоцорч байна л даа. Тэгэхээр энэ дээр яг тийм акт юм гарчихсан газруудаа онцгойлж авч үзэж болоогүй юу гэдэг асуултыг асууя.

Т.Аюурсайхан: 80 дугаар микрофон дээр Ганбат дарга хариулья.

Ж.Ганбат: Хүүхдийн мөнгөтэй холбоотой бид нар Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа. Энэ бол энэ 22 оны төсвийн тухай хууль дээр бол бид бол халамжаас нь гаргаад Ирээдүйн өв сангийн хуульд нь өөрчлөлт оруулаад иргэдийн хувь сонгоод санхүүжүүлнэ гээд заачихсан байснаа буцаагаад бид нар яг өмнөх хуулийнхаа дагуу халамжийн хууль дээр нь өөрчлөлт оруулаад нэгт хүүхдийн мөнгөн тэтгэмж гэдгийг 13.1.6 дахь заалт болгоод буцаагаад оруулчхаж байгаа. Мөн энэтэй холбогдуулаад хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журмыг Засгийн газар батална гэдэг ийм болон орц оруулсан.

Ер нь бол өмнөх жилүүдэд, КОВИД-оос өмнөх жилүүдэд бол хүүхдийн мөнгийг нийт хүүхдээ 60 хувьд олгоод л явж байсан үе бол байгаа. 80 хувьд олгоод явж байсан ийм үеүд байгаа л даа. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаман дээр орлогыг орлуулан тооцох аргачлал гээд Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд дэмжлэгтэйгээр энэ аргачлалыг нь бол батлуулаад ингээд бэлэн болчихсон байж байгаа. Энэ аргачлалынхаа хүрээнд орлогыг орлуулан тооцох аргачлалын хүрээндээ энэ айл өрхүүдийнхээ орлогыг нь бол авч үзнэ.

Тэгээд бид бол хамгийн бололцоотой дээд хэсгийнхээ хэмжээнд

хүүхдийн мөнгөнөөс татгалзана гэдэг ийм байдлаар. Жишээ нь юу гэдэг юм. Оюу толгойд ажиллаж байгаа компанийн захирал сарын 10, 20 сая төгрөгийн цалинтай, өрхийн орлого нь 10, 20 сая байдаг. 20, 30 саяд байгаа энэ айлуудыг бол хүүхдийн мөнгөнөөс бол татгалзана гэдэг ийм байдлаар бол тооцож бид нар 9 хувьд нь бол хүүхдийн мөнгөнөөс татгалзах гэж бол оруулж өгсөн байгаа. Орон нутгийн нэмэгдлийн 20 хувийг бол бид нар төсөвт нь орон нутгийн суурь зарлагад нь тооцоод нийтдээ 33 тэрбум төгрөгийг нийт улсын хэмжээгээр орон нутгийн суурь зарлагын төсөвт нь орон нутгийн нэмэгдэл 20 хувийг бол тооцоод тусгачихсан байгаа. Тэгэхдээ төсөв батлагдсаны дараа орон нутаг бол энийгээ иргэдийн хурлаараа батлахдаа тэр суурь зарлагаасаа энэ орон нутгийн нэмэгдлээ тусад нь яг энэ арга хэмжээгээ хэрэгжүүлэхээр батлах ийм бүрэн бололцоотой гэж ийм байгаа.

Таны хэлснээр мэргэжлийн хяналтын дүгнэлт гарчихсан байруудыг оруулж болоогүй юм уу гэдэг дээр ер нь бол энэ бид нар ирэх жилийн төсөв дээр ТЭЗҮ, зураг төсөв боловсруулахтай холбоотой 80 тэрбум төгрөгийг тавьсан. Ер нь бид бол сая хэмнэлтээ бол Улсын Их Хурлаар батлагдчихсан. Төсвийн хууль нь байгаа ерөөсөө зураг төсөв, ТЭЗҮ нь энэ дээрээ ирэх жилдээ анхааръя. Тэрний дараа шинээр барих барилга байгууламжийн асуудлаа 24 оноос дахиж авч үзье гэдэг ийм байдлаар оруулж ирсэн байгаа. Тэтгэвэртэй холбоотой нийгмийн даатгалын шинэчлэлийн багц хуулийг бол нийгмийн хамгааллын.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Нийгмийн хамгааллын дэд сайд нэмж хариулья. Туваан гишүүний асуултад. 96 дугаар микрофон 1 дүгээр индэр дээр. Яасан? Туваан гишүүний асуултад нэмж хариулна шүү.

С.Зулпхар: Улсын Их Хурлын гишүүддээ энэ өдрийн амар амгаланг

айлтган мэндчилье. Жаргалмаа гишүүний асуултад хариулъя.

Т.Аюурсайхан: Туваан гишүүний асуултад нэмж хариулна. Жаргалмаа гишүүний асуултыг дараа нь би өөрөөс чинь авна. Сая асуултууд асуусан шүү дээ.

С.Зулпхар: Туваан гишүүний асуулт дээр би хоцорч орж ирээд сонссонгүй гишүүн. Би тэрийг бичээд аваад дахиад хариулъя.

Т.Аюурсайхан: Бүтэн сууж байсан шүү дээ. Тодруулах юм уу Туваан гишүүн?

С.Зулпхар: Тодруулъя.

Т.Аюурсайхан: Туваан гишүүнд микрофон өгье.

Ц.Туваан: Нийгмийн даатгалын ерөнхий хууль, дагалдах хуулиуд чинь хаачихсан бэ? Юу болсон бэ? Энэ төсөв дагаж орж ирж байгаа хуулиуд дээр чинь энэ дотортой холбоотой ямар нэгэн зүйл, заалтууд байна уу? Энэ дагалдаж орж ирж байгаа 82 хууль дотор чинь Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах гээд байна. Энэ талаар л асуусан юм.

Хоёрдугаарх нь тэр хяналтын чиг үүргүүд задраад яамнууд руугаа, тодорхой яамнууд руу очиж байгаа. Тэгээд үлдсэн яг юу гэдэг юм, Мэргэжлийн хяналтыг ерөнхий газар гэдэг шиг ямар бүтэц, орон тоотойгоор үлдэж ажиллах вэ гэдэг асуулт Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас.

Т.Аюурсайхан: Эхлээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын С.Зулпхар дэд сайд хариулаад, дараа нь Амарбаясгалан дарга. 1 дүгээр индрийн 96 дугаар микрофон.

С.Зулпхар: Туваан гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын

багц хууль бол бэлэн болсон. Засгийн газар энэ хуулийн хүрээнд бол төрийн захиргааны төв байгууллагуудаас саналыг нь авсан. 3 хууль бол үндсэндээ өргөн баригдсан. 2 хууль бол бэлэн болсон байгаа гэдгийг хэлье. Намрын чуулганаар бол бид энэ багц хуулиар бүгдийг нь хэлэлцүүлнэ. Энэ хүрээнд бол нийгмийн даатгалын тогтолцооны бүрэн ийм реформ хийгдэх учиртай. Энэ дотор тэтгэврийн жишээ нь даатгалтай, сантай холбоотой, ажилгүйдлийн даатгалын сантай холбоотой, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн даатгалын сантай холбоотой шинэчлэлүүд бүрэн хийгдэнэ гэсэн ийм төсөөлөлтэй байгаа.

Жаргалмаа гишүүний асуултад хариулах уу?

Т.Аюурсайхан: Сууж бай би. Амарбаясгалан сайд хариулах уу? 91 дүгээр микрофон. Амарбаясгалан сайд.

Д.Амарбаясгалан: Туваан гишүүний асуултад товчхон хариулъя. Мэргэжлийн хяналтын байгууллага үндсэндээ татан буугдаж байгаа гэж ингэж ойлгож болно. Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргүүдийг мэргэжлийн яамнуудад шилжүүлж байгаа. Нэг зүйлийг их тодорхой ойлгомоор байгаа юм. Мэргэжлийн хяналтын байгууллагаар хяналт тавина гээд ерөнхий хяналт яриад байгаа. Түүрүүн манай Баасандорж дарга бас тодорхой хариулж байгаа.

Ер нь салбарын бодлого гаргаж байгаа хэсэг маань өөрийнхөө бодлогын хэрэгжилтэд хяналт тавьдаг энэ тогтолцоог бид бий болгох гэж үзэж байгаа гэж ингэж ойлгож болно. Нэг ёсондоо хяналт шалгалт гэдгийн энэ үндсэн зорилго, үүрэг нь өөрөө Монгол Улсад, тухайн салбарт мөрдөгдөж байгаа чанар, стандартын хэрэгжилтийг хянаж, шалгаж байх чухал үүрэгтэй байгууллага гэж ингэж бол ойлгож болох юм байгаа юм. Яах вэ, өнөөдөр орж байгаа хуульд 2

хууль зэрэг явж байгаа учраас манай гишүүд зарим тохиолдолд бас хольж хутгаж ойлгоод байгаа ийм тохиолдол гарч байна.

Нэгдүгээрт нь мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаад чиг үүргийг нь салбарын яамнуудад өгч байгаа юм.

Хоёрдугаарт нь гүйцэтгэх засаглал, дотоодынхоо өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилготойгоор төрийн байгууллага буюу Засгийн газрын харьяа яам, агентлагийн үйл ажиллагаанд тогтмол хяналт шалгалт хийх зорилготойгоор гүйцэтгэх засаглалын дотоод хяналт шалгалтын байгууллагыг бас байгуулж байгаа юм. Энэ тохиолдолд энэ 2 хуулийг дэмжигдсэнээр ямар нэгэн байдлаар төрд бол нэмэгдэх орон тоо юм уу, орон тооны хязгаарыг давах тийм зүйл бол байхгүй. Хооронд нь зохицуулалтыг хийж, тооцож Сангийн яамтай тохиролцож оруулж ирж байгаа гэдгийг бас энэ ташрамд хэлмээр байгаа юм.

Ер нь төрийн албанд ороод төрийн албаны үүрэг, хариуцлагыг сайжруулах шаардлага бол маш өндөр бий болсон байна. Сүүлийн жилүүдэд улс төрийн түвшинд бол хариуцлагын асуудлыг ихээхэн ярьдаг болсон боловч яг төрийн албаныхаа анхан, дунд шатанд энэ хариуцлагын тогтолцоо гээч зүйл нь бол эзэнгүйдэж явж ирсэн нь ийм байдал бол байна. Маш товчхондоо хэлэхдээ хариуцлагыг эзэнжүүлэх ийм алхмыг Засгийн газар бол хийж эхэлж байгаа юм гэж ингэж ойлгож болно.

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ нарын урилгаар Хэнтий аймгийн Биндэр сумын оюутнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт

гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг асуулт асууна.

М.Оюунчимэг: Би энэ нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлтэй холбоотой Хэрэг эрхлэх газрын даргаас нэг асуулт байна. Бусдыг нь Сангийн яамныхнаас бас асууя гэж бодож байна. Энд бас Эрүүл мэндийн яамнаас хүмүүс байна уу, үгүй юу? Бид Эрүүл мэндийн даатгалын сан, нийгмийн даатгалын сан 2-ыг хоёуланг нь бол аль болохоор ашигтай ажиллуулах энэ зорилго барьдаг. Тэгээд нийгмийн даатгалын сан бол өнөөдөр бүр үнэхээр алдагдал нь бол дэндчихсэн байгаа л даа. Энийгээ эргээд авах асуудал ч хүртэл хэцүү байгаа. Сая бид нар Үндэсний статистикийн газрын мэдээллийг ингээд л сонсоод сууж байхад 2030 он гэхэд энэ нийгмийн даатгалын сангийнхаа өр төлбөрийн асуудлыг нэг тийш нь цэгцэлж, энэ орлогын асуудлыг шийдэхгүй бол өнөөгийн үнэ цэнээр Оюу толгойн хэмжээний буюу бараг 16 тэрбум америк долларын хөрөнгийн орлогыг татан төвлөрүүлж байж энэ ирээдүйд гарах алдагдлыг нөхөх ийм тооцоо байгаад байгаа гээд байгаа шүү дээ.

Тэгэхээр өнөөдөр бид нар энэ нийгмийн даатгал дээр яаж энэ Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах, дагалдах хуулиар бас орж ирж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ алдагдлыг бууруулах, нийгмийн даатгалын санг ашигтай ажиллах, эсвэл энэ нийгмийн даатгалын тогтолцоогоо сайжруулах тал дээр жишээлбэл ямар бодлого орж, ямар өөрчлөлт оруулахаар энд орж ирж байгаа юм бэ гэдэг нэг асуулт байна. Тэгээд энэ дээр ялангуяа Хэрэг эрхлэх газрын дарга бас давхар алба хашиж байгаа учраас яг энэ нийгмийн даатгалын тогтолцоотой холбоотой асуудал дээр хариулт авахыг би хүсэж байна. Ялангуяа ингээд байгаа

шүү дээ. Хувийн тэтгэврийн сан гэхээр төсвөөсөө хэрвээ нэг тодорхой хувийг нь санхүүжүүлбэл орлого салгаад явчих учраас бүр ч алдагдалд орно гээд манай Сангийн яамныхан маань тайлбарлаж байгаа. Энэ бас нэг талаасаа үнэн.

Нөгөө талаасаа 5 жил, 7 жил гээд л яриад байдаг. Гэтэл тэтгэврийн насаа та нар нэмэхгүйгээр энэ нийгмийн даатгалын сан чинь цаашдаа алдагдалтай ажиллана. Алдагдалтай ажилласнаар та нар цалин хөлс, тэтгэврээ тавьж чадахгүйд хүрэх учраас энэ тэтгэврийн насаа өөрчил гэдэг зөвлөмжийг олон улсын байгууллагуудаас өгөөд байдаг. Тэгээд өнөөдөр би хэлж байна шүү дээ. 2030 он гэхэд энэ алдагдал яваад байвал та нар өнөөдрийн үнэ цэнээр Оюу толгойн хэмжээний буюу 16 тэрбум долларын орлого төвлөрүүлэх энэ шаардлага гарч байна гээд байгаа юм. Өнөөдөр 2023 он буюу бараг 7 жилийн дараах алдагдлыг ярьж байна шүү дээ. Тэгэхээр бид энэ дээр яах ёстой вэ? Нийгмийн даатгалын багц хууль ирэх онд орж ирэх үү? Энэ орж ирвэл өнөөдрийн энэ өөрчилөлт, хуулиудтайгаа яаж уяж байгаа вэ? Ямар ч байсан хувийн тэтгэврийн асуудлуудыг бид давхар шийдэх ёстой гээд байгаа юм.

Гэхдээ төсвөөс 1 юм уу, 2 хувь нь гэхээр төсвийн орлогыг салгачих учраас энэ өөрөө алдагдал танайд авчирна гээд олон улсын байгууллагуудаас бас зөвлөмж өгөөд байгаа шүү дээ. Насыг та нар мэдэж байгаа байх. Та 7-г бүр 5 болго гээд зарим нэг улс төрийн хүчнээс хүртэл ингээд л яриад байдаг. Гэтэл бодит байдал дээр энэ ямар ч боломжгүй байгааг эдийн засагчид бас яриад байдаг. Тэгэхээр энэ мэдээллүүдээ маш зөв өгөх хэрэгтэй байгаа. Энэ дээр Хэрэг эрхлэх газрын даргын болоод энэ Сангийн яамныхны энэ нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын багц хуультай яаж уяж орж ирж байгааг асууя гэж бодож байна.

Хоёр дахь асуулт. Сая ингээд л асуугаад байна л даа. Хүүхдийн мөнгө дээр 93 хувьд нь өгөх үү гээд л эцэслэж болж шийдээгүй байгаа. Тэгэхдээ энийг өгөхдөө архи, тамхинд энэ мөнгө явж байна уу, үгүй юу гэдгийг хянана гэж байгаа юм. Энэ ямар хуулиар энийг хянах гэж байгаа юм? Энэ бололцоогүй шүү дээ. Энэ мөнгө архинд явж байгаа юм уу, тамхинд явж байгаа юм уу гэдгийг хянах бололцоогүй байж байж энд орж ирээд тэгж ярихаар энэ чинь өөрөө тэгээд л элэг доог болоод явчхаад байх юм.

Харин хүүхдийн мөнгө хүүхдэдээ хөрөнгө оруулалт болж, хүүхдэдээ зарцуулагдах ёстой гэдэг дээр би л хувьдаа хатуу байр суурьтай байдаг. Гэхдээ энийг тэнд явахгүйгээр ямар хуулиар жишээлбэл, архи, тамхинд энэ мөнгө явахгүй шүү гэдгийг ямар зохицуулалт хийх гэж байгаа юм. Эсвэл энийг нөгөө нэг бусад улс орон шиг тодорхой хэмжээний нөгөө картаар өгдөг ч юм уу, тэр нь хүүхдийн хувцас, цүнх, хөрөнгө оруулалт, биеийн тамир, эрүүл мэндэд нь зарцуулдаг тийм механизм, технологийг энүүгээр давхар хийх гэж байгаа юм уу? Ямар хуулиар ийм зохицуулалтыг оруулж ирэх гэж байгаа юм? Тэгээд энэ дээр бас тодорхой нэгдүгээрт тайлбарууд авахыг хүсэж байна.

Хоёрт нь тэр эрүүл мэндийн даатгалын сангаас биеийн тамир, спортыг санхүүжүүлээд явах тухай асуудал бол байж болохгүй. Өнөөдөр Эрүүл мэндийн даатгалын сан маань өөрөө санхүүгийн хувьд асуудал маш ихтэй байгаа. Сангийн яам, Эрүүл мэндийн даатгалын сан хоёрын хоорондын өглөг, авлага 200 гаруй тэрбумд хүрчхээд яваад байгаа шүү дээ. Энэ авлага нь ингээд л тухайн үеийн сайд нар нь шийдэхгүй хойшлогдоод л яваад байгаа.

Т.Аюурсайхан: Амарбаясгалан сайд. 91 дүгээр микрофон.

Д.Амарбаясгалан: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын сан алдагдалтай явж байгаа. Тэгээд энэ чиглэл дээр Засгийн газрын зүгээс энэ нийгмийн даатгалын сангийн алдагдлыг хэрхэн бууруулах чиглэл дээр бас үе шаттай арга хэмжээг авахаас өөр аргагүй нөхцөл байдалд бол орсон байгаа. Яг арга хэмжээ авахгүй явах юм бол 2025 он, 2027 он гэхэд энэ сан бол бас нэлээдгүй өндөр эрсдэлтэй болох ийм магадлалтай байгаа. Тэгээд энэний эх үүсвэрийг та бас сая үгэндээ хэллээ. Ер нь бол тэтгэврийг олгож байгаа байдал, тэтгэвэр тогтоож байгаа байдал зэрэг нөгөө хоорондоо харилцан уялдаа холбоотой иж бүрэн, тооцооллыг бүрэн хийж чадахгүй байгаагаас үүдэлтэйгээр нөхцөл байдал бол энэ түвшинд хүрчээ гэж ингэж бол харж байгаа юм. Тэгэхээр энэ нийгмийн даатгалын сангийн алдагдлыг нь мэдээж Засгийн газраас бодлого хэрэгжүүлж байж арилгах боломж бол нэгдүгээрт байгаа.

Хоёрдугаарт, энэ тэтгэвэр, цалингийн нэмэгдлийн асуудлыг бол Засгийн газрын зүгээс ирэх онд оруулж ирэх нийгмийн даатгалын багц хуулиудад нэлээн тодорхой болгож оруулж ирэхээр зорьж байгаа. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр итгэлцүүрийг бий болгож, тэтгэврийн зөрүүг нэгдүгээрт арилгах, цаашдаа тэтгэврийг улс төрийн шийдвэрээр нэмдэг бус тухайн жилийнхээ инфляцын түвшинтэй уялдаж тэтгэвэр, цалин нэмэгддэг байх тэр тогтолцоог бий болгохоор Засгийн газраас бол энэ нийгмийн даатгалын багц хуулийг оруулж ирэхээр зорин ажиллаж байгаа гэдгийг бас хэлье. Тэгээд өшөө нэмэлт мэдээллийг Хөдөлмөр, нийгэм хамгааллын дэд сайд Зулпхар сайд хариулна.

Т.Аюурсайхан: 96 дугаар микрофон өгье.

С.Зулпхар: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгож эхэлсэнтэй

холбоотойгоор тэр мөнгийг буруу зүйлд зарцуулах чиглэлээр цаашид ямаршуу зохицуулалт, ямар шуу хязгаарлалт хийж чадах юм бэ гэсэн ийм асуулт байна. Энэ бол бидэнд урьдын туршлага байгаа. Хүнсний эрхийн бичгийг бид өнгөрсөн 2 жилийн дотор нэгдүгээрт журмыг нь өөрчлөөд, хоёрдугаарт шалгууруудыг нь өөрчлөөд, гуравдугаарт энэ картаар олгодог болгоод карт дээр нь хязгаарлалтууд тавьж өгсөн юм.

Тэр картыг нь хязгаарлалт нь бол хүнсний эрхийн бичгээр авдаг 10 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүн байдаг. Тэрнээс өөр бараа бүтээгдэхүүн авч болохооргүй ингээд хязгаарласан. Яг үүнтэй нэгэн адилаар бол энийг бол бид хийх бас боломж байгаа гэж үзэж байгаа юм. Гэхдээ тодорхой хугацаа шаардана, зохион байгуулалт шаардана, бас тодорхой төрийн болон банк, санхүүгийн байгууллагуудын ийм хамтын ажиллагаа шаардахаар байгаа. Тэгэхээр бид энийг бол боломжтой гэж үзэж байгаа. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Оюунчимэг гишүүнд микрофон өгье.

М.Оюунчимэг: Манай энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэд сайд маань үнэхээр бөөрөнхийлөхийн мастер шүү. Бид мэдэж байгаа шүү дээ. Хүнсний өгдгийг. Гэхдээ олон жил ингэж явж байгаа. Тэгэхдээ энэ маань тэр бусад өөрийн чинь хэлээд байгаа архинд ч явдаг, тамхинд ч явдаг, чихэр жимсэнд ч явдаг, талханд ч явдаг. Энэ бодит үнэн. Гэхдээ тийм, явж байгаа, дэвшиж байгаа гээд л Байнгын хороон дээр ч тэгээд л яриад байх юм. Бид яаж өөрчлөх гэж байгаа юм бэ? Архи, тамхинд өгөхгүй гэдгийг ийм хуулиар юм уу, ийм технологийн дэвшлээр бид шийдэх бүрэн боломжтой юу гэж л би нэгд асуугаад байгаа шүү дээ.

Хоёрт нь 5, 7 жил нөгөө ажилласан жилээр тэтгэвэрт энэтэй холбоотой асуудал өнөөдөр Нийгмийн бодлогын

байнгын хорооны гишүүн болгон л, өглөө болгон л 5 жил болгооч, энэ 7 жилээ ингээч гээд л ирээд байгаа байхгүй юу. Энд жишээ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам шууд хариу өгчих ёстой байхгүй юу. Одоогоор 5 жил бол болохгүй байна. 7 жил ч бүр ийм байна, эсвэл болох юм бол болно гээд ингэчихгүй бол нэг горьдлого тээгээд л, хэсэг гишүүд одоогийн эрх барьж байгаа нам нь ард түмнийхээ эсрэг ингээд зогсоод байгаа юм шиг энэ ойлголт сая 3, 4 жил ингээд болоод явчхаад.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Амарбаясгалан сайд нэмж хариулья. 91 дүгээр микрофон.

Д.Амарбаясгалан: Хүүхдийн мөнгийг картаар олгох, карт НӨАТ-ын падаанаараа хянагдаад, архи, тамхины худалдаанд худалдаа эрхлэхэд уншигддаггүй байх зохицуулалтыг хийх бүрэн боломж бол манай татварын систем дээр бол бий болсон байгаа юм байна. Тэгэхээр и-баримтын байгууллагатай хамтраад богино хугацаанд энэ хүүхдийн мөнгийг картаар олгодог системд нэвтрүүлнэ гэж ингэж бол зорьж байгаа.

Ер нь цаашдаа хүүхдийн мөнгийг халамжийн хэлбэрт оруулсан учраас яг хүүхдэд зориулагдсан хоол хүнс, гэжээлийн бүтээгдэхүүн зөвхөн тэр картаар үйлчилдэг системийг ойрын жилүүдэд нэвтрүүлэх боломжтой гэж бидний зүгээс үзэж байна. Бүр болж өгдөг бол зөвхөн үндэсний үйлдвэрлэгчдийг дэмждэг тэр үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн өөрөө хүүхдийн эрүүл ахуй, тэгээд бүх хэрэгцээ шаардлагыг хангадаг байх энэ тогтолцоо руу бусад энэ хөгжилтэй орнуудын жишигт аваачна гэж ингэж бол зорьж байгаа.

Тэтгэврийн тогтоолтын асуудлыг 5 жил, 7 жил гэж ярьж байгаа боловч энэ нь өөрөө яг бас л улс төрийн шийдвэр

болж ирсэн байдаг. Хамгийн шударга тогтолцоо бол бүх насаараа ажилласан.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Амарбаясгалан сайдад 1 минут нэмж өгье.

Д.Амарбаясгалан: Ер нь нэг хамгийн чухал нь бол бүх насаараа ажиллах хугацаандаа авсан цалингийн дунджийг тэтгэвэр болгож олгодог байх тогтолцоог бол хамгийн шударга гэж үзэж байгаа. Гэхдээ энэний өмнө бол итгэлцүүрийг бий болгох ёстой. Тухайн үеийнх нь мөнгөн төгрөгийн ханш нь өнөөдрийнхтэй ямар хэмжээнд тооцогдож, үнэн бодитой байх вэ гэдэг нь бол хамгийн түрүүний бидний шийдэх ёстой асуудал. Энийг шийдэж чадсанаар ажилласан нийт жилийнх нь дунджаар тэтгэврийг олгодог болох юм бол хамгийн шударга болно гэж ингэж бол үзэж байгаа.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд асуулт асууна.

Н.Энхболд: Би дагаж орж ирж байгаа 2 хуультай холбогдуулж асуулт тавина гэж бодсон юм. Мэргэжлийн хяналтын тогтолцоог илүү боловсронгуй болгохтой холбоотой хуулиуд, нөгөөдөх нь Хувь хүний орлогын албан татвартай холбоотой хууль. Мэргэжлийн хяналтын талаар Амарбаясгалан сайд бас сая нэлээн дэлгэрэнгүй хариулчихлаа.

Ер нь бол Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүх хуулийн хэрэгжилтийг бүх шатанд хариуцаж, тэгээд тайлагнадаг үүрэгтэй учраас одоо өөрчлөлт оруулаад, ялангуяа засгийн байгууллагууд, төрийн байгууллагууд, захиргааныхаа байгууллагуудын хувьд, төрийн байгууллагын хувьд энэ хяналт шалгалтын ажлыг яаж хийж байна гэдгийг нь илүү төрийн алба гэдэг рүү нь хандаж ийм өөрчлөлт оруулах гэж байгааг бол би зөв гэж бодож байгаа. Энэнийхээ хажуугаар мартаж болохгүй

зүйл юу гэвэл одоо тэртээ тэргүй хууль нь байж байгаа. Энэ стандарт, чанар тиймээ, үйлдвэрлэл, үйлчилгээ бүх л зүйлийн стандарт чанарт үйлдвэрлэл эд нар тавьж байгаа энэ хяналтаа бол алдагдуулж болохгүй. Зөвхөн захиргаа руугаа, төрийн алба руугаа хандаад нарийн мэргэжлийн хийдэг юмнуудаа яаж илүү боловсронгуй болгож, хажуугаар нь давхардуулалгүй явуулах вэ гэдгээ дараа дараагийн тэр дүрэм, журмын юмнуудаа их нарийн тооцох хэрэгтэй гэж ингэж бодож байна.

Дээр нь одоо ч гэсэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас энэ хуулийн хэрэгжилтийн явцад яамдаас мэдээ тайлан аваад мониторинг хийгээд, дүгнэлт хийгээд явдаг нэг ийм функц байж байгаа юм. Энэ бол байж байх ёстой функц гэж би боддог. Шинээр оруулж ирж байгаа зорилт функцүүдтэйгээ их зөв уялдуулбал боловсронгуй болгоод цаашаа үргэлжлүүлээд явах нь зүйтэй. Харин оруулж ирж байгаа шинэ санаан дээр чинь сайн суурь байж байгаа шүү гэдгийг нэг хэлчье. Энэ дээр асуулт алга.

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль дээр нэг ийм санаа байна. Би бас Байнгын хороон дээр хэлсэн. Ажлын хэсэг энийг ярихдаа анхаарч үзээрэй гэдгийг хэлсэн байгаа. Би анхаарна байх гэж бодож байна. Тэгээд одоо бол энэ хувиа хүмүүсийн орлогоос нь хамааруулаад бага орлоготойгоос нь бага, их орлоготойгоос их орлого авах ийм санаатай хуулийн төсөл орж ирж байгаа. Зарчмын хувьд шаталсан ийм татварын тогтолцоо байхыг бол би зөв гэж боддог. Ялангуяа манай нийгэмд энэ баян, ядуугийн ялгаа их болчихсон, дундаж анги гэж бас хөл дээрээ босож чадахгүй байгаа энэ үед бол энэ зөв.

Гэхдээ оруулж ирж байгаа хувь нь бол харьцангуй бас их өндөр байна. Шүүмжлэл их явж байгаа шүү яг энэ асуудлаар. Жоохон гайгүй юм хийж

байгаа хүмүүс нь орлого олохоор тэрнээс нь илүү их авах гээд байна гээд. Энэ өөрөө бас янз бүрийн асуудал үүсгэж магадгүй юм байгаа юм. Байнгын хороон дээр ч гэсэн анхаарах байх.

Тэгэхээр миний санаа бол ийм байгаа юм. Одоо бид нарын авах гээд байгаа татвар бол яг хүмүүсийн ил байгаа орлогоос авч байгаа байхгүй юу. Яг тайлагнасан тиймээ? Би тэдэн төгрөгийн орлоготой ил тавьчихсан. Ерөнхий сайд юу гэж хэлсэн бэ гэхээр Монголд далд эдийн засаг байна. Бараг ил эдийн засагтайгаа адилхан хэмжээний шахуу юм далд эдийн засаг байна. Энийг яаж ил болгох вэ, энүүгээр гүйж байгаа мөнгө, орлогыг яаж эргэлтэд оруулах вэ гэдгээр онцгой анхаарах ёстой гэсэн.

Тэгээд яг энэ үүднээс аваад үзвэл бид нар хувь хүний орлогын татварыг нэмэгдүүлэхээсээ илүү энэ тансаг хэрэглээний татвар дээр онцгой анхаарах хэрэгтэй юм биш байгаа. Яагаад гэвэл яг хууль бусаар олсон, далд эдийн засгаас орж ирсэн мөнгөний ил гардаг цэг нь яг энэ хэрэглээн дээрээ, борлуулалтад юм худалдаж авах, зарцуулах үе дээр энэ дээрээ гарч ирдэг байхгүй юу. Албан ёсоор хаана ч тусдаггүй. Тэгсэн мөртөө баахан үнэтэй юм авдаг, том хэрэглээ хэрэглэдэг.

Тэгээд үнэхээр далд эдийн засаг ийм том байгаа бол энэ дээр тооцоо хийж үзээд энэ тансаг хэрэглээнээс, энэ мэдэгддэггүй орлогоос зарцуулж байгаа мөнгөнөөс нь татвар авах нь энэ төсвийн хуулийг дагаж орж ирсэн хувь хүний орлогын албан татвараас олох 12 тэрбум төгрөгөөс чинь арай илүү гарах юм биш биз. Энийг заавал тооцоо хийж байж, үзэж байж, ажлын хэсэг дээр ярьж байж Тэмүүлэн даргаа тиймээ анхаараарай. Би.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Энхболд гишүүн. Нямаагийн Энхболд гишүүнд 1 минут өгье.

Н.Энхболд: Далд эдийн засгийн янз бүрийн бүртгэл тусдаггүй, орлого ерөөсөө гарч ирдэг цэг нь энэ болохоор энэ дээр нь л барьж аваад юм хийвэл нийгэмд ч ойлгомжтой болно. Хүмүүсийн дургүй хүрэх нь ч бас гайгүй болно гэсэн ийм би бодолтой байгаа. Тэгэхээр Сангийн яам яаралтай өөр ямар яаманд энэ мэдээлэл байдаг юм. Татварын газар ч байна уу, энэ тооцоогоо хийгээд ажлын хэсэгт, Төсвийн байнгын хороонд өгөх хэрэгтэй. Тэрний дараа энэ асуудалд яаж хандах вэ гэдгээ Улсын Их Хурал шийдэх байх. Би бас нэлээн олон гишүүнтэй санал сольж үзсэн. Засгийн газар дээр энэ асуудлыг хэлэлцсэн протоколтой танилцсан.

Тэгэхээр үнэхээр бас 2 янзын байр суурьтай байсан юм билээ. Нэг хэсэг нь яг ийм тансаг хэрэглээ, ийм зүйлээс татвар авах нь зүй гээд. Нөгөө хэсэг нь үгүй хувь хүний орлогын татвараасаа авъя гээд. Би бол ийм байр суурьтай байгаа. Энийг тооцож үзээд, тооцоогоо үзүүлээд, тэгээд эцэслэж шийдэх, энэ дүгнэлт гаргах материал бэлдэж өгөөрэй. Тэгж байж дараа нь энийг ярих ёстой. 12 тэрбум л юм байна лээ шүү дээ. Учиргүй их биш. Тэгэхдээ нийгэмд үүсэх долгион нь өгөх ойлголт.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Ганбат дарга хариулъя. 80 дугаар микрофон.

Ж.Ганбат: Энхболд гишүүний асуултад хариулъя. Бид бол яах вэ, энэ хүн амын орлогын албан татвар дээр шатлалтай болгохдоо бид нар орлого олоход нь бас зориогүй л дээ. Яг орлогын дүнг харах юм бол нөлөөлөл нь бол тийм бол өндөр биш. Гэхдээ бид энэ орлогын тэгш хуваарилалтыг бий болгох зорилгоор ер нь энэ шатлалтай байх нь зөв юм гэдэг байдлаар эхний ээлжид оруулж ирж байгаа юм. Бид өмнө нь бол энэ шатлалыг оруулаад бас хэрэгжилт дээрээ асуудал үүсээд буцсан тохиолдол байгаа юм.

Ерөнхийдөө бол дэлхийн бусад орнуудын жишиг бол бүгд, ер нь хувь хүний орлогын албан татвар бол бүгд шатлал руу явчихсан. Манайх бол шаталсан татвартай биш. Тэгэхээр энэ дээрээ бол биднийг шаталсан байх нь зөв юм гэж. Нөгөө талдаа таны асуусан тансаг хэрэглээний татвар гэдэг юмыг сүүлийн хэдэн жил Сангийн яам нэлээд судалсан. Энэ асуудал төсөв оруулж ирэх болгонд яригддаг асуудал. Гэхдээ тансаг хэрэглээний татварыг хувь хүний яг хэрэглээнд нь ногдуулаад аваад амжилттай хэрэгжсэн ер нь улс орон их ховор байна. Яг хэрэглээнд ногдуулаад, голцуу буцаж тэрийгээ больсон тохиолдлууд нь их байгаад байгаа юм. Нөгөө талдаа голцуу тансаг хэрэглээний татварыг юун дээрээс, гол нь аваад байна шүү дээ. Хөрөнгө дээр нь авч байгаа юм.

Тийм учраас одоо бид нар энэ үл хөдлөх хөрөнгийн татварын тухай хуульд өөрчлөлт ороод 2-оос дээш орон сууц дээр нь үл хөдлөх хөрөнгийн татвар авахаар ийм хууль батлагдаад энийг тэгэхдээ бид ямар ч байсан энэ юун дээрээ бол үл хөдлөх хөрөнгийн татвар авахад 2 орон сууцтай юман дээр бол нэгэн дээр нь үл хөдлөх хөрөнгийн татвар бол аваад явна гээд. Тансаг хэлбэрийн энэ үл хөдлөхийн албан татварын хууль боловч яг шинж чанар нь бол тансаг хэрэглээний ийм татвар байгаа юм. Яг хөрөнгө дээр ноогдож байгаа юм.

Тэгээд энийг бол хэрэгжүүлээд эхлээд бол ингээд явчихсан бол тансаг хэрэглээний татварыг бол бид хэрэгжүүлж байна гэдэг ийм байдлаар юмнуудыг нь тооцож байгаа. Тэгээд бид нар шаталт, юун дээрээ бол далд эдийн засаг, ер нь бол гол юм бол яг манай дээр бол гол судалгаа эндээс ингээд харахад бол манай дээр хамгийн том далд эдийн засаг бол ер нь үл хөдлөх хөрөнгө дээр байгаа. Хөрөнгийн үнэлгээний асуудлууд байна. Хөрөнгийн бүртгэлийн асуудал байна. Сүүлийн хэдэн жил Засгийн газар цахим бүртгэлийн асуудал дээр, цахимжуулалт дээрээ анхаарснаа бол

ерөнхийдөө бид нар манай харьяа нь НӨАТ бус мэдээллийн төв энэ тэрээр дамжуулаад, ерөнхийдөө бүртгэлээ бид нар ил тод болгоод л энэ дээрээ үндэслээд бид тэр хөрөнгийн татваруудаа бид нар үнэлгээг нь зөв тогтоогоод авах нь бол илүү зөв юм гэсэн энэ байдлаараа түлхүү бид ажиллаж ингэж явж байгаа л даа. Үр дүнгүүд нь бол эхнээсээ гараад эхэлчихсэн ийм байдалтай байгаа.

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалангийн урилгаар Говь-Алтай аймгийн Тайшир сумын малчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан асуулт асууна.

Б.Энх-Амгалан: Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яамнаас асууя. Шинэ хөрөнгө оруулалт хийгдэхгүй, төсөв хэмнэж байгаа гэдгийг бол ойлгож байгаа. Гэхдээ энэ жил ингээд баруун 5 аймаг, тэр дундаа Говь-Алтай аймаг зун зуншлага их муу болсон, газрын гарц их муутай байгаа. Энэ бол цаашлаад өвөлжилт, хаваржилт хүндрэх ийм төлөв байдал ажиглагдаж байна. Сая нутгаа тойроод ингээд ирэхэд бол бас малчид, хөдөлмөрчид маань хэлж байна. Мах бэлтгэл, улсын мах бэлтгэлд манай аймгийг хамруулж өгөөч. Мал борлуулах хэрэгтэй байна. Мал үнэгүйдсэн. Ингээд малаа борлуулж чадах юм бол бид нар бас жоохон хэд гурван цаасаа хадгалаад, ингээд эргээд малжих ийм бололцоо улам бүрдэнэ.

Малын гаралтай түүхий эд үнэгүйдлээ, энийгээ экспортод гаргах талаар анхаараач. Хөдөө аж ахуйн яам нэг стандарт гаргачихдаг. Тэгээд боловсруулж чадахгүй байж тэгээд

авахгүй болохоор энэ арьс шир, ноос ноолуур, энэ малын гаралтай түүхий эд чинь үнэгүйдээд байна. Малчдын залуу халааг бэлтгэхэд жоохон анхаараач. Энэ жил ер нь нэлээн хүндрэх учраас өвс тэжээлийн бэлтгэл нөөц бэлтгэж өгөхөд туслах хэрэгтэй байна гэж хэлсэн юм байгаа юм. Энэ дээр тийм зардал төсөв ямархуу юмнууд тавив? Энэ дээр нэг хэлээч.

Хоёр дахь нь зах хязгаарт ажиллаж байгаа төрийн албан хаагчид, ер нь энэ зах хязгаарт ажиллаж байгаа хүмүүс бол хамгийн бага цалинтай. Тэгсэн хэр нь хамгийн өндөр өртөгтэй бараа бүтээгдэхүүн хэрэглэж байгаа. Бензин тос хэрэглэж байгаа. Ийм учраас энэ зах хязгаарт ажиллаж байгаа хүмүүсийн цалин пүнлүүний асуудлыг бодолцооч ээ. 1000 километрээс дээш байж байгаа энэ хүмүүст цалингийнх нь 500 мянган төгрөгийг 3 дахин нэмчих бололцоо байдаггүй юм уу? Тэгэх юм бол энэ чинь хүмүүсийнх нь тоо их бага шүү дээ. Улсын төсөвт очих дарамт нь их бага. Тэгэхгүй бол энэ зах хязгаараас чинь төв рүү нүүх нүүдэл явсаар байгаад энэ нутаг орон эзгүйрлээ шүү гэдэг ийм асуудал ярьж байгаа юм.

Гурав дахь нь Бургастайн боомт бол Говь-Алтай баруун талын Ганц боомт. Энүүгээр Алтайн хүдрийн хүдэр гардаг. Тэгээд энэ боомтыг сая Мэргэжлийн хяналтынхан үйл ажиллагааг нь зогсоосон гэдэг юм яриад байдаг. Энэ үнэн үү, худлаа юу?

Хоёр дахь нь бол энэ Артсуурь, Завхан чиглэлийн 154 километр замын зураг төсөв хийгдээд дуусаж байгаа юм байна лээ. Говь-Алтай, Завхан чиглэлийн 200 километр зам Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдээд ингээд явахаар ингээд зөвшөөрөл нь ирсэн гэж ингээд сонслоо. Тэгээд Говь-Алтайн Бургастайн чиглэлдээ буюу Шарга, Төгрөг, Бугат чиглэлийн энэ замын зураглалыг хийх тал дээр тийм бололцоо боломж байна уу? Тэгвэл энэ чинь

баруун бүсийн босоо тэнхлэгийн чинь зам тэр чигтээ бүтэн орчих бололцоо байгаа юм. Алтайн Хүдрээс цаашаа 187 километр зам байдаг. Тэгээд тэрний наяд хэдэн километр замыг нь бол асфальтаар хуччихсан учраас энэ бол хучигдах бололцоо боломж байгаа. Тэгэхээр энэ баруун бүсийн зам маань ингээд бүтэн болчих ийм бололцоо байна. Энэ дээр тавигдсан энэ дээр тавьж болох тийм төсөл хөтөлбөр юмнууд байна уу гэдгийг асууя. Ингээд ийм 3 асуултад хариулт авъя.

Т.Аюурсайхан: 80 дээр. 80 дугаар микрофон. Хариулт авъя.

Ж.Ганбат: Энх-Амгалан гишүүний асуултад хариулья. Энэ өвөлжилттэй холбоотой орон нутаг дээр ямар нэгэн санхүүгийн дэмжлэг байна уу гэдэг дээр. Бид энэ 22 оны төсөв боловсруулахдаа бид нар Засаг даргын нөөц хөрөнгийг нь бол ерөнхийдөө 5 дахин нэмэгдүүлж өгсөн байгаа энэ онд. Энэ оны төсөв дээр. Засаг даргын нөөц хөрөнгийг нэмэгдүүлж өгсөнтэй холбоотой Сангийн яамнаас сая 9 сард бүх аймгийн Засаг даргад албан тоот явуулсан. 8 сард юм байна. Өвөлжилтийн байдалдаа ингээд онцгой анхаараач. Ингээд аймгуудын өөрийнхөө боломжийн нөөц ...хөрөнгийг нь нэмэгдүүлж өгсөн. Энэ хүрээндээ ажлаа өөрсдөө зохион байгуул. Дээрээс Засгийн газраас болон улсын төсвөөс ямар нэгэн дэмжлэг бол та нар харалгүйгээр өөрсдөө нийлээд зохион байгуулаач гэдэг ийм бол чиг өгсөн.

Ер нь бол бид Сангийн яамнаас, ер нь орон нутаг дээр ямар бодлого барьж байгаа вэ гэх дээр яах вэ, өөрсдөө би боломжоороо төсвөө батлуулахдаа энэ өвөлжилт ган, зудтай холбоотой, энэ байгалийн гамшигтай холбоотой асуудлуудаа өөрсдийнхөө төсөв дээрээ зардлуудаа тавиад ингээд яваач гэдэг ийм байдлаар чиглэлийг нь бол өгч ажилласан байгаа. Алслагдсан аймгуудад дээр бол цалингийн нэмэгдлийг яаж шийдэж байгаа вэ гэхээр бид түрүүнд бол ярьсан.

Бид ирэх жилийн төсөв дээр бол орон нутгийн нэмэгдэл гээд 20 хувийг бол бүх аймгуудад суурь зарлагад нь тооцоод нийт дүнгээрээ 33 тэрбум төгрөгийг бол орон нутгийн суурь зарлагад нь тооцоод тавьчихсан.

Нөгөө талдаа төрийн албан хаагч, хөдөө орон нутагт ажилласны нэмэгдлүүд гээд салбар салбараасаа өөр олон ийм нэмэлтүүд бол байгаа. Хөдөө орон нутагт ингээд төрийн алба хаагчид ажиллах юм бол 5 жил, 3 жил нэмэгдлүүд цалинтайгаа тэнцэх хэмжээний нэмэгдлийг 1 удаа авна гэдэг энэ нэмэгдлүүд бол бас хэрэгжээд явна. Ийм байдлаар бол зохицуулалтыг хийж өгсөн байгаа.

Нөгөө талдаа төвлөрлийг сааруулах татварын бодлогын хүрээнд бид нар орон нутагт шилжилт хөдөлгөөнийг дэмжих зорилгоос бол нийслэл Улаанбаатараас хөдөө орон нутаг руу хэрвээ шилжиж буй, нүүсэн тохиолдолд татвар ноогдох орлогоос хасагдахдаа тэр гарсан зардлынх нь 50 хувиар нэмэгдүүлж тооцно. Хөдөлмөрийн биржид бүртгэлтэй хүмүүс ажилд авсан тохиолдолд цалингийн зардлыг нь 20 хувиар нэмэгдүүлж, албан татвар ноогдох орлогоос хасаж тооцно. Ингээд татварын бодлогоор ер нь хөдөө орон нутагт ажил хөдөлмөр эрхлэх юм бол ажлын байрыг нэмэгдүүлсэн тохиолдолд компани дээр нь нэг дэмжлэг өгөөд, тухайн ажлын байрыг бий болгосон хүмүүст бас дэмжлэг өгөх байдлаар ийм дэмжлэгийн арга хэмжээг бол бид нар хувь хүн дээр нь, цалин дээр нь нөгөө талдаа бас татварын бодлогоороо давхар ингэж дэмжлэг өгч байгаа.

Т.Аюурсайхан: Тодруулах юм уу? Эдийн засгийн хөгжлийн яамнаас нэмэх юм уу? 81 дүгээр микрофон дээр.

С.Наранцогт: Бургастайн боомтын хувьд мэргэжлийн хяналтын дүгнэлтээр хаасан бол Мэргэжлийн хяналт хариулсан нь дээр байх. Яг энэ дээр.

Манай яаман дээр бол яг тийм тодорхой мэдээлэл алга байна.

Т.Аюурсайхан: 93 дугаар микрофон дээр Баасандорж дарга хариулъя.

Б.Баасандорж: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя, Баасандорж. Яг өнөөдрийн байдлаар бол Энх-Амгалан гишүүнээ Бургастайн боомтыг зогсоосон, хаасан зүйл бол байхгүй. Би сая Лачинжав генералтай ярилаа. Мөн Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн хяналтын даргатай ярилаа. Ер нь бол хилийн хяналтын чиг үүрэг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас шилжээд Гаалийн ерөнхий газар руу шилжсэн байгаа шүү.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Энэ намрын ээлжит бус чуулган болоод л манай Их Хурлын гишүүд давхар дээл өмсөхийн тулд 2 өдрийн дотор Үндсэн хуульдаа өөрчлөлт хийгээд л, тэгээд ер нь бол тэгээд л албан тушаалын төлөө бол 2 өдрийн дотор л Үндсэн хуульд өөрчлөлт оруулж байна лээ дээ. Тэгээд л сайдаа ч хийнэ, гишүүнээ ч хийнэ гээд л бүх юманд идэвхтэй оролцоно гээд байсан Их хурлын гишүүд хаана байна сайд нар? Хоёр сайд сууж байна. Ганбаатар сайд, Учрал сайд. Энэ 2 сууж байна. Бусад нь тэгээд хаачихсан юм? Энэ чинь төсвийн хууль хэлэлцэж байна. Төсвийн энэ дагалдаж орж байгаа хуулиудыг хэлэлцэж байна. Бүгдээрээ тэгээд энэ одоо нэг тэнд очоод нэг сайдынхаа ерөөнд л баахан л юм хувааж байгаа л даа. Тэр ч яах вэ. Тэгээд сайдуудаа дуудаарай.

Татвар нэмэхгүй, шинэ төрлийн татварыг бий болгохгүй гэсэн яасан? Ерөөсөө энэ төсвийн төсөл болгон дээр л шинэ татвар оруулж ирэх юм. Ард түмэнд болохлоороо энэ сонгуулийн үеэр

тэгээд л үгүй, бид нар ёстой та нарын төлөө ажлыг гялалзуулаад өгнө, бүх зардлыг багасгаад, татвар нэмэхгүй гэж байгаад л гарч ирчхээд, гарч ирснийхээ дараа ингээд л бүх төсвийн хуулиар, дээрээс нь төсвийн бус үед ч гэсэн татвараа нэмээд ингээд яваад байгаа юм. Хүн амын орлогын татвар дээр ингээд нэмээд л явчихлаа. Тэгээд баялаг бүтээдэг хүмүүсээ ингээд дээрэмдэх замаар энэ улс орныг хөгжүүлнэ гэж юу байх вэ дээ. Энэ дээр хариулт авъя.

Энэ хөрөнгө оруулалтууд бол шинэ хөрөнгө оруулалт бол дандаа Улаанбаатар хотод тавигдсан байна. Улаанбаатар хотоо хөгжүүлээд байх юм бол хөдөө орон нутгийн шилжилт чинь наашаа зогсохгүй. Адилхан тэгш хөгжүүлэх тэр зарчмыг баримтлах ёстой байхгүй юу даа. Энийг баримтлахын тулд хөдөө орон нутагтаа, тэр зах хязгаар бүс нутагт амьдарч байгаа, тэр Дорнодын Матадад амьдарч байгаа, Ховдын Булганд амьдарч байгаа тэр хүмүүс тэндээ ая тухтай, нийгмийн асуудлаа шийдвэрлэсэн тийм хөрөнгө оруулалтуудыг эндээс хийж өгөхгүй бол тэнд чинь амьдардаг хүнгүй болохлоор бүгдээрээ Улаанбаатар хот руу шилжинэ. Улаанбаатар хотод хүн амын суурьшил ихэссэнээр улам л нөгөө тэр түгжрэл чинь ихэснэ шүү дээ. Тэгээд нэг юмаа хийх гэж байгаад нөгөө юмаа ерөөсөө бүгдийг нь хаядаг ийм юмыг яах юм. Энэ төсвийн 2 дугаар хэлэлцүүлэг дээр энэ шинэ хөрөнгө оруулалтаар зайлшгүй тавих ёстой тэр хөрөнгө оруулалтыг тавих юм уу, тавихгүй юм уу?

Энэ хөдөө орон нутагт хүмүүс, жишээ нь 4 суманд би хэлээд өгье. Төрийн албан хаагчдын цалин 650 мянга байгаа учраас тэнд ажилладаг хүн байхгүй байна. 4 суманд нэгдүгээрт нийгмийн бодлогын мэргэжилтэн алга байна. Хоёрт байгаль орчны байцаагч байхгүй байна.

Гуравдугаарх нь иргэний бүртгэлийн мэргэжилтэн байхгүй байна.

Дөрөвт нь мал эмнэлгийн тасгийн 2 мэргэжилтэн дутуу байна. Эрүүл мэндийн төвийн хүний нөөц нь хэд хэдэн хүнээр дутагдалтай байна. Багийн эмч нь байхгүй байна. Тэгээд оронд нь нөгөө тэтгэвэрт гарсан хүмүүс ажиллаж байгаа. Одоо тэтгэвэрт гарсан хүмүүсээ бүгдийг нь энд орж ирж байгаа хуулиар байхгүй, ажилгүй болгоно. Ийм ийм дутагдалтай байна. Тийм учраас энэ төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх, тэнд хүмүүст маш сайн үйлчилгээ үзүүлэх. Тэгэхийн тулд бас тодорхой хэмжээгээр тэр хүмүүсийн цалинг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байж байна. Тэгэхгүй бол бүгдээрээ л энэ хот руу, аймаг руу шилжсээр байгаад энэ суманд ажилладаг хүмүүс ерөөсөө байхгүй болчихоод байна. Энэ төрийн албан хаагчдын цалинг яаж нэмэгдүүлэх бодлого барьж байгаа юм бэ? Энэ дээр хариулт авъя.

Сүүлд нь хүүхдийн мөнгөн дээр. Хүүхдийн мөнгөөр архи, тамхи худалдаж авахгүй гээд байна. Тэрийгээ тэгээд яаж хянах юм? Аав нь хүүхдийнхээ мөнгөний тэр картаар нь АТМ-ээс очиж мөнгө авчхаад л, тэгээд л нэг 20000 төгрөг бариад л тээ? Дэлгүүрт очоод л 1 шил архи авъя гээд л тэгнэ. Тэгэнгүүт архи авна гэх дээр нөгөө дэлгүүрийн худалдагч нь үгүй наад мөнгийг үнэрлэж үзэх юм уу, яах юм ?

Т.Аюурсайхан: Сангийн яам хариул 80.

Ж.Ганбат: Пүрэвдорж гишүүний асуултад хариульа. Татвар нэмж байгаа гэдэг бас яг тэр утгаар нь ойлгоход бас ерөөсгөл л дөө. Бид өөрөөр хэлэх юм бол хувь хүний орлогын албан татварыг шатлалтай болгож байгаа юм. Өнөөдөр 10 сая төгрөгийн цалин авч байгаа хүн 1 сая төгрөгийн цалин авч байгаа хүн яг адилхан татвар төлж байгаа юм. Энэ бол орлогын тэгш хуваарилалт гэдэг юмтай нийцэж байна уу, үгүй юу гэдэг ийм асуудал байгаа. Ер нь бид бол шатлалтай

байх нь зөв зүйтэй юм гэж үзээд өндөр орлоготой, өөрөөр хэлбэл 10 сая төгрөгөөс дээш орлоготой хүмүүс дээр бол бид нар 15 хувиар, 15 сая-аас дээш орлоготой хүмүүс дээр 20 хувиар татвар авна гэдэг ийм байдлаар үзэхдээ нийт хувь хүний орлогын албан татвар төлж байгаа хүмүүсийн 0.1 хувь нь л энэ шатлалд хамаарч байгаа юм. Бид бол тэгэх дээр өндөр орлоготой хүмүүс ингээд энэ үүн дээр бол хамрагдана.

Ер нь бол орлогын тэгш хуваарилалт гэдэг юм. Ер нь дэлхий нийтийн анги, хандлагыг нь ингээд харахад КОВИД-ын дараах энэ орлогын ялгаатай байдал улам бүр нэмэгдэж байгаа өндөр орлоготой иргэд бол инфляц энэ эдийн засгийн хүндрэлд бол бага өртөж байгаа учраас, ер нь бол энэ шатлалтай байх нь зүйтэй юм гэдэг ийм байдлаар бол бид шатлалыг бол оруулж ирсэн. Гэхдээ бид нийт хувь хүний орлогын албан татвар төлдөг 817.2 мянган иргэдийн 0.1 хувьд нь л энэ хамаарахаар ингэж оруулж ирсэн байгаа.

Нөгөөдөх нь би энэ Улаанбаатар хотод бид нар түгжрэлтэй холбоотой хөрөнгө оруулалтуудыг бол тавьсан байгаа. Энэ хөдөө орон нутаг дээр ийм арга хэмжээнээс бид 22 оны, энэ оны төсвөөс эхлээд сая тодотгол энэ тэр дээр бид ер нь энэ төвлөрлийг сааруулах Улаанбаатар хотоос хөдөө орон нутаг руу шилжих иргэдийн шилжилт хөдөлгөөнийг ер нь цогцоор нь авч хэрэгжүүлэе гээд үе шаттай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэе. Эхнийх нь иргэн Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт ажиллана тэр хүнд ипотекийн хөнгөлөлттэй зээл өгнө. Амьдрах байр дээр нь ингээд дэмжлэг үзүүлчхэж байгаа юм.

Нөгөө талдаа тэр хүн тэнд очоод ажлын байраар хангагдаад иргэддээ өөрөөр хэлбэл хувиараа хөдөлмөр эрхлээд бизнес хийхэд нь зориулаад хөнгөлөлттэй 1 хувийн зээлийг 50 хүртэл

сая төгрөгийн зээл аваад ингээд амьдрах боломжийг нь хангачхаж байгаа юм.

Нөгөө талдаа тэр хүмүүсийг хөдөө орон нутагт нь аваад ажиллуулсан аж ахуй нэгж дээр нь татварын бодлогоор нь бас хасах зардлыг нь нэмэгдүүлээд ингээд дэмжлэг үзүүлэх байдлаар ингээд цогц арга хэмжээг бол авч хэрэгжүүлээд ингээд явж байгаа юм. Тэгэх дээр бид өөрөөр хэлэх юм бол зөвхөн Улаанбаатарт анхаараагүй бидний бодлого бол хөдөө орон нутаг руу чиглэсэн саяын төвлөрлийг сааруулах ийм бодлогуудыг бол цогцоор нь авч хэрэгжүүлээд бид сая энэ өргөн барьсан хууль дээр хүртэл үед Улаанбаатараас хөдөө орон нутагт шилжин суурьшихад нь 0.7 Га газрыг тэр очсон газарт нь үнэ төлбөргүйгээр олгох ийм бас өөрчлөлтийг оруулж ирж байгаа юм. Тэгэх дээр өөрөөр хэлэх юм бол бид Улаанбаатараас хөдөө орон.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Пүрэвдорж гишүүнд микрофон өгье.

Б.Пүрэвдорж: Тэгээд хүүхдийн мөнгийг архи, тамхинд зарцуулахгүйгээр энийг яаж хянах юм бэ гээд. Аав нь хүүхдийнхээ картаар АТМ-ээс мөнгө аваад л, тэгээд нэг 20000 төгрөгөө барьж очоод л архи авъя гэхлээр нь тэгээд дэлгүүрийн худалдагч үнэрлэж үзэх юм уу, яаж шалгах юм? Тэгээд энэ хүүхдийн чинь мөнгө байна. Тийм учраас архи өгөхгүй гэж хэлэх юм уу? Ийм хачин юм хийгээд л энэ нь ингээд хүмүүст гоё сонсогдох байх. Хэзээ ч амьдралд хэрэгжихгүй, тэгээд л нэг ийм PR-ын шинжтэй юм ингээд л хийдгээ боль л доо. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, би Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр энэ хуулийн заалтуудаар ярина. 4 өдөр хуралдана. Бүгдийг чинь бүх асуулт дээр хариулт авна. Би товчлоод өнөөдөр асуултаа асуулаа.

Т.Аюурсайхан: Тэр яаж, тэр хяналт тавих юм тэрийгээ? 80 энэ асуудлыг ер нь энэ хүүхдийн мөнгийг яг тэр хүүхдэд нь зориулдаг болгох талаар нэлээн судалгаануудыг бол хийж үзсэн. Зарим орны жишээнүүдийг бол бид нар судалж үзсэн. Хүүхдийн мөнгө нь энэ карт руу нь ингээд картын хэлбэрт шилжинэ. Бэлнээр олгохгүй. Энэ картыг өөрөөр хэлэх юм бол зориулалтынх нь дагуу гаргах хэмжээнд банкнуудтайгаа хамтарч хэрэгжүүлэх ийм боломж байгаа юм. Жишээ нь зарим орнуудад бол тэр мөнгийг одоо яг дэлгүүрт ороод юм авахад нь тэрийг чинь архи, тамхины төрлийн юм уншдаггүй. Тийм байдлаар хязгаарладаг боломж байна. АМТ-ээс бэлэн мөнгө гаргахгүй. Ийм байдлаар бид зохицуулаад, ер нь энийг үр дүнтэй хүүхдэд нь зорьдог болгоё гэдэг талаар бид ийм Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтайгаа хамтраад яг саяын хэлсний дагуу банкнуудтай хамтраад энийг хэрэгжүүлэх бололцоотой л гэж үзэж байгаа.

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь, Наянтай Ганибал нарын урилгаар Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын гишүүн Цэдэвийн Сэргэлэн асуулт асууна.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Би Төрийн албаны тухай хуульд орж байгаа өөрчлөлттэй холбоотой асуулт асууя. Нэгдүгээрт, төрийн албан хаагчдын цалингийн шатлалыг өөрчилснөөр төрийн албан хаагчдын авах цалин одоогийнхоосоо дунджаар хэдэн хувиар нэмэгдэх боломжтой болох вэ? Сангийн яам хариулж өгөөч.

Хоёрдугаар асуудал. Тэтгэвэр тогтоолгосон иргэд төрийн албанд ажиллуулахгүй гэсэн ийм хуулийн төсөл явж байгаа. Зөвхөн гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлж болно гэж. Энэ дээр бол би зөвхөн цалин, тэтгэврийг давхар давхцуулан олгож байгаатай холбоотой асуудал үүсэж байна уу гэж харж байгаа юм. Тийм учраас хэрвээ иргэд өөрсдөө хүсвэл цалин юм уу, тэтгэврийнхээ аль нэгийг нь аваад төрийн албанд ажиллаж болдог энэ сонголтыг сонгож болоогүй юм уу? Олон мянган тэтгэвэр тогтоосон төрийн албан хаагчид дотор ур чадвар өндөртэй, туршлага бүхий өндөр мэргэжилтэй, төрд хэрэгтэй олон хүмүүс бий. Ажлынхаа онцлогоос болоод харьцангуй эрт тэтгэвэр тогтоолгосон байдаг. Жишээлбэл, төрийн тусгай албан хаагчид, цэрэг, цагдаагийнхан, уул уурхай болон бусад хүнд, хортой нөхцөлд ажилласны улмаас харьцангуй эрт тэтгэвэрээ тогтоолгосон, ажлын өндөр чадавх бүхий ийм иргэд олон бий. Эдгээрийн төрд ажиллах боломжийг нь сонголттойгоор, эсвэл тэтгэвэрээ аваад ажилла, эсвэл цалингаа ав. Мэдээж хүн аль арай илүү цалингийн юм уу, тэтгэврийг нь сонгоод ажиллах болох байх. Ийм сонголттой байлгаж болоогүй юм уу гэсэн 2 дахь асуулт байна.

Гуравдугаарт, би татвартай холбоотой юм асууя гэж бодож байна. Энэ өндөр үнэ бүхий үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөнүүд, архи, тамхины татварыг илүү өндөр тогтоох нь үр дүнтэй гэж би үзэж байгаа юм. Улаанбаатар хотоор дүүрэн өндөр өндөр оффисын барилгууд байж байна. Энэ оффисын барилгуудын түрээнээс олдог орлого бол ямар байгааг хүн болгон мэднэ. Улаанбаатар хотын гудмаар дүүрэн энэ түгжрэл яриад байна. Машиныудыг ангилан авч үзвэл маш өндөр үнэ бүхий том оврын жийп төрлийн автомашинууд маш их явж байгаа. Эдгээрийн татварууд байж байна. Харин эсрэгээрээ хөдөө орон нутагт,

хязгаар нутагт ажлын байр бий болгосон, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга объектуудыг барьсан тохиолдолд татвараас чөлөөлдөг. Ийм ялгавартай хандлага байвал аль аль талдаа илүү үр дүнтэй юм болов уу. Миний ярьж байгаа энэ татварын асуудал бол бага болон дунд орлоготой иргэдэд бол төдийлөн хамаарахгүй асуудал шүү гэж ойлгоорой.

Дараагийн нэг асуудал байна. Энэ татвар, нийгмийн даатгалын байцаагч нар, тээврийн байцаагч гэж байгаа, Гадаадын иргэн, харьяатын албаныхан гэх мэтчилэн төрийн албадууд хувцас форм хэрэглэж байгаа юм. Форм, янз бүрийн таних тэмдэг бүхий харахад зарим нь цэрэг, цагдаагаас ч ялгагдахгүй, зарим нь ч генерал шиг ч байдаг юм уу, тэгээд ийм өндөр үнэтэй хувцас, форм эдгээр албадуудад ашиглах шаардлага байдаг юм уу нэгдүгээрт?

Хоёрдугаарт энд улсын төсвөөс хэдий хэмжээний хөрөнгө төсөвлөж байгаа юм? Харин энэний оронд эдгээр төрийн албан хаагчдаа унааны болон бусад нэмэгдлүүдийг нь олгоод өгчих, цалинг нь нэмээд өгчих, ингэвэл илүү үр дүнтэй юм биш үү? Болсон, болоогүй янз бүрийн хувцас, форм хэрэглээд энэ үр дүн нь юу байдаг юм бол ер нь?

Т.Аюурсайхан: 82 дээр Сангийн яам хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Сэргэлэн гишүүний асуултад хариулъя.

Тэгэхлээр цалингийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд бол бид нар үндсэн 3 арга хэмжээг бол авч хэрэгжүүлнэ. Нэгдүгээр асуудал бол суурь цалингийн хувьд бол төрийн захиргаа болон төрийн тусгай албан хаагчийн хувьд бол бид шатлалыг бол байхгүй болгох ийм арга хэмжээ авна. Энэ бол өмнө нь бол эрүүл мэнд, боловсрол дээр бол хийчихсэн. Энэтэй холбоотой бол 21.4 мянган

төрийн захиргааны албан хаагч, төрийн тусгай албан хаагч 39.3 мянган хүн хамрагдана. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ирэх жил бол 550 мянга болж байгаатай холбоотойгоор нийт төрийн нийтлэг үйлчилгээ үзүүлж байгаа 47 мянган албан хаагчийн цалин хөлс нэмэгдэнэ.

Мөн ажилласан жилийн нэмэгдлийг бол бид нар жил болгоныг нь төрд ажилласан жилийг нь үнэлээд 1, 1 хувиар бол нэмэгдүүлэхээр тооцсон байгаа. Үүнд бол төрийн захиргааны 21.4 мянга, төрийн тусгайн 39.3 мянга, төрийн үйлчилгээний 107 мянган хүн бол хамрагдана.

Мөн гурав дахь арга хэмжээ бол орон нутгийн нэмэгдлийг бол бид олохоор оруулж ирж байгаа. Энэ нь бол төрийн захиргааны 11.4 мянган хүн орон нутагт ажиллаж байгаа хүн бол хамаарах юм байгаа юм. Ингэхлээр нийт дүнгээрээ бол энэ 3 тогтолцооны өөрчлөлтийг оруулсны үр дүнд бол төрийн захиргааны албан хаагчийн цалин бол 16-39 хувь, төрийн захиргааны албан хаагч мөн ялгаагүй 10-19 хувиар цалин, хөлс нь нэмэгдэх ийм боломж тавьж байгаа. Төрийн үйлчилгээний албан хаагчийн нийтлэг ердийн төрийн үйлчилгээний албан хаагчийн хувьд бол 10 хувь орчмоор бол цалин хөлс бол нэмэгдэнэ гэсэн бол ийм бол тооцоотой орж ирж байгаа.

Дараачийн ээлжид бол Төрийн албаны тухай хуульд бол бид нар 22.1 гэдэг хэсэг байгаа. 22 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт бол төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах нийтлэг шаардлага гэсэн хуулийн заалт байгаа. Энэ заалт дээр бол бид нар тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн болон төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн бол төрийн жинхэнэ албан хаагчийн энэ шалгуурт бол буцаагаад томилох эрхгүй байхаар ийм заалт бол оруулж ирж байгаа.

Тэгэхлээр бол гол энэ дээр баримталсан зарчим бол юу вэ гэхлээр тэтгэвэрт тогтоолгох насанд хүрээд тэтгэвэрт гараад, тэтгэврээ авч эхэлчхээд нэг бол төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээд хуулиараа төрийн албыг үргэлжлүүлж хаах боломжгүй болчихсон мөртөө цолны нэмэгдэл гэдэг юм уу, төрийн албан хаагчийн хангамж эдлээд явдаг нэмэгдлүүдийг бүгдийг нь аваад явдаг ийм төрийн албан хаагч гэхлээр 5100 хүн байна гэдгийг бол манайх цалингийн тэр сан дээрээс бол гаргаж ирсэн байгаа юм.

Тэгэхлээр энэ хүмүүсийг бол бид нар бол юу гэдэг юм хөдөлмөр эрхлэхийг нь бол хориглоогүй. Хөдөлмөр бол хувийн секторт ч гэдэг юм уу эрхлэх энэ боломжууд нь бол байж байгаа. Мөн зөвлөх үйлчилгээ байдлаар юу гэдэг юм, гэрээний үндсэн дээр богино хугацааны ажил, хөдөлмөр гүйцэтгэх тэр эрх нь бол байж байгаа юм.

Дараачийн ээлжид бол дүрэмт хувцасны асуудал дээр бол Төрийн хэмнэлтийн тухай хууль дээр бол 8 дугаар зүйл дээр дүрэмт хувцасны асуудлыг бол тодорхой зохицуулсан байгаа. Үүнд бол цэргийн албан хаагч, прокурор, гадаадын иргэн харьяат.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Сэргэлэн гишүүнд 1 минутыг нэмж өгье.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Хариултаас харж байхад та дандаа төрийн захиргааны албан хаагчид, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн тухай асуудал хариулчихлаа. Төрийн тусгай албан хаагчид хамаарна биз дээ? Хамаарна гэж би ойлгож байгаа. Тийм ээ? Хоёрдугаарт сая та хариулт өгөхдөө энэ минутаас болоод гүйцэд хариулж чадсангүй тэр хувцасны талаар ахиад тодруулаад хариулаад өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

Т.Аюурсайхан: 82 Сангийн яам.

М.Санжаадорж: Сэргэлэн гишүүний асуултад гүйцэж хариулъя. Тэгэхлээр Төрийн хэмнэлтийн тухай хуулиар бол төрийн албан хаагч, цэргийн албан хаагч, прокурор, Гадаад иргэн, харьяатын улсын байцаагч, гаалийн улсын байцаагч бол төрийн хөрөнгөөр албан юу гэдэг юм дүрэмт хувцас бол худалдан авч бол болохоор байгаа юм. Бусад ямар ч төрийн албан хаагч бол төсвийн хөрөнгөөр бол ийм дүрэмт хувцас худалдаж авахыг бол хориглохгоод байгаа юм.

Тэгэхээр бол энэ бусад таны түрүүний хэлсэн тэр алба хаагчдын хувьд бол төсвөөс бол хөрөнгө зарж, дүрэмт хувцас бол худалдан авч байгаа зүйл бол байхгүй. Харин зүгээр хамт олныхоо хүрээнд тэр тухайн байгууллагынхаа үйлчилгээний соёл гэдэг юм уу, юу гэдэг юм онцлогтоо тохируулан өөрсдийнх нь цалингаараа байдаг юм уу, эсвэл нэгдсэн зохион байгуулалтаар авахыг бол тэр нь бол нээлттэй. Ямар ч тохиолдолд төсвийн хөрөнгө оруулалт болохгүй гэдэг ийм байр суурьтай байгаа. Тэгэхлээр бол төсвөөс мөнгө зарцуулаагүй гэж хэлэх байна. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд асуулт асууна.

Г.Ганболд: Бид нар төсөв дагасан хуулиуд гэж нэрлээд ийм заншчихсан. Олон хууль хэлэлцэж байна л даа. 140, 50 хууль. 4, 500 хуудастай уншиж амжихгүй байна л даа. Тэгэхээр нэг логик дарааллын хувьд би Төсвийн байнгын хорооны даргаас асуух гээд байгаа юм. Цуг орж ирээд уг нь бол эхлээд бид нар энэ дагах хуулиудаа төсвийнхөө түрүүнд нь хэлэлцмээр байна. Тэгээд энэ хуулиуд чинь дэмжигдэх юм бол бид нар төсвөө шууд яриад явахгүй бол одоо төсвөө бид нар эхлээд хэлэлцчихсэн. Хэрэв дагах хуулиуд уначих юм бол дахиад л төсөв задарна.

Тэгэхээр зэрэг ер нь бол энэ орж ирж байгаа хуулиудаа түрүүлж төсвийнхөө өмнө хэлэлцээд явах нь бол яг логик дарааллын хувьд бол зөв байгаа юм. Эд нар дэмжигдсэн тохиолдолд бид нар төсвөө үргэлжлүүлээд хэлэлцээд явах. Хэрэв дэмжигдээгүй бол төсвийн яамнууд дээр ч тавьж байгаа төсвүүд чинь өөр өөр болно шүү дээ. Тэгээд ийм чиглэлээр явахгүй бол энэ дараалал нь ер нь алдагдаад байна гэж хэлэх гээд байгаа юм. Тэр битгий хэл энэ дотор төсөв дагасан хууль биш, бие даасан хууль хүртэл явж байна. Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай хууль гэдэг чинь бүр бие даасан хууль байна шүү дээ. Тэгээд бие даасан энэ том хуулиудыг чинь ингээд төсөв дагасан хууль гээд энэ 140, 50 юм дотор оруулж ирэхээр чинь бид нар олж харж унших ч боломжгүй. Ингээд шууд хууль батлагдаад яваад байна шүү дээ.

Тэгэхээр би Баасандорж даргаас асуух гээд байгаа юм. Би мэргэжлийн хяналтын байгууллага олон жил үйл ажиллагаа явуулж ирсэн. Бас тодорхой хэмжээгээр нийгэмд бол үүргээ ч гүйцэтгэсэн. Тэгээд өнөөдөр та одоо Мэргэжлийн хяналтын дарга болоод, ер нь энэ байгууллага бол нийгэмд гүйцэтгэх үүргээ гүйцэтгэсэн одоо бол нэмэргүй юм байна гэж хэлээд та ер нь бол татан буулгах саналыг оруулж ирж байгаа юм байна гэж ойлголоо. Таны хариултуудаас ер нь бол энэ байгууллага бол Мэргэжлийн хяналтын хяналтын чиг үүргүүдээ бараг биелүүлэх боломжгүй болсон гэсэн тайлбарыг өгч байх шиг байна л даа. Тэгээд энэ гүйцэтгэх засаглал дахь хяналтын хуулийг батлуулаад, энэ дотор бол аймаг, нийслэл, яамдуудыг төрийн өмчит компаниудыг л хянадаг ийм бүтэц бий болгох гэж байгаа юм байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар чинь байх юм уу?

Тэгээд 1 байгууллагынхаа эрхэлж байгаа ажлыг өөр 1 агентлаг байгуулаад эрх үүргийг нь авдаг, одоо нэг ёсондоо

миний ойлгож байгаагаар бол Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнээс Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудал руу шилжиж байгаа юм байна л даа. Яг ийм болсноороо ер нь та ямар үр дүн гаргана гэж хараад байгаа юм? Өмнө нь Мэргэжлийн хяналтын байгууллагаас энэ санхүүгийн хяналтыг Сангийн яам руу өгсөн шүү дээ. Тэгээд яг ямар үр дүн гарсан юм? Миний ойлгож байгаагаар бол бас энэ мэргэжлийн хяналтын байдлаа бол харьцангуй хөндлөнгийн байгууллага.

Гэтэл өнөөдөр төсвийн ерөнхийлөн захирагч өөрөө томилдог байгууллагаараа өөрийгөө хянуулах гэж байна. Өөрөө томилоод, дороо даргаар тавьсан хүнээрээ өөрийнхөө төсөв дээр байгаль орчин дээр, хүнс, хөдөө аж ахуй дээр өөрөө өөрийгөө хянуулах гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ яг зөв тогтолцоо мөн юм уу? Тэгэхээр энэ дээр би таныг бас тодорхой хариулт өгөөч гэж хэлэх гээд байгаа юм. Хэрэвзээ та нарын оруулж ирсэн энэ хууль батлагдаад явах юм бол энэ Мэргэжлийн хяналтад ажиллаж байгаа энэ олон ажилтнууд чинь бүгдээрээ яг салбар салбарынхаа агентлаг руу шууд ямар нэгэн шалгуургүйгээр очиж ажиллах уу? Тэнд өчнөөн мянган төрийн албан хаагчид юм яах нь ойлгомжгүй, сүүлийн хэдэн жил ерөөсөө ямар ч хяналт шалгалтын эрх, үүргийг нь авчихсан, одоо татан буугдах нь тодорхойгүй ингээд байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр та бас нэг тодорхой хариулт хэлээч гэж хэлэх гээд байгаа юм.

Энэ Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай хууль гээд байна л даа. Энэ дээр бол улсын ерөнхий шалгагч нь бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга байна гээд. Тэгээд л бас л нэг байгууллага дээр давхардуулаад аваачаад өгчихсөн. Тэгээд яг энэний яг үндсэн чиг үүрэг нь юу юм? Миний ойлгож байгаагаар яг энэ байгууллагын үндсэн

ажил нь одоогийн Мэргэжлийн хяналтаас өөр нь яг юу юм бэ? Төрийн өмчит компаниуддаа шалгалт хийнэ гэж байгаа бол энэ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар гээд том газар байгаа.

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярын урилгаар Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн бие бүрэлдэхүүний төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ нийт Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Сангийн яам эхлээд хариулъя, 80 дээр. Дараа нь Баасандорж дарга бэлдэж байгаарай. 93 дээр хариулах уу? 93 дээр хариул.

Б.Баасандорж: Ганболд гишүүний асуултад хариулъя, Баасандорж. Өнгөрсөн 2021 оны намрын ээлжит чуулганаар Шинэ сэргэлтийн бодлогыг хууль тогтоох байгууллага бол баталсан байгаа. Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичгийн 6 шинэ сэргэлтийн 6 дахь сэргэлт дээр төрийн бүтээмжийн сэргэлт байгаа. Энэ төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд Засгийн газар Их Хурлын өмнө үүрэг хүлээсэн. Тэр нь өөрөө төрийн хяналт шалгалтын тогтолцоог оновчтой болгох. Энэ дагуу төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг оруулж ирээрэй гэдэг үүргийг өгсөн байгаа. Энэ үүргийн хүрээнд Ганболд гишүүнээ 2003 онд бол Мэргэжлийн хяналтын байгууллага буюу төрийн хяналт шалгалтад маш том өөрчлөлт орсон. Маш том дэвшил гарсан. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд бид нарт оносон зүйлс маш их байгаа. Сүүлдээ бас алдсан зүйлүүд ч байгаа. Энэ 2022 оны энэ хуулиар өөрчлөгдөж байгаа өөрчлөлт бол би энэ байгууллага татан буугдаад байхгүй болж байна гэж үзэхгүй байгаа. Энэ байгууллага өөрчлөн зохион

байгуулалтад ороод 13 яаманд шилжиж байгаа. Ингэснээрээ гол нь бизнес эрхлэгч, аж ахуй нэгжид ээлтэй, хүнд сурталгүй, ухаалаг, бодитой ийм үйл ажиллагааг л үзүүлэх ёстой. Энэ нь оновчтой байх ёстой.

Мэдээж дагаад энэ төрийн албан хаагчдын асуудал яригдана. Манай Мэргэжлийн хяналтын байгууллага өнөөдөр 1600 гаруй албан хаагчтай. Энэ 1600 албан хаагчдаас улсын хэмжээнд байцаагчийн эрх эдэлж, үйл ажиллагаа явуулдаг орон нутаг, нийслэл, ерөнхий газрын бүх байцаагч нар маань салбар яам болон төрийн захиргааны байгууллага, орон нутаг дахь төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын харьяа байгууллагуудад шууд шилжинэ. Байцаагч нараас 1 ч хүн ажилгүй болохгүй. Харин ажлын асуудал нь Төрийн албаны тухай хуульд заасныхаа дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий гарзын удирдлага, Ерөнхий газрын дарга болон 21 аймгийн дарга, Нийслэлийн мэргэжлийн хяналтын дарга нар бол чөлөөлөгдөнө. Бусад хэвийн үйл ажиллагаагаа мэргэжлийн хяналтын чиг үүргээр улсын байцаагчийн эрхээ эдэлж байгаа бүх байцаагч нар бол шууд чиг үүргээр шилжиж ажиллана гэдгийг танд хэлье.

Та бас маш чухал нэг асуудал хөндөж байна. Хөндлөнгийн болон хараат бусын асуудал ярьж байна. Энэ салбартаа мэргэжлийн хяналтын байгууллага очсоноороо хөндлөнгийн хяналт бол алдагдана гэдэг зүйл бол огт байхгүй. Хөндлөнгийн хяналт гэж юу юм бэ гэж олон улсын байгууллагын тодорхойлолт байдаг. Энэ тодорхойлолтоор хөндлөнгийн хяналт гэдэг гэдэгт тухайн аж ахуйн нэгж байгууллагыг төрийн аль нэг байгууллага хянахыг л энэ хөндлөнгийн хяналт гэж байгаа. Тэрнээс биш аль нэг агентлаг, тухайн харьяа яам дээр очсоноороо төрийн хяналт бол алдагдах гэдэг бол

зүйл байдаггүй. Би танд нэг жишээ хэлье л дээ.

Өнөөдөр Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо бүгд л зөвшөөрөл өгдөг. Жишээ нь хууль зүйн салбар дээр тамга тэмдэг үйлдвэрлэх, харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх галт зэвсэг гэх мэт зөвшөөрлийг өгөөд харьяа агентлагууд хянадаг. Монголбанк банк байгуулах үйл ажиллагаа дээр зөвшөөрөл өгдөг. Монголбанк өөрөө хянадаг. Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрөл өгдөг. Улсын бүртгэлийн байгууллага зөвшөөрөл өгдөг. Яг ийм тогтолцоо бол манайд байгаа. Тэгэхээр гол нь тэр таны яагаад байгаа юм, тэр салбарын яам дээрээ очсоноороо энэ шийдвэр биелэлтдээ яаж хяналт тавих юм бэ гэдэг дээр бол хараат бусын асуудал яригдаж байгаа юм. Магадгүй Б гэдэг байцаагч өөрийн тэр харьяа сайд, Төрийн нарийныхаа даалгавраар энэ хяналт шалгалтын асуудалд ашиг сонирхлын зөрчил гаргах юм бол энэ өөрөө авлигыг бол ашиг сонирхлын.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Сангийн яам хариулчих. Төсвийн өмнө нь хэлэлцэх нь зүйтэй шүү гэсэн ийм санал гаргаад байна шүү дээ. Үндэслэл, шаардлагыг нь. 80 Ганбат дарга.

Ж.Ганбат: Бид төсвийг бол боловсруулахдаа бол хүчин төгөлдөр байгаа хуулийн хүрээнд, эсвэл хууль өөрчлөх бол төсвийг дагалдуулж хуулийн өөрчлөлтөө өргөн барьдаг ийм зарчимтай. Төсвийг хэлэлцэх юм бол Улсын Их Хурлын дэгийн хуулийнхаа дагуу зохицуулагдаад явах болохдоо тэрийг бол би Төсвийн байнгын хороо хариулах нь илүү зохимжтой байх л гэж үзэж байна.

Т.Аюурсайхан: Ганбат дарга Төсвийг дагасан хууль гэдэг томъёолол бол байхгүй шүү дээ. Дагасан хууль юм уу, бие даасан хууль гэдэг ийм ялгасан ийм томъёолол бол хаана ч байхгүй шүү

дээ. Та нар өөрсдөө битгий буруу хариулаад бай л даа. Төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулиуд бүгд. Энэ бүгд бол Ганболд гишүүний томъёолоод байгаа. Бүгд бие даасан гэж томъёолоод байгаа хуулиуд мөн шүү дээ.

Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут асуулт асууя.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Би хоёрхон асуулт байна. Тэгээд бас яамныхыг хариулахдаа энэ тогтоолын төслийг уншиж өгч битгий хариулаарай гэж хүсмээр байна. Би тэгээд тэр тогтоолын төслийг нь уншаад өгчихье. Монгол Улсын 2023 онд Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай гээд түүний 3-т Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогод туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх болон орон нутгийн барилга байгууламжийн их засвар урсгал засвар, тоног төхөөрөмж худалдан авахаас бусад шинэ төсөл, арга хэмжээг бүх шатны орон нутгийн төсөв, Засгийн газар болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эх үүсвэрээр 2023 онд хэрэгжүүлэхгүй байх гээд. Ингээд орон нутгийн эрх хэмжээг хязгаарлаж байна л даа.

Улсын төсөв 23 онд шинэ хөрөнгө оруулалт, шинэ төслүүдийг хэрэгжүүлэхгүй гэхсэн байгаа. Тэгэхдээ амьдрал цаана нь явж л байна. Монголчуудын маань. Тэнд бас хэрэгцээ шаардлагууд маш их байгаа. Шинэ цэцэрлэг, шинэ сургууль, шинэ эмнэлгүүд гээд, Тэгэхээр энэ нэг улсын төсөв бүрдүүлэхэд төвлөрүүлэлт хийдэг 5 аймаг байгаа юм л даа. Манай аймаг гэхэд 1 жилдээ 50-60 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт орон нутагтаа хийдэг. Улсын төсөв 120 гаруй тэрбум төгрөг тэгшитгэдэг ийм аймаг. Тэгэхээр бид нар энэ заалтаараа шинэ хөрөнгө оруулалтыг хасаад зөвхөн засвар үйлчилгээ дээр энэ мөнгийг зарцуулах гээд байгаа. Болж

байна. Бас нийгмийн бусад хөтөлбөрүүд рүү. Цаана чинь тэгтэл 2, 3 ээлжид орох гэж байгаа цэцэрлэгүүд байна шүү дээ, сургуулиуд байна шүү дээ. Зайлшгүй шаардлагатай эмнэлэг, өрх, гэр, эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаанууд бас байна шүү дээ.

Тэгэхээр бид нарт энэ гарц гаргалгааг хориглох биш нээж өгөх боломж бололцоо байхгүй юм уу? Энэ дээр ямар боломж байгаа гэж үзэж байгаа вэ? Зөвхөн 5 аймагт улсын төсөв бүрдүүлэхэд оролцдог 5 аймаг биш бусад аймгууд ч гэсэн зарим нэг төрлийн давсан орлогоороо хөөрхөн бүтээн байгуулалт хийж болно шүү дээ. Яагаад орон нутгийн бие даасан байдлыг бид бүхэн илүү хангаж ажиллана гэххэд яг газар дээрээ, цаг дээрээ цаг нь болонгуут ингээд боомилсон, хаасан болоод байгаа ийм тогтоолын төсөл батлах гээд байгаа юм бэ? Үгүй, энэ чинь амьдрал явагдана, цаана чинь асар их хэрэгцээ, шаардлагууд байгаа учраас улсын төсвөөр хийдэггүй юм бол орон нутгийн төсвүүд дээр бүгдээрээ бас хийе л дээ. Жоохон бүтээн байгуулалт хийе л дээ. Харин хаа очиж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлууд маш сайн явагддаг юм шүү. Бүрэн дүүрэн дуусдаг. Улсын төсөв дээр тавигддаг ажлууд л жил жилээс ингээд хойш сунжирч удааширдаг ийм л асуудлууд байгаа. Энэ дээр би хариулт авъя гэж бодож байна.

Хоёрдугаарт нь Сэргэлэн гишүүнд бас хариулчих шиг боллоо. Төрийн захиргааны албан тушаалтнуудын цалинг нэмнэ гэж байгаа сайн хэрэг. Нэмэх цаг нь ч болсон. Харин ч бүр бага нэмж байна гэж хэлэхээр байгаа. Гэтэл төрийн үйлчилгээгээ бас нэмнэ гэж оруулж ирж байна. 10 хувь л нэмэгдэх юм байна л даа. Та нар бодоод үз дээ. Тэр хүмүүс дөрөв, таван зуун мянган төгрөгийн л цалин авдаг юм шүү дээ. Гар дээрээ. Тэгээд 10 хувь нь нэмнэ гэхээр 40 мянга, 50 мянга нэмэгдэх юм уу? Үгүй, бид чинь нэг жоохон эргэлт хийж болохгүй байгаа

юм уу? Хүнээ бодож болдоггүй юм уу? Энэ нийгмийг бүтээж босгож байгаа энэ хүмүүсийн асуудал дээр яагаад ингэж ач холбогдол өгөхгүй ингэж хаяж байгаа юм бэ? Жоохон нэмэгдүүлэх боломж байхгүй юу? Магад.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Ганбат дарга 80.

Ж.Ганбат: Батлут гишүүний асуултад хариулъя. Бид ирэх жил бол эдийн засгийг тогтворжуулах зайлшгүй ийм шаардлага нэн яаралтай авч хэрэгжүүлэх шаардлага. Энэ хүрээндээ бид нар төсвийн болон мөнгөний хатуу бодлого бид хэрэгжүүлэхээс өөр арга байхгүй. Энэ хүрээндээ бид нар төлбөрийн тэнцэл, валютын нөөцөө бид хамгаалах, хадгалах энэ дээрээ бид нар онцгой анхаарах зайлшгүй шаардлага байгаа. Энэ бодлогын хүрээнд л бид нар шинэ хөрөнгө оруулалтыг энэ жил тэвчье гэдэг ийм л бодлогыг хэрэгжүүлж байгаа.

Бид улсын төсөв дээрээ нэг шинэ хөрөнгө оруулалт байгаа дээр ер нь бүх шатны төсөв дээрээ л ийм бодлого хэрэгжүүлэх өөр арга байхгүй. Яг үнэндээ бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаас илүү Өмнөговь, Орхон энэ тэр гээд бие даасан аймгуудын хөрөнгө оруулалт бол бас чамлахааргүй их хэмжээгээр бол хийгдэх боломж бол байгаа юу? Байгаа нь үнэн. Гэхдээ 1 жил энийгээ тэвчээч гэж байгаа юм. Том эдийн засгийн бодлогоо дэмжлэг үзүүлээд саяын хэлдэг бид нар эдийн засгаа тогтворжуулах, төлбөрийн тэнцлээ, валютын нөөцөө хадгалах, хамгаалах, энэ хүрээндээ л энэ арга хэмжээг авч хэрэгжүүлэхээс арга байхгүй. Энийг л ойлгооч л гэж байгаа юм.

Тэрнээс бид улсын төсөв дээр арга хэмжээ авчаад орон нутгийн түвшиндээ нээх боломж бол байвал байна. Бид өмнөх хямралын үед, сая энэ КОВИД-ын үед, ер нь эдийн засгийн хүндрэлтэй арга хэмжээнүүдийг бид болж өгвөл орон нутаг дээр зөвхөн улсын төсөв дээрээ л

авч хэрэгжүүлдэг байсан. Бид орон нутгийн төсвийг болж өгвөл энэ ирэх жил шиг ингэж хөрөнгө оруулалтыг нь ингээд зогсоочихсон үе ер нь байгаагүй л дээ. Тэгэх дээр ирэх жилийн хувьд бол онцлог байгаа. Бид валютын нөөцөө бид нар хамгаалах энэ чиглэлд онцгой анхаарахгүй бол энэ бол улсаараа бол бас бид энэ дээр эдийн засгаа тогтворжуулах энэ арга хэмжээг хэрэгжүүлэх учраас энэ орон нутгийн төсөвт бүх шатны төсөвт төрийн компаниуд энэ дээрээ анхаараач гэдэг энийг зайлшгүй хэрэгжүүлнэ. Энийг л ойлгооч гэж хүсэхээр байна.

Хоёр дахь нь, ирэх жилийн цалинг нь бид нар яах вэ, төсвийн боломжтой л уялдуулаад л энэ арга хэмжээнүүдийг авч үзэж байгаа. Бас инфляцын түвшинтэйгээ бас үүнийг бас уялдуулаад л авч үзэж байгаа. Цалин бол бүр илүү бид бол боломжоор л нэмж байгаа. КОВИД-ын үед цалинг бол бид бас нэмээгүй ингээд байсан. Сая тэтгэврийг бид нар, хавар 2 сард нэмсэн. Төрийн албан хаагчдын цалин дээр ТҮ-гийн хувьд бид нар 22 оны түвшинд бол бид шатлалгүй болгоод төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг бол ер нь нэмчихсэн. Гүйцэтгэлд суурилсан үр дүнтэй нь уялдуулаад. Ирэх жил бид нар бас энийг нь боломжоор нь бас саяын байдлаар 10 хувь нэмэхээр бол ингэж оруулж ирсэн ийм байгаа.

Т.Аюурсайхан: Батлут гишүүнд 1 минут нэмж өгье. Батлут гишүүнд микрофон өгөөрэй.

Д.Батлут: Ийм байж болмооргүй байгаа юм. Та бүхэн зүгээр яахав, өнгөрсөн...

Т.Аюурсайхан: Энэ техник яагаад саатаад байна. Батлут гишүүнд 1 минут.

Д.Батлут: Өнгөрсөн 20 оноос хойш төсвийн хөрөнгө оруулалтуудаа. Байна уу? Өнгөрсөн 20 оноос хойш улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалтуудыг та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Аймаг бүр

харилцан адилгүй хөрөнгө оруулалтууд хийгдчихсэн байгаа. Гэтэл одоо ингээд 23 онд бид нар ямар ч хөрөнгө оруулалт хийхгүй гэхээр тухайн бага хөрөнгө оруулалт хийгдэж байгаа аймгуудын ард иргэд маань ямар нөхцөл байдалд орох юм бол? Та бүхэн социал дээр явж байгаа мэдээллүүд бүгдээрээ харж л байгаа байх. Энэ орон нутгийн хэдэн хөрөнгө оруулалтын зардлыг бид нар хэмнэснээрээ валютын нөөцийг нэмэгдүүлнэ гэдэг гэвэл тэр шиг хурдан юм байхгүй гэж харж байгаа. Тэрэн дор далд эдийн засгаа ил болгох, энэ мөнгөнийхөө урсгалуудыг нягталж шалгах ажлуудаа эрчимжүүлэх хэрэгтэй, сайжруулах хэрэгтэй. Ингэж эдийн засгийн.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяагийн урилгаар Баянзүрх дүүргийн ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор асуулт асууна.

Д.Өнөрболор: Ирэх оны төсвийн төслийг дагаж өргөн баригдсан хуулийн төслүүдийг бол бид хэлэлцэж байна. Үүний дотор энэ Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай гэсэн бие даасан хууль орж ирж байна. Энэ хуулийн төслөөр бол зарим бол сайн талууд бол байна. Тухайлбал, хяналтын тогтолцоо бэхжих, Ерөнхий сайдаас бодлого шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, сайжрах, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төрийн үйлчилгээг сайжруулах, ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зэрэг бас энэ чухал асуудлуудыг бол тусгасан байна.

Нөгөөтээгүүр энэ мэргэжлийн хяналтын байгууллагын зарим чиг үүрэг нь бол бодлогын яамд шилжиж байгаа

юм байна гэж бол ойлголоо. Нэг талаасаа энэ хяналтын давхардал буурах боловчиг, нөгөө талаасаа бол бодлого хяналт 2-ыг бол нэг субъект дор аваачиж ингэж хэрэгжүүлэх нь ер нь хэр оновчтой вэ гэж асууя. Мэргэжлийн хяналт бол ер нь төрийн тусгай чиг үүрэгт бол тооцогддог. Тэгээд энэ хүнсний, байгаль, экологийн, хөдөлмөрийн гээд 20 гаруй хууль тогтоомжоор чухал үүрэг гүйцэтгэдэг ийм оролцоотой бол бүтэц байгаа. Тэгэхлээр энэ хуулийг дагаж Үндэсний аюулгүй байдлын хуульд байгаа энэ Мэргэжлийн хяналтын чиг үүргийг бол хасахаар орж ирж байгаа юм байна. Нэгдсэн Үндэстний байгууллагын судалгаагаар бол энэ хүнсний аюулгүй байдал дэлхий даяар бол бас нэлээн эрсдэлд орсон. Манай улсын хувьд ч гэсэн бол импортын хамаарал 48 хувьтай байна.

Тэгэхлээр энэ хүнсний хангамж өндөр эрсдэлтэй байгаа бол хэвээрээ байгаад байна. Тэгэхлээр энэ чиг үүргийг нөхөх зохицуулалтыг ер нь хэрхэн тусгасан байх вэ? Тэгээд энэ чиг үүргийг ер нь хэн хэрэгжүүлэхээр энэ асуудлыг зохицуулалт хийж байгаа вэ гэж асууя.

Т.Аюурсайхан: 93 дээр Баасандорж дарга хариулья.

Б.Баасандорж: Өнөрболор гишүүний асуултад хариулья Баасандорж. Бодлого, хяналт 2-ыг нэг дор аваачиж байгаа нь хэр оновчтой вэ гэсэн нэг дэх асуултыг асуулаа. Тэгэхээр яг өнөөдөр яг манай тогтолцоо бол бодлого хэрэгжилт 2 тусдаа. Хяналт нь бол яг өнгөрсөн 20 жилийн хугацаанд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар дээр явсаар ирсэн. Өөрөөр хэлбэл, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар дээр анх 30 гаруй төрлийн хяналт хийдэг байсан бол өнөөдөр 26 хяналт хийж байгаа. Өөрөөр хэлбэл 26 бодлого дээр хэрэгжилтийнх нь хувьд хяналт тавьж байгаа. Тэгээд яг мэргэжлийн хяналтын байгууллага хэдийн хяналтаа хийгээд, буцаагаад нөгөө эргэх бусад

ямнуудтайгаа, салбарын яамнуудтайгаа бодлогыг сайжруулах тал дээр эргэх тийм уялдаа холбоо байдаггүй. Жишээ нь би танд ганц жишээ хэлье л дээ. Хүнсний аюулгүй байдал бол маш чухал таны хэлсэн яг. Дэлхий дээр хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндийн аюулгүй байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал буюу байгаль орчны аюулгүй байдал хамгийн эрсдэл өндөртэй, анхаарах ёстой хяналтууд байдаг. Жишээ нь манайд хүнсний аюулгүй байдлын сүлжээ бол заавал нэг эргэлтээр явах ёстой.

Манайд өнөөдөр бол энэ алдагдчихсан явж байгаа байхгүй юу. Жишээ нь мал аж ахуй Хүнс, хөдөө аж ахуйн яам дээр явж байгаа. Малын хяналт Мэргэжлийн хяналт дээр бас явж байгаа. Хөдөө аж ахуй нь бас Хүнс, хөдөө аж ахуй манай 2 дээр явж байгаа. Импортын асуудал байна. Хүнсний бүтээгдэхүүний импортын асуудал Гааль дээр явж байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ нэг байх ёстой хүнсний аюулгүй байдлын сүлжээ маань өөр өөр төрийн байгууллагууд дээр очсон байгаа. Би яг энэ хүнсний аюулгүй байдлын хяналт маань Хүнс, хөдөө аж ахуйн яам дээрээ очсоноороо бодлого, хэрэгжилт, хяналт 3 нэг дор очоод, хяналтаар гарсан алдаа дутагдал, бодлого бол бодлого дээрээ эргэх холбоотой сайжирна гэж хараад байгаа юм. Яг нэг хүнсний сүлжээ бол нэг дээр очно гэж үзэж байгаа. Дээрээс нь мөн яг манайтай юутай холбоотой энэ мэргэжлийн хяналтын тогтолцоо бол 13 яаманд, салбарт бол шилжиж байгаа. 13 салбарт.

Өөрөөр хэлбэл энэ 13 салбар дээр 13 салбарын ерөнхий байцаагч яам болгон дээр ажиллах юм. Энэ яаман дээр ажиллаж байгаа салбарын ерөнхий байцаагч болон салбарын ерөнхий байцаагчийн дор ажиллаж байгаа ахлах байцаагч нар бол улсын хэмжээнд, жишээ нь хүнсний салбар дээр. Салбарын ахлах байцаагч нь салбарын ерөнхий байцаагчтайгаа улсын хэмжээнд байгаа. Тэр орон нутагт байгаа байцаагч нараа

хяналтаа тавьдаг, мэргэжил арга зүйн удирдлагаараа хангадаг. Бодлого дээр эрх холбоог танилцуулж байх ёстой. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар өнөөдөр шалгалт хийгээд ямар ч байгууллагын үйл ажиллагааг зөвшөөрлийг нь хүчингүй болгох юм уу, эрхийг нь цуцлах эрх бол байдаггүй. Жишээ нь ингээд сая махны асуудал дээр ингээд дуулиан болоод асуудал яригдсан. Махны асуудал дээр манай мэргэжлийн хяналтын байгууллага хяналт шалгалт хийгээд буцаагаад Хүнс, хөдөө аж ахуйн яамандаа, гаалийн байгууллагадаа тэр саналуудыг л хүргүүлж байгаа юм. Энэ байгууллагууд дээр яагаач. Барилгын салбар дээрээ зөрчилтэй барилгыг манайх шууд эрхийг нь цуцлаад зөвшөөрлийг нь, тусгай зөвшөөрлийг цуцлах эрх байдаггүй. Энэ нь яамандаа байдаг.

Тэгэхээр яамандаа энэ хяналт очсоноороо хариуцлага туйлын тодорхой болно. Бодлого хэрэгжилтээрээ дамжаад хариуцлага эзэнтэй болно. Өнөөдөр яг тухайн байгууллагаар хяналтаар илэрсэн зөрчлүүдийг бид нар 100 хувь арга хэмжээ авч зогсоож, мэргэжлийн хяналтын байгууллагад хүч хүрдэггүй, хуулиараа боломжгүй байдаг байхгүй юу. Тэгэхээр яг салбартаа шилжсэнээр хамгийн том давуу тал нь хариуцлага тодорхой болно. Тэгээд иргэн, аж ахуй нэгжүүд болон бизнес эрхлэгчдэд маань оновчтой, ээлтэй болно гэж хараад байгаа.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа асуулт асууна.

С.Одонтуяа: Тэгэхээр хүүхдийн мөнгөө 100 хувь өгөхөө больж байгаа юм байна. Тэгэхээр энэ 9 хувийг хэмнэснээр ер нь яг хэдийг хэмнэх гээд байгаа юм бол? Ер нь энэ хүүхдийн мөнгө өгснөөс эдийн засаг ядуураад л, эдийн засаг муудаад байгаа юм байхгүй шүү дээ. Бид нар чинь баялгаасаа иргэддээ хүртээе гэсэн ийм л зорилгоор анх энэ мөнгө санаачлагдаж байсан. Ер нь Монгол Улс

чинь энэ авлигач, хулгайчдаасаа л болж ядуураад байгаа шүү дээ. Бидний байнга жишээ авдаг орнууд байна. Манай Улсын Их Хурлын гишүүд туршлага судална гээд л бид нар ичих ч үгүй хэчнээн олуулаа байнга явдаг. Норвеги байна, Австрали байна. Яаж энэ баялгаасаа иргэддээ түгээдэг юм бэ гээд л зөндөө судалдаг шүү дээ. Хүний хөгжлийн сан, энэ Ирээдүйн өв сан. Энэ зүйлд чинь л ерөөсөө хүүхдүүдэд мөнгө өгч байгаа. Ирээдүйн боловсролд нь өгдөг. Энэ бол халамжийн мөнгө бол биш байхгүй юу. Энэ чинь баялагтай орнууд баялгаасаа иргэддээ өгч байгаа бол мөнгөний хэлбэр.

Энэ хүүхдүүддээ мөнгө өгдөг, гэр бүлийг дэмждэг, энэ тэр бид нарын байнга жишээ авах дуртай газрууд чинь төрөөс нь тэрбумтнууд төрдөггүй л байхгүй юу. Төрөөс нь тэр олигархууд нь төрдөггүй юм. Аль болохоор байгаа бүх юмаа л хүүхдэдээ, гэр бүлд өгөхийг л хичээдэг ийм л бодлоготой улс орнууд.

Нүүрсний хулгайчдын орлого хэдэн зуун тэрбумд хүрсэн гээд л ичих ч үгүй чуулган дээрээ та нар хоорондоо ил хэрэлдэж л байдаг шүү дээ. Тэгэхээр энэ 9-хөн хувийг хэмнэснээр ер нь юу хэмнэх гээд байгаа юм? Та нар сонгуулиас санал авах гээд л тараасан хавтгайрсан халамжаас л энэ улс орон ер нь сүйрч байгаа шүү дээ. Хүүхдийн мөнгөнөөс болоод байгаа юм ер байхгүй. Энэ дагалдах хууль дээр энэ хуулиа засаж орж ирж байгаа нь нэг талаасаа бол нөгөө Үндсэн хууль зөрчихгүй болж байгаа юм байна.

Нөгөө талаасаа бид нарын нөгөө Монгол Улсын баялгаасаа хүртэх энэ концепц чинь л шууд нуран унаж байгаа, байхгүй болж байгаа байхгүй юу. Бид нар чинь баялгаасаа хүүхэд болгондоо өгье. Тэр байтугай бид нар тэтгэвэр авагч болгондоо баялгаасаа өгье гэсэн ийм тэтгэврийн шинэчлэлийн бодлого ярьдаг шүү дээ. Тэтгэвэр авагч болгонд нэг суурь мөнгө энэ баялгаасаа өгье гээд л

ярьдаг. Нөгөө Ирээдүйн өв сан, энэ бүх юм чинь байхгүй болж байгаа байхгүй юу. Бүгдийг нь цөлмөөд цөлмөөд дуусчхаж байгаа юм. Уул уурхайн бүтээгдэхүүн ийм өндөр үедээ л бид нар энэ сандаа мөнгө хадгалж, энэ сандаа байгаа мөнгөөрөө энэ үр хүүхдүүддээ л өгөх ёстой. Ер нь бол энэ хүүхдийн мөнгө, шалгуурууд нь их зөв гарсан юм л даа. Энэ бол 3 шалгуур байсан.

Нэгдүгээрт, хүүхэд завсардахгүй байх ёстой.

Хоёрт, тэр товллын вакцинаа хийлгэсэн байх ёстой.

Гуравт, гэртээ хүмүүждэг байх ёстой гээд. Энэ шалгуур гарснаас хойш ерөөсөө хүүхдүүд сургууль завсардах нь багассан. Гэртээ хүмүүждэг болсон. Тэр хүүхдийн мөнгөө авах гээд гэртээ хүүхдүүд хүмүүжиж байна. Вакциндаа хамрагддаг болсон гээд маш сайн талууд байгаа шүү дээ.

Тийм учраас энэ асуудлууд чинь дахиад л байхгүй болох нь. Тэгэхээр би бол энэ дээр нэг тодорхой санал хэлмээр байна л даа. Бид нар олон хүүхэдтэй гэр бүлийг дэмжье гээд л байнга л ярьдаг. Яг яаж дэмжих гээд байгаа юм бэ гэхээр байхгүй учраас бид нар Гэр бүлийн хуулийг дандаа буцаадаг шүү дээ. Тэгэхээр 1 хүүхэдтэй хүнд тэгвэл тэр 20 мянгыг нь өгье. 2 хүүхэдтэй айлд тэрийг нь 2-оор үржүүлээд, 1 хүүхэд нь 40 мянга аваг. 3 хүүхэдтэй айлд энэ 1 хүүхэд оногдох мөнгө нь 60 мянга, ингээд 180 мянга ингээд авъя. 4 хүүхэдтэй хүн 4-өөр үржүүлээд ингээд гэр бүлийг дэмжье л дээ.

Ер нь Монголын гэр бүлийг яаж дэмжихсэн юм? Энэ олон хүүхэдтэй ээжүүдийг ер нь яаж дэмжихсэн юм? Нэг одон л өгдөг шүү дээ. Тэгэхээр бусад орны туршлага байна. Одоо Унгар бол шууд 3 хүүхэдтэй айл 117 мянган евро өгч байна. Орос, Хятад гээд л манай хөрш орнууд ч гэсэн бүгдээрээ л тусалж

байна шүү дээ. Дэмжиж байна олон хүүхэдтэй айлуудад. Ер нь бид бол дэмжихгүй л байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бол бид нар ингэж шууд нь зүгээр халамж маягаар болгож бол болохгүй юм. Бүртгэлгүй мөнгө бол байгаа. Энэтэйгээ л ажиллах ёстой. Сая манай бас хэд хэдэн Их Хурлын гишүүд хэлж байна. Бүртгэлгүй мөнгө чинь өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувь болчихоод байгаа юм. За.../минут дуусав./

Т.Аюурсайхан: 80 микрофон дээр хариулъя.

Ж.Ганбат: Асуултад хариулъя. Хүүхдийн мөнгө 91 хувьд нь өгнө гээд ирэх жилийн 23 оны төсөв дээр 1 их наяд 394.6 тэрбум төгрөгийг бид 2023 оны төсөвт дээр бол тусгаж оруулж ирсэн байгаа. 100 хувь хүүхдийн мөнгө олгоно гэвэл 1 их наяд 532.5 тэрбум төгрөг болно. Тэгэх дээр энэ хоёрын зөрүүгээр 137.9 тэрбум төгрөгөөр бол өөрөөр хэлбэл хүүхдийн мөнгө буурч орж ирж байгаа. Ер нь бол бид ийм л бодлого барьж байгаа юм. 91 гээд бид нар 9 хувьд нь өгнө, өгөхгүй гээд ер нь орлогын тэгш хуваарилалт гэдэг нэг юм байна. Ерөнхийдөө бол би түрүүнд бас жишээ татаад хэлсэн 10 сая төгрөгийн цалинтай хүн, сая төгрөгийн цалинтай хүн адил төрлийн татвар төлөөд байна? Сая төгрөгийн цалинтай хүн ч хүүхдийн мөнгө адилхан аваад байна? 10 сая төгрөгийн цалинтай хүн ч адилхан аваад байна? Энэ ер нь орлогын тэгш хуваарилалтаа зөв үү гэдэг энэ өнцгөөсөө уул хараад л.

Ерөнхийдөө бол бид үнэхээр бололцоотой хүмүүс нь хүүхдийн мөнгөнөөсөө татгалзаач. Бололцоотой хүмүүс нь илүү татвар төлөх нь зөв юм гэдэг ийм байдлаар бол Засгийн газар дээр бодлого яригдаж, төсвийн төсөлдөө тусгаж энэ асуудлыг оруулж ирсэн байгаа. Ер нь бол орлогын тэгш хуваарилалт гэдэг юмыг бид анхаарахгүй бол сая төгрөгийн орлоготой хүн

адилхан, 10 сая төгрөгийн цалинтай ч хүн адилхан. Тэгэх дээр энэ дээр бас жоохон ялгавартай хандъя гэдэг ийм байдлаар бол бодлогыг оруулж ирсэн байгаа.

Далд эдийн засгийн хувьд бол янз бүрийн тоонууд бол байгаа. Албан болон албан бус байдлаарх. Статистикаас бид нар бол албан ёсны мэдээллийг Үндэсний статистикийн газрын мэдээлэл дээр л үндэслэж тооцдог. Статистикийн газрын тооцсоноор бол далд эдийн засаг бол 9.2-15.7 хувь байна гээд ингэж тооцсон. Далд эдийн засаг бид нар гол хаанаа байна гэхээр бидний харж байгаагаар уул уурхайн бүтээгдэхүүнүүдэд бол далд эдийн засаг байна. Үнэхээр бидний тооцож байгаа дэлхийн зах зээлийн үнээр бол юмаа гаргаж чадаж байна уу, үгүй юу, бас энэ дээр бид нар хангалттай татвараа авч чадаж байна уу гэдэг нь.

Хоёр дахь нь үл хөдлөх хөрөнгө дээр байгаа. Бид бол үл хөдлөх хөрөнгө дээр үнэлгээний асуудлууд байгаа. Тэгэх дээр бид далд эдийн засгийг бид нар тэмцэнэ гээд захиргаадгалтын аргаар байна уу? Энэ дээр бол бид хатуу арга хэмжээ аваад явахаасаа илүү бид нар бүртгэлээ сайжруулъя гэдэг арга хэмжээг ер нь сүүлийн нэлээд олон жил яриад энэ бүртгэлийнхээ хэмжээг л бид ил тод болгоно. Үнэлгээг нь бол адил болгоно. Энэ хүрээндээ л бид далд эдийн засгийг бууруулна гэдэг ийм байдлаар арга хэмжээнүүдийг аваад төсөв дээр бол бид нар өнгөрсөн жилээс эхлээд далд эдийн засгийг бууруулах зорилгоор бол 200 тэрбум төгрөг гээд энийгээ бол бид биелүүлээд, ер нь бол бид нар мэдээллийг цахимжуулах хүрээндээ л бид далд эдийн засгийг бууруулж, энэ хэмжээгээрээ бид нар орлогоо нэмэгдүүлнэ гэж ингэж тооцож тусгасан байгаа.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа асуултаа тодруулъя.

С.Одонтуяа: Би тэр орлогоос өндөр орлоготой хүмүүсээс татвар нэмэх, тансаг хэрэглээнээс татвар нэмж авдаг бол энийг бол би дэмжиж байгаа. Ерөөсөө улс орнуудад байдаг л юм. Энийг бол татварын бодлогоор хязгаарлах, багасгах, тэгшитгэх ч гэдэг юм уу, тодорхой хэмжээний ийм бол зүйлүүд бол байдаг юм. Энийг бол бид дэмжээд явж байгаа. Гагцхүү би нөгөө асуугаад байгаа юм нь бид нар байгалийн баялгаасаа, хүний хөгжлийн сангаас хүүхэд бүр тэгш хүртээдэг больё, тэтгэврийнхэнд тэгш хүртээдэг больё гээд нэг ийм тэтгэврийн шинэчлэлийн бодлого яриад байгаа шүү дээ. Ийм юм ер нь танай Сангийн яаман дээр ер нь яригддаг юм уу? Цаашдаа бид нар энэ байгалийн баялгаасаа ард иргэддээ ингэж хүртээж явах юм уу, эсвэл бүр больчихож байгаа юм уу? Бид нар тэтгэврийн шинэчлэл дээр зөндөө л ярьдаг шүү дээ. Үгүй, тэтгэврийнхэндээ ядаж ийм тэгшитгэсэн юу өгье. 2 дахь үе энэ хүмүүс тэтгэврээ авна, 3 дахь нь юу гэдэг юм, сайн дурын ч гэдэг юм уу?

Т.Аюурсайхан: Ганбат дарга нэмээд хариулчихъя.

Ж.Ганбат: Нэмэлт тайлбар хэлье. Байгалийн баялгаасаа хуваарилалт гээд. Ер нь бол ийм түүх нь бол ийм шүү дээ. Хүүхдийн мөнгийг эхэлж Монгол Улс өгдөг болохдоо яг ийм зорилгоор өгсөн шүү дээ. Ер нь бол ингээд үнийн есөлтөөс бий болсон байгалийн баялгаасаа үр хүүхдэдээ өгье гээд. Бүр яг тухайн үед бол шийдэхдээ уул уурхайгаас орж ирж байгаа орлогоосоо өндөр үед нь өгөөд, буурсан үед нь энэ бол зогсоно. Ингэж эхлээд явж байгаад сүүлдээ энэ бол байнгын болчихсон. Ингээд ерөнхийдөө бол сүүлдээ бол энэ чинь Монгол Улсыг хөгжүүлэх сангаас ингээд сангууд руу явж байгаад, тэгээд сүүлдээ энэ бол байнгын шинэ нэр дагуулж ирээд л улсын төсөв рүү орж ирсэн. Бид бол энэ оны хувьд энийг бол бид нар байгалийн баялаг гэдэг шинж чанартай эхнээсээ гарсан учраас энийг

бид нар бас хуримтлал үүсгэх нь зөв юм гэдэг байдлаар энэ оны, 22 оны төсөв дээр бид нар Ирээдүйн өв сантай үед хуримтлал руу нь явуулах гэж үзсэн. Гэхдээ үнэхээр хэрэгжилт дээрээ энэ мөнгө бол хуримтлал үүсгэдэггүй юм байна.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд асуулт асууна.

Т.Доржханд: Баярлалаа. За байз манай Монгол чинь яг Шри-Ланкын араас орчихлоо шүү. Тэгээд Венесуэл чинь их ойрхон болчихлоо доо. Тэгээд манай Их Хурлын гишүүд нэг л ойлгохгүй байна даа. Тэгээд Сангийн яам, Төв банкныхан макро эдийн засгийнхаа юмыг тодорхойнхон шиг тэр зоригтой хамгаалаад яв л даа. Тухайлбал энэ халамж чинь урсгал зардлын 2 төрөг тутмын 1 болчихлоо гээд. Наад хүүхдийн мөнгө чинь бол анх байгалийн баялаг гэж орж ирээгүй шүү дээ. 2003 онд нөхцөлтэйгөөр орж ирсэн шүү дээ энэ чинь. Хүүхдүүдээ сургуульд хамруулахын тулд, нэг. Вакцинд хамруулахын тулд 2 нөхцөлтэйгөөр оруулж ирээд 3000 гэж аваад сүүлдээ сонгууль болгоноор хүүхдэдээ хайр зарладаг, санал авах л хэрэгсэл болоод л явсан шүү дээ. Популист амлалтаар. Тэгээд нэг барууны үзэлтэй Ардчилсан намынхан маань бас одоо энэ дээр яг нийгмийн халамжийн асуудал дээр жаахан яг үзэл санаагаараа баймаар байна, нэг. Одоо ингээд тодорхой яг бодлогоороо ялгарахгүй бол болохгүй.

Хоёрдугаарт, энэ цаашаагаа явсаар байгаад яг хамгийн эцэст Ганбат даргаа ноднин жил та нар бол тэр Ирээдүйн өв сандаа гар дүрээд, Монгол Улсын ирээдүйд зориулах хуримтлал руу гар дүрээд, тэр эх үүсвэрийг нь болохоор хүүхдээ мөнгөндөө зарцуулна гээд л ингээд л байгалийн баялаг болж далийж яваад сүүлдээ байгалийн баялаг бол хуваарилалт, Үндсэн хуулийн асуудал болоод нөгөө халамж гэдэг агуулгаасаа

болиод явчихсан шүү дээ. Энэ чинь бол халамж шүү дээ. Халамж байхгүй юу. Эдийн засгийн онолын бүх textbook дээр энэ халамж байдаг. Бүх төрийн бодлого, бүх улсуудын төрийн бодлого дээр нь халамж гээд явдаг. Тэгээд тэрийгээ болохоор хүн амаа өсгөх гоё бодлого, хөрөнгө оруулалтын бодлого, байгалийн хуваарилга гоё гоё нэр өгөөд л яваад байдгаа болих хэрэгтэй. Мэргэжлийн эдийн засагчид нь мэргэжлийн байх хэрэгтэй, хамгаалаад гардаг байх хэрэгтэй. Нэг.

Хоёрдугаарт, 10 сая байна уу, 20 сая байна уу, 100 саяын орлоготой хүмүүс нь мөн адилхан нэг 500 мянган төгрөгийн цалинтай, 1 сая төгрөгийн цалинтай адилхан ингээд л хүүхдүүдийн мөнгө аваад яваад байдаг нь буруу шүү дээ. Дэлхий дээр байгалийн баялагтай 200 улсын 40 нь байдаг юм. Тэгээд эд нар чинь бүгдээрээ ялгаатай байдаг юм. Ялгаатай байж байж нийгмийн энэ орлогын тэгш бус байдлыг хангаж явдаг юм. Үгүй, тэгээд энэ дэлхийгээ хар л даа. Тэгээд ийм юман дээр чинь ингээд 2 талд болоод л. Нэг нь хамгаалсан болоод л, нөгөөдөх нь болохоор ингээд иргэдэд таалагдсан байдлаар явж болохгүй. Одоо энэ дээр бол хатуу байх хэрэгтэй. Яагаад гэвэл эдийн засаг чинь дефолт болох гээд байна шүү дээ. Энийгээ хэл л дээ. Төлбөрийн баланс дээр чинь доллар байхгүй. Бөөн төлбөр, бондуудын өр төлбөртэй байгаад байдаг. Тэгээд төсвөө ингээд халамжаа таная, төсвийнхөө зардлуудыг таная гээд орж ирчхээд л энд бас ингээд жаахан хүчтэй биш ш дээ тээ? Нэг дагуулсан байдлаар ингээд тайлбар өгөхөө боль. Одоо ингээд нэр төртэйгөөр яг л институцийн байдлаар явах хэрэгтэй.

Тэгээд Их Хурлын гишүүд ч гэсэн бас ойлгоод авахгүй бол дампуурлаа шүү дээ нийтээрээ. Дахиад дампуурах нь тодорхой болчихлоо шүү дээ. Дэлхийн дампуурал руу чинь 12 жилийн циклтэй байдаг бол Монголын дампуурал 4, 5 жилийн циклтэй болчихоод байгаа шүү дээ. Юундаа гэхлээр ийм их халамж, хайр

ард түмэндээ ингээд уянгалсан ийм хөгийн гоё гоё нэртэй хөтөлбөрүүдээс чинь болоод байна шүү дээ. 10 их наядын хөтөлбөр чинь худалдааг дэмжсээр байгаад үр дүнд нь 4.1 тэрбум долларын валютаа алдчихсан. Бодитой байдал нь энэ жирийн үеийнхээс 3 дахин их байхгүй юу. Одоо төлбөрийн баланс дээр чинь улаан гэрэл асаад байгаа. Маш хэцүү үе эхэлж байна шүү дээ. Тэгээд энийгээ сайн ойлгуул л даа. Тэгэхлээр 2 асуулт байна.

Нэгдүгээрт, энэ мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг ингээд татан буулгах гэж байгаа нь зөв. Бизнесүүдээ дэмжих биш бизнестээ давхар давхар дарамт өгөөд байгаа нь чухал. Тэгэхдээ яг үр дүнд нь энэ өөрчлөлтөөс чинь хувийн хэвшил яаж хожих юм бэ гэдэг дээр тодорхой хариулт өгмөөр байна.

Хоёрт нь энэ Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай хууль чинь бол зөв. Энэ бол бизнесүүдийг хянах гэхээсээ илүү төрийн байгууллагуудыг хянах. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улсад гээд тэгэхэд зарим гишүүд ч гэсэн цуг явж байсан. Мэдэж байгаа шүү дээ. Энэ нөгөө үр ашиггүй агентлагууд болон төрийн өмчийн компаниудыг татан буулгах тэр хяналтын функц хэрэгтэй байхгүй юу. Үр ашиггүй байгаа юм л шууд татан буулгадаг. Заавал Их Хурлаар оруулахгүйгээр ийм байдлаар ингээд төрийг жижиглэх боломж нь энд байгаа.

Т.Аюурсайхан: 93 дугаар микрофон. Баасандорж дарга хариулъя.

Б.Баасандорж: Доржханд гишүүний асуултад хариулъя, Баасандорж. Энэ мэргэжлийн хяналтын 20 жил болж байгаа тогтолцоог 2003 онд хийсэн шинэчлэлийн үргэлжлэл гэж харж байгаа. Тэгээд энэ шинэчлэлийн үргэлжлэл одоо буцааж салбарын 13 яаманд нь хяналтын чиг үүргийг Мэргэжлийн хяналтын ерөнхий гарзын хяналтын чиг үүргүүдийг 13 салбарт хуваагдаж очиж байгаа. Тэгэхээр мэдээж

энэ дээр бол яг хүрэх үр дүн нь бол хариуцлага бол туйлын тодорхой болно. Тухайн салбарт асуудал гарах юм бол тэр хариуцлага бол тодорхой болно. Иргэн, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид гол нь энэ хуулийн үзэл баримтлалын гол зорилго нь бол энэ дээр бол төрийн алба татан буугдаж байна уу, өөрчлөгдөж байна уу гэхээсээ илүү энэний үр шимийг нь бизнес эрхлэгч иргэн, аж ахуй нэгж хүртэх ёстой.

Тэгэхээр өөрөөр хэлбэл бизнес эрхлэгч аж ахуй нэгжүүд маань зөвшөөрлөө, дүгнэлтээ, мэдээлэл зэрэг төрийн үйлчилгээ авахдаа яг нэг дороос авдаг болно. Тэгэхээр хүнсний салбарынхан маань яг хүнсний салбараасаа л бүх тэр бодлоготой холбоотой, хэрэгжилттэй холбоотой, хяналттай холбоотой бүх асуудлаа үндэсний салбартаа хэрэгжүүлнэ гэсэн үг байгаа юм. Тэгээд бодлого, хэрэгжилт, хяналт 3 нэг дор очсоноороо бодлого сайжирч байна гэдэг маань өөрөө эргээд иргэн, аж ахуй нэгждээ энэ хүртээмж нь очиж байна гэж харж байгаа юм. Энэ сайн талаасаа.

Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай хуулийн талаар бас та асуулаа. Энэ хуулийн гол зорилго нь бол маш товчхондоо бол яг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага, гүйцэтгэх засаглал, тэр дотроо 16 яам, 37 агентлаг, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд компаниудад хяналт тавих юм. Дотогшоо чиглэсэн хяналтуудыг тавина. Яг төрийн байгууллагууддаа. Ямар чиглэлээр тавих вэ гэхээр Засгийн газрын шийдвэрээр, өөрсдийн санаачилгаар, мөн иргэдээс гаргасан өргөдөл, гомдол дээр албан тушаалтан болон тухайн төрийн байгууллагатай холбоотой асуудлаар чирэгдэл үүсгэсэн төрийн байгууллагуудын талаар хяналт шалгалтыг иргэдийн өргөдөл, гомдолд үндэслэж хийх юм.

Т.Аюурсайхан: Доржханд гишүүн асуултаа тодруулъя.

Т.Доржханд: Тэгэхлээр Баасандорж дарга тов тодорхой асууж байна. Тэр нь юу вэ гээд тэгэхлээр өнөөдөр төрийн өмчийн компаниуд гамшиг болчхоод байгааг бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Маш олон төрийн өмчийн компанитай, бүгдээрээ алдагдалтай, өр үйлдвэрлэдэг, тэгээд авлига хээл хахуулийн гол уул уурхай бол төрийн өмчийн компани. Тэгсэн мөртөө татан буулгадаггүй. Одоо тэгээд хууль оруулж ирээд хязгаарлана гэсэн ийм л байдалтай байгаа шүү дээ.

Тэгээд энэ чинь бол нийт эдийн засгийн чинь 20 хувь, GDP-д 20 хувь оролцоотой. Тэгэхдээ далд эдийн засагтаа эд нар чинь дахиад 20 хувь гээд нийтдээ 40 хувийн оролцоотой. Тэгсэн мөртөө үхэж өгдөггүй, сэхэж өгдөггүй паразитууд байдаг. Ялсан намын нөхдүүд очоод тэндээ ингээд шигдчихдэг. Тэгээд авлигал, хээл хахууль энгийн жишээ гэх юм бол Хөгжлийн банк, 2 их наяд, тэгээд л төмөр замын хулгай гээд л. Ингээд л бүх юмнууд чинь энэ дээр байгаа шүү дээ. Тэгээд энийг чинь ингээд үнэлэлт, дүгнэлт өгөөд хянаад татан буулгах, хариуцлага тооцох эрх нь яг энэ хуулиар олгогдсон уу?

Т.Аюурсайхан: Баасандорж дарга 93.

Б.Баасандорж: Яг энэ Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай хуулиар энэ хуулиар бий болж байгаа Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага шинээр бий болж байгаа. Яг энэ байгууллагын эрх, хэмжээ нь өөрөө яг таны хэлсэн, ярьсан асуудлаар тухайн орон нутгийн өмчит гэдэг юм уу, төрийн өмчийн компанид хяналт шалгалтыг бол шууд хийнэ. Хийгээд зөрчил гаргасан тохиолдолд яг эрх бүхий тэр татан буулгах шаардлагатай гэж хэргээ тэр ажлын хэсгийн магадгүй үзэх юм бол холбогдох

төрийн байгууллагуудад тийм саналыг хүргүүлнэ. Энэ саналтай харин дараа нь гүйцэтгэлийн хяналт юуг хийж байгаа юм. Яг өөрөө бол шууд шийдвэрээрээ энэ Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллага бол шууд татан буулгах шийдвэрийг бол гаргахгүй.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар асуулт асууна.

Н.Наранбаатар: Баярлалаа. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан Гүйцэтгэх засаглалын хяналтын хууль гэж оруулж ирээд, тэгээд агентлаг байгуулаад тэгээд л энэ агентлаг дээрээ Мэргэжлийн хяналтын чиг үүрэг, төрийн өмчийн болон энэ яамд, агентлагууд, аймгуудыгаа хяналт шинжилгээ, үнэлгээ, мониторинг хийдэг болох гэж байгаа юм байна. Хэрэг эрхлэх газрын хуулийн хүнээс асууя. Хуулийн хэлтсийн даргаас. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Улсын Их Хурлын хууль, Хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Үндсэн энэ бүх хуулиудад энэ хөгжлийн бодлого төлөвлөлтөд хяналт шинжилгээ, үнэлгээ хийдэг эрх нь Засгийн газарт байна гээд заачихсан. Тэгээд энэ Засгийн газар нь Улсын Их Хуралд танилцуулна гээд ингээд хуульчилчихсан.

Нэгдүгээрт, энэ чинь болж байгаа юу? Засгийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээ хийдэг бодлогын баримт бичгүүд болох хөгжлийн урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, хөгжлийн төлөвлөгөө, аймаг, нийслэлийн энэ олон төлөвлөгөөнүүдэд энэ агентлаг хяналт, шинжилгээ хийгээд ингээд энэ Улсын Их Хуралд танилцуулж болох юм уу? Энэ олон хуулиудаа яах юм, энэ олон хуулиудаа зөрчих юм уу? Нэг бол энэ олон хуулиудаа, том хуулиудаа дагуулж, дагалдах хууль болгож орж ирэх ёстой байсан юм уу? Ер нь энэ төсөв дагуулаад ингээд анхдагч,

бие даасан энэ хууль орж ирэх нь хуульд нийцэж байгаа юм уу, хууль зөрчиж байгаа юм уу? Энэ яагаад төсөв ер нь дагуулж ийм зүйл оруулж ирж байгаа юм? Үүнийгээ дараа нь төсвөө хэлэлцсэн дараагаар энэ гүйцэтгэх засаглалынхаа асуудал, хяналтынхаа асуудлыг тусад нь ярьж, хэлж болдоггүй юм уу? Олон түвшинд, олон газруудаас саналыг нь аваад ингээд нухацтай ярьж хэлж болдоггүй юм уу гэсэн нэг ийм асуудал байна.

Энэ Засгийн газрын энэ хяналт, шинжилгээ, мониторинг энэ яамд, аймгууд хийх энэ үнэлгээ, бодлогын шинжилгээ, үнэлгээг нэг агентлаг цуглуулаад хийгээд ингээд явах нь хууль зөрчихгүй юу гэсэн нэг ийм асуулт байна.

Дараа нь энэ шинэ хөрөнгө оруулалтыг орон нутагт бас хязгаарласан. Орон нутаг, улсын хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бол байхгүй. Орон нутгийг бас мөн дахиад ингээд давхар хаачихдаг нь ямар учиртай юм? Орон нутгийн бие даасан байдлыг хангах, орон нутгийг хөгжүүлэх, өөрөө өөрийгөө цааш нь авч явах, корпорацын хэлбэрт оруулах гээд олон сайхан зүйлүүд бид нар ярьж хууль, энэ тогтоомждоо тусгаад ингээд явж байгаа.

Тэгэхлээр эсрэгээрээ энэ оруулж ирж байгаа хууль чинь орон нутгийнхаа хөрөнгө оруулалт, өөрийнхөө бие дааж хөгжих энэ боломжийг нь хаасан, боомилсон ийм зүйл орж ирж байгаа нь хэр нийцтэй байгаа юм бэ? Орон нутгийг өөрийг нь өөрийнхөө орлогыг давуулах, орлогоо бүрдүүлэх давсан жаахан орлогоороо тэнд байгаль орчинд нөлөөлөөд байгаа сөрөг нөлөөлөл, цөлжилт энэ усны хомсдолын асуудал энэ хил боомт дээр үүсээд байгаа асуудал, тэнд дутагдалтай байгаа зам, дэд бүтэц, цахилгаан эрчим хүч энэ зүйлүүдээ орон нутаг чинь өөрөө хийж болохгүй юм уу? Бүгдийг нь ингээд хаагаад хаячихдаг нь ямар учиртай юм

бэ? Цаашдаа хөдөө орон нутгаа хөгжүүл, төвлөрлийг сааруулна гэсэн мөртөө нөгөө талаараа болохоор хөдөө орон нутгийнхаа хөгжлийг боомилоод ингээд нэн тулсан асуудлуудаа өөрөө шийддэг энэ байдлыг нь яагаад хаагаад хаячхаж байгаа юм?

Дараагийн 3 дахь асуудал. Төрийн үйлчилгээний албан тушаалтнуудыг байнга асуудал оруулж ирэх болгондоо, шийдвэр гаргах болгондоо хаях. Сумын Тамгын газар, орон нутгийн харьяалалтай нэг төрийн үйлчилгээний албан хаагчдаа энэ Төрийн албаны зөвлөлийнхөн ТЗ-гийн цалинг орон нутаг нь нэмэх энэ юундаа оруулаад хамтад нь.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Мягмар дарга хариулах уу? Ганбат дарга хариулчих юм уу? Хэрэг эрхлэх газрын Хуулийн хэлтсээс асуусан шүү дээ эхлээд. 92 дээр Ганбат дарга эхлээд хариул.

Б.Ганбат: Наранбатаар гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын Хэрэг эрлэх газрын Тэргүүн дэд дарга Ганбат. Энэ хяналт шинжилгээ, үнэлгээтэй холбоотой асуудлыг яг одоо байж байгаа энэ процедурын бүтэц зохион байгуулалттай холбогдолтой бас бага зэрэг өөрчлөлт бол орно. Энэ дээр ер нь бол хяналтын хэлбэрүүдийн нэг нь бол энэ хяналт шинжилгээ, үнэлгээний асуудал бол ялт ч үгүй мөн байгаа. Тэгэхээр ерөнхий чиг үүргийнхээ хувьд бол Засгийн газраас санал болгож оруулж ирж байгаа энэ шинэ агентлагийн эрхлэх чиг үүргийн нэг хэлбэр нь бол ялт ч үгүй энэ хяналт шинжилгээ, үнэлгээтэй холбоотой асуудал бол байна. Тийм нэг чиг үүрэгтэй бол байна.

Энэ дээр таны яг саяын асуудаг Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, дээр нь Засгийн газрын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн явцыг танилцуулдаг ийм 2 үндсэн чиг үүрэг бүх салбарын яамнууд дээр байгаа. Энэ бүх салбарын

яамнуудаас Засгийн газар луу Засгийн газрын хуралдаанд нэгтгэгдэж оруулж ирж, ингээд холбогдох дээд шатны байгууллагуудад хүргэгддэг энэ нэгтгэлийн асуудал бол чиг үүргийнхээ хувьд бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээрээ хэвээр хадгалагдаж байна.

Өөрөөр хэлбэл тогтоол, шийдвэрийн хэрэгжилттэй холбогдолтой биелэлт нь бол гаргадгаараа өнөөдөр гаргаад явж байгаа тэр процедур нь бол хэвээрээ байна. Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлыг бүх салбарын яамнуудаас нэгтгээд Засгийн газрын хуралдаанд танилцуулж, ингээд дээшийгээ хүргэгдэг энэ процессын үйл ажиллагаа бол хэвээрээ хийгдээд явна.

Үндсэн чиг үүрэг хэлбэрийнхээ хувьд бол Засгийн газрын шинээр байгуулагдах энэ орж ирж байгаа хяналтын чиг үүрэгтэй энэ агентлагийн үндсэн үйл ажиллагааны нэг хэлбэр нь бол тэр хяналт шинжилгээ, үнэлгээтэй холбогдолтой чиг үүрэг нь бол ялт ч үгүй тэр агентлагийнхаа чиг үүрэгт хамаараад явна. Бааска дарга нэмж хариулах уу?

Т.Аюурсайхан: 93 дугаар микрофон дээр нэмж хариулъя.

Б.Баасандорж: Наранбаатар гишүүний асуултад хариулъя, Баасандорж. Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай хуулиар бий болж байгаа Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх агентлагийн 14 чиг үүргийн 1 нь яг таны саяын хэлсэн хяналт шинжилгээ, үнэлгээ байгаа. Өнөөдөр Засгийн газар дээр хяналт, шинжилгээ, үнэлгээг бол Хэрэг эрхлэх газрын 10 хүний бүрэлдэхүүнтэй 1 газар хийж байгаа. Энэ шинэ агентлагт шилжсэнээрээ энэ тэр шинэ агентлагийн 14 чиг үүргийнхээ л нэг хэсэг.

Гэхдээ та сая Их Хуралтай харьцаж болж байгаа юм уу гэж асуулаа. Энэ агентлаг бол Их Хуралтай харьцахгүй. Их Хуралтай Засгийн газар л харьцана.

Угаасаа Засгийн газрын хууль, юугаараа. Засгийн газрын хуралдаанд нэгжийн нэг газарт хийдэг байсан асуудлыг бүтэн төрийн захиргааны байгууллага дүн шинжилгээ, хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээд Засгийн газрын хуралдаан дээр танилцуулж, Засгийн газар цаашаагаа Их Хуралдаа танилцуулаад явах юм гишүүнээ. Нэмээд хэлэхэд 14 чиг үүргийнх нь яг 1 л чиг үүрэг нь шүү гэдгийг хэлье. Хяналт шинжилгээ, үнэлгээ.

Т.Аюурсайхан: Сангийн яам уу? 82 дугаар микрофон дээр Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр цалингийн бодлогын хувьд бол Засгийн газраас дэвшүүлж байгаа бодлого бол хийсэн, гүйцэтгэсэн, бүтээмжээрээ цалингаа авдаг ийм бодлого руу бол бид нар шилжиж яваад орчхоод байгаа. Тэгэхлээр төрийн үйлчилгээний албан хаагчид буюу эрүүл мэнд, боловсрол, соёл, биеийн тамир дээр нь нэмээд төрийн шууд чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагыг дэмжих чиг үүрэгтэй төрийн үйлчилгээний албан хаагчдыг бол цалинг нь бид нар 2022 ондоо бол шатлалгүй болгоод, өөрөөр хэлбэл 5 шатлал байсныг нь 1 шатлал руу аваачаад ингээд шатлалыг шатлалгүй болгоод цалинг нь бол нэмчихсэн. Одоо бол эрүүл мэнд, боловсрол бол хийсэн ажилласан, бүтээснээрээ бол ингээд цалингаа нэмэгдүүлээд явах боломж бол хамгийн түрүүчид... Яг таны ярьж байгаа төрийн үйлчилгээний, одоо таны ярьсан орон нутагт ажиллаж байгаа тэр төрийн үйлчилгээний тэр дэмжих чиг үүргийн энэ албан тушаалтнуудын ТҮ-гийн 1 бол одоо жишээ нь цалингийн шатлал нь бол 523 мянган төгрөгөөс бол эхэлж байгаа.

Гэтэл төрийн захиргааны албан хаагчид бол сүүлийн 3 жил бол цалин

нэмэгдээгүй. ТЗ-гийн 1 бол 515 мянган төгрөгөөс эхэлж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл төрийн захиргааны албан хаагч маань бол өөрөө ТҮ-гийнхээ доор орчхоод байгаа. Тэгэхлээр бол бид нар ирэх жил гол фоксолж байгаа зүйл бол юу вэ гэхээр төрийн захиргаа болон төрийн тусгай дээр бол бид нар энэ асуудлуудыг явуулах, төрийн үйлчилгээг бол илүү бүтээмжээр нь бол бид нар цалин хөлсөө нэмэх боломжийг нь бол Төрийн албаны тухай хууль дээр бол цалингийн доод жишиг байхаар бол оруулснаар бол баталгаажуулчихсан байгаа. Энэ хүрээндээ бол цалин хөлсийг нь бол нэмэгдүүлээд явна гэсэн ийм бодлого баримтлаад бол явж байгаа.

Т.Аюурсайхан Наранбаатар гишүүнд микрофон өгье.

Н.Наранбаатар: Энэ асуултаа би уг нь Хэрэг эрхлэх газрын Хуулийн хэлтсийн даргаас асуусан юм. Тэгээд дэд дарга нь энэ Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээ, мониторинг энэ нь бол байх юм гээд Мэргэжлийн хяналтын дарга нь агентлаг дээрээ байх юм гээд л 2 өөр юм ярих юм. Хуулийн хэлтсийн даргаас би тодорхой асуусан шүү дээ. Энэ төсөв дагуулаад ингээд анхдагч хууль ороод ирж болж байгаа юм уу? Энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль, Их Хурлын тухай хуулиар чинь энэ Засгийн газар гээд явж байгаа агентлаг гэсэн юм байхгүй шүү дээ. Тэгээд энэ чинь тэр хуультайгаа таарч байгаа юм уу гээд ингээд асуусан. Тэрэнд тодорхой хариулмаар байх юм. ТҮ-г ч гэсэн боловсрол энэ тэрийг бол би огт яриагүй. Тэр Төрийн албаны хуульд энэ дагаж орж ирж байгаа хуульд ТҮ-г яагаад оруулахгүй хаячихсан юм бэ л гэж байгаа шүү дээ. Орон нутаг нь мэдээд 80 хувийг нь нэмэх эрхийг нь өгчхөөч л гээд байгаа байхгүй юу. Энэ дээр болох юм уу, үгүй юу гэдгийг бас хэлээд өгчихмөөр байх юм.

Т.Аюурсайхан: Алив Мягмар дарга хариулъя. 96 дугаар микрофон. 1 дүгээр индэр дээр.

Н.Мягмар: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ шинээр орж ирж байгаа Гүйцэтгэх эрх мэдэл дэх хяналтын тухай хууль бол төсөв дагаж ингэж орж ирж байгаа. Хууль тогтоомжийн тухай хуулиар бол төсвийн хуулийг бол Сангийн сайд болон Хууль зүйн бодлогын хувьд Хууль зүй, дотоод хэргийн сайд бол үзэл баримтлалын баталж ингэж орж ирж байгаа ийм хууль байж байгаа. Тэгэхлээр Засгийн газрын хуулийн бодлогын зөвлөх, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд энэ төсөв дагалдуулсан хууль дээр бол өргөн мэдүүлэх зөвшөөрлийг өгсөн учраас ингэж орж ирж байгаа. Юуны хувьд бол. Хяналт шинжилгээний чиг үүрэгтэй холбоотой зохицуулалтыг бол сая Баасандорж дарга болон Тэргүүн дэд дарга маань бол тодорхой хариулчихсан учраас энэ дээр бол нэмэлт тайлбар байхгүй байна.

Т.Аюурсайхан: Түрүүн хариулчихсан биз дээ? Үгүй үгүй тийм юу байхгүй шүү дээ. Дэг байхгүй. Та дахиад тодруулж болно шүү дээ. Наранбаатар гишүүнд 1 минут өгье.

Н.Наранбаатар: Тэр төрийн үйлчилгээний ажилчид гээд цөөхөн орон нутагт байгаа Тамгын газрын харуул, жижүүр, үйлчлэгч нар л байгаа шүү дээ. Тэрийг нь цалинг нь нэмэгдүүлэх боломжийг нь тэр аймагт л өгчихмөөр байгаа юм. Тэгээд ТЗ-г нь оруулчихаад төрийн үйлчилгээний нь хаячих юм. Төрийн үйлчилгээ хангалттай цалин авдаг болчихсон гээд хэлчих шиг боллоо. 500 мянган төгрөгөөс хэтрэхгүй. Тэр бол хангалттай биш. Өнөөдрийн энэ үнийн өсөлт нь тэр чинь юу ч биш болчихоод байна. Тийм учраас энэ яагаад оруулахгүй байгаа юм гэж би асуусан. Оруулчих боломж байгаа юм уу гэж асуусан. Орон нутгийн хөрөнгө оруулалтыг яагаад хязгаарлаад байгаа

юм? Энийг нь наад дагалдсан хуульдаа зарчмын зөрүүтэй санал оруулахад цаашаагаа явчих, нээгээд өгчих боломж байгаа юу? Юу нь гай болоод буруудчих гээд байгаа юм гэсэн тов тодорхой асуулт байгаа шүү дээ.

Т.Аюурсайхан: 82 дээр гүйцээж хариулъя.

М.Санжаадорж: Гишүүний асуултад тодруулж хариулъя. Уучлаарай түрүүн буруу асуултыг жаахан дутуу хариулчихлаа. Төрийн үйлчилгээний албан хаагчийн хувьд бол бид нар, төрийн албан хаагчийн цалинг, үйлчилгээний албан хаагчийн цалинш тухайн Засгийн газрын тогтоож байгаа нь бол цалингийн доод хэмжээ байна гээд хуульд өөрчлөлт оруулаад заачихсан юм. Тэгэхлээр өөрөөр хэлбэл аймаг орон нутаг бол тухайн хэмжээнээс нь дээш нь тогтоож өгөх, тэр тухайн хүний бүтээмжээс нь шалтгаалаад нэмэгдэж өгөх боломжийг нь бол бид нар 22 оны төсвийн жилээс эхлээд олгоод өгчихсөн байгаа. Тэгээд энэ хүрээндээ бол төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг бол нэмэгдүүлж тооцох боломжтой гэж үзсэн байгаа. Яг суурь зардал хянахын хувьд бол төрийн үйлчилгээний албан хаагчдын хувьд суурь зардал бол 20 хувийг хянаагүй байгаа. Орон нутгийн нэмэгдэл гэдэг ойлголтыг бол зөвхөн төрийн захиргааны албан хаагч дээр бол эхний ээлжид бол ингэж 20 хувиар оруулж ирсэн байгаа. Төрийн үйлчилгээ дээр хэрвээ 20 хувиар суурь.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг асуулт асууна. Нэрээ татаж байгаа юм байна. Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайхан асуулт асууна.

Б.Баярсайхан: Эрүүл мэндийн яамнаас асуулт байна. Өнөөдөр Монголд ходоодны хорт хавдар, элэгний хорт хавдраар дэлхийд тэргүүлж байгаа. 10 хүн тутмын 8-ыг нь бид нар энэ цаг бус

халдварт бус өвчлөл, осол эндэгдлээр нас барахаас хамгаалж чадна гэж байгаа. Үүний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 20-24 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Монголын нийт ард иргэдийг эрүүл мэндийн боловсрол олгож, зохистой хоол хөдөлгөөнөөр хорт хавдар, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлнэ гээд ингээд тодорхой төсөвтэй ингээд явж байсан. Өнгөрсөн хаврын чуулганаар энэ гүйцэтгэлийн төсөв хэлэлцэж байх үед энэ ажлаа Эрүүл мэндийн яам 100 хувь гэж үнэлж орж ирсэн. Энэ жил энэ ажил хийгдэх үү? Манай Завхан аймагт бол энэ нийтийн эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр бол ямар нэгэн ажил хийгдээгүй байгаа.

Тэгэхээр энэ жилийн төсөв дээр энэ ажил яаж суугдсан юм бэ, төсөв нь байгаа юу гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёр дугаар асуудал. Энэ хүүхэд хөгжил, хамгааллын зардлыг 8 тэрбумаас яагаад ингээд 5.2 тэрбум болгоод буулгачихсан юм бэ? Энэ засагдаж ядаж хуучнаараа батлагдах боломжтой юу? Хүүхдийн хүчирхийлэл ихсээд байдаг. Бид нар хүүхэд хөгжил хамгааллын ажил нь Нэгдсэн Үндэстний Байгууллага Монгол Улсыг хангалтгүй байна гээд дүгнэчихсэн байгаад байдаг. Ингээд бид нар төсвөө хасаад байж болж байгаа юм уу гэсэн 2 дахь асуулт байна.

Гуравдугаар асуудал. Энэ боловсролын салбарын модон жорлонг орчин үеийн ус, ариун цэврийн байгууламжаар хангах ажлын хүрээнд Эрдэнэт үйлдвэрээс 100 тэрбум төгрөг төсөвлөгдөөд ингээд явж байгаа. Боловсролын салбарын мэдээллээс өнөөдөр энэ 100 хувь хийгдчихсэн байх ёстой ажил өнөөдөр 30 хувийн гүйцэтгэлтэй явж байгаа гэж байгаа. Энэ жилийн төсөвт энэ хөрөнгө оруулалттай холбоотойгоор энэ мөнгөнд та бүхэн маань гар хүрэхгүй биз дээ? Энэ жорлонгийн ажил бол энэ чигээрээ явна биз дээ гэсэн энэ 3 дахь асуудал асуулт байна.

Дараагийн асуулт энэ Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас асууж байна. Баруун аймгуудад өвөлжилтийн асуудал бол нэлээн хэцүү байгаа. Өвөлжилт, хаваржилт хүндрэх ийм асуудалтай байгаа. Манай Завхан аймаг гэхэд нийт 100 гаруй өрхийн бараг 60 мянга гаруй мал, Баянхонгор, Хөвсгөл, Архангай, Булган, Төв аймаг руу ингээд оторлож байгаа. Тэгэхээр 2016 онд Монгол Улсын Шадар сайдын тушаал гараад энэ бусад аймгуудад оторлож байгаа малчдыг малтай нь хамт ямар нэгэн байдлаар хөөхгүйгээр нутагтаа оторлох энэ боломжоор хангах тухай ийм тушаал гарч байсан юм байна лээ. Энэ жил энэ тушаал гарах уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ өвөлжилт, хаваржилтын хүндрэлтэй асуудлыг бид нар урьдчилж харж байгаа энэ тохиолдолд төсөвт энэ мөнгө хангалттай сууж чадсан уу гэдгийг бас асууж байна?

Сүүлийн асуудал. Энэ соёлын салбараас асуумаар байна. Өнгөрсөн хаврын чуулганаар төсвийн тодотголоор хөдөө орон нутаг, сумдад соёлын төвүүдэд шинээр баригдсан соёлын төвүүдэд тоног төхөөрөмжүүд нь хасагдчихсан байж байгаа. Манай Завхан аймагт гэхэд нийтдээ 180 сая төгрөг энэ соёлын салбарын тоног төхөөрөмжид суусан байсан. Энэ төсвийн тодотголоор хасагдсан. Энэ жил хийгдэх үү? Завхан аймаг дараа жил 100 жилийн ойтой, Ванганы нэрэмжит театр маань ашиглалтад орох ёстой байгаа. Энэ ажил бүрэн гүйцэтгэлтэй дуусах уу гэдэг энэ асуултуудад тодорхой хариулт авъя. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Дорж дарга. 82 дээр Сангийн яам хариулъя. Дараа нь Хүнс, хөдөө аж ахуйн.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр хүүхэд

хамгааллыг шууд хэрэгжүүлж байгаа боловсрол, эрүүл мэндийн байгууллагаас бусад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын хүрээнд бол “Өнөр бүл” хүүхдийн төв, Найрамдал олон улсын хүүхдийн зуслан, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, аймгуудад, бас энэ Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, тэгээд Нийслэлийн хүүхдийн төлөө газар, Хүүхдийн тусламжийн 108 үйлчилгээний төв, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгааллын байр, дээр нь дүүргүүдийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хэлтсүүд гээд нийтдээ 37 байгууллага бол хүүхэд хамгааллын чиг үүргийг бол шууд хэрэгжүүлж байгаа.

Эдгээр байгууллагуудын зардал бол 2022 оны хувьд бол 31.5 тэрбум төгрөг байгаа. Ирэх жил бол яг энэ хэмжээндээ байгаа. Энэ байгууллагуудад таны түрүүний хэлсэн тэр 8 тэрбум төгрөгийн хүүхэд хамгааллын зардал бол хуваагдаж суусан байгаа юм. Үүнээсээ бол яг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар буюу үндсэн агентлаг дээр бол 5 тэрбум төгрөг нь болж суусан байгаа. Бид бол хүүхэд хамгааллын зардлыг бол илүү юу гэдэг юм, тодорхой байлгах үүднээс өмнө нь бол бөөн дүнгээр тавьсан тохиолдолд бол концерт зохион байгуулах ч гэдэг юм уу, хурал зөвлөгөөн гэдэг дээр нэлээд их зардал гараад байсан. Тэгээд Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотойгоор илүү их зардлыг нь чиглүүлэх үүднээс болоод томилолтын зардал, тэр эм бэлдмэл, эмнэлгийн эрсдэлийн зардал, тээвэр шатахууны зардал, шуудан холбооны зардал гэдэг дээр бол бас зардлуудыг нь бол нэмэгдүүлж өгч ингэж хуваарилсан байгаа. Тийм. Тэгэхлээр 8 тэрбум төгрөгийн зардал бол хэвдээ бол байж байгаа гэсэн үг. Тийм.

Т.Аюурсайхан: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд нэмж хариулья.

Л.Энх-Амгалан: Баярсайхан гишүүний асуултад хариулья. Энэ манай Улсын Их Хурлын эмэгтэй гишүүдийн

санал, санаачилгаар өнгөрсөн жил энэ төсөвтэй уялдуулж, энэ Эрдэнэт улсын үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд бол 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдэж, энэ хүрээнд Монгол Улсад өнөөдөр байгаа 720 сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлон, 820 тийм. 820 нүхэн жорлонтой байгаа цэцэрлэг, сургууль, дотуур байруудыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох энэ ажил эхэлсэн. Эхэлсэн.

Гэхдээ нэг асуудал бол нөгөө мордохын хазгай гэдэг шиг эхний энэ өнгөрсөн 20 оны намар зарлагдсан энэ тендер нь анхнаасаа түлхүүр хүлээлгэж өгөх тухай гэрээ гэдэг ийм гэрээгээр зарлагдаад, тэгээд зураггүй зарлагдчихсан нийт 300 гаруй объектууд зарлагдаж эхлээд тэгээд тэн дээр нэлээн их олон хүндрэлүүд гарсан. Нэгэнт зураггүй эхэлчихсэн учраас газар дээр нь очоод үзэхэд бол яг хийж гүйцэтгэж байгаа компаниудын гүйцэтгэлтэй холбоотой алдаа дутагдлууд.

Хоёрдугаарт нь бол орон нутгаас анх өгсөн мэдээллүүд бас зөрсөн. Ойдоо манайх яг энэ байрыг ариун цэврийн байгууламжтай болгоно гэдэг дотуур байрных нь зай тиймээ, сургуулиудынх нь зай, цэцэрлэгүүдийн нь зайнууд гэх мэтчилэнгээр ингээд орон нутгаас анхан шатаар ирсэн мэдээллүүд нэлээн дутуу ирсэн мэдээллүүд дээр үндэслэгдэж, тендерүүд зарлагдсан учраас бол нэлээн их асуудлууд үүсээд энэ үйл ажиллагааг түр зогсоож байгаад, ерөнхийдөө, ер нь эхэлж зургийг нь хийж, энэ ажлуудыг эхлүүлэх ёстой юм байна гэдэг энэ ажлыг зохион байгуулаад 4 үе шаттай зохион байгуулахаар төлөвлөсөн байгаа.

Тэгээд ямар ч байсан өнөөдөр эхний ээлжид бол 320 орчим объектуудын зураг төслүүд сая барилгын төвөөр магадлан итгэмжлэх гээд бүх зураг төслүүд нь гаргасан. Хийгдсэн зургийнхаа дагуу өмнөх алдаа, дутагдлууд засагдаж байгаа.

Засагдаж байгаа. Тэгэхээр энэ жил бол энэ намрын хичээлийн жилд 170 гаруй сургууль, цэцэрлэг, дотуур байрууд бол ариун цэврийн байгууламж.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн. 27 дугаар микрофоныг өгөөрэй.

Т.Жамбалцэрэн: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр Засгийн газрын 77 дугаар тогтоол гарсан байгаа. Энэ хүрээнд өвөлжилт хүндэрч болзошгүй зуншлагын байдал, ургамлын ургалт, газрын гарц тааруу зэргээс шалтгаалан Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс зэрэг 11 аймаг өвөлжилт хүндрэх төлөвтэй байгаа. Аймгуудын удирдлагуудад Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар хүргэгдсэн. Шадар сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар тушаалын хамтарсан тушаалаар ажлын хэсэг орон нутагт Онцгой комиссоор ахлуулсан ажлын хэсэг орон нутагт ажиллаж байна,. Аймгийн удирдлагууд холбогдох чиглэлийг өгсөн байгаа. Аймаг орон нутаг хоорондоо гэрээ байгуулж, энэ отор нүүдлээр явж байгаа иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, сургуулийн хүүхэд, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах чиглэлийг өгсөн. Мөн улсын зэрэглэлтэй отрын бүс, аймаг, сумын зэрэглэлдээ отрын бүс нутгуудад отроор өвөлжих малчдын судалгаа, захиалгыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжуулаад захиалгыг авч байна. Отрын бүс нутгуудад гэрээ байгуулж, отор нүүдлийн ажлыг зохион байгуулна.

Өвс тэжээлийн бэлтгэл нөөцтэй холбоотой өнгөрсөн 21 оны зуншлагын байдал сайн байсан. Аймаг, орон нутгуудад өнгөрсөн жилийн аюулгүйн нөөцүүд үндсэндээ бүтэн байгаа. 22-23 оны өвөл, хаврын бэлтгэлийг, ажлыг хангах хүрээнд аймаг, сум бүрээр бэлтгэх

шаардлагатай өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх албан даалгаврыг өгсөн. Энэ хүрээнд өнөөдрийн байдлаар орон нутгууд бэлтгэвэл зохих өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлтийг 51 хувьтай хангасан байж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр байнгын ажлын хэсэг гараад хяналт тавиад ажиллаж байгаа.

Шаардлагатай тохиолдолд хөрш зэргэлдээ улсуудаас хүчитгэсэн тэжээлийг импортоор авах нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Бусад орон нутгуудад бол тариалангийн гол бүс нутгаас хүчтгэсэн.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Баярсайхан гишүүн тодруулъя.

Б.Баярсайхан: Уул нь төсөв хэлэлцэж байгаа үед энэ салбарын асуудал асуухаар ингээд бүр яамдаас нь ч хүн байхгүй, сайд нараас нь ч байхгүй юм. Засгийн газраас нэг зүйл асуумаар байна. Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ Завхан аймагт ажиллахдаа нэлээн том том бүтээн байгуулалтуудын ажлуудыг хийнэ гэдгээ амласан. Мэдээж энэ жилийн 23 оны төсөв дээр энэ ажлууд бол суухгүй. Гэхдээ Завхан аймгийн иргэд бол хүлээлттэй байгаа. Тэгээд энэ ажлууд 24 онд яг хийгдэнэ гэсэн төлөвлөлт байх болов уу гэдгийг Засгийн газар, Сангийн яамнаас асууя. Мөн Жамбалцэрэн даргын үгнээс нь тэр Шадар сайдын бичиг бол гарна гэж ойлголоо. Зөв үү тиймээ? Энэ асуудлыг тодруулж асууя.

Т.Аюурсайхан: Ганбат дарга 80 дугаар микрофон дээр хариулъя.

Ж.Ганбат: Бид энэ оны ирэх жилийн төсвийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ бид нар Улсын Их Хурлын тогтоолыг бол бас хамт өргөн мэдүүлсэн байгаа. Энэ тогтоол дээр ямар арга хэмжээг тусгасан бэ гэдэг дээр бид энэ тогтоол дээр ийм арга хэмжээнд Ерөнхий сайдын хөдөө орон нутагт ажиллах үеэр

сая Баярсайхан гишүүний ярьсан энэ арга хэмжээнүүдийн бэлтгэл ажлыг нь хангаад 2024 оны төсөвт тусгаж орж ир гэдэг байдлаар яг энэ жагсаалтын тусдаа Их Хурлын тогтоолоор хавсралт болгож оруулж ирсэн байгаа. Энэ дээр яг тэр Ерөнхий сайдыг хөдөө орон нутагт ажиллахдаа яригдсан асуудлуудыг тусгахаар жагсаалтын хэлбэрт оруулж байж, хэрэгжих эхлэх хугацааг нь 24 он гэж тавьсан байгаа.

Тэгэхлээр энэ тогтоолыг, энэ батлагдах юм бол бид яг 24 оны төсөвтөө энэ жагсаалтыг заавал тусгаж Улсын Их Хуралд төсвөө өргөн барина. 24 оны төсвийг.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар асуулт асууна.

С.Ганбаатар: Төсөв бол улс орон даяараа анхаарах ёстой хамгийн чухал асуудал. Баялаг бүтээгчдээс, ард иргэдээс татварын мөнгийг аваад тэр мөнгөөрөө бид бизнесийн таатай орчныг бий болгох, төрийн үйлчилгээгээ баталгаажуулах, төр, хувийн хэвшил хамтарч хувиараа хийж чадахгүй байгаа том бүтээн байгуулалтууд, дэд бүтцээ хийдэг ийм л 3 зорилготой.

Дээр нь иргэдийн аюулгүй байдлыг, эдийн засгийн аюулгүй байдлыг төр хангах ёстой. Үүрэг нь тэр. Үндсэн хуулиараа ч тийм байгаа. Тэгэхлээр инфляц 16.2 хувьд хүрчихлээ, нөлөөлөл нь хүнсэнд 40.1 хувьд нь хүнсэнд нөлөөлөөд байна. Энэ бага орлоготой, дунд орлоготой ард иргэд болон тэтгэврийнхэнд маш том нөлөө үзүүлж байна. Зарим одоо хүнсний бараа бүтээгдэхүүн 80, 90 хувь өсчихсөн байгаа шүү дээ. Тэгэхлээр 1 сая төгрөг та нарыг эрх барихаас өмнө бол 513 доллар байсан. Одоо 1 сая төгрөг 9 сарын байдлаар 290 доллар болчихсон. Засгийн газар, Монголбанк нийлээд хамтарч төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой доод түвшинд барина гэж

үүрэг байгаа. Энийгээ та нар хийж чадаагүй.

Тэгэхлээр хүмүүсийн цалин орлого тэтгэвэр дунджилбал 40-өөс дээш хувь та нарын буруугаас болж хулгайлагдчихлаа. Жишээ нь өөрсдийнх нь зөвшөөрөлгүйгээр алга болно гэдэг хулгайлагдсан. Энэ мөнгийг цалин нэм гэж би хэлсэнгүй шүү дээ. Энэ мөнгийг хэдийд өгөх вэ? Яаж өгөх вэ? Энэ дагасан хуулиуд дотор би юу ч олж харсангүй. Энд би нэг л тийм социалист юм яриад байна гэж шүүмжлэх байх. Зарим нь та нарын шүтээд байдаг Америкт Cost of Living Adjustment гэж хэлж байгаа шүү дээ. COLA гэж байгаа. Европ бол COLI гэж байгаа Cost of Living Index гэж байгаа. Индексжүүлж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй уялдуулж, ард иргэдийн цалин тэтгэвэр дээр та нарын буруугаас болж алдагдсан тэр мөнгийг нь яаж буцааж өгөх вэ? Хэзээ өгөх вэ? Хэдээр өгөх вэ? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Цалин боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээ дээр дунджаар 500 мянган төгрөг маш муу байгаа шүү дээ. Төрийн үйлчилгээ үндсэндээ бүр үндсэндээ төрд ажиллах хүн ч хэцүү болчихлоо. Сум, баг дээр бол бүр хүнд байгаа. Тэгэх дээр та нар энэ дотор би уншиж цаг үрээд яах вэ. Дандаа цалинг 80 хүртэл хувиар нэмэгдүүлэх, олгох эрх зүйн орчныг бий болгосон. Цалин 2 дахин нэмэгдэх боломжтой. Яг Оюу толгойн гэрээ шиг боломжтой, харж үзнэ, эргэж бодно. Энэ төсөл дээр нь байж байгаа юм. Хуудас 156. Орон нутагт ажилладаг төрийн албан хаагчдын цалинг 20-100 хүртэл хувиар нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэхээр төлөвлөж байна. Мөн сайхан хуурах юм. Цалин хэдээр нэмэгдэх юм, цалингийн сан хэдэн хувиар нэмэгдэх юм? Дээр нь нэмээд Хөдөлмөрийн хууль дотор, Хөдөлмөрийн хууль дотор салбарын хэлэлцээрээр цалинг тогтооно гэсэн байгаа шүү. Яг энэ шинэ хуулиар. Урьд нь бол төр шууд өөрөө тогтоодог байсан.

Салбарын хэлэлцээрүүдээ хийсэн үү? Хийгээгүй бол та нар Үндсэн хууль зөрчиж байна гэсэн үг.

Хоёрдугаарт, та нар энэ шинэ Хөдөлмөрийн хууль дээр орсон байгаа. Ижил хөдөлмөрт ижил хөлс. Урьд нь ийм байгаагүй өөр заалт байсан. Хувийн хэвшилд ажиллаж байгаа багш, эмч, улсын хэвшилд ажиллаж байгаа төрийн үйлчилгээнийхэн яг ижилхэн цалин авна гэж Хөдөлмөрийн хуульд заасан байгаа. Та нар энийг яаж зохицуулж байна. Дагалдах хууль дээр яаж орж ирсэн бэ? Тоо баримттай хувиар хэлнэ үү.

Дээр нь нэмээд тэр хүнснээс гадна шатах, тослох материал, бензин ард иргэдийн нуруун дээр том ачаа болдог. Энэ Уул уурхайн яам үеийн үедээ тэр фиксац гэж тэр Оросоос л бензин авдгаас цааш төрийн бодлогын хувьд энэ бензин, шатах, тослох.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам хариулах юм уу? Наранцогт дарга хариулья. 81.

С.Наранцогт: Инфляцтай холбоотой хэсэгт нь хариулт өгье. Ганбаатар гишүүний. Инфляцын асуудал бол бас үнэхээр Засгийн газрын хувьд тулгамдсан асуудал болоод энэ дээр нэлээн анхаарал тавьж ажиллаж байна. Дэлхий даяар бас инфляц ялгаагүй нь цар тахал, дайны улмаас бол. Энэ ганц манай улсын ч биш бас олон улсын асуудал болж байгаа. Засгийн газрын зүгээс бол нийлүүлэлтийн гаралтай инфляцыг тогтворжуулах, бууруулах чиглэлээр тодорхой ажил, ажлын хэсэг Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан. Бүх яамнууд оролцоод энэ дээр бол Засгийн газраас хийж болох бүх талын ажлыг бол хийж байгаа.

Гол асуудал бол бас энэ манай инфляцын 55, 6 хувь нь бол яг импортоос үүдэлтэй. Нэг ёсондоо гаднын бид нар энэ инфляцыг импортолж оруулж ирж байна гэсэн үг. Инфляц хамгийн

өндөртөө 16 хувьд хүрсэн. Одоо бол 9 сарын дүнгээр 13.8 хувьтай. Ирэх онд энэ төсөв дээр бид нар төсөв, мөнгөний бодлогоо нэлээн шахаж оруулж ирж байна. Тэгээд энэний үр дүнд бол 1 оронтой тоонд оруулна гэсэн ийм зорилт тавьсан энэ төсвийн макро эдийн засгийн бодлогын асуудал орж ирж байгаа. Инфляцтай холбоотой Засгийн газраас бол иймэрхүү тодорхой арга хэмжээнүүдийг салбар бүр дээр үнийн задаргаагаа гаргаад, яг өөрсдөөсөө хамаарч Засгийн газраас хийж болох ажлуудыг зохион байгуулж, тээвэр, зохион байгуулалт албаа бусад асуудлууд дээрээ бол тодорхой ажлуудыг зохион байгуулаад явж байна.

Т.Аюурсайхан: 82 дээр нэмж хариулья.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулья. Тэгэхээр манай төсөв бол 20.4 их наяд төгрөг байгаа. Үүнээс бол боловсрол, эрүүл мэнд, соёл, биеийн тамир гээд энэ гүйцэтгэлээрээ санхүүждэг, бүтээмжээрээ цалингаа авдаг энэ салбарынхнаас бусад төрийн албан хаагчдын цалин буюу ТЗ, ТТ-гийн цалин хөлс, туслах чиг үүргийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлс бол нийлээд бол 1.9 их наяд төгрөг байгаа. Бид бол хувийн хэвшлийнхэнтэй цалин хөлсийг бол ойролцоо түвшинд аваачихын төлөө бол явж байгаа. Жишээ нь орон нутгийн нэмэгдлийн гол зорилго бол ерөөсөө тэр байгаа. Жишээ нь Өмнөговь аймагт хувийн хэвшилд ажиллаж байгаа нягтлан хүн байлаа гэхэд бол төрийн албанд ажиллаж байгаа нягтлан хүн бол 500 мянга, нөгөө талдаа бол 1 сая 500 байлаа гэхэд бол үнэхээр таны хэлж байгаа үнэн. Төрд ажиллах хүн байхгүй болчихоод байгаа юм.

Ийм учраас бол бид нар орон нутгийн нэмэгдлийг нэмж өгөх, үүнийгээ бол орон нутгийн онцлогтой тааруулаад бас олгох эрхийг нь бол орон нутагт нь

нэмж олгочхоод байгаа юм. Тэгэхдээ нэг зүйлийг бол та бас ойлгоорой. Хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж байгаа, Жишээ нь багш байлаа гэхэд бол зөвхөн цалингаа аваад явж байгаа. Төрийн өмчит байгууллагад ажиллаж байгаа багш гэх юм бол орон нутгийн нэмэгдэл юу гэдэг юм, унаа түлшний нэмэгдэл ч гэдэг юм уу, тэтгэвэрт гарахад 36 сарын нэмэгдэл, энэ маань өөрөө бараг 40-өөд сая төгрөг авчихна гэх мэтээр маш өндөр тийм нэмэгдлүүд бас байж байгаа. Цалин хөлсийг нь бид нар яг ижилхэн болгоод тавьчих юм бол хувийн хэвшилд ажиллах тийм хүн олдохоо болино. Тийм учраас бид нар бас нөгөө талдаа бас хувийн хэвшлээ бол бодох хэрэгтэй. Тэгэхдээ мэдээж хэрэг өрсөлдөхүйц байх зүйл шаардлагатай гэдэг дээр бол санал нэг байна.

Дараачийн асуудал бол бид нар Үйлдвэрчний эвлэлтэй бол энэ талаар бол танилцуулгаа бол хийсэн байгаа. Төсөв өргөн барихаас өмнө бол цахимаар бол бүх аймгийн үйлдвэрчин орсон энэ хэлэлцүүлэг дээр орж бол танилцуулга хийсэн байгаа. Мөн маргааш бол Соёлын төв ордонд бол Үйлдвэрчний эвлэлийнхэн бол хэлэлцүүлэг хийнэ гэсэн тийм урилга бол ирүүлсэн байсан. Үүн дээр бол.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Ганбаатар сайд. Жамбалын Ганбаатар сайд шатахуунтай холбоотой асуултад хариулъя.

Ж.Ганбаатар: С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Шатахууны асуудал бол инфляцад бас тодорхой, маш нөлөө үзүүлдэг ийм бүтээгдэхүүн. Гэхдээ уул уурхайн сайдын хувьд бид харин түүхэн гэмээр ч юм уу, гэрээ байгуулж бол чадсан байгаа. Тэгээд 5 жилийн хугацаатай, дахиад 5 жил сунгах бололцоотой. 2023 оны 1 сарын 1-нээс эхлээд А92 болоод дизель түлш дээр Тогтвортой байдлын гэрээг Роснефть-тэй бол байгуулж чадсан. Энэний дэлгэрэнгүй зүйлийг хэлэхэд бол бид бол их айхтар зарлаж гүйхгүй байгаа л даа.

Сошиал дээр бас зарим зүйлүүд буруу зөрүү явж байгаа. Тэгээд А92-ын хувьд бол бид 815 доллароор тогтвортой байдлын гэрээ байгуулж чадаж байна. Дизель түлшний хувьд бол зах зээлийн үнээс Сингапурын биржийн үнээс гэж шууд ойлгож болно. 10 хувийн хөнгөлөлттэй гэрээг бол бас байгуулсан. Энэ бол өмнө нь бас байгуулагдаж байгаагүй гэрээ гэж ойлгож болно. Ханган нийлүүлэгч компаниудын хувьд бол энэ гэрээг үндэслээд үнээ тогтвортой барих ийм боломж бол гарч ирж байгаа.

Тэгэхээр энэ гэрээг бас манай ханган нийлүүлэгч компаниуд манай яамны дэд сайд очоод бас гэрээгээ хийж чадсан. Сошиал дээр явж байгаа мэдээнүүд бас нэг тийм мушгин гуйвуулсан ч юм уу, буруу юмнууд яриад байна лээ. Тэгээд манай яамны хувьд бол нэг их айхтар зарлаж явахгүй байгаа. Эрсдэл бол байна. Эрсдэлийн хувьд бол валютын ханшны эрсдэл үүсэх магадлалтай. Гэхдээ бид биднийг бас зохицуулах талаар Монголбанктай хамтран ажиллаж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүнд микрофон өгье.

С.Ганбаатар: Хөдөлмөрийн хуулиа л дагана шүү. Хөдөлмөрийн хуульд цалин, хөлсийг Засгийн газраас, төрөөс боловсрол, эрүүл мэнд байна уу, төрийн үйлчилгээ дээр шууд тогтдог байсан бол салбарын хэлэлцээрээр, тарифын гэрээгээр тогтоно гэж заасан байгаа шүү. Тэр нь дотроо харин гэрээ хэлэлцээр дотроо тэр тэтгэвэрт гарахад нь тэгнэ, ингэнэ гэдэг нарийн юмаа ярьж болно. Гэхдээ тийм юм байхгүй байна гэдэг хууль зөрчиж байна.

Хоёрдугаарт, би Засгийн газар та нарын, Оюун-Эрдэнийн Засгийн газар та нарын ноцтой, буруу алдаанаас болоод доллар хөөрөгдөөд, юмны үнэ ханш өсөөд, хүмүүсийн гарт, кармад байгаа мөнгө 40-өөс дээш хувиар

хулгайлагдчихаж байна. Энэ мөнгийг нөхөж олгох уу, эсвэл үгүй юу? Үгүй бол уучлаарай гэж хэлэх үү? Маш тодорхой би асууж байна. Энэ олон улсад байдаг жишиг шүү дээ. Би хариулт авъя.

Т.Аюурсайхан: Наранцогт дарга 81 дээр хариулчих.

С.Наранцогт: Ганбаатар гишүүний асуултад тодруулж хариулъя. Инфляцын асуудлыг бол би бас танд тодорхой хэмжээгээр бид нар энэ асуудлыг анхаарлын төвд, Засгийн газрын хувьд гол асуудлын нэг болгож авч үзэж ажиллаж байна гэдэг талаар ингээд тайлбар хийсэн. Гол нь бол энэ бас яг зөвхөн Засгийн газрын бодлогоос болж үүссэн зүйл биш, зөвхөн манай улсын хувьд бол их онцлог байгаа юм. Өргөн хэрэглээний барааны 56 хувь нь бол зөвхөн импортын, гаднын инфляцын үйлдлээс болж орж ирж байна. Нөгөө талд бол бас таны хэлж байгаа энэ ханшийн асуудал байгаа. Ханшийн хувьд бол энэ бас л ялгаагүй яг одоогийн цаг үеийн нөхцөл байдлаар манай өмнөд хөршөөс бол бид нарын экспорт бол 90 гаруй хувиар хамаарч байгаа юм. Тэгэхээр ТЭГ-КОВИД бодлогын үүднээс бол бид нар.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал асуулт асууна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр төсвийн хуулийг дагуулж өргөн баригдаж орж ирсэн хуулиудын төслийн талаар ярилцаж байна. Тэгээд би бол хамгийн түрүүн ийм л бодол бодоод байна л даа. Үнэхээрийн энэ улсын төсвөөсөө бараг давсан шахуу хөрөнгийг эрх захирч байгаа улсууд бол энэ төрийн өмчтэй компаниуд байгаад байгаа юм. Энэ чинь байдлыг тийм амар биш байлгаад байна. Тийм учраас энэ нөхдүүдийн эрх үүрэг, хөрөнгө зардал, санхүүгийн хариуцлагыг сайжруулах, энүүгээрээ дамжуулж валютынхаа нөөц ханш, тэгээд гадаад төлбөр тооцоо

гүйцэтгэх тэр тэмцлийнхээ нааштай байдал, эргээд тэр инфляцынхаа асуудлыг шийднэ гэвэл тэр асуудлуудаа оруулж ирэхгүй юм уу? Тэр компаниудынхаа харилцааг зөв зохицуулах хуулиуд чинь орж ирэхгүй юм уу? Нэг ийм асуудал байна.

Хоёр дахь асуудалд энэ хуулийг дагуулаад өргөн барьчихсан хуулиуд дотроос анхдагч хууль ч байна. Бүхэл бүтэн багц хууль нь өргөн баригдчихсан хуулиуд ч байгаад байгаа юм. Жишээ нь Газрын тухай хууль, Газар өмчлөлийн тухай хууль ороод ирж байгаа юм. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, хөдөө орон нутаг руу шилжин суурьшилтыг дэмжих бодлого байх шиг байна. Зөв гэж бодож байна. Гэхдээ энэний цаана олон юм байна лээ. Алсын аймгууд руу магадгүй энэ хууль гайгүй хэрэгжиж мэднэ. Төв аймаг дээр бол нэлээн хүндрэх юм байна лээ. Улаанбаатараас гарсан хүнд газар эзэмшүүлдэг, эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дуусахаар өмчлүүлдэг энэ үйл явц чинь яг энэ хотын түгжрэлийг бууруулахад нөлөөгөө өгөх юм уу? Энийг юу гэж үзэж байна вэ?

Хоёр дахь зүйл хүүхдийн мөнгийг бид халамж биш ирээдүйн хөгжлийг нь дэмжих хөрөнгө гэж үзээд Ирээдүйн өв сангаасаа өгвөл яасан юм бэ? Тийм учраас тэр өвс сангийн хууль дээр оруулах гээд байгаа өөрчлөлтөөр татаад авчих бололцоо байхгүй юм уу? Хуримтлалын нэгдсэн сангийнхаа хуулийг оруулж ирээд тэрнийхээ нэг бүрэлдэхүүн хэсэг нь энэ Ирээдүйн өв сангийн чинь асуудал яваад, тэгээд тэрний тэр менежмент, үржилтийнх нь ажлыг тэр хуулийнхаа зохицуулалтаар авч явна гээд зоривол яасан юм бэ? Нэг хэсэг нь хуримтлалтай болог л дээ. Энэ талаасаа бодвол яасан юм гэж.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлтүүд орсон байна лээ. Нийт Монгол ажилчдын 5-аас доошгүй хувь нь

орон нутгийн буюу сумын ажилчид байхаар заасан. Тэр энийг хангаагүй тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлж төлбөр авахаар хуульд тусжээ. Тэр төлбөрийг уг нь яг тухайн суманд нь үлдээчихмээр байна. Тэгвэл тэр сумын хөдөлмөр эрхлэлт, ажлын байр, нэмэгдэлтийн асуудалд нэлээн бодитой үр дүн болно. Үүнийг ингэж өөрчлөх, зохицуулах бололцоо байгаа юу гэж нэг ийм асуулт байна. Гүйцэтгэх засаглалын хяналтын тухай хууль ороод ирсэн юм байна лээ. Энэ анхдагч хууль. Энийг их бодмоор зүйл байгаад байгаа.

Ер нь энэ реформ хийж байгаа, чиг үүрэг, бүтцийн том өөрчлөлт хийж байгаа тохиолдолд тухайлсан нэг аймаг нэгж дээр түр журам, зохицуулалтаар туршиж үзээд оноо алдаагаа дэнслээд, тэгээд илүү сайжруулсан хувилбартай эрх зүйн зохицуулалтаа хийгээд үндэснийхээ хэмжээнд мөрдөөд ажилладаг байвал бидэнд онолт нь их зөв болох юм биш үү? Яг нарийндаа бол явж байсан практик одоо бүх байдлыг ингээд харьцуулаад дүгнэхээр ярих зүйлүүд их олон байгаа. Тэгэхдээ даанч цаг бага юм. Ярьж боломгүй байна гэж.

Тэгэхээр төсвийн хууль батлахтай холбогдуулаад авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоол байгаа юм. Тэр тогтоолын 1 дэх заалтаар тэр 24 оноос эхлэх төсөл, арга хэмжээний жагсаалт бичсэн байгаа юм. Яаж гарч ирээд байна нөхдүүдээ. Хоёр, гуравхан аймаг дээр юм хийнэ. Бусад дээр нь юм эхлүүлэхгүй гэсэн санаа байна лээ шүү дээ. Ингэмгүй байна шүү. 3 дахь заалт дээр нь тэр.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Сангийн яам хариулъя. Ганбат дарга.

Ж.Ганбат: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Бид энэ оны өмнө нь 2022 оны төсвийн хуулийг Улсын Их Хуралд өргөн барих яг өнгөрсөн жилийн яг өдийд бид төрийн өмчит компаниудын

шинэчлэлийн асуудлыг бол энэ төсвийн төсөлтэйгөө хамт бол ингэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж бол батлуулсан байгаа. Үүн дээр бол бид яг энэ төрийн өмчит компаниудын бүтцийн өөрчлөлт, төрийн өмчит компаниудын засаглалын хувьд бол сайжруулах, бүтцийн өөрчлөлт хийх гээд энэний дагуу энэ 2022 оны 6 сарын 29-ний өдрийн Засгийн газрын шийдвэрээр энэ төрийн өмчит компаниудын үр ашиг, засаглалын сайжруулах, шинэчлэлийг хийх гээд бүтцийн өөрчлөлтийн хувьд нэгтгэн нийлүүлэх, зохион байгуулах, удирдлагын хувьд үр дүнтэй ажиллах гэх мэтчилэн энэ заалтуудыг бол Засгийн газрын тогтоолоор хэрэгжүүлээд бол ажиллаж байгаа. Ер нь бол төрийн өмчит компаниудын яг энэ тэгээд энэ Засгийн газраас бол холбогдох салбарын яамнуудад нь үүрэг өгөөд, энэ арга хэмжээг бол уг нь төрийн өмчит компаниудын шинэчлэлийг энэ оны төсвөөс эхлээд хэрэгжүүлээд ингээд явж байгаа үе шаттайгаар.

Тийм учраас бид нар яг энэ төсвийн, ирэх оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр бол төрийн өмчит компаниудын талаар тусдаа арга хэмжээг бол оруулж ирээгүй. Их Хурлын түвшинд шийдвэрүүдээ гаргаад засагт үүрэг өгчихсөн учраас Засгийн газрын түвшинд бол энэ төрийн өмчит компаниудын шинэчлэлийн асуудлуудыг бол бид эрчимжүүлэх л асуудал дээр анхаараад, хэрэгжилт дээрээ анхаараад л явж байгаа гэдгийг хэлье. Газрын хувьд бол бид нар ер нь бол бид нар төвлөрлийг сааруулах Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьшилтай холбоотой хэд хэдэн багц арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа юм.

Хэрвээ энэ дээр бид нар санхүүгийн хувьд нь ипотекийн зээл энэ тэр гээд багц арга хэмжээнүүд байгаа юм. Яг өнөөдөр бол ингээд хөдөө орон нутагт Улаанбаатараас хүн очин суурьшихад бол газрын хувьд бол маргаантай асуудал байгаа учраас энэ дээр газрын хуулийн

энэ өөрчлөлтийг бол оруулж ирсэн байгаа. Газрыг бол 1 удаа 0.7 Га газрыг олгоно гэдэг ийм байдлаар. Тийм учраас энэ дээр бол бид бол ийм байгаад байгаа юм. Газрын хууль дээр Нийслэлийн гэр бүлийн хэрэгцээнд бол 0.7 Га газар өгнө. Тэгээд энэ асуудлыг бол байршлыг нь бол Засгийн газар тогтооно гэдгээр энэ ингээд оруулж өгсөн байгаа юм. Энэ бол гол зорилго нь бол бид юун дээрээ л хийчхэж байгаа юм. Төвлөрлийг сааруулахтай холбоотой л энэ газрыг оруулж ирж байгаа юм. Ирээдүйн өв сантай холбоотой хуримтлал үүсгэхээр бол төсөв батлагдсан. Яг хэрэгжилтийн явцдаа бол үнэхээр.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Тодруулах уу? 80 дээр. 1 минут нэмж өгье.

Ж.Ганбат: Асуултыг нь гүйцээж хариулъя. Ирээдүйн өв сан дээр бол сая ингээд хуримтлал үүсгэнэ гэсэн. Яг бодитоор хуримтлал бол үүсгээгүй учраас бид улсын төсөв рүү бол ингээд хүүхдийн мөнгөө татаж авч үзсэн. Ирээдүйн өв санг хуримтлал байдлаараа бол цаашдаа аваад явна. Тодорхой 2, 3 жилийн хугацаанд шилжилтийн юм авч хэрэгжүүлнэ гэж. Ашигт малтмалын хууль дээр бол бид яг таны хэлж байгаатай адилхан. Энэнээсээ хэтэрсэн юмыг нь бид нар тухайн суманд нь бий болохоор ингэж хуулийн өөрчлөлтийг нь бол тусгаж өгсөн байгаа.

Бид нар бүр энэ дээр бол бүр сумаас, Жишээ нь орон нутгаас бол ийм хүсэлт тавьсны үндсэн дээр энийг бид нар хийж байгаа шүү дээ. Жишээ нь орон нутгийн сумын Засаг дарга бол бид ийм байдлаар ганц бололцоотой хянах юманд бид тэр гадаад иргэдийн юм дээр ингэнэ. Хоёрт бид нар орон нутгийн ажлын байрыг түлхүү аваач гэдэг ийм байдлаар. Ер нь энэ ашигт малтмалтай холбоотой орон нутгийн харилцааг бол Сангийн яам бол нэлээн судалж үзсэн. Бусад орнуудын жишээг харахад тухайн орон нутгаасаа ажлын байрыг.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ асуулт асууна. Айн?

Ж.Бат-Эрдэнэ: Асуултаа асуучихъя. Дараа нь буцаад хариулна биз дээ. Ингэсэн ер нь Төсвийн тухай хууль боловсруулах, дагалдах хуулиудын тухай та бүхэн урьд өмнө танилцуулга хийсэн. Энэ өргөн барихаас өмнө. Үүндээ бол энэ хүнсний бүтээгдэхүүнийг боловсруулахтай холбоотой хүнсний Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн барьсан хүнсний хангамж, аюулгүй байдалтай холбоотойгоор энэ 2022 оны 6 сарын 17-нд баталсан 36 дугаар тогтоол байгаа шүү дээ. Энэний хүрээнд боловсруулах үйлдвэрийг 1 шатаар ахиулья гэсэн ийм санал орж ирсэн. Би тухайн үед бол санал гаргаж байсан. Та бүхэн санаж байгаа. Хэрвээ боловсруулах үйлдвэрийг 1 шатаар ахиулна гэж байгаа бол тодорхой дэмжлэг гаргах ёстой. Үүн дээр татварын хөнгөлөлтийг тоног төхөөрөмж болон тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт үзүүлэх эрхтэй гээд. Ингээд энэ татварын хөнгөлөх тухай хууль орж ирсэн байна.

Нэгдүгээрт бол Баярлалаа. Энийг ингээд оруулж ирсэнд.

Хоёрдугаарт, энэ яг тогтоолтойгоо холбоотой тогтоол бол ерөөсөө хүнсний үйлдвэрлэлийг дэмжье гэж байгаа шүү дээ. Хүнсний хангамжийг сайжруулья гэж байгаа юм. Дотооддоо 19 нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэе гэж байгаа байхгүй юу. Энд та бүхний оруулж ирсэн дээр болохоор хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн зориулалттай тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэсэн шинэ тоног төхөөрөмжийг 100 хувь хөнгөлнө гэж байгаа. Яг энэ үг, үсгээс чинь харах юм бол нөгөө боловсруулах үйлдвэр биш, бараг л аж үйлдвэр лүү орчхож байна наадах чинь.

Хоёрдугаарт, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн зориулалттай гээд. Наад зориулалт чинь л бол шал ондоо болж байна шүү дээ. Танилцуулга дээр бол яг энэ тогтоолоо дурдаад, хүнсний үйлдвэрлэлийн хангамжтай холбоотой асуудлууд, склад, агуулах, тэгээд үйлдвэрлэлтэй холбоотой тоног төхөөрөмжүүд гэсэн байна. Тэгээд энэ дээр нэг тайлбар хийж өгөөч. Та бүхэн энэ хуулийн төсөл боловсруулахдаа үг, үсгэн дээр алдчихсан уу? Эсвэл үнэхээр зөвхөн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдээ бид нар тоног төхөөрөмжийг нь хөнгөлөх гээд байгаа юм уу гэж.

Хоёрдугаарт, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа юм. Үүнд нэг ийм өгүүлбэр байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад, энэ ашигт малтмалаас орсон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тодотголын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдсэн хэсгээс Ирээдүйн өв санд хуваарилах хувь гэж байгаа юм. Үүнд 2023 онд бол 0, 24 онд 25, 25 онд 45, 26 онд 65 хувь гээд. Энэ нөгөө үндсэн чиглэлтэй чинь хэр давхцаж байгаа юм бэ? Бид дөнгөж өнөөдөр үндсэн чиглэлээ бас яриад явсан шүү дээ. 23 он, 24, 25 оных нэгдүгээрт.

Хоёрдугаарт энийгээ яг ингэж урьдчилаад тодорхойлох шаардлага байсан юм уу? Эдийн засаг бид нар 23 оноос инфляцын түвшинг бага 1 тоонд оруулна. 24 оноос 6 хувь дээр аваачна. Эдийн засгийн өсөлтийг 5 хувь л авчирна. Энэ коронагийн өмнөх улс орны нөхцөл байдал, эдийн засгийн нөхцөл байдал руу бид нар хэвийн байдал руу орно гэж ийм өөдрөг төлөвлөлтийг та бүхэн оруулж ирж байгаа юм. Хэрвээ тийм байгаа бол энэ эдийн засгийнхаа энэ Ирээдүйн өв сан руу оруулах энэ хувиар ингэж эрт тохирох ер нь шаардлага

байсан юм уу? Ямар учиртай энэ 25 он хүртэл ингэж 65 хүртэл хувиар бодно гэж ингэж орж байсан юм бэ? Энэ 2 асуултын хариултыг авъя. Баярлалаа.

Т.Аюурсайхан: 80 дугаар микрофон өгье.

Ж.Ганбат: Энэ ерөөсөө Ирээдүйн өв сангийн өөрчлөлт нь хүүхдийн мөнгөтэй л холбоотой. Бид 22 оны төсөв дээр Ирээдүйн өв сангаас хүүхдийн мөнгө олгоно гээд тусгагдчихсан байгаа. Бид түүнийгээ улсын төсөв рүү хүүхдийн мөнгөө буцаагаад оруулж ирж байгаа юм. Энэнтэй холбоотой бид нар дээр эх үүсвэрийн хувьд хүндрэлтэй юм шууд орж ирэхэд бид нар тодорхой шилжилтийн хугацаа шаардлагатай болсон. Тийм учраас бид нар Ирээдүйн өв санд орж байсан АМНАТ-ын 65 хувийг ирэх жил бол улсын төсөв рүү төвлөрүүлнэ. Тэгээд дараагийн ээлждээ буцаад 3 жилийн дараа бид нар Ирээдүйн өв санд нь буцааж 65 хувь төвлөрүүлэх юм.

Тэгэх дээр өөрөөр хэлэх юм бол бид нар хүүхдийн мөнгөө улсын төсөв рүү авч байгаатай холбоотой л эх үүсвэрийн хувьд бол түр зуурын, шилжилтийн байдлаар бол ингэж буцааж бол аваад, тэгээд тэрнээс цааш бол Ирээдүйн өв санг бол бид яг хуримтлал байдлаар нь ингээд дахиж бол ашиглахгүй цаашаа бол ингээд явна гэсэн ийм байдлаар оруулж ирсэн байгаа. Татварын юмыг нь.../минут дуусав./

Т.Аюурсайхан: 84 дүгээр микрофон дээр.

Б.Тэлмүүн: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Төсөвтэй хамт бол Гаалийн албан татвараас хөнгөлөх хуулийн төслийг бол оруулсан. Энэ хуулийн төсөл бол үндсэн агуулга бол Засгийн газраас дэвшүүлж байгаа энэ түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг 1 шатаар ахиулж, нэмүү өртөг

шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гэсэн энэ бодлогын хүрээнд бол яг хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэдэг шинэ тоног төхөөрөмжийг бол хөнгөлөлт үзүүлнэ гэсэн ийм агуулга бол орсон байгаа.

Үүнээс гадна байгаа хууль тогтоомжийн хүрээнд бол мөн татварын хөнгөлөлт дэмжлэгүүд бол байдаг. Энэ дээр Гаалийн тариф, Гаалийн албан татварын тухай хууль дээр бол хөдөө аж ахуй, хүнсний боловсруулах үйлдвэр барихтай холбоотойгоор бол гаалийн албан татвар төлөх хугацааг 2 жил хугацаагаар сунгах, хойшлуулах ийм хуулийн бололцоо байдаг.

Т.Аюурсайхан: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүнд микрофон өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ дээр чинь ингээд хүнс гээд таслал байгаа шүү. Тэгэхээр хүнсний үйлдвэрлэл, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж гэж би ойлголоо. Энэ дээр бас нэг тодруулж өгөөрэй. Зөв үү, үгүй юу? Хамгийн гол нь бид нарт өнөөдөр энэ тогтоол буюу хүнсний үйлдвэрийн хангамжтай холбоотой асуудал чинь чухал байгаад байна шүү дээ. Энэ хүнсний үйлдвэрийн хангамжийг сайжруулахын тулд үйлдвэрлэгчид бий болгох ёстой. Үндсэн хөрөнгө бий болгох ёстой.

Хоёрдугаарт, Засгийн газар тоног төхөөрөмжийн заалтыг оруулж ирнэ гэж байна. Одоо та бүхэн тэгээд нэг ийм бүдэг бадаг юм юу яачхаад батлуулчихаад, дараа нь тэгээд эргээд харахаар нөгөө яг үйлдвэрлэл рүүгээ хандчихсан тоног төхөөрөмж нь байж чадах уу, үгүй юу гэдэг асуудал гарч ирнэ шүү дээ. Дахиад л нэг шүүмжлэл бий болчихоод байдаг. Тэгэхээр энэ дээрээ яг яах юм? Ямархуу санал авч байгаад тусгах юм уу? Энийг нэг хариулаач.

Т.Аюурсайхан: 81 дээр хариулчихъя.

С.Наранцогт: Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмж тодруулж хариулья. Тэгэхээр таны ойлгосон хүнс, хөдөө аж боловсруулах үйлдвэр гээд тэгээд яг аль аль тоног төхөөрөмж вэ гэдэг чинь хэрэгжүүлэх дээрээ тэр гаалийн фаткусын кодоороо батлагдаад явдаг учраас яг таны хэлж байгаа агуулгаар энэ хүнс, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлд энэтэй холбоотой үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлнө л гэсэн энэ агуулгаар орж ирж байгаа юм.

Т.Аюурсайхан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байвал нэрээ өгье. Батжаргал гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар үг хэлнэ. Тэр Төсвийн тухай хууль дагуулж орж ирж байгаа 24 онд хийх жагсаалт дотор Ерөнхий сайд Өмнөговь аймагт энэ хавар очиж ажиллахдаа хэлсэн, амласан зүйлүүдийг дутуу тусгачихсан байх юм. Тэгээд энийг нэг мөсөн нэгэнтээ амлаад, хэлээд ингээд ард олны өмнө алга ташуулаад ингээд хэлчихсэн юмыг нь ингээд заримыг нь цавчаад хаячих юм. Энийг нь гүйцээгээд тусгачих ийм боломж байхгүй юм уу? Сайд нарын багцыг энэ Байнгын хорооны хурал дээр жаахан задалж сонсмоор байх юм.

Тухайлбал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд энэ төсөв дотор сайдын шууд гээд. Тэгээд 31 тэрбум гээд тавьсан. Тэгээд тодорхой нь энэ юунд байгаа юм гэдгийг нь үзэх гэхлээр байхгүй юм. Энэ өнөө Ерөнхийлөгчийн санаачилсан хүнсний хангамж гээд энэ чиглэлээр аймаг орон нутгууд юу хийх юм? Шинэ хөрөнгө оруулалтыг нь хасаад хаячихсан. Өөрөө шинэ хөрөнгө оруулалт өөрөө хийх гэхээр тэрийг нь дахиад болохгүй гээд хаачихсан. Тэгээд энэ хөдөө аж ахуй энэ хүнсний хангамжийн

чиглэлээрээ юу хийх нь мэдэгдэхгүй нэг ийм бүрхэг юм болчихоод байх юм.

Мөн тэр түрүүн би бас асуулт дээр асууж хэлсэн. Тэр сумын хэдхэн төрийн үйлчилгээний албан хаагчдыг энэ төрийн албаныхаа тухай хуулийн ТЗ-гийн тэр нэмэгдлийг нь орон нутгийн нэмэгдлийг иргэдийн хуралд нь эрхийг нь өгч байгаа бол ингээд ТҮ-г нь хаяад яах юм бэ? ТҮ-г нэг мөсөн оруулаад л ингээд л яв. Тэгээд чадалтай өгдөг орон нутаг нь өгөөд л ингээд л цаашдаа нэг, нэгээрээ нэмэгдээд л хөдөө, орон нутагт ажиллаж байгаа хүмүүсийн чинь бас нийгмийн асуудал нь орон нутаг нь өөрөө хариуцаад ингээд шийдэх боломж нь бүрдээд ингээд явчих юм биш үү. Тэгэхгүй бол энэ орон нутагт, хөдөө суманд ялангуяа ажиллах энэ төрийн үйлчилгээ, аймгийн төв ч ялгаа байхгүй хүн байхгүй болчихлоо шүү. 4, 5 зуун, мянган төгрөгөөр.

Мөн дараагийн санал энэ орон нутагт шинэ хөрөнгө оруулалт өөрөө орлогоо босгоод, давуулж олоод ингээд хийх боломжийг нь нээгээд өгчих ийм зүйлийг нээгээд өгчих юм хэрэгтэй байна. Тэр бас мэргэжлийн хяналттай холбоотой хяналтын агентлаг, байгууллагатай холбоотой зөндөө олон, хууль тогтоомж зөрччихсөн учраас энийгээ эргэж хармаар байна. Хуульдаа нийцүүлж энэ дагасан хуулиудаа бас оруулж ирмээр байна гэсэн ийм саналууд байна. Тэгээд аймаг, энэ яамнуудыг цахимжуулаад нэг ижил цахим программ, аппликэйшн энэ Тамгын газрууд нь нэгтгээд тэгээд энэ дээрээ нөгөө Засгийн газрынхаа хяналт шинжилгээ, нөгөө мөрийн хөтөлбөр, хөгжлийн бодлогынхоо баримт бичгийн хэрэгжилтийг нь нэг ижил, жигд форматаар авчихдаг ийм хөнгөн шуурхай цаг, зав, цаас зардал хэмнэсэн ийм ажлыг бол бас ирэх онд заавал хийх шаардлагатай байгаа. Өнөөдрийн байдлаар бол яам, аймгууд бол өөр өөр төрлийн программ өөр өөр компаниар аж ахуй нэгжээр хийлгээд ингээд явж

байгаа. Үүнийг цэгцлээд нэг юунд оруулчихвал зүгээр байгаа юм гэсэн ийм л саналууд байна.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Энэ дагалдаж байгаа хуулиуд дээр бас анхаарах юмнууд байна. Бид нар чинь хаврын чуулганаар Хэмнэлтийн хууль баталсан. Төсөв маань Хэмнэлтийн хуультайгаа зохицож байна уу гэхээр бас жоохон хэцүү. Ялангуяа яамнууд нэмэгдчихсэн. Дээрээс нь агентлагууд нэмэгдчихсэн. Тэгээд ер нь бол хэмнэлтийг гол харуулах төсвийн гол үзүүлэлт бол урсгал зардал байх ёстой. Гэтэл урсгал зардал 1 их наяд гаруйгаар ингээд нэмэгдчихсэн байх юм.

Би Наранбаатар гишүүнтэй санал нэг байна. Засгийн газрын үйл ажиллагааг хянах чинь Төрийн аудитын хуулиараа явж байгаа. Тусгайлсан хууль гаргаж, Засгийн газрын дотор ийм хяналтын чиг үүргийн байгууллага нь бол хуультай сайн нийцэхгүй байх гэж би ингэж бодож байгаа юм. Яагаад гэвэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мониторинг, дотоод аудит байхаар хуультай шүү дээ. Тэр хүрээндээ Засгийн газрынхаа агентлаг, яамдад дүн шинжилгээ хийгээд явах ёстой. Ганбат дарга хуульч хүн энийг бас зөвлөхгүй юу даа. Тэгээд энэ талаасаа энэ бол болохгүй байна гэж харж байгаа юм.

Мөн дагалдах хууль дээр тэр нэг тусдаа 20 хэдэн хөрөнгө оруулалтыг л сонгож аваад л энийг тогтоолоор хэрэгжүүл гэж заачихсан байгаа. Үгүй ямар нь хөрөнгө оруулалт хийж болдог, ямар нь хөрөнгө оруулалтаа хийж болдоггүй юм? Энийг тэр тогтоолоос хасах нь зүйтэй юм болов уу гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт, тэр миний яриад байгаа тэр Хөгжлийн банкны ирэх онд

төлөгдөх гадаад зээлийн төлбөрийг дахин санхүүжүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах асуудлыг бол ер нь энэ удаа болих хэрэгтэй. Эхлээд тэр зээл авсан нөхдүүдийнхээ асуудлыг шийдэж өгөх хэрэгтэй. Ингэчихвэл хэн ч төлөхгүй шүү дээ. Moral Hazard гэж байгаа юм. Тэр олон улсын хэллэгээр, сая эдийн засгийн хэллэгээр бол үүсэх байхгүй юу даа. Төлөхгүй байх сонирхол үүсэх байхгүй юу. Ингээд л болчих юм байна, төр баталгаа гаргаад төлчих юм байна, ямар нэг байдлаар булзааруулж болох юм байна гэж. Ийм л юм болох гээд байгаа учраас би тусад нь санал хураалгах юм уу, яах юм дагалдах хуулиудыг гэж танд хэлэх гээд байна л даа. Одоо багцаар нь ингээд л явчих юм уу? Энийг бол анхаараарай.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал үг хэлнэ.

Ж.Батжаргал: Гаргасан хуулиудыг мэдээж мэргэжлийнхээ Байнгын хороонууд дээр нэлээн сайн ярьцгаах байх. Бодоход би тэгж бодож байна. Тэгэхдээ бид Ирээдүйн өв сангийн тухай хуулийн ерөнхий үзэл баримтлал, зарчмаа бодмоор байгаа юм. Байгалийн баялгийнхаа нөөцийн төлбөрөөс тогтворжуулалтын сандаа тодорхой хувиар аваад үлдсэнээс нь 65 хувиар энэ Ирээдүйн өв санд авъя. Нөхцөл байдал хүндэрсэн үед энэ сангаасаа ашиглана гэсэн ийм л бодлогын чиглэл, үзэл баримтлал байгаа юм.

Тэгэхээр үүнийг бид яг энэ сангаас нь хүүхдүүддээ хуримтлал үүсгэх эрх зүйн зохицуулалтыг нь хийж өгөөд, тэгээд яваад тодорхой нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд тэр сангаас нь Засгийн газрын бонд гаргах хэлбэрээр татаад ашиглаад явах юм бол үзэл баримтлал нь ч зөрчигдөхгүй. Нэг хэсэг иргэд маань ирээдүйн баталгаатай, хуримтлалтай болоод явах бололцоо нь ч бүрдэнэ. Үүнийгээ ингэж хиймээр санагдаад байх юм. Төсөв рүүгээ татаж халамж хэлбэрээр гаргах гээд ингээд

байгаа чинь нэг тийм зохилтой биш байна. Магадгүй энэ хүнд цаг үед тодорхой амьдралын түвшин зааж байгаад энэ хэсгийг нь бол ёстой тэр бэлнээр нь олгоё. Энэ хэсгийг нь бол яг энэ хуримтлал хэлбэрээр нь, тэгэхдээ хий бичилт хийхгүйгээр мөнгөжүүлсэн, баталгаатай бүрдүүлэлт хийх замаар яваад сангийнх нь нөөцийг бий болгох нь зөв байх. Хуримтлалын нэгдэл нэгдсэн сантайгаа дахиад уялдах байх.

Тэгээд менежментээрээ өсөх байх. Тэгж байж энэ улс орны эдийн засгийг бас жоохон тэлэх, өсгөх тийм хөрөнгийн эх үүсвэрийн тодорхой боломж, нөхцөл бий болох болов уу гэж би энэ талаас нь хараад байх юм. Үүнийг та бүхэн нэг бодвол яасан юм бол гэж. Ер нь зүгээр би ганц энэ Хяналт, шалгалтын хууль дээр яриагүй. Ер нь үндэсний хэмжээнд том реформ, чиг үүргийн бүтцийн шинэчлэл хийх гээд байгаа бол тодорхой нэгжүүд дээр түр журам, зохицуулалтаар туршиж үзээд, оноо алдаагаа хараад, тэгээд илүү боловсронгуй Монголын амьдрал ахуй, хөрсөнд нийцсэн эрх зүйн зохицуулалтаа хийгээд үндэсний хэмжээндээ реформаа аваад явах юм бол энэ улсын ирээдүй баталгаатай болно шүү.

Таарах, таарахгүйг нь мэдэхгүй том том асуудлуудыг гэнэт оруулж ирээд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх гээд байдаг явдал бол оновол их сайн онох байх, алдвал их л том алдана. Тоглоом байхгүй. Тийм учраас үүнийг ер нь бид энэ төрийн ажлынхаа юманд бодох ёстой. Соци-ийн үед бас энэ системийг тодорхой түвшинд явсан юм байна лээ. Дан дамаа тэр аж ахуй, зохион байгуулалтын түвшин хэтэрвэл энийг туршаад, үзээд, тэгээд болохоор нь бусад аж ахуй, зохион байгуулалтынхаа нэгжүүд рүү нэгдсэн бодлогоор хэрэгжүүлээд явж байсан. Энэ бол яах аргагүй бас нэг тийм зөв арга, механизм байсан юм билээ. Энийг ер нь төр ой санамждаа авч, зөв зохицуулж авч явах талаас нь бодох ёстой болов уу гэж ингэж бодож байна.

Төсөв дагуулж авч хэрэгжүүлэх гэж байгаа арга хэмжээний тогтоолын нэгдүгээр хавсралтыг болих ёстой. Засгийн газар өөрийнхөө ой санамжид авч, бэлтгэл зохион байгуулалтаа ханга. Их Хурлаас гарах гэж байгаа шийдвэр дотор хоёр, гуравхан аймаг дээр 24 онд хөрөнгө оруулалт хийнэ гэж хавсралт баталж таарахгүй. Тийм учраас тэр хийнэ гэж бодож байгаа зүйлүүдээ Засгийн газар өөрийнхөө ой санамжид авч, бэлтгэлээ ханга. Энэ хавсралтаа боль гэдэг үгийг би зориуд хэлмээр байна. Ийм байж таарахгүй шүү дээ энэ чинь.

Дараагийн нэг зүйл энэ орон нутгийн эрх мэдлийг хумхи гэсэн асуудлуудаас аль болох л бид хязгаарлах ёстой. Одоо биднүүс төвлөрлийг сааруулах тухай асуудал ч ярьж байгаа, бизнес, аж ахуйг дэмжих тухай ч асуудал ярьж байгаа. Тэгээд буцаад тэр нааштай гэдэг юм уу, таатай орчин бүрдүүлдэг юм нь юун дээр очиж бууж байна гэхээр зэрэг орон нутгийн төсвийг бүрдүүлдэг хэдэн гол орлогынх нь эхний 5 жилийг тэглэнэ. Дараагийн 5 жилийг 75-лана, дараагийн 5 жилийг 50-лана ч гэдэг юм уу ингээд үндсэндээ орон нутгийнхаа эдийн засаг, төсвийн чадамжийг

нэмэгдүүлэх бололцоог нь энд хуулиар биднүүс нэлээн тийм хязгаарласан гэж хэлэх юм уу, саармагжуулсан шийдэл гаргаад яваад байгаа улс байхгүй юу.

Хэрвээ тийм шийдвэр гаргах гэж байгаа бол тэр хэмжээний хөрөнгийг нь орон нутагт төвлөрсөн төсвөөс нь дамжуулж олгох ёстой. Тэгж байж тэр орон нутгууд чинь илүү хурдан, эдийн засаг нь тэлэх, бас харьцангуй эдийн засаг, төсвийн эрх чөлөөтэй болж, өөрийнхөө өмнө тулгамдсан хийгээд хөгжлийнхөө асуудлуудыг шийдэх гарц, гаргалгаа нь бий болох ёстой. Үүнийг бол би энэ талаас нь хараасай гэж. Одоо жишээ нь Өмнөговь эдийн засаг хүндрэлтэй ч байна уу, хүндрэлгүй ч байна уу? Өөрөө зуун бараг дөчөөд тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт.../минут дуусав./

Т.Аюурсайхан: Гишүүд үг хэлж дууслаа. Ингээд үүгээр өнөөдрийн нэгдсэн хуралдааныг өндөрлүүлж байна. Ажлын хэсэгт баярлалаа. Маргаашийн нэгдсэн хуралдаан санал хураалтаар эхэлнэ.

18.11 цаг